Энэ хэсэгт аймаг дахь эрүү, иргэн, захиргааны хэргийн анхан шатны тус бүр 21 шүүх, сум дундын 8 шүүх, 19 аймаг дахь эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх, Орхон, Дархан-Уул аймаг дахь давж заалдах шатны эрүүгийн мөн иргэний нэг шүүх 23 шүүх, Нийслэлийн захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн “шийдвэрлэсэн хэргийн тоо, шүүгчийн тоо, шүүх бүрэлдэхүүн²” гэсэн үзүүлэлтийг шинжиллээ.

21 аймгийн шүүхийн хувьд тус тусад нь задалж 2017-2021 оны динамикийн өгөгдлийн хувьд дараагийн залгамж шинжилгээг үргэлжлүүлэх нь төвөгтэй тул бүсээр нь авч үзэх нь тохиромжтой эсэхийг шалгах зорилгоор 2 хүчин зүйлийн дисперсийн шинжилгээг явуулав. Мөн энэ шинжилгээний үр дүнгээс бүсүүд болон динамикийн үзүүлэлтийн хосолсон дунджийг хялбар тодорхойлох боломжтой байдаг. Шинжилгээний 1-р хүчин зүйл нь бүс, 2-р хүчин зүйл нь 2017-2021 он гэсэн динамик юм. Хоёр хүчин зүйлийн дисперсийн шинжилгээний үр дүнг дараах хүснэгтээр харуулбал:

Хэргийн төрөл	Анхан		Дангаар		Бүрэлдэхүүнээр		Давах	
	Бүс	Динамик	Бүс	Динамик	Бүс	Динамик	Бүс	Динамик
Иргэн	Хангай 321	●	Хангай 317	●	×	×	Баруун 17.6	×
	Төв 215		Төв 211				Зүүн 9.4	
Эрүү	Зүүн 104	●	Зүүн 93	●	Зүүн 5.3	●	Хангай 17.8	●
	Баруун 56		Баруун 50		Баруун 2.03		Баруун 10.7	
Захиргаа	Баруун 20	●	Баруун 18.8	×	Баруун 0.8	×	Баруун 31.7	×
	Зүүн 10.5		Зүүн 10.03		Зүүн 0.5		Зүүн 14.6	
Зөрчил	Хангай 212.5	●	—	—	—	—	×	●
	Төв 83.7							

Хүснэгт 2.1. Аймаг дахь анхан болон давж заалдах шатны шүүхийн нэг шүүгчид ногдох шийдвэрлэсэн хэргийн тоонд хийсэн дисперсийн шинжилгээний үр дүн

Үүнд: ● -

нөлөөлөлтэй, × - нөлөөлөлгүй, — - тооцоо хийгдэхгүй

Энэхүү хүснэгтээр Аймаг дахь сум дундын анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрлэсэн хэргийн (эрүү, зөрчил, иргэн, захиргаа) ачаалалд бүсийн болон динамикийн нөлөөлөл, ялгаа байгаа эсэх, мөн АШШ-д дангаар болон бүрэлдэхүүнээр шийдвэрлэсэн хэрэгт дээрх нөлөөлөл, ялгаа байгаа эсэхийг харуулав.

АШШ-д хамаарах бүсийн нөлөөг тайлбарлавал: Аймаг дахь ИХАШШ ба зөрчлийн хэргийн хувьд дунджаар нэг шүүгчид ногдох шийдвэрлэсэн хэргийн тоогоор хангайн бүс хамгийн өндөр, төвийн бүс хамгийн бага хэрэг шийдвэрлэсэн дүнтэй байна. Эрүүгийн

² Сум дундын шүүхүүдийн “Шүүх бүрэлдэхүүн” үзүүлэлт нь судалгааны багт өгөгдөөгүй болно. Харин зөрчлийн хэрэг нь анхан шатанд зөвхөн дангаар шийдвэрлэгддэг тул энэ үзүүлэлтийг зөрчлийн хэрэгт хамааруулж шинжлэх шаардлагагүй, шийдвэрлэсэн хэргийн дүнд хамаарах шинжилгээ бүхэлдээ дангаар шийдвэрлэсэн зөрчлийн хэргийн үр дүнг төлөөлнө.

хэргийн хувьд захиргааны хэргийн эсрэг үр дүнг харуулсан байна. Зүүн бүс хамгийн өндөр буюу нэг шүүгч жилд 104 хэрэг, баруун бүс хамгийн бага буюу нэг шүүгч жилд 56 хэрэг шийдвэрлэсэн байна. Захиргааны хэргийн хувьд эрүүгийн баруун бүс хамгийн өндөр буюу нэг шүүгч жилд 20 хэрэг, зүүн бүс хамгийн бага буюу нэг шүүгч жилд 10-11 хэрэг шийдвэрлэсэн байна. Эндээс дүгнэн хэлэхэд баруун бүсийн ард түмэн маргаан, зарга их хийдэг бөгөөд үүнийгээ захиргааны хэргийн шүүхэд хандан шийдвэрлүүлдэг хэв шинжтэй харагдаж байна. Харин зүүн бүсийн ард түмэн маргаан, зарга хийхгүй шууд нударга, мэсээр асуудлаа шийддэг хэв шинжтэй харагдаж байна.

Динамикийн нөлөөлөлтэй гэдгийг тайлбарлавал хуулийн өөрчлөлт, ковид 19-н нөлөөлөл байсан эсвэл цаашид өсөх эсвэл буурах хандлага (динамикийн хандлагыг дараа дараагийн дэд бүлгүүдэд тодорхой харуулах болно.) байгаа болохыг харуулж байна.

Эрүү, зөрчил, иргэн, захиргааны хэргийн бүсийн хэв шинжийг ерөнхийд нь харвал аль нэг бүс бүх төрлийн хэргийг зонхилсон хэв шинжгүй байна. Энэ нь бүсүүд өөр өөр хэв шинжтэй гэдгийг харуулж байна.

Дангаар шийдвэрлэсэн аймаг дахь ИХАШШ-н хувьд хангайн бүс мөн хамгийн өндөр буюу нэг шүүгч жилд 317 хэрэг, зүүн бүс хамгийн бага буюу нэг шүүгч жилд 211 хэрэг шийдвэрлэсэн байна. Эрүүгийн хэргийн хувьд мөн зүүн бүс хамгийн өндөр буюу нэг шүүгч жилд 93 хэрэг, баруун бүс хамгийн бага буюу нэг шүүгч жилд 50 хэрэг шийдвэрлэсэн байна. Захиргааны хэргийн хувьд баруун бүс хамгийн өндөр буюу нэг шүүгч жилд 19 хэрэг, зүүн бүс хамгийн бага буюу нэг шүүгч жилд 10 хэргийг дангаар шийдвэрлэсэн байна.

Бүрэлдэхүүнээр шийдвэрлэсэн аймаг дахь ИХАШШ-н хувьд бүсийн нөлөөлөлгүй гэсэн үр дүнг харуулсан байна. Энэ нь бүрэлдэхүүнээр шийдвэрлэсэн иргэний хэргийн хувьд бүх бүсүүд ижил байсан байна. хэрэг шийдвэрлэсэн бөгөөд хамгийн их, хамгийн бага гэж ялгах шаардлагагүй гэсэн үг юм. Эрүүгийн хэргийн хувьд мөн зүүн бүс хамгийн өндөр буюу нэг шүүгч жилд 5 хэрэг, баруун бүс хамгийн бага буюу нэг шүүгч жилд 2 хэрэг бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэсэн байна. Захиргааны хэргийн хувьд ийм өгөгдөл байхгүй тул шинжилгээ хийгдээгүй.

Анхан шатны шүүхүүдийн хамгийн их, бага утгыг харуулж байгаа бүсийн нөлөөлөл дангаар болон бүрэлдэхүүнээр шийдвэрлэсэн хэргийн нөлөөлөлтэй ижил байна. Энэ нь дараагийн шинжилгээнд дангаар болон бүрэлдэхүүнээр шийдвэрлэсэн хэргийн өгөгдлийг дахин шинжлэх шаардлагагүй зөвхөн аймаг дахь АШШ-н хэргийн төрлөө дагахад болно гэсэн мэдээллийг өгч байна.

ДЗШШ-д хамаарах өгөгдлийн хувьд нэг шүүгчид хамаарах ачааллын тухай хэрэг тус бүрээр нь салгаж шинжилсэн үр дүн юм. Энэ шатны шүүхийн нэг шүүгчийн шийдвэрлэсэн иргэний хэргийн тоо баруун бүсэд хамгийн өндөр буюу 18 байгаа бол зүүн бүсэд хамгийн бага буюу 9 байна. Харин эрүүгийн хэргийн хувьд хангайн бүсийн нэг шүүгчийн шийдвэрлэсэн хэргийн тоо хамгийн өндөр буюу 18, баруун бүс хамгийн бага буюу 11 байсан байна.

Давж заалдах шатны шүүхэд шийдвэрлэсэн хэргийн өгөгдлийн динамикийн нөлөөний хувьд эрүүгийн болон зөрчлийн хэргийн тоонд хуулийн өөрчлөлт, ковид 19-н нөлөөлөл орсон болохыг харуулж байна.

Мөн хүснэгт 2.1-д харуулсан “захиргаа-давах” үр дүн бол 21 аймгийн ЗХАШШ-д шийдвэрлэсэн хэрэгт давж заалдах гомдол гарч, хянуулсан буюу Нийслэлийн захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх нь анхан шатны шүүхээс хүлээн авч “хянасан бүгд” үзүүлэлтийн хүрээнд хийгдсэн шинжилгээний үр дүн юм. Иймд ЗХДЗШШ хянасан бүгд

үзүүлэлтэд баруун бүс 31.7 буюу өндөр, зүүн бүс 14.6 буюу бага дүнтэй байна. Энэ нь ЗХДЗШШ нь 5 жилийн дунджаар баруун бүсэд байрлаж байгаа ЗХАШШ-үүдээс хүлээн авч, хянасан бүгд дүн бусад бүс дэх шүүхүүдээс хамгийн өндөр бөгөөд 32 хэрэг (захирамж, тогтоол, бусад) хянаж байгааг харуулж байгаа бол эсрэгээрээ зүүн бүсийн шүүхүүдээс хүлээн авч, хянасан бүгд тоо бусад бүсээс хамгийн бага буюу 15 хэрэг (захирамж, тогтоол, бусад) байна.

2.1.1. Дүүрэг, нийслэлийн шүүхэд шүүн таслах ажиллагааны тодорхой төрлөөр шийдвэрлэсэн хэргийн тооны өгөгдөлд хийсэн шинжилгээ

- Эрүүгийн хэрэг

Эрүүгийн хэргийн тайлан мэдээллийн маягтын үндсэн үзүүлэлт болох шийдвэрлэсэн хэрэг, үлдэгдэл хэрэг (11-р шалгуур)-н тоон мэдээлэлд хийсэн 2 хүчин зүйлийн дисперсийн шинжилгээний үр дүнг хүснэгтээр харуулъя. Шинжилгээнд 1-р хүчин зүйлээр дүүргийн байршил (төв, зах), 2-р хүчин зүйлээр динамикийн үзүүлэлт (2017-2021 он)-г авсан.

Эрүүгийн хуулийн бүлгээр	Шийдвэрлэсэн хэрэг		Үлдэгдэл хэрэг	
	Дүүрэг	Динамик	Дүүрэг	Динамик
Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг (10-р бүлэг)	Зах 3.0	×	Зах 0.3	×
	Төв 21.3		Төв 3.4	
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг (11-р бүлэг)	Зах 74.1	×	Зах 4.3	×
	Төв 607.4		Төв 31.8	
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг (12-р бүлэг)	Зах 2.9	×	Зах 0.8	×
	Төв 24.5		Төв 4.5	
Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг (13-р бүлэг)	Зах 0.3	×	Зах 0.1	×
	Төв 2.9		Төв 0.7	
Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг (14-р бүлэг)	×	×	×	×
Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг (15-р бүлэг)	Зах 0.1	×	×	×
	Төв 0.6			
Хүүхдийн эсрэг гэмт хэрэг (16-р бүлэг)	Зах 0.1	○ mh	—	—
	Төв 1.2			
Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг (17-р бүлэг)	Зах 17.5	×	Зах 0.6	×
	Төв 315.6		Төв 38.9	
Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг (18-р бүлэг)	Зах 0.1	×	Зах 0.0	×
	Төв 2.7		Төв 0.54	
Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг (19-р бүлэг)	×	×	×	×
Олон нэг шүүхийн аюулгүй байдал ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг (20-р бүлэг)	Зах 1.6	×	Зах 0.3	×
	Төв 28.3		Төв 4.2	
Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг (21-р бүлэг)	×	×	Зах 0.08	×
			Төв 0.5	
Авилгын эсрэг гэмт хэрэг (22-р бүлэг)	Зах 0.4	•	Зах 0.0	×
	Төв 6.7		Төв 2.5	
Нэг шүүхийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг (23-р бүлэг)	Зах 1.33	•	Зах 0.0	×
	Төв 7.9		Төв 0.8	
Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг (24-р бүлэг)	Зах 0.4		Зах 0.0	×
	Төв 4.2		Төв 0.4	
Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг (25-р бүлэг)	×	×	×	×
Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг (26-р бүлэг)	Зах 0	×	Зах 0.0	—
	Төв 1.04		Төв 0.2	
	Зах 6.8	×	Зах 0.4	×

Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг (27-р бүлэг)	Төв 70.9		Төв 8.4	
Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг (28-р бүлэг)	×	×	×	×
Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг (29-р бүлэг)	×	×	×	×

Хүснэгт 2.2. Дүүргийн шүүхэд шийдвэрлэсэн ба үлдэгдэл эрүүгийн хэргийн төрөлд хийсэн дисперсийн шинжилгээний үр дүн

Үүнд: ● - нөлөөлөлтэй, × - нөлөөлөлгүй, — - тооцоо хийгдэхгүй

Хүснэгт 2.2-д үзүүлсэн эрүүгийн хуулийн 10 дугаар бүлэг буюу хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэргийн шийдвэрлэсэн хэргийн тооны өгөгдөлд хийсэн шинжилгээний үр дүнг жишээ болгож тайлбарлая.

АШШ-д хамаарах дүүргийн байршлын нөлөөг тайлбарлавал: ДЭХАШШ-н хувьд дунджаар нэг шүүгчид ногдох шийдвэрлэсэн хэргийн тоогоор төвийн дүүрэг их буюу 21 хэрэг, захын дүүрэг бага буюу 3 хэрэг 1 жилд шийдвэрлэсэн байна.

10 дугаар бүлгийн үлдэгдэл хэргийн хувьд захын дүүргийн нэг шүүгч нэг жилд 0.3 буюу 5 жилд 1-2 хэрэг, төвийн дүүргийн нэг шүүгч жилд 3.4 хэргийн үлдэгдэлтэй явж ирсэн байна.

Динамикийн нөлөөлөлгүй байсан гэдэг нь хууль эрх зүйн ямар нэгэн өөрчлөлт, Ковид-19-н нөлөөлөлд энэ бүлгийн үзүүлэлт өртөөгүй байжээ гэсэн үг юм. Үүнээс гадна ямар нэгэн өсөлт бууралтын хандлага байхгүй тул 10-р бүлгийн хэргийн тоо өөрчлөлтгүй, тогтмол гэсэн утгыг мөн илтгэнэ. Энэ мэтчилэн эрүүгийн хуулийн бусад бүлгийн шинжилгээний үр дүнг дээрх тайлбартай адил утгаар ойлгоно.

Эрүүгийн хэргийн тайлан мэдээллийн маягтын үндсэн үзүүлэлт болох шийдвэрлэсэн хэрэгт хамаарах хүний тоо, үлдэгдэл хэрэгт хамаарах хүний тоон (11-р шалгуур)-ий мэдээлэлд хийсэн 2 хүчин зүйлийн дисперсийн шинжилгээний үр дүнг хүснэгтээр харууля. Шинжилгээнд 1-р хүчин зүйлээр дүүргийн байршил (төв, зах), 2-р хүчин зүйлээр динамикийн үзүүлэлт (2017-2021 он)-г авсан.

Эрүүгийн хуулийн бүлгээр	Шийдвэрлэсэн хэргийн хүн ³		Үлдэгдэл хэргийн хүн	
	Дүүрэг	Динамик	Дүүрэг	Динамик
Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг (10-р бүлэг)	Зах 3.4 Төв 23.6	×	Зах 0.2 Төв 4	×
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг (11-р бүлэг)	Зах 81 Төв 682.7	×	Зах 4.6 Төв 38.5	×
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг (12-р бүлэг)	Зах 3.6 Төв 28.4	×	Зах 1 Төв 6.3	×
Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг (13-р бүлэг)	Зах 0.4 Төв 4.4	×	Зах 0.2 Төв 1.6	×
Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг (14-р бүлэг)	×	×	×	×
Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг (15-р бүлэг)	Зах 0.08 Төв 1.2	×	Зах 0.2 Төв 0.2	×
Хүүхдийн эсрэг гэмт хэрэг (16-р бүлэг)	Зах 0.08 Төв 1.2	○ mh	—	—
	Зах 20.3		Зах 0.9	

³ Статистик тайлан мэдээллийн маягт дахь үзүүлэлтийн албан ёсны нэршлийг энэхүү шинжилгээнд ашиглав. Шийдвэрлэсэн хэрэг, хүн гэсэн үзүүлэлтээр тайлан, мэдээлэл гардаг байна.

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг (17-р бүлэг)	Төв 396.7	×	Төв 62.4	×
Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг (18-р бүлэг)	Зах 0.2 Төв 8.5	×	Зах 0.0 Төв 1.6	×
Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг (19-р бүлэг)	Зах 0.1 Төв 2.3	×	×	×
Олон нэг шүүхийн аюулгүй байдал ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг (20-р бүлэг)	Зах 2.2 Төв 45.7	×	Зах 0.6 Төв 10.5	×
Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг (21-р бүлэг)	×	×	Зах 0.08 Төв 1.6	×
Авилгын эсрэг гэмт хэрэг (22-р бүлэг)	Зах 0.8 Төв 17.7	•	Зах 0.0 Төв 13.2	×
Нэг шүүхийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг (23-р бүлэг)	Зах 1.5 Төв 9.6	×	Зах 0.0 Төв 1.3	×
Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг (24-р бүлэг)	Зах 0.5 Төв 7.2	—	—	×
Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг (25-р бүлэг)	×	×	×	×
Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг (26-р бүлэг)	Зах 0 Төв 1.6	×	—	—
Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг (27-р бүлэг)	Зах 6.9 Төв 71.6	×	Зах 0.42 Төв 8.67	×
Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг (28-р бүлэг)	×	×	×	×
Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг (29-р бүлэг)	×	×	×	×

Хүснэгт 2.3. Дүүргийн шүүхэд шийдвэрлэсэн ба үлдэгдэл эрүүгийн хэргийн хүний тооны төрөлд хийсэн дисперсийн шинжилгээний үр дүн

Үүнд: • - нөлөөлөлтэй, × - нөлөөлөлгүй, — - тооцоо хийгдэхгүй

Хүснэгт 2.3-д үзүүлсэн эрүүгийн хуулийн 10 дугаар бүлэг буюу хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэргийн шийдвэрлэсэн хэрэгт хамаарах хүний тоон өгөгдөлд хийсэн шинжилгээний үр дүнг жишээ болгож тайлбарлая.

АШШ-д хамаарах дүүргийн байрилын нөлөөг тайлбарлавал: ДЭХАШШ-н хувьд дунджаар нэг шүүгчид ногдох шийдвэрлэсэн хэрэгт хамаарах хүний тоогоор төвийн дүүрэг их буюу 24 хүнтэй холбоотой хэрэг, захын дүүрэг бага буюу 3 хүнтэй холбоотой хэргийг нэг шүүгч нэг жилд шийдвэрлэсэн байна.

10 дугаар бүлгийн үлдэгдэл хэрэгт хамаарах хүний тооны хувьд захын дүүргийн нэг шүүгч нэг жилд 0.2 буюу 5 жилд 1 хүнтэй холбоотой хэргийн үлдэгдэлтэй, төвийн дүүргийн шүүгч жилд 4 хүнтэй холбоотой хэргийн үлдэгдэлтэй явж ирсэн байна.

Динамикийн нөлөөлөлгүй байсан гэдэг нь хууль эрх зүйн ямар нэгэн өөрчлөлт, Ковид-19-н нөлөөлөлд энэ бүлгийн үзүүлэлт өртөөгүй байжээ гэсэн үг юм. Үүнээс гадна ямар нэгэн өсөлт бууралтын хандлага байхгүй тул 10-р бүлгийн хэргийн хүний тоо өөрчлөлтгүй, тогтмол гэсэн утгыг мөн илтгэнэ. Энэ мэтчилэн эрүүгийн хуулийн бусад бүлгийн шинжилгээний үр дүнг дээрх тайлбартай адил утгаар ойлгоно.

• Иргэний хэрэг

Иргэний хэргийн тайлан мэдээллийн маягтад маргааны төрлөөр батлагдсан, албан ёсны үзүүлэлтээс Монгол Улсын шүүхийн тайланд маргааны төрөл болон нэг шүүхэд тархаагддаг дараах үзүүлэлтийн хүрээнд 2 хүчин зүйлийн дисперсийн шинжилгээг хийсэн.

Шинжилгээнд 1-р хүчин зүйлээр дүүргийн байршил (төв, зах), 2-р хүчин зүйлээр динамикийн үзүүлэлт (2017-2021 он)-г авсан. Шинжилгээний үр дүнг дараах хүснэгтээр харуулъя.

Маргааны төрлөөр	Дүүрэг	Динамик
Иргэний хуулиар	Зах 226.8	×
	Төв 2560.2	
Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуулиар	Зах 77.0	×
	Төв 848.2	
Гэр бүлийн тухай хуулиар	Зах 42.4	×
	Төв 399.1	
Хөдөлмөрийн тухай хуулиар	Зах 5.7	×
	Төв 144.5	
Газрын тухай хуулиар	Зах 1.9	×
	Төв 13.1	
Дампуурлын тухай хуулиар	Зах 0.2	×
	Төв 2.7	
Компанийн тухай хуулиар	Зах 2.07	×
	Төв 2.8	
Нийгмийн даатгалын багц хуулиар	Зах 8.8	×
	Төв 35.1	
Шүүхийн шийдвэр гүйцэдгэх тухай хуулиар	Зах 1.4	×
	Төв 54.8	
Татварын ерөнхий хуулиар	×	×
Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн тухай хуулиар	×	×
Төрийн албаны тухай хуулиар	×	×
Цагаатгалын нөхөн олговор	Зах 6.1	×
	Төв 25.1	
Бусад хуулиар	Зах 0.08	×
	Төв 76.1	

Хүснэгт 2.4. Дүүргийн шүүхэд шийдвэрлэсэн иргэний хэргийн маргааны төрөлд хийсэн дисперсийн шинжилгээний үр дүн

Үүнд: ● - нөлөөлөлтэй, × - нөлөөлөлгүй, — - тооцоо хийгдэхгүй

Хүснэгт 2. 4-д үзүүлсэн маргааны төрлийн иргэний хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоон өгөгдөлд хийсэн шинжилгээний үр дүнг жишээ болгож тайлбарлая.

Дүүргийн байршлын нөлөөг тайлбарлавал: ДИХАШШ-н хувьд дунджаар нэг шүүгчид ногдох иргэний хуулиар шийдвэрлэсэн хэргийн хувьд төвийн дүүрэг их буюу 2560 хэрэг, захын дүүрэг бага буюу 227 хэргийг нэг шүүгч нэг жилд шийдвэрлэсэн байна.

Динамикийн нөлөөлөлгүй байсан гэдэг нь хууль эрх зүйн ямар нэгэн өөрчлөлт, Ковид-19-н нөлөөлөлд энэ бүлгийн үзүүлэлт өртөөгүй байжээ гэсэн үг юм. Үүнээс гадна ямар нэгэн өсөлт бууралтын хандлага байхгүй тул иргэний хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо өөрчлөлтгүй, тогтмол гэсэн утгыг мөн илтгэнэ. Гэх мэтчилэн иргэний хэргийн маргааны төрлийн бусад хуулийн хувьд хийсэн шинжилгээний үр дүнг дээр өгсөн тайлбартай адил утгаар ойлгоно.

● Захиргааны хэрэг

Нийслэлийн хэмжээнд захиргааны хэргийн нэг шүүх байдаг тул энэ шүүхийн хувьд дисперсийн шинжилгээ хийгдэхгүй, нэгдсэн үр дүнг хүснэгт 2.1-с харна уу.

2.1.2. Аймаг дахь сум дундын анхан шатны шүүхэд шүүн таслах ажиллагааны тодорхой төрлөөр шийдвэрлэсэн хэргийн тооны өгөгдөлд хийсэн шинжилгээ

Хүснэгт 2.1-д дурдсан аймаг дахь АШШ-н өгөгдөлд хийсэн дисперсийн шинжилгээний бүс болон динамикийн нөлөөллийг эрүү, зөрчил, иргэн, захиргааны хэргийн хувьд дараах хүснэгтүүдээр задалж харуулъя.

Бүс	Иргэн	Эрүү	Захиргаа	Зөрчил	Динамик	Иргэн	Эрүү	Зөрчил
Төв	214.9	68.1	11.3	83.7	2017	237	61.2	-
Зүүн	274.5	104.2	10.4	165.8	2018	280	77.1	106.2
Баруун	257.1	56.1	19.6	109.1	2019	245	85.2	137.1
Хангай	321	89.7	12.6	212.5	2020	323	84.2	155.7
Дундаж	267	79.5	13.5	142.8	2021	233	75.3	154.2
					Дундаж	264	76.6	138.3

Хүснэгт 2.5. Аймаг дахь АШШ, бүсээр

Хүснэгт 2.6. Динамикаар

Хүснэгт 2.5-н тайлбарыг Хүснэгт 2.1-н утгыг тайлбарласан хэсгээс харна уу. Жишээ болгож зөвхөн хүснэгт 2.5-н утгыг тайлбарлая. Аймаг дахь ИХАШШ-н нэг шүүгчийн нэг жилд шийдвэрлэсэн хэргийн тоогоор 2020 он хамгийн өндөр үзүүлэлттэй буюу 323 шийдвэрлэсэн жил байжээ. 2021 онд хамгийн бага буюу нэг шүүгч 233 хэрэг шийдвэрлэсэн жил байсан байна. Энэ үзүүлэлт Ковид-19-н нөлөөлөлд орсон үзүүлэлт байна. Аймаг дахь ЭХАШШ-н нэг шүүгчийн нэг жилд шийдвэрлэсэн хэргийн тоогоор 2019 он хамгийн өндөр үзүүлэлттэй буюу 85 шийдвэрлэсэн жил байжээ. 2017 онд хамгийн бага буюу нэг шүүгч 61 хэрэг шийдвэрлэсэн жил байсан байна. Энэ үзүүлэлт хууль эрх зүйн өөрчлөлтэй холбоотой байна. Зөрчлийн хэргийн хувьд нэг шүүгчийн нэг жилд шийдвэрлэсэн хэргийн тоогоор 2020 он хамгийн өндөр үзүүлэлттэй буюу 156 шийдвэрлэсэн жил байжээ. 2018 онд хамгийн бага буюу нэг шүүгч 106 хэрэг шийдвэрлэсэн жил байсан байна. Энэ үзүүлэлт шинэ хууль хэрэгжүүлэх үе шат мөн Ковид-19-н нөлөөлөлд орсон үзүүлэлт байна. Бусад хүснэгтийн хувьд дээр өгсөн тайлбартай адил утгаар ойлгоно.

Бүс	Иргэн	Эрүү	Захиргаа	Динамик	Иргэн	Эрүү	Захиргаа
Төв	211.2	58.3	10.7	2017	233.1	30.0	14.6
Зүүн	271.2	93.3	10.0	2018	275.6	72.9	11.9
Баруун	253.4	50.3	18.7	2019	240.9	81.5	12.5
Хангай	316.6	79.0	12.0	2020	319.8	79.4	11.1
Дундаж	263.1	70.3	12.9	2021	230.5	72.8	14.4
				Дундаж	259.9	67.4	12.9

Хүснэгт 2.7. Аймаг дахь АШШ дангаар, бүсээр

Хүснэгт 2.8. Динамикаар

Бүс	Иргэн	Эрүү	Захиргаа	Динамик	Иргэн	Эрүү	Захиргаа
Төв	3.1	3.2	0.5	2017	4.2	2.1	0.6
Зүүн	3.3	5.4	0.4	2018	3.8	2.9	0.8
Баруун	3.74	2.0	0.8	2019	3.6	3.1	0.6
Хангай	3.99	4.6	0.6	2020	3.4	4.7	0.5
Дундаж	3.5	3.8	0.6	2021	2.6	5.2	0.5
				Дундаж	3.5	3.6	0.6

Хүснэгт 2.9. Аймаг дахь СДШ бүрэлдэхүүнээр, бүсээр

Хүснэгт 2.10. Динамикаар

• Эрүүгийн хэрэг

Аймаг дахь АШШ-н шийдвэрлэсэн нэг шүүх хэргийн хувьд хэргийн төрөл доторх эрүүгийн хуулийн бүлэг, маргааны төрөл тус бүрд мөн 2 хүчин зүйлийн дисперсийн

шинжилгээ хийсэн. Шинжилгээнд 1-р хүчин зүйлээр бүс, 2-р хүчин зүйлээр динамикийн үзүүлэлт (2017-2021 он)-г авсан. Шинжилгээний үр дүнг дараах хүснэгтээр харуулъя.

Эрүүгийн хуулийн бүлгээр	Шийдвэрлэсэн хэрэг		Үлдэгдэл хэрэг	
	Бүс	Динамик	Бүс	Динамик
Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг (10-р бүлэг)	Баруун 2.3 Хангай 5.4 Төв 4.9 Зүүн 7.2	×	×	•
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг (11-р бүлэг)	Баруун 73.9 Хангай 146.2 Төв 118.6 Зүүн 136.6	×	Баруун 2.4 Хангай 6.4 Төв 5.9 Зүүн 2.4	×
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг (12-р бүлэг)	Баруун 5.6 Хангай 13.7 Төв 7.2 Зүүн 10.6	×	Баруун 0.6 Хангай 1.8 Төв 1.2 Зүүн 0.5	×
Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг (13-р бүлэг)	×	×	×	×
Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг (14-р бүлэг)	×	×	×	×
Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг (15-р бүлэг)	×	×	×	×
Хүүхдийн эсрэг гэмт хэрэг (16-р бүлэг)	×	o h	—	—
Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг (17-р бүлэг)	Баруун 50.5 Хангай 75.6 Төв 51.5 Зүүн 81.4	×	Баруун 2.8 Хангай 7.08 Төв 4.6 Зүүн 4.6	×
Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг (18-р бүлэг)	Баруун 0.1 Хангай 0.3 Төв 0.9 Зүүн 1.5	×	×	×
Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг (19-р бүлэг)	o	×	×	×
Олон нэг шүүхийн аюулгүй байдал ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг (20-р бүлэг)	×	•	—	×
Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг (21-р бүлэг)	Баруун 0.95 Хангай 2 Төв 1.03 Зүүн 0.17	×	×	×
Авилгын эсрэг гэмт хэрэг (22-р бүлэг)	Баруун 2.65 Хангай 1.62 Төв 1.21 Зүүн 1.1	•	×	•
Нэг шүүхийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг (23-р бүлэг)	Баруун 2.6 Хангай 2.4 Төв 2.8 Зүүн 1.9	×	×	×
Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг (24-р бүлэг)	Баруун 9.3 Хангай 21.2 Төв 9.2	—	—	×

	Зүүн 10.7			
Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг (25-р бүлэг)	×	×	×	×
Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг (6-р бүлэг)	×	×	—	—
Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг (27-р бүлэг)	Баруун 13.1	×	×	×
	Хангай 24.1			
	Төв 24.4			
	Зүүн 27.2			
Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг (28-р бүлэг)	×	×	×	×
Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг (29-р бүлэг)	×	×	×	×

Хүснэгт 2.11. Аймаг дахь сум дундын шүүхэд шийдвэрлэсэн ба үлдэгдэл эрүүгийн хэргийн төрөлд хийсэн дисперсийн шинжилгээний үр дүн

Үүнд: • - нөлөөлөлтэй, × - нөлөөлөлгүй, — - тооцоо хийгдэхгүй

Хүснэгт 2.11-д үзүүлсэн эрүүгийн хуулийн 10 дугаар бүлэг буюу хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэргийн шийдвэрлэсэн хэргийн тооны өгөгдөлд хийсэн шинжилгээний үр дүнг жишээ болгож тайлбарлая.

АШШ-д хамаарах бүсийн нөлөөг тайлбарлавал: АЭХАШШ-н хувьд дунджаар нэг шүүгчид ногдох шийдвэрлэсэн хэргийн тоогоор зүүн бүс хамгийн өндөр буюу 7 хэрэг, баруун бүс хамгийн бага буюу 2 хэрэг жилд шийдвэрлэсэн байна. Хангай болон төвийн бүс нэг шүүгчид ногдох шийдвэрлэсэн хэргийн тоогоор дундаж буюу 5 хэрэг жилд шийдвэрлэсэн байна. 10 дугаар бүлгийн үлдэгдэл хэргийн хувьд бүсийн нөлөөлөл байхгүй гэдэг нь бүх бүсүүд ижил тогтмол үзүүлэлттэй байсан байна гэсэн утгыг илтгэж байна.

Шийдвэрлэсэн хэргийн тоонд динамикийн нөлөөлөл байхгүй байсан гэдэг нь хууль эрх зүйн ямар нэгэн өөрчлөлт, Ковид-19-н нөлөөлөлд энэ бүлгийн үзүүлэлт өртөөгүй байжээ гэсэн үг юм. Үүнээс гадна ямар нэгэн өсөлт бууралтын хандлага байхгүй тул 10-р бүлгийн хэргийн тоо өөрчлөлтгүй, тогтмол гэсэн утгыг мөн илтгэнэ. Харин үлдэгдэл хэргийн тооны хувьд динамикийн нөлөөлөлд орсон байна. Энэ нь үлдэгдэл хэргийн тоонд Ковид-19-н нөлөөлөл орсон гэсэн үг юм. Энэ мэтчилэн эрүүгийн хуулийн бусад бүлгийн шинжилгээний үр дүнг дээр өгсөн тайлбартай адил утгаар ойлгоно.

Эрүүгийн хэргийн тайлан мэдээллийн маягтын үндсэн үзүүлэлт болох шийдвэрлэсэн хэрэгт хамаарах хүний тоо, үлдэгдэл хэрэгт хамаарах хүний тоон (11-р шалгуур) мэдээлэлд хийсэн 2 хүчин зүйлийн дисперсийн шинжилгээний үр дүнг хүснэгтээр харуулъя. Шинжилгээнд 1-р хүчин зүйлээр бүс, 2-р хүчин зүйлээр динамикийн үзүүлэлт (2017-2021 он)-г авсан.

Эрүүгийн хуулийн бүлгээр	Шийдвэрлэсэн хүн		Үлдэгдэл хүн	
	Бүс	Динамик	Бүс	Динамик
Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг (10-р бүлэг)	Баруун 2.4	×	×	•
	Хангай 6.08			
	Төв 5.6			
	Зүүн 8.08			
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг (11-р бүлэг)	Баруун 83.0	×	Баруун 2.65	•
	Хангай 162.9		Хангай 7.83	
	Төв 130.7		Төв 7.03	
	Зүүн 145.9		Зүүн 2.91	
	Баруун 6.8			

Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг (12-р бүлэг)	Хангай 14.8 Төв 8.2 Зүүн 11.6	×	×	×
Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг (13-р бүлэг)	×	×	×	×
Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг (14-р бүлэг)	×	×	×	×
Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг (15-р бүлэг)	×	•	×	×
Хүүхдийн эсрэг гэмт хэрэг (16-р бүлэг)	×	×	—	—
Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг (17-р бүлэг)	Баруун 65.4 Хангай 102.8 Төв 105.5 Зүүн 69.2	×	Баруун 4.3 Хангай 15.2 Төв 8.07 Зүүн 6.0	×
Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг (18-р бүлэг)	×	×	×	×
Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг (19-р бүлэг)	○ ○	×	×	×
Олон нэг шүүхийн аюулгүй байдал ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг (20-р бүлэг)	×	×	—	×
Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг (21-р бүлэг)	Баруун 1.2 Хангай 3.5 Төв 2 Зүүн 1.5	×	×	×
Авилгын эсрэг гэмт хэрэг (22-р бүлэг)	Баруун 5.4 Хангай 2.7 Төв 2.7 Зүүн 1.7	•	×	×
Нэг шүүхийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг (23-р бүлэг)	×	×	×	×
Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг (24-р бүлэг)	Баруун 13.4 Хангай 27.6 Төв 13.4 Зүүн 16.2	•	—	×
Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг (25-р бүлэг)	×	×	×	×
Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг (26-р бүлэг)	×	×	—	—
Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг (27-р бүлэг)	Баруун 13.5 Хангай 24.6 Төв 25.3 Зүүн 27.2	×	×	×
Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг (28-р бүлэг)	×	×	×	×
Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг (29-р бүлэг)	×	×	×	×

Хүснэгт 2.12. Аймаг дахь сум дундын ЭХАШШ-д шийдвэрлэсэн хэргийн хүний тооны төрөлд хийсэн дисперсийн шинжилгээний үр дүн

Үүнд: • - нөлөөлөлтэй, ×- нөлөөлөлгүй, — - тооцоо хийгдэхгүй

Хүснэгт 2.12-д үзүүлсэн эрүүгийн хуулийн 10 дугаар бүлэг буюу хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэргийн шийдвэрлэсэн хэрэгт хамаарах хүний тоон өгөгдөлд хийсэн шинжилгээний үр дүнг жишээ болгож тайлбарлая.

АШШ-д хамаарах бүсийн нөлөөг тайлбарлавал: АЭХАШШ-н хувьд дунджаар нэг шүүгчид ногдох шийдвэрлэсэн хэрэгт хамаарах хүний тоогоор зүүн бүс хамгийн их буюу 8 хүнтэй холбоотой хэрэг, баруун бүс хамгийн бага буюу 2 хүнтэй холбоотой хэргийг нэг шүүгч нэг жилд шийдвэрлэсэн байна. Харин хангай болон төвийн бүсийн шүүгч 5-6 хүнтэй холбоотой хэргийг нэг шүүгч нэг жилд тус тус шийдвэрлэсэн байна. 10 дугаар бүлгийн үлдэгдэл хэргийн хүний тооны хувьд бүсийн нөлөө байхгүй бүх бүсийг ижил гэж үзэж болно гэсэн үр дүнг харуулсан байна.

Шийдвэрлэсэн хэргийн хүний тооны хувьд динамикийн нөлөөлөлгүй байсан гэдэг нь хууль эрх зүйн ямар нэгэн өөрчлөлт, Ковид-19-н нөлөөлөлд энэ бүлгийн үзүүлэлт өртөөгүй байна гэсэн үг юм. Үүнээс гадна ямар нэгэн өсөлт бууралтын хандлага байхгүй тул 10-р бүлгийн хэргийн хүний тоо өөрчлөлтгүй, тогтмол гэсэн утгыг мөн илтгэнэ. Харин үлдэгдэл хэрэгт хамаарах хүний тооны хувьд динамикийн нөлөөлөлд орсон байна. Энэ нь үлдэгдэл хэргийн тоонд Ковид-19-н нөлөөлөл орсон гэсэн үг юм. Гэх мэтчилэн эрүүгийн хуулийн бусад бүлгийн хэрэгт хамаарах хүний тоон өгөгдөлд хийсэн шинжилгээний үр дүнг дээр өгсөн тайлбартай адил утгаар ойлгоно.

• Иргэний хэрэг

Иргэний хэргийн тайлан мэдээллийн маягтад маргааны төрлөөр батлагдсан, албан ёсны үзүүлэлтээс Монгол Улсын шүүхийн тайланд маргааны төрөл болон нэг шүүхэд тархаагддаг дараах үзүүлэлтийн хүрээнд 2 хүчин зүйлийн дисперсийн шинжилгээг хийсэн. Шинжилгээнд 1-р хүчин зүйлээр бүс, 2-р хүчин зүйлээр динамикийн үзүүлэлт (2017-2021 он)-г авсан. Шинжилгээний үр дүнг дараах хүснэгтээр харуулъя.

Маргааны төрлөөр	Бүс	Динамик
Иргэний хуулиар	Баруун 191.7	×
	Хангай 354.1	
	Төв 279.8	
	Зүүн 332.8	
Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуулиар	Баруун 444.8	•
	Хангай 614.7	
	Төв 344.2	
	Зүүн 325.4	
Гэр бүлийн тухай хуулиар	Баруун 46.4	×
	Хангай 125.6	
	Төв 90.6	
	Зүүн 85.8	
Хөдөлмөрийн тухай хуулиар	Баруун 52.9	•
	Хангай 25.1	
	Төв 18.4	
	Зүүн 18.3	
Газрын тухай хуулиар	Баруун 1.6	×
	Хангай 1.7	
	Төв 2.4	
	Зүүн 0.6	
Дампуурлын тухай хуулиар	×	×
Компанийн тухай хуулиар	×	×

Нийгмийн даатгалын багц хуулиар	×	×
Шүүхийн шийдвэр гүйцэдгэх тухай хуулиар	×	×
Татварын ерөнхий хуулиар	×	•
Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн тухай хуулиар	×	×
Төрийн албаны тухай хуулиар	Баруун 1.1	×
	Хангай 0.07	
	Төв 0.2	
	Зүүн 0.07	
Цагаатгалын нөхөн олговор	Баруун 5.4	•
	Хангай 6.07	
	Төв 7.7	
	Зүүн 20.2	
Бусад хуулиар	Баруун 20.2	×
	Хангай 1.5	
	Төв 5.8	
	Зүүн 54.6	

Хүснэгт 2.13. Аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд шийдвэрлэсэн хэргийн маргааны төрөлд хийсэн дисперсийн шинжилгээний үр дүн

Үүнд: • - нөлөөлөлтэй, × - нөлөөлөлгүй, — - тооцоо хийгдэхгүй

Хүснэгт 2.13-д үзүүлсэн маргааны төрлийн иргэний хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоон өгөгдөлд хийсэн шинжилгээний үр дүнг жишээ болгож тайлбарлая.

Бүсийн нөлөөг тайлбарлавал: АИХАШШ-н хувьд дунджаар нэг шүүгчид ногдох иргэний хуулиар шийдвэрлэсэн хэргийн хувьд хангай бүсэд хамгийн их буюу 354 хэрэг, баруун бүсэд хамгийн бага буюу 192 хэргийг нэг шүүгч нэг жилд шийдвэрлэсэн байна.

Динамикийн нөлөөлөлгүй байсан гэдэг нь хууль эрх зүйн ямар нэгэн өөрчлөлт, Ковид-19-н нөлөөлөлд энэ бүлгийн үзүүлэлт өртөөгүй байжээ гэсэн үг юм. Үүнээс гадна ямар нэгэн өсөлт бууралтын хандлага байхгүй тул иргэний хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо өөрчлөлтгүй, тогтмол гэсэн утгыг мөн илтгэнэ. Гэх мэтчилэн иргэний хэргийн маргааны төрлийн бусад хуулийн хувьд хийсэн шинжилгээний үр дүнг дээр өгсөн тайлбартай адил утгаар ойлгоно.

Иргэний хэргийн хариуцагчийн тоо 3-р бүлгийн гол хэсгийн шинжилгээний бүрэлдэхүүн хэсгийн загварт хувьсагч хэлбэрээр орох тул ерөнхий тохиолдолд бүсийн болон динамикийн нөлөөг тодорхойлох зорилгоор мөн 2 хүчин зүйлийн дисперсийн шинжилгээ явуулав.

Хариуцагч	Бүс	Динамик
Иргэн	Баруун 289.56	×
	Хангай 480.70	
	Төв 388.86	
	Зүүн 495.73	
Хуулийн этгээд	Баруун 94.6	×
	Хангай 64.73	
	Төв 57.46	
	Зүүн 50.73	

Хүснэгт 2.14. Аймаг дахь сум дундын шүүхийн иргэний хэргийн хариуцагчийн тоонд хийсэн дисперсийн шинжилгээний үр дүн

Үүнд: • - нөлөөлөлтэй, × - нөлөөлөлгүй, — - тооцоо хийгдэхгүй

Хүснэгт 2.14-д үзүүлсэн иргэний хэргийн хариуцагчийн тоонд хийсэн шинжилгээний үр дүнг тайлбарлая.

Бүсийн нөлөөг тайлбарлавал: АИХАШШ-н хувьд дунджаар нэг шүүгчид ногдох иргэний хэрэгт хамаарах иргэний тоогоор зүүн бүс хамгийн их буюу 496 иргэнтэй холбоотой хэрэг, баруун бүс хамгийн бага буюу 290 иргэнтэй холбоотой хэргийг нэг шүүгч нэг жилд шийдвэрлэсэн байна. Харин хангайн бүсийн иргэний хэргийн нэг шүүгч 481 хэрэгт хамаарах иргэний хэргийг, зүүн бүсийн иргэний хэргийн нэг шүүгч 389 хэрэгт хамаарах иргэний хэргийг тус тус шийдвэрлэжээ.

Динамикийн нөлөөлөлгүй байсан гэдэг нь хууль эрх зүйн ямар нэгэн өөрчлөлт, Ковид-19-н нөлөөлөлд энэ бүлгийн үзүүлэлт өртөөгүй байжээ гэсэн үг юм. Үүнээс гадна ямар нэгэн өсөлт бууралтын хандлага байхгүй тул иргэний хэрэгт хамаарах иргэний тоо өөрчлөлтгүй, тогтмол гэсэн утгыг мөн илтгэнэ. Гэх мэтчилэн иргэний хэргийн хуулийн этгээдийн тооны тухай үр дүнг дээр өгсөн тайлбартай адил утгаар ойлгоно.

• **Захиргааны хэрэг**

Аймгийн захиргааны хэргийн шүүхэд шийдвэрлэсэн хэргийн маргааны төрөлд мөн 2 хүчин зүйлийн дисперсийн шинжилгээ явуулсан үр дүнг дараах хүснэгтэд харуулав.

Маргааны төрлөөр	Бүс	Динамик
Газар	Баруун 9.6	×
	Хангай 4.4	
	Төв 6.9	
	Зүүн 5.2	
Төрийн алба	Баруун 4.5	•
	Хангай 6.6	
	Төв 17.5	
	Зүүн 9.2	
Ашигт малтмал	×	×
Үл хөдлөх хөрөнгийн улсын бүртгэл	×	×
Төрийн хяналт шалгалт	×	×
Тендер	×	×
Татвар	Баруун 1.4	•
	Хангай 0.2	
	Төв 0.4	
	Зүүн 1.3	
Нийгмийн даатгал	×	×
Иргэний бүртгэл	×	×
Бусад маргаан	×	×

Хүснэгт 2.15. Аймгийн захиргааны хэргийн шүүхэд шийдвэрлэсэн хэргийн маргааны төрлийн өгөгдөлд хийсэн дисперсийн шинжилгээний үр дүн

Үүнд: • - нөлөөлөлтэй, × - нөлөөлөлгүй, — - тооцоо хийгдэхгүй

Хүснэгт 2.15-д үзүүлсэн захиргааны хэргийн маргааны төрлийн газрын маргааны өгөгдөлд хийсэн шинжилгээний үр дүнг тайлбарлая.

Бүсийн нөлөөг тайлбарлавал: АЗХАШШ-н хувьд дунджаар нэг шүүгчид ногдох газрын маргааныг шийдвэрлэсэн хэргийн тоогоор баруун бүс хамгийн их буюу 10 хэрэг, хангайн бүс хамгийн бага буюу 4 хэргийг нэг шүүгч жилд шийдвэрлэсэн байна. Харин төвийн бүсийн захиргааны хэргийн нэг шүүгч 7 хэргийг, зүүн бүсийн захиргааны хэргийн нэг шүүгч жилд 5 газрын маргааны хэргийг тус тус шийдвэрлэжээ.

Динамикийн нөлөөлөлгүй байсан гэдэг нь хууль эрх зүйн ямар нэгэн өөрчлөлт, Ковид 19-н нөлөөлөлд энэ газрын маргааны үзүүлэлт өртөөгүй байна гэсэн үг юм. Үүнээс гадна ямар нэгэн өсөлт бууралтын хандлага байхгүй тул захиргааны хэргийн газрын маргааны

шийдвэрлэсэн хэргийн тоо өөрчлөлтгүй, тогтмол гэсэн утгыг мөн илтгэнэ. Гэх мэтчилэн захиргааны хэргийн бусад маргааны төрлийн шийдвэрлэсэн хэрэгт хийсэн шинжилгээний үр дүнг дээр өгсөн тайлбартай адил утгаар ойлгоно.

Захиргааны хэргийн нэхэмжлэгч, хариуцагчийн тоо 3-р бүлгийн гол хэсгийн шинжилгээний бүрэлдэхүүн хэсгийн загварт тус тусдаа хувьсагч хэлбэрээр орох тул ерөнхий тохиолдолд бүсийн болон динамикийн нөлөөг тодорхойлох зорилгоор мөн 2 хүчин зүйлийн дисперсийн шинжилгээ явуулав.

Нэхэмжлэгч, хариуцагч		Бүс	Динамик
Нэхэмжлэгч	Иргэн	Баруун 13.23	×
		Хангай 13.13	
		Төв 38.8	
		Зүүн 21.9	
	Хуулийн этгээд	×	×
Захиргааны байгууллага, албан тушаалтан		×	×
Бусад		×	×
Хариуцагч	Төрийн гүйцэдгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг байгууллага, албан тушаалтан	Баруун 27.69	×
		Хангай 23.27	
		Төв 42.16	
		Зүүн 30.80	
	Нутгийн өөрөө удирдах байгууллага болон шийдвэр, үйл ажиллагаанд нь гомдол гаргахаар заасан байгууллага	Баруун 3.29	•
		Хангай 3.93	
		Төв 7.16	
		Зүүн 3.43	
	Нэг шүүхийн эрх зүйн субъект болох бусад байгууллага, албан тушаалтан	баруун 1.14	×
		хангай 0.40	
төв 2.64			
зүүн 0.90			

Хүснэгт 2.16. Аймгийн захиргааны хэргийн анхан шатны шүүхэд шийдвэрлэсэн хэргийн нэхэмжлэгч, хариуцагчийн тоонд хийсэн дисперсийн шинжилгээний үр дүн

Үүнд: • - нөлөөлөлтэй, × - нөлөөлөлгүй, — - тооцоо хийгдэхгүй

Хүснэгт 2.16-д үзүүлсэн захиргааны хэргийн нэхэмжлэгчийн тоонд хийсэн шинжилгээний үр дүнг тайлбарлая.

Бүсийн нөлөөг тайлбарлавал: АЗХАШШ-н хувьд дунджаар нэг шүүгчид ногдох захиргааны хэрэгт хамаарах шийдвэрлэсэн хэргийн нэхэмжлэгч иргэний тооны хувьд төвийн бүс хамгийн их буюу 39 нэхэмжлэгч иргэний, хангайн ба баруун бүс хамгийн бага буюу 13 нэхэмжлэгч иргэний хэргийг нэг шүүгч жилд шийдвэрлэсэн байна. Харин зүүн бүсийн захиргааны хэргийн нэг шүүгч 22 нэхэмжлэгч иргэнд хамаарах хэргийг тус тус шийдвэрлэжээ.

Динамикийн нөлөөлөлгүй байсан гэдэг нь хууль эрх зүйн ямар нэгэн өөрчлөлт, Ковид-19-н нөлөөлөлд нэхэмжлэгч иргэний тоон үзүүлэлт өртөөгүй байна гэсэн үг юм. Үүнээс гадна ямар нэгэн өсөлт бууралтын хандлага байхгүй тул шийдвэрлэсэн захиргааны хэргийн нэхэмжлэгч иргэний тоо өөрчлөлтгүй, тогтмол гэсэн утгыг мөн илтгэнэ. Гэх мэтчилэн захиргааны хэрэгт хамаарах бусад нэхэмжлэгч, хариуцагчийн шинжилгээний үр дүнг дээр өгсөн тайлбартай адил утгаар ойлгоно.

2.1.3. Суман дахь сум дундын шүүхэд шүүн таслах ажиллагааны тодорхой төрлөөр шийдвэрлэсэн хэргийн тооны өгөгдөлд хийсэн шинжилгээ

Сум дундын шүүхэд ажиллаж байгаа шүүгч нь хүснэгтэд харуулсан 3 өөр төрлийн хэргийг хянан шийдвэрлэх ажлыг хийж байна. Эдгээр хэргийн төрөл тус бүрд 2 хүчин зүйлийн дисперсийн шинжилгээг хийж, үр дүнг дараах хүснэгтээр харуулав.

Хэргийн төрөл	Анхан	
	Бүс	Динамик
Иргэн	Хангай 151.1	•
	Зүүн 76.7	
Эрүү	Төв 35.3	×
	Баруун 21.7	
Зөрчил	Хангай 137.6	•
	Зүүн 43.4	

Хүснэгт 2.17. Сум дундын шүүхийн нэг шүүгчид ногдох шийдвэрлэсэн хэргийн тоонд хийсэн дисперсийн шинжилгээний үр дүн

Үүнд: • - нөлөөлөлтэй, × - нөлөөлөлгүй, — - тооцоо хийгдэхгүй

Хүснэгт 2.17-д үзүүлсэн сум дундын шүүхийн нэг шүүгчийн шийдвэрлэсэн иргэний хэргийн тоонд хийсэн шинжилгээний үр дүнг тайлбарлая.

Бүсийн нөлөөг тайлбарлавал: Сум дундын нэг шүүгчийн шийдвэрлэсэн иргэний хэргийн тооны хувьд хангайн бүсийн шүүгч хамгийн их буюу 151 хэргийг, зүүн бүсийн шүүгч хамгийн бага буюу 77 хэргийг жилд шийдвэрлэсэн байна.

Динамикийн нөлөөлөлтэй байна гэдэг нь сум дундын нэг шүүгчийн шийдвэрлэсэн иргэний хэргийн тоонд хууль эрх зүйн ямар нэгэн өөрчлөлт эсвэл Ковид-19-н нөлөөлөл орсон гэсэн үг юм. Үүнээс гадна ямар нэгэн өсөлт бууралтын хандлага байгаа тул шийдвэрлэсэн иргэний хэргийн тоо динамикийн хувьд ялгаатай гэсэн утгыг мөн илтгэнэ. Энэ мэтчилэн нэг шүүгчийн шийдвэрлэсэн эрүүгийн болон зөрчлийн хэргийн шинжилгээний үр дүнг дээр өгсөн тайлбартай адил утгаар ойлгоно.

Сум дундын шүүхийн нэг шүүгчид ногдох шийдвэрлэсэн хэргийн өгөгдөлд 2 хүчин зүйлийн дисперсийн шинжилгээ хийсэн үр дүнг бүс болон динамикийн нөлөөллөөр дараах хүснэгтэд харуулав.

Бүс	Иргэн	Эрүү	Зөрчил	Динамик	Иргэн	Эрүү	Зөрчил
				2017	81.1	28.4	-
Төв	82.1	35.3	43.5	2018	100.2	30.04	46.8
Зүүн	76.7	22.07	43.4	2019	90.4	34.4	57.6
Баруун	111.2	21.7	61.8	2020	128.5	30.3	67.01
Хангай	151.2	31.7	137.6	2021	86.4	25.7	67.6
Дундаж	105.3	27.7	71.5	Дундаж	97.3	29.7	59.8

Хүснэгт 2.18. Сум дахь СДШ, бүсээр

Хүснэгт 2.19. Динамикаар

Бүсийн хувьд: Нэг шүүгчид оногдох хянан шийдвэрлэсэн хэргийн дүнг харвал иргэний хэрэг дээр хангай болон баруун бүсийн сум дундын шүүгч хамгийн их ачаалалтай ажилласан байна. Харин зүүн бүсийн сум дундын шүүгч хамгийн бага буюу 77 хэрэг шийдвэрлэсэн байна. Бусад хянан шийдвэрлэсэн хэргийн тухайд дээр өгсөн тайлбартай адил утгаар ойлгоно.

Динамикийн хувьд: Сум дундын нэг шүүгчийн хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн хувьд 2020 онд хамгийн их буюу 129 хэрэг, 2017 онд хамгийн бага буюу 81 хэргийг тус тус

шийдвэрлэжээ. 2021 онд нэг шүүгчийн хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн тоо 86 байсан нь Ковид-19-н нөлөөлөл байсан гэсэн үг юм. Бусад хянан шийдвэрлэсэн хэргийн тухайд энд өгсөн тайлбартай адил утгаар ойлгоно.

Сум дундын шүүхийн хянан шийдвэрлэсэн нэг шүүх хэргийн хувьд хэргийн төрөл доторх эрүүгийн хуулийн бүлэг, маргааны төрөл тус бүрд мөн 2 хүчин зүйлийн дисперсийн шинжилгээ хийсэн. Шинжилгээнд 1-р хүчин зүйлээр бүс, 2-р хүчин зүйлээр динамикийн үзүүлэлт (2017-2021 он)-г авсан. Шинжилгээний үр дүнг дараах хүснэгтээр харуулъя.

• **Эрүүгийн хэрэг**

Эрүүгийн хуулийн бүлгээр	Шийдвэрлэсэн хэрэг		Үлдэгдэл хэрэг	
	Бүс	Динамик	Бүс	Динамик
Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг (10-р бүлэг)	×	×	×	×
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг (11-р бүлэг)	Баруун 24.5	×	×	×
	Хангай 39.5			
	Төв 53.18			
	Зүүн 35.25			
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг (12-р бүлэг)	Баруун 1.5	×	×	×
	Хангай 3			
	Төв 6			
	Зүүн 3.5			
Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг (13-р бүлэг)	×	×	×	×
Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг (14-р бүлэг)	×	×	×	×
Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг (15-р бүлэг)	×	×	×	×
Хүүхдийн эсрэг гэмт хэрэг (16-р бүлэг)	×	×	—	—
Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг (17-р бүлэг)	Баруун 12.62	×	Баруун 0.62	×
	Хангай 25.5		Хангай 3.75	
	Төв 26.62		Төв 1.62	
	Зүүн 20		Зүүн 2.25	
Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг (18-р бүлэг)	Баруун 0.15	×	×	×
	Хангай 0.33			
	Төв 0.89			
	Зүүн 1.58			
Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг (19-р бүлэг)	×	×	×	×
Олон нэг шүүхийн аюулгүй байдал ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг (20-р бүлэг)	×	×	—	×
Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг (21-р бүлэг)	Баруун 0.95	×	×	×
	Хангай 2			
	Төв 1.03			
	Зүүн 0.17			
Авилгын эсрэг гэмт хэрэг (22-р бүлэг)	Баруун 2.65	×	×	×
	Хангай 1.62			
	Төв 1.21			
	Зүүн 1.08			
Нэг шүүхийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг (23-р бүлэг)	Баруун 2.65	×	×	×
	Хангай 2.41			
	Төв 2.82			

	Зүүн 1.91			
Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг (24-р бүлэг)	Баруун 9.3	—	—	×
	Хангай 21.16			
	Төв 9.21			
	Зүүн 10.75			
Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг (25-р бүлэг)	×	×	×	×
Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг (26-р бүлэг)	×	×	—	—
Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг (27-р бүлэг)	Баруун 13.15	×	Баруун 0.62	×
	Хангай 24.08		Хангай 0	
	Төв 24.39		Төв 1.5	
	Зүүн 27.25		Зүүн 0	
Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг (28-р бүлэг)	×	×	×	×
Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг (29-р бүлэг)	×	×	×	×

Хүснэгт 2.20. Сум дахь сум дундын шүүхэд шийдвэрлэсэн болон үлдэгдэл эрүүгийн хэргийн тооны төрөлд хийсэн дисперсийн шинжилгээний үр дүн

Үүнд: ● - нөлөөлөлтэй, × - нөлөөлөлгүй, — - тооцоо хийгдэхгүй

Хүснэгт 2.20-д үзүүлсэн эрүүгийн хуулийн 10 дугаар бүлэг буюу хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэргийн хянан шийдвэрлэсэн хэргийн тооны өгөгдөлд хийсэн шинжилгээний үр дүнг жишээ болгож тайлбарлая.

Бүсийн нөлөөг тайлбарлавал: Сум дундын нэг шүүгчид ногдох хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэргийн хянан шийдвэрлэсэн хэргийн тооны хувьд бүх бүсийн шүүхийн шүүгчид ижил тоотой хэрэг шийдвэрлэсэн гэсэн үг юм.

Динамикийн нөлөөлөлгүй байсан гэдэг нь хууль эрх зүйн ямар нэгэн өөрчлөлт, Ковид 19-н нөлөөлөлд энэ бүлгийн үзүүлэлт өртөөгүй байна гэсэн үг юм. Үүнээс гадна ямар нэгэн өсөлт бууралтын хандлага байхгүй тул 10-р бүлгийн хэргийн тоо өөрчлөлтгүй, тогтмол гэсэн утгыг мөн илтгэнэ. Энэ мэтчилэн эрүүгийн хуулийн бусад бүлгийн шинжилгээний үр дүнг энд өгсөн тайлбартай адил утгаар ойлгоно.

Эрүүгийн хэргийн тайлан мэдээллийн маягтын үндсэн үзүүлэлт болох шийдвэрлэсэн хэрэгт хамаарах хүний тоо, үлдэгдэл хэрэгт хамаарах хүний тоон (11-р шалгуур)-ий мэдээлэлд хийсэн 2 хүчин зүйлийн дисперсийн шинжилгээний үр дүнг хүснэгтээр харуулъя. Шинжилгээнд 1-р хүчин зүйлээр бүс, 2-р хүчин зүйлээр динамикийн үзүүлэлт (2017-2021 он)-г авсан.

Эрүүгийн хуулийн бүлгээр	Шийдвэрлэсэн хэрэг		Үлдэгдэл хэрэг	
	Бүс	Динамик	Бүс	Динамик
Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг (10-р бүлэг)	×	×	×	×
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг (11-р бүлэг)	Баруун 26.12	×	×	×
	Хангай 43.5			
	Төв 60.93			
	Зүүн 37.25			
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг (12-р бүлэг)	Баруун 1.5	×	×	×
	Хангай 3.25			
	Төв 7.75			
	Зүүн 3.75			
Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг (13-р бүлэг)	×	●	×	×

Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг (14-р бүлэг)	×	×	×	×
Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг (15-р бүлэг)	×	×	×	×
Хүүхдийн эсрэг гэмт хэрэг (16-р бүлэг)	×	×	—	—
Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг (17-р бүлэг)	×	×	×	×
Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг (18-р бүлэг)	×	×	×	×
Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг (19-р бүлэг)	○	×	×	×
Олон нэг шүүхийн аюулгүй байдал ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг (20-р бүлэг)	×	×	—	×
Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг (21-р бүлэг)	×	×	×	×
Авилгын эсрэг гэмт хэрэг (22-р бүлэг)	×	×	×	×
Нэг шүүхийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг (23-р бүлэг)	×	×	×	×
Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг (24-р бүлэг)	Баруун 25.6 Хангай 22.5 Төв 7.7 Зүүн 0.0	×	—	×
Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг (25-р бүлэг)	×	×	×	×
Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг (26-р бүлэг)	×	×	—	—
Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг (27-р бүлэг)	Баруун 7.5 Хангай 7.5 Төв 16.5 Зүүн 1	×	Баруун 0.6 Хангай 0 Төв 1.7 Зүүн 0.0	×
Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг (28-р бүлэг)	×	×	×	×
Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг (29-р бүлэг)	×	×	×	×

Хүснэгт 2.21. Сум дахь сум дундын шүүхийн шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн хүний төрөлд хийсэн дисперсийн шинжилгээний үр дүн

Үүнд: ● - нөлөөлөлтэй, × - нөлөөлөлгүй, — - тооцоо хийгдэхгүй

Хүснэгт 2.21-д үзүүлсэн эрүүгийн хуулийн 10 дугаар бүлэг буюу хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэргийн шийдвэрлэсэн хэрэгт хамаарах хүний тоон өгөгдөлд хийсэн шинжилгээний үр дүнг жишээ болгож тайлбарлая.

Бүсийн нөлөөг тайлбарлавал: Сум дундын шүүхийн хувьд дунджаар нэг шүүгчид ногдох шийдвэрлэсэн хэрэгт хамаарах хүний тооны хувьд бүх бүсийн шүүхийн шүүгчид ижил тоотой хэрэг шийдвэрлэсэн байна.

Динамикийн нөлөөг тайлбарлавал: Хянан шийдвэрлэсэн хэргийн хүний тооны хувьд динамикийн нөлөөлөлгүй байсан гэдэг нь хууль эрх зүйн ямар нэгэн өөрчлөлт, Ковид-19-н нөлөөлөлд энэ бүлгийн үзүүлэлт өртөөгүй байна гэсэн үг юм. Үүнээс гадна ямар нэгэн өсөлт бууралтын хандлага байхгүй тул 10-р бүлгийн хэргийн хүний тоо өөрчлөлтгүй, тогтмол гэсэн утгыг мөн илтгэнэ. Гэх мэтчилэн эрүүгийн хуулийн бусад бүлгийн хэрэгт хамаарах

хүний тоон өгөгдөлд хийсэн шинжилгээний үр дүнг энд өгсөн тайлбартай адил утгаар ойлгоно.

• **Иргэний хэрэг**

Иргэний хэргийн тайлан мэдээллийн маягтад маргааны төрлөөр батлагдсан, албан ёсны үзүүлэлтээс Монгол Улсын шүүхийн тайланд маргааны төрөл болон нэг шүүхэд тархаагддаг дараах үзүүлэлтийн хүрээнд 2 хүчин зүйлийн дисперсийн шинжилгээг хийсэн. Шинжилгээний үр дүнг дараах хүснэгтээр харуулья.

Маргааны төрөл	Бүс	Динамик
Иргэний хуулиар	Баруун 61.6	×
	Хангай 107.0	
	Төв 152.2	
	Зүүн 110.6	
Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуулиар	Баруун 242.0	•
	Хангай 307.0	
	Төв 95.6	
	Зүүн 64.0	
Гэр бүлийн тухай хуулиар	Баруун 13.7	×
	Хангай 34.4	
	Төв 38.7	
	Зүүн 26.2	
Хөдөлмөрийн тухай хуулиар	Баруун 8.7	×
	Хангай 5.8	
	Төв 3.35	
	Зүүн 5.2	
Газрын тухай хуулиар	Баруун 1.6	×
	Хангай 0.8	
	Төв 0.6	
	Зүүн 1.8	
Дампуурлын тухай хуулиар	×	×
Компанийн тухай хуулиар	×	×
Нийгмийн даатгалын багц хуулиар	×	×
Шүүхийн шийдвэр гүйцэдгэх тухай хуулиар	×	×
Татварын ерөнхий хуулиар	×	×
Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн тухай хуулиар	×	×
Төрийн албаны тухай хуулиар	×	×
Цагаатгалын нөхөн олговор	×	•
Бусад хуулиар	×	×

Хүснэгт 2.22. Сум дундын шүүхэд шийдвэрлэсэн иргэний хэргийн маргааны төрлийн тоонд хийсэн дисперсийн шинжилгээний үр дүн

Үүнд: • - нөлөөлөлтэй, × - нөлөөлөлгүй, — - тооцоо хийгдэхгүй

Хүснэгт 2.22-д үзүүлсэн маргааны төрлийн иргэний хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоон өгөгдөлд хийсэн шинжилгээний үр дүнг жишээ болгож тайлбарлая.

Бүсийн нөлөөг тайлбарлавал: Сум дундын нэг шүүгчид ногдох иргэний хуулиар шийдвэрлэсэн хэргийн хувьд төвийн бүсийн сум дундын шүүхэд хамгийн их буюу 152 хэрэг, баруун бүсийн сум дундын шүүхэд хамгийн бага буюу 62 хэргийг нэг шүүгч жилд шийдвэрлэсэн байна.

Динамикийн нөлөөлөлгүй байсан гэдэг нь хууль эрх зүйн ямар нэгэн өөрчлөлт, Ковид-19-н нөлөөлөлд энэ бүлгийн үзүүлэлт өртөөгүй байжээ гэсэн үг юм. Үүнээс гадна ямар нэгэн өсөлт бууралтын хандлага байхгүй тул иргэний хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо өөрчлөлтгүй, тогтмол гэсэн утгыг мөн илтгэнэ. Гэх мэтчилэн иргэний хэргийн маргааны төрлийн бусад хуулийн хувьд хийсэн шинжилгээний үр дүнг дээр өгсөн тайлбартай адил утгаар ойлгоно.

Иргэний хэргийн хариуцагчийн тоо 3-р бүлгийн гол хэсгийн шинжилгээний бүрэлдэхүүн хэсгийн загварт хувьсагч хэлбэрээр орох тул ерөнхий тохиолдолд бүсийн болон динамикийн нөлөөг тодорхойлох зорилгоор мөн 2 хүчин зүйлийн дисперсийн шинжилгээ явуулав.

Хариуцагч	Бүс	Динамик
Иргэн	Баруун 82.7	×
	Хангай 150.4	
	Төв 209.95	
	Зүүн 150.2	
Хуулийн этгээд	×	×

Хүснэгт 2.23. Сум дундын шүүхийн иргэний хэргийн хариуцагчийн тоонд хийсэн дисперсийн шинжилгээний үр дүн

Үүнд: • - нөлөөлөлтэй, ×- нөлөөлөлгүй, – - тооцоо хийгдэхгүй

Хүснэгт 2.23-д үзүүлсэн иргэний хэргийн хариуцагчийн тоонд хийсэн шинжилгээний үр дүнг тайлбарлая.

Бүсийн нөлөөг тайлбарлавал: Сум дундын шүүхэд хянан шийдвэрлэсэн иргэний хэрэгт хамаарах иргэний хувьд төвийн бүсийн сум дундын шүүхийн нэг шүүгч хамгийн их буюу 210 иргэнтэй холбоотой хэрэг, баруун бүсийн сум дундын шүүхийн нэг шүүгч хамгийн бага буюу 83 иргэнтэй холбоотой хэргийг нэг жилд шийдвэрлэсэн байна. Харин хангайн ба зүүн бүсийн сум дундын шүүхийн нэг шүүгч 150 хэрэгт хамаарах иргэний хэргийг тус тус шийдвэрлэжээ.

Динамикийн нөлөөлөлгүй байсан гэдэг нь хууль эрх зүйн ямар нэгэн өөрчлөлт, Ковид-19-н нөлөөлөлд энэ бүлгийн үзүүлэлт өртөөгүй байжээ гэсэн үг юм. Үүнээс гадна ямар нэгэн өсөлт бууралтын хандлага байхгүй тул иргэний хэрэгт хамаарах иргэний тоо өөрчлөлтгүй, тогтмол гэсэн утгыг мөн илтгэнэ. Гэх мэтчилэн иргэний хэргийн хуулийн этгээдийн тооны тухай үр дүнг энд өгсөн тайлбартай адил утгаар ойлгоно.

2.1.4. Давж заалдах шатны шүүхэд шүүн таслах ажиллагааны тодорхой төрлөөр шийдвэрлэсэн хэргийн тооны өгөгдөлд хийсэн шинжилгээ

- **Нийслэл**

Нийслэлийн хэмжээнд нэг шүүх байгаа тул энэ шүүхийн хувьд дисперсийн шинжилгээ хийгдэхгүй, нэгдсэн үр дүнг хүснэгт 2.1-оос харна уу.

- **Аймаг**

Бүс	Иргэн	Эрүү	Захиргаа	Зөрчил
Төв	11.3	16.9	17.4	3.31
Зүүн	9.4	12.8	14.6	3.48
Баруун	17.6	10.7	31.6	4.42
Хангай	10.3	17.8	16.0	4.28
Дундаж	12.2	14.6	19.9	3.8

Динамик	Иргэн	Эрүү	Захиргаа	Зөрчил
2017	13.5	6.4	22.1	-
2018	13.1	15.5	19.6	2.2
2019	10.6	14.9	19.57	2.7
2020	13.4	19.3	18.1	4.4
2021	11.4	18.4	20.7	5.9
Дундаж	12.4	14.9	20.0	3.8

Хүснэгт 2.24. Аймаг дахь ДЗШШ, бүсээр

Хүснэгт 2.25. Динамикаар

Аймаг дахь давж заалдах шатны шүүхийн шинжилгээний үр дүнг тайлбарлая.

Бүсийн нөлөөллийн хувьд: Нэг шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн дүнг харвал баруун бүсийн иргэний хэрэг дээр ажилласан шүүгч хамгийн их буюу 18 хэргийг, зүүн бүсийн иргэний хэрэг дээр ажилласан шүүгч хамгийн бага буюу 9 хэргийг тус тус шийдвэрлэжээ. Бусад хэргийн тухайн энд өгсөн тайлбартай адил утгаар ойлгоно.

Динамикийн нөлөөллийн хувьд: АДЗШШ-н шүүгч 2017, 2020 онд иргэний хэрэг дээр хамгийн их буюу 13-14 хэрэг хянан шийдвэрлэсэн байна. 2021 онд хамгийн бага буюу 11 хэрэг хянан шийдвэрлэсэн байна. Энэ нь Ковид-19-н нөлөөлөл байсан гэсэн үг юм. Бусад хянан шийдвэрлэсэн хэргийн тухайд энд өгсөн тайлбартай адил утгаар ойлгоно.

2.2. ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ХЭРГИЙН ТООНЫ ӨГӨГДӨЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ, КЛАСТЕРААР

ШЕЗ-с гаргаж өгсөн өгөгдлийг дундаж утгаар илэрхийлвэл 5 жилийн динамикийн өгөгдлийн онцлогийг нуугдмал хэлбэрт оруулах магадлалтай тул кластерийн шинжилгээг дараагийн шинжилгээний аргаар сонгосон. Кластерийн шинжилгээний онолтой 1-р бүлгээс товч танилцана уу. Бид 2 хүчин зүйлийн кластерийн шинжилгээ хийсэн бөгөөд 1-р хүчин зүйлээр 2017-2021 он, 2-р хүчин зүйлээр нэг шүүгчийн 1 жилд шийдвэрлэсэн хэргийн тоо (тухайн шүүхэд шийдвэрлэсэн нэг шүүх хэргийн тоог тухайн шүүхэд ажилласан шүүгчийн тоонд хуваах)-г сонгож авсан. Нөгөө талаас кластерийн шинжилгээний үр дүн (нэг шүүгчийн 1 жилд шийдвэрлэсэн хэргийн тоог)-г дахин задалж тухайн шүүхэд шийдвэрлэсэн нэг шүүх хэргийн тоо, тухайн шүүхэд ажилласан шүүгчийн тоогоор мөн ижил хэв шинжтэй байж чадах эсэхийг Хотелингийн шинжүүрийг ашиглан шалгасан. Энэ нь шүүхүүдийг тухайн шүүхэд хянан шийдвэрлэсэн нэг шүүх хэргийн тоо (1-р шинж), тухайн шүүхэд ажилласан шүүгчийн тоо (2-р шинж), тухайн шүүхийн нэг шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн ачаалал (3-р шинж) гэсэн шинжүүдээр ижил хэв шинжтэй шүүхүүдийг бүлэглэж чадах процесс гэж судалгааны баг үзсэн.

Мөн 2 хүчин зүйлийн дисперсийн шинжилгээний дээрх үр дүнгүүдээс харвал бүсүүд тухайн хэргийн төрөл, анхан болон давж заалдах шатны шүүхүүд дээр ялгаатай үр дүнг харуулж байгаа нь тухайн бүс дотор багтсан аймаг (дүүрэг)-н шүүхүүд өөр өөрийн өвөрмөц онцлогтой гэдгийг илтгэж байна. Иймд тухайн бүс дотор хамгийн их нөлөөтэй үзүүлэлт бүхий аймаг (дүүрэг) эсвэл нөлөөгүй шахам үзүүлэлттэй аймаг (дүүрэг)-г тодорхойлж адил төсөөтэй шинжээр нь бүлэглэх зорилгоор бүс (дүүрэг)-н бүрэлдэхүүнд багтсан шүүхүүдийг задалж, нэг шүүгчид ногдох хянан шийдвэрлэсэн хэргийн тоогоор кластерийн шинжилгээ явуулсан. Кластерийн шинжилгээг явуулснаар бүсийн тоог бодвол харьцангуй олон бүлэгт аймгууд хуваагдана. Кластерийн шинжилгээ явуулсан үр дүнг доорх дэд бүлгүүдэд харуулья.

2.2.1. Анхан шатны шүүх

Нийслэлийн 9 шүүхийн хувьд төвийн дүүргийн 6 шүүх ба захын дүүргийн 3 шүүхийн өгөгдлийг салгаж кластерийн шинжилгээ хийв. Учир нь төвийн болон захын дүүргийн шүүхийн үйл ажиллагаа эрс тэрс өөр хэв шинжтэй тул тус тусад нь салгаж кластерийн шинжилгээг явуулвал зөв үр дүнг өгнө. ДЭХАШШ-н нэг шүүгчийн 1 жилд шийдвэрлэсэн хэргийн тоогоор кластерийн шинжилгээ явуулахад Чингэлтэй, Сүхбаатар, Баянгол, Сонгинохайрхан дүүргүүд нэг шүүгчийн 1 жилд шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоогоор ижил хэв шинжтэй, Баянзүрх, Хан-Уул дүүргүүд нэг шүүгчийн 1 жилд шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоогоор өөрийн гэсэн онцлог хэв шинжтэй гэсэн ангилалд оров. Кластерийн шинжилгээний үр дүнг Хотелингийн шинжүүрээр шалгаж баталгаажуулсны дараа 3 ба 4-р бүлэгт кластерт багтсан нэгжүүдийн тухай итгэлтэй ярих нөхцөл бүрдэнэ. Учир нь Хотелингийн шинжүүрээр шалгасан кластерийн шинжилгээний үр дүн 4-р бүлгийн шаардлагатай шүүгчийн тоог тодорхойлох тэнцэтгэл бишийн системд бүлэг бүлгээрээ тусдаа зааглалтын нөхцөлийг бүрдүүлэх юм. Хотелингийн шинжүүрийн онолын ойлголттой 1-р бүлгээс товч танилцана уу.

А. Дүүргийн шүүх

№	Кластерын бүрэлдэхүүн	Дундаж		Таамаглал $H_0: \mu'_i = [\mu_{i1}, \mu_{i2}]$	Шинжүүр		Дүгнэлт $H_0: T_i^2 < T_{\text{онол}}^2$
		$\bar{x}_i = [\bar{x}_{i1} \quad \bar{x}_{i2}]$			T_i^2	$T_{\text{онол}}^2$	
1	Чингэлтэй, Сүхбаатар, Баянгол, Сонгинохайрхан	$\bar{x}_1 = [937.3 \quad 8.1]$		$H_0: \mu'_1 = [940, 8]$	12.2	57.	$H_0: T_1^2 < T_{\text{онол}}^2$
2	Баянзүрх, Хан-Уул	$\begin{pmatrix} 1594. & 9.6 \\ 681 & 6 \end{pmatrix}$		–	–	–	–
3	Багануур, Налайх, Багахангай	$\begin{pmatrix} 123. & 3.3 \\ 178.4 & 2.7 \\ 10.2 & 0.6 \end{pmatrix}$		–	–	–	–

Хүснэгт 2.26. ДЭХАШШ-н шүүхэд шийдвэрлэсэн 1 шүүгчид ногдох эрүүгийн хэргийн тоонд хийсэн Хотелингийн шинжүүрийн үр дүн


Дундаж: 1-р кластерт орсон дүүргүүдийн (Чингэлтэй, Сүхбаатар, Баянгол, Сонгинохайрхан) эрүүгийн хэргийн шүүхэд дунджаар 8 шүүгч ажилласан бөгөөд нэг шүүх 937 хэрэг хянан шийдвэрлэсэн байна.

Таамаглал: 1-р кластерт орсон эдгээр дүүргүүдийн (Чингэлтэй, Сүхбаатар, Баянгол, Сонгинохайрхан) эрүүгийн хэргийн шүүхэд дунджаар 8 орчим шүүгч ажиллаж нэг шүүх 940 хэрэг хянан шийдвэрлэсэн гэдэг үнэн үү?


Шинжүүр: Таамаглалыг шалгах тооцооллын ба онолын коэффициентийн утга

Дүгнэлт: Таамаглал зөв тул 1-р кластерт орсон дүүргүүд (Чингэлтэй, Сүхбаатар, Баянгол, Сонгинохайрхан) 3-н шинж (тухайн шүүхэд хянан шийдвэрлэсэн нэг шүүх хэргийн тоо, тухайн шүүхэд ажилласан шүүгчийн тоо, тухайн шүүхийн нэг шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн ачаалал)-ээрээ ижил байсан байна.

Гэх мэт бусад кластерийн тайлбарын энд өгсөн тайлбартай ижил утгаар ойлгоно. Гэхдээ 2 ба 3-р кластерийн бүлгүүд бүгд ялгаатай өөрийн онцлогтой ДЭХАШШ гэсэн утгаар тус тусад нь тайлбарлана.



Зураг 2.1. ДЭХАШШ-д шийдвэрлэсэн 1 шүүгчид ногдох эрүүгийн хэргийн тоогоор ижил кластерт багтсан шүүхүүд



Зураг 2.2. ДЭХАШШ-д шийдвэрлэсэн 1 шүүгчид ногдох зөрчлийн хэргийн тоогоор ижил кластерт багтсан шүүхүүд

№	Кластерын бүрэлдэхүүн	Дундаж $\bar{x}_i = [\bar{x}_{i1} \ \bar{x}_{i2}]$	Таамаглал $H_0: \mu'_i = [\mu_{i1}, \mu_{i2}]$	Шинжүүр		Дүгнэлт $H_0: T_i^2 < T_{\text{онол}}^2$
				T_i^2	$T_{\text{онол}}^2$	
1	Чингэлтэй, Сүхбаатар Баянгол, Сонгинохайрхан, Хан-Уул	$\bar{x}_2 = [1152 \ 1]$	$H_0: \mu'_1 = [1200, 1]$	6.67	57.	$H_0: T_2^2 < T_{\text{онол}}^2$
2	Баянзүрх	(2607 1)	—	—	—	—
3	Багануур, Налайх, Багахангай	$\begin{pmatrix} 241. & 3.3 \\ 155 & 2.7 \\ 23.2 & 0.6 \end{pmatrix}$	—	—	—	—

Хүснэгт 2.27. ДЭХАШШ-н шүүхэд шийдвэрлэсэн 1 шүүгчид ногдох зөрчлийн хэргийн тоонд хийсэн Хотелингийн шинжүүрийн үр дүн


Дундаж: 1-р кластерт орсон дүүргүүдийн (Чингэлтэй, Сүхбаатар, Баянгол, Сонгинохайрхан, Хан-Уул) эрүүгийн хэргийн шүүхэд зөрчлийн хэргийн 1 шүүгч ажилласан бөгөөд нэг шүүх 1152 хэрэг хянан шийдвэрлэсэн байна.

Таамаглал: 1-р кластерт орсон эдгээр дүүргүүдийн (Чингэлтэй, Сүхбаатар, Баянгол, Сонгинохайрхан, Хан-Уул) эрүүгийн хэргийн шүүхэд зөрчлийн хэргийн 1 шүүгч ажиллаж нэг шүүх 1200 орчим хэрэг хянан шийдвэрлэсэн гэдэг үнэн үү?


Шинжүүр: Таамаглалыг шалгах тооцооллын ба онолын коэффициентийн утга

Дүгнэлт: Таамаглал зөв тул 1-р кластерт орсон дүүргүүд (Чингэлтэй, Сүхбаатар, Баянгол, Сонгинохайрхан, Хан-Уул) 3-н шинж (тухайн шүүхэд хянан шийдвэрлэсэн нэг шүүх хэргийн тоо, тухайн шүүхэд ажилласан шүүгчийн тоо, тухайн шүүхийн нэг шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн ачаалал)-ээрээ ижил байсан байна.

Гэх мэт бусад кластерийн тайлбарын энд өгсөн тайлбартай ижил утгаар ойлгоно. Гэхдээ 2 ба 3-р кластерийн бүлгүүд бүгд ялгаатай өөрийн онцлогтой ДЭХАШШ гэсэн утгаар тайлбарлагдана.



Зураг 2.3. ДЭХАШШ-д шийдвэрлэсэн 1 шүүгчид ногдох зөрчлийн хэргийн тоогоор ижил кластерт багтсан шүүхүүд



Зураг 2.4. ДЭХАШШ-д шийдвэрлэсэн 1 шүүгчид ногдох зөрчлийн хэргийн тоогоор ялгаатай кластерт багтсан шүүхүүд

№	Кластерын бүрэлдэхүүн	Дундаж $\bar{x}_i = [\bar{x}_{i1} \quad \bar{x}_{i2}]$	Таамаглал $H_0: \mu'_i = [\mu_{i1}, \mu_{i2}]$	Шинжүүр		Дүгнэлт $H_0: T_i^2 < T_{\text{онол}}^2$
				T_i^2	$T_{\text{онол}}^2$	
1	Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул	$\bar{x}_1 = [3916.3 \quad 11.5]$	$H_0: \mu'_1 = [3950, 12]$	1.05	57.	$H_0: T_1^2 < T_{\text{онол}}^2$
2	Баянзүрх, Чингэлтэй, Баянгол,	$\bar{x}_2 = [4432 \quad 14.2]$	$H_0: \mu'_2 = [4450, 14]$	35.5	57.	$H_0: T_2^2 < T_{\text{онол}}^2$
3	Багануур, Налайх, Багахангай	$\begin{pmatrix} 540.4 & 3.4 \\ 539. & 3.1 \\ 32. & 0.6 \end{pmatrix}$	—	—	—	—

Хүснэгт 2.28. ДЭХАШШ-н шүүхэд шийдвэрлэсэн 1 шүүгчид ногдох иргэний хэргийн тоонд хийсэн Хотелингийн шинжүүрийн үр дүн


Дундаж: 1-р кластерт орсон дүүргүүдийн (Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул) иргэний хэргийн шүүхэд 11-12 шүүгч ажилласан бөгөөд нэг шүүх 3916 хэрэг хянан шийдвэрлэсэн байна.

Таамаглал: 1-р кластерт орсон эдгээр дүүргүүдийн (Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул) иргэний хэргийн шүүхэд ойролцоогоор 12 шүүгч ажиллаж нэг шүүх 4000 орчим хэрэг хянан шийдвэрлэсэн гэдэг үнэн үү?


Шинжүүр: Таамаглалыг шалгах тооцооллын ба онолын коэффициентийн утга

Дүгнэлт: Таамаглал зөв тул 1-р кластерт орсон дүүргүүд (Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул) 3-н шинж (тухайн шүүхэд хянан шийдвэрлэсэн нэг шүүх хэргийн тоо, тухайн шүүхэд ажилласан шүүгчийн тоо, тухайн шүүхийн нэг шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн ачаалал)-ээрээ ижил байсан байна.

Гэх мэт бусад кластерийн тайлбарын энд өгсөн тайлбартай ижил утгаар ойлгоно. Гэхдээ 2 кластерийн тайлбар 1-р кластерийн тайлбартай адил байх бөгөөд 3-р кластерийн бүлгүүдийн Багануур, Налайх ДИХАШШ ижил байсан байна. хэв шинжтэй бөгөөд Багануур ДИХАШШ өөрийн онцлогтой шүүх гэсэн утгаар тайлбарлагдана.



Зураг 2.5. ДЭХАШШ-д шийдвэрлэсэн 1 шүүгчид ногдох иргэний хэргийн тоогоор ижил кластерт багтсан шүүхүүд



Зураг 2.6. ДЭХАШШ-д шийдвэрлэсэн 1 шүүгчид ногдох иргэний хэргийн тоогоор ялгаатай кластерт багтсан шүүхүүд

Б. Аймаг дахь сум дундын шүүх

Аймаг дахь хэрэг (эрүү, зөрчил, иргэн, захиргаа)-н 21 АШШ-н өгөгдөлд кластерийн шинжилгээ хийв. Кластерийн шинжилгээний үр дүнг Хотелингийн шинжүүрээр шалгаж

баталгаажуулсны дараа 3 ба 4-р бүлэгт кластерт багтсан нэгжүүдийн тухай итгэлтэй ярих нөхцөл бүрдэнэ. Учир нь Хотелингийн шинжүүрээр шалгасан кластерийн шинжилгээний үр дүн 4-р бүлгийн шаардлагатай шүүгчийн тоог тодорхойлох тэнцэтгэл бишийн системд бүлэг бүлгээрээ тусдаа зааглалтын нөхцөлийг бүрдүүлэх юм. Хотелингийн шинжүүрийн онолын ойлголттой 1-р бүлгээс товч танилцана уу.

• **Эрүүгийн хэрэг**

Аймаг дахь 21 ЭХАШШ-н нэг шүүгчийн 1 жилд шийдвэрлэсэн хэргийн тоогоор кластерийн шинжилгээ явуулахад 5 ижил төсөөтэй хэв шинжээрээ бүлэглэгдсэн кластерийн бүлгүүд үүссэн бөгөөд Дархан-Уул, Төв, Дорнод аймгийн ЭХАШШ нэг шүүгчийн 1 жилд шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоогоор өөрийн гэсэн онцлог хэв шинжтэй гэсэн ангилалд оров.

№	Кластерын бүрэлдэхүүн	Дундаж $\bar{x}_i = [\bar{x}_{i1} \quad \bar{x}_{i2}]$	Таамаглал $H_0: \mu'_i = [\mu_{i1}, \mu_{i2}]$	Шинжүүр		Дүгнэлт $H_0: T_i^2 < T_{\text{онол}}^2$
				T_i^2	$T_{\text{онол}}^2$	
1	Завхан, Говь-Алтай Дундговь, Говьсүмбэр	$\bar{x}_1 = [112.4 \quad 2.8]$	$H_0: \mu'_1 = [115, 3]$	7.71	57.	$H_0: T_1^2 < T_{\text{онол}}^2$
2	Баян-Өлгий Өмнөговь, Дорноговь	$\bar{x}_2 = [173.3 \quad 3.01]$	$H_0: \mu'_2 = [180, 3]$	1.99	798.	$H_0: T_2^2 < T_{\text{онол}}^2$
3	Увс, Ховд, Өвөрхангай	$\bar{x}_3 = [194.7 \quad 2.72]$	$H_0: \mu'_3 = [200, 3]$	90.2	798.	$H_0: T_3^2 < T_{\text{онол}}^2$
4	Булган, Архангай Баянхонгор Сэлэнгэ, Хэнтий Сүхбаатар	$\bar{x}_4 = [237.7 \quad 2.74]$	$H_0: \mu'_4 = [250, 3]$	6.37	17.35	$H_0: T_4^2 < T_{\text{онол}}^2$
5	Хөвсгөл, Орхон,	$(360.4 \quad 3.58)$ $(379.4 \quad 3.88)$	—	—	—	—
6	Дархан-Уул, Төв Дорнод	$(428.8 \quad 4.54)$ $(436.6 \quad 4.58)$ $(347.8 \quad 2.74)$	—	—	—	—

Хүснэгт 2.29. АЭХАШШ-н шүүхэд шийдвэрлэсэн 1 шүүгчид ногдох эрүүгийн хэргийн тоонд хийсэн Хотелингийн шинжүүрийн үр дүн

Дундаж: 1-р кластерт орсон аймгуудын (Завхан, Говь-Алтай, Дундговь, Говьсүмбэр) эрүүгийн хэргийн шүүхэд 2.8 шүүгч ажилласан бөгөөд нэг шүүх 112 хэрэг хянан шийдвэрлэсэн байна.

Таамаглал: 1-р кластерт орсон эдгээр аймгуудын (Завхан, Говь-Алтай, Дундговь, Говьсүмбэр) эрүүгийн хэргийн шүүхэд ойролцоогоор 3 шүүгч ажиллаж нэг шүүх 115 орчим хэрэг хянан шийдвэрлэсэн гэдэг үнэн үү?


Шинжүүр: Таамаглалыг шалгах тооцооллын ба онолын коэффициентийн утга

Дүгнэлт: Таамаглал зөв тул 1-р кластерт орсон аймгууд (Завхан, Говь-Алтай, Дундговь, Говьсүмбэр) 3-н шинж (тухайн шүүхэд хянан шийдвэрлэсэн нэг шүүх хэргийн тоо, тухайн шүүхэд ажилласан шүүгчийн тоо, тухайн шүүхийн нэг шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн ачаалал)-ээрээ ижил байсан байна.

Гэх мэт бусад кластерийн тайлбарын энд өгсөн тайлбартай ижил утгаар ойлгоно. 6-р кластерийн бүлгүүдийн Дархан-Уул, Төв, Дорнод аймгийн ЭХАШШ өөрийн онцлогтой шүүх гэсэн утгаар тайлбарлагдана.



Зураг 2.7. АЭХАШШ-д шийдвэрлэсэн 1 шүүгчид ногдох эрүүгийн хэргийн тоогоор ижил кластерт багтсан шүүхүүд



Зураг 2.8. АЭХАШШ-д шийдвэрлэсэн 1 шүүгчид ногдох эрүүгийн хэргийн тоогоор ялгаатай кластерт багтсан шүүхүүд

• **Зөрчлийн хэрэг**

АЭХАШШ-н шүүгч эрүүгийн болон, зөрчлийн хэрэг дээр давхар ажилладаг онцлогтой. Аймаг дахь 21 ЭХАШШ-н нэг шүүгчийн 1 жилд шийдвэрлэсэн зөрчлийн хэргийн тоогоор кластерийн шинжилгээ явуулахад 6 ижил төсөөтэй хэв шинжээрээ бүлэглэгдсэн кластерийн бүлгүүд үүссэн бөгөөд 7-р кластерийн Баян-Өлгий, Дархан-Уул, Баянхонгор, Хэнтий, Өвөрхангай, Орхон аймгийн ЭХАШШ нэг шүүгчийн 1 жилд шийдвэрлэсэн зөрчлийн хэргийн тоогоор өөрийн гэсэн онцлог хэв шинжтэй гэсэн ангилалд оров.

№	Кластерын бүрэлдэхүүн	Дундаж		Таамаглал		Шинжүүр		Дүгнэлт
		$\bar{x}_i = [\bar{x}_{i1} \quad \bar{x}_{i2}]$		$H_0: \mu'_i = [\mu_{i1}, \mu_{i2}]$		T_i^2	$T_{\text{онол}}^2$	
1	Завхан Өмнөговь, Дорноговь	$\bar{x}_1 = [214.2 \quad 2.84]$		$H_0: \mu'_1 = [220, 3]$		4.61	798.	$H_0: T_1^2 < T_{\text{онол}}^2$
2	Сэлэнгэ, Дундговь, Говьсүмбэр	$\bar{x}_2 = [168.9 \quad 2.58]$		$H_0: \mu'_1 = [170, 3]$		28.69	798.	$H_0: T_2^2 < T_{\text{онол}}^2$
3	Говь-Алтай, Сүхбаатар	$(240.25 \quad 2.95)$ $(267. \quad 2.63)$		–		–	–	–
4	Ховд, Дорнод	$(361.5 \quad 2.53)$ $(421.25 \quad 2.6)$		–		–	–	–
5	Хөвсгөл, Төв	$(509.5 \quad 3.475)$ $(667.75 \quad 4.5)$		–		–	–	–
6	Увс, Булган, Архангай,	$\bar{x}_6 = [411.5 \quad 2.8]$		$H_0: \mu'_1 = [420, 3]$		8.58	798.	$H_0: T_6^2 < T_{\text{онол}}^2$
7	Баян-Өлгий, Дархан-Уул	$(340.75 \quad 3.5)$ $(373.25 \quad 4.6)$		–		–	–	–
	Баянхонгор, Хэнтий	$(569.75 \quad 2.98)$ $(514.75 \quad 2.3)$		–		–	–	–
	Өвөрхангай, Орхон	$(1012.75 \quad 2.75)$ $(1014.0 \quad 3.93)$		–		–	–	–


Хүснэгт 2.30. АЗХАШШ-н шүүхэд шийдвэрлэсэн 1 шүүгчид ногдох зөрчлийн хэргийн тоонд хийсэн Хотелингийн шинжүүрийн үр дүн

Дундаж: 1-р кластерт орсон аймгуудын (Завхан, Өмнөговь, Дорноговь) эрүүгийн хэргийн шүүхэд 2.8 шүүгч ажилласан бөгөөд нэг шүүх 214 зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэсэн байна.

Таамаглал: 1-р кластерт орсон эдгээр аймгуудын (Завхан, Өмнөговь, Дорноговь) эрүүгийн хэргийн шүүхэд ойролцоогоор 3 шүүгч ажиллаж нэг шүүх 220 орчим зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэсэн гэдэг үнэн үү?

Шинжүүр: Таамаглалыг шалгах тооцооллын ба онолын коэффициентийн утга

Дүгнэлт: Таамаглал зөв тул 1-р кластерт орсон аймгууд 3-н шинж (тухайн шүүхэд хянан шийдвэрлэсэн нэг шүүх хэргийн тоо, тухайн шүүхэд ажилласан шүүгчийн тоо, тухайн шүүхийн нэг шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн ачаалал)-ээрээ ижил байсан байна. Гэх мэт бусад кластерийн тайлбарын энд өгсөн тайлбартай ижил утгаар ойлгоно. 7-р кластерийн бүлгүүдийн Баян-Өлгий, Дархан-Уул, Баянхонгор, Хэнтий, Өвөрхангай, Орхон аймгийн ЭХАШШ-д зөрчлийн хэргээрээ өөрийн онцлогтой шүүх гэсэн утгаар тайлбарлагдана.



Зураг 2.9. АЭХАШШ-д шийдвэрлэсэн 1 шүүгчид ногдох зөрчлийн хэргийн тоогоор ижил кластерт багтсан шүүхүүд



Зураг 2.10. АЭХАШШ-д шийдвэрлэсэн 1 шүүгчид ногдох зөрчлийн хэргийн тоогоор ялгаатай кластерт багтсан шүүхүүд

• Иргэний хэрэг

АИХАШШ-н шүүгч дан иргэний хэрэг дээр дагнаж ажилладаг онцлогтой. Аймаг дахь 21 ИХАШШ-н нэг шүүгчийн 1 жилд шийдвэрлэсэн иргэний хэргийн тоогоор кластерийн шинжилгээ явуулахад 4 ижил төсөөтэй хэв шинжээрээ бүлэглэгдсэн кластерийн бүлгүүд үүссэн бөгөөд 5-р кластерийн Говьсүмбэр, Дорноговь, Орхон, Дархан-Уул, Хөвсгөл, Баян-Өлгий аймгийн ИХАШШ нэг шүүгчийн 1 жилд шийдвэрлэсэн иргэний хэргийн тоогоор өөрийн гэсэн онцлог хэв шинжтэй шүүх гэсэн ангилалд оров.

№	Кластерын бүрэлдэхүүн	Дундаж		Таамаглал $H_0: \mu'_i = [\mu_{i1}, \mu_{i2}]$	Шинжүүр		Дүгнэлт $H_0: T_i^2 < T_{\text{онол}}^2$
		$\bar{x}_i = [\bar{x}_{i1}, \bar{x}_{i2}]$			T_i^2	$T_{\text{онол}}^2$	
1	Завхан, Говь-Алтай, Сэлэнгэ, Дундговь, Өмнөговь, Сүхбаатар	$\bar{x}_1 = [622.2, 2.9]$		$H_0: \mu'_1 = [650, 3]$	1.11	17.35	$H_0: T_1^2 < T_{\text{онол}}^2$
2	Ховд, Өвөрхангай, Булган	$\bar{x}_2 = [785.8, 2.7]$		$H_0: \mu'_2 = [800, 3]$	148.84	798.	$H_0: T_2^2 < T_{\text{онол}}^2$
3	Увс, Хэнтий, Архангай, Баянхонгор	$\bar{x}_3 = [890.7, 2.8]$		$H_0: \mu'_1 = [900, 3]$	47.62	57.	$H_0: T_3^2 < T_{\text{онол}}^2$
4	Төв, Дорнод,	$(1434. 4.4)$ $(1134.6 3.8)$		–	–	–	–
5	Говьсүмбэр, Дорноговь	$(217.2 2.7)$ $(457. 2.9)$		–	–	–	–
	Орхон, Дархан-Уул	$(1601.2 4.9)$ $(1396.6 4.2)$		–	–	–	–
	Хөвсгөл, Баян-Өлгий	$(1677.6 5.5)$ $(974. 4.)$		–	–	–	–


Хүснэгт 2.31. АИХАШШ-н шүүхэд шийдвэрлэсэн 1 шүүгчид ногдох иргэний хэргийн тоонд хийсэн Хотелингийн шинжүүрийн үр дүн

Дундаж: 1-р кластерт орсон аймгуудын (Завхан, Говь-Алтай, Сэлэнгэ, Дундговь, Өмнөговь, Сүхбаатар) иргэний хэргийн шүүхэд 2.9 шүүгч ажилласан бөгөөд нэг шүүх 622 хэрэг хянан шийдвэрлэсэн байна.


Таамаглал: 1-р кластерт орсон эдгээр аймгуудын (Завхан, Говь-Алтай, Сэлэнгэ, Дундговь, Өмнөговь, Сүхбаатар) иргэний хэргийн шүүхэд ойролцоогоор 3 шүүгч ажиллаж нэг шүүх 650 орчим хэрэг хянан шийдвэрлэсэн гэдэг үнэн үү?

Шинжлүүр: Таамаглалыг шалгах тооцооллын ба онолын коэффициентийн утга

Дүгнэлт: Таамаглал зөв тул 1-р кластерт орсон аймгууд 3-н шинж (тухайн шүүхэд хянан шийдвэрлэсэн нэг шүүх хэргийн тоо, тухайн шүүхэд ажилласан шүүгчийн тоо, тухайн шүүхийн нэг шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн ачаалал)-ээрээ ижил байсан байна. Гэх мэт бусад кластерийн тайлбарын энд өгсөн тайлбартай ижил утгаар ойлгоно. 5-р кластерийн бүлгүүдийн Говьсүмбэр, Дорноговь, Орхон, Дархан-Уул, Хөвсгөл, Баян-Өлгий аймгийн ИХАШШ өөрийн онцлогтой шүүх гэсэн утгаар тайлбарлагдана.



Зураг 2.11. АИХАШШ-д шийдвэрлэсэн 1 шүүгчид ногдох иргэний хэргийн тоогоор ижил кластерт багтсан шүүхүүд



Зураг 2.12. АИХАШШ-д шийдвэрлэсэн 1 шүүгчид ногдох иргэний хэргийн тоогоор ялгаатай кластерт багтсан шүүхүүд

В. Аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүх

АЗХАШШ-н шүүгч дан захиргааны хэрэг дээр дагнаж ажилладаг онцлогтой. Аймаг дахь 21 ЗХАШШ-н нэг шүүгчийн 1 жилд шийдвэрлэсэн захиргааны хэргийн тоогоор кластерийн шинжилгээ явуулахад 6 ижил төсөөтэй хэв шинжээрээ бүлэглэгдсэн кластерийн бүлгүүд үүссэн бөгөөд 7-р кластерийн Баян-Өлгий, Дундговь, Завхан аймгийн ЗХАШШ нэг шүүгчийн 1 жилд шийдвэрлэсэн зөрчлийн хэргийн тоогоор өөрийн гэсэн онцлог хэв шинжтэй шүүх гэсэн ангилалд оров.

№	Кластерын бүрэлдэхүүн	Дундаж $\bar{x}_i = [\bar{x}_{i1} \quad \bar{x}_{i2}]$	Таамаглал $H_0: \mu'_i = [\mu_{i1}, \mu_{i2}]$	Шинжүүр		Дүгнэлт $H_0: T_i^2 < T_{\text{онол}}^2$
				T_i^2	$T_{\text{онол}}^2$	
1	Өвөрхангай, Говьсүмбэр, Дорноговь, Хэнтий	$\bar{x}_1 = [19.4 \quad 2.6]$	$H_0: \mu'_1 = [21, 3]$	4.08	57.	$H_0: T_1^2 < T_{\text{онол}}^2$
2	Сэлэнгэ, Төв	$(32. \quad 2.7)$ $(45. \quad 3.)$	–	–	–	–
3	Булган, Дорнод	$(25.8 \quad 2.)$ $(28. \quad 2.1)$	–	–	–	–
4	Орхон, Баянхонгор Дархан-Уул, Өмнөговь, Сүхбаатар	$\bar{x}_4 = [33.4 \quad 3.0]$	$H_0: \mu'_1 = [35, 3]$	3.55	19.1	$H_0: T_4^2 < T_{\text{онол}}^2$
5	Говь-Алтай, Хөвсгөл	$(31. \quad 1.72)$ $(32.2 \quad 2.)$	–	–	–	–
6	Увс, Ховд, Архангай,	$\bar{x}_6 = [43.7 \quad 2.4]$	$H_0: \mu'_1 = [50, 2]$	9.25	798.	$H_0: T_6^2 < T_{\text{онол}}^2$
7	Баян-Өлгий	$(77.4 \quad 2.9)$	–	–	–	–
	Дундговь, Завхан	$(27.2 \quad 2.2)$ $(38. \quad 3.)$	–	–	–	–

Хүснэгт 2.32. АЗХАШШ-н шүүхэд шийдвэрлэсэн 1 шүүгчид ногдох захиргааны хэргийн тоонд хийсэн Хотелингийн шинжүүрийн үр дүн






Дундаж: 1-р кластерт орсон аймгуудын (Өвөрхангай, Говьсүмбэр, Дорноговь, Хэнтий) эрүүгийн хэргийн шүүхэд 2.6 шүүгч ажилласан бөгөөд нэг шүүх 19 захиргааны хэрэг хянан шийдвэрлэсэн байна.

Таамаглал: 1-р кластерт орсон эдгээр аймгуудын (Өвөрхангай, Говьсүмбэр, Дорноговь, Хэнтий) захиргааны хэргийн шүүхэд ойролцоогоор 3 шүүгч ажиллаж нэг шүүх захиргааны 19 орчим хэрэг хянан шийдвэрлэсэн гэдэг үнэн үү?

Шинжүүр: Таамаглалыг шалгах тооцооллын ба онолын коэффициентийн утга

Дүгнэлт: Таамаглал зөв тул 1-р кластерт орсон аймгууд (Өвөрхангай, Говьсүмбэр, Дорноговь, Хэнтий) 3-н шинж (тухайн шүүхэд хянан шийдвэрлэсэн нэг шүүх хэргийн тоо, тухайн шүүхэд ажилласан шүүгчийн тоо, тухайн шүүхийн нэг шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн ачаалал)-ээрээ ижил байсан байна.

Гэх мэт бусад кластерийн тайлбарын энд өгсөн тайлбартай ижил утгаар ойлгоно. 7-р кластерийн Баян-Өлгий, Дундговь, Завхан аймгийн ЗХАШШ-д хянан шийдвэрлэдэг захиргааны хэргээрээ өөрийн онцлогтой шүүх гэсэн утгаар тайлбарлагдана.



Зураг 2.13. АЭХАШШ-д шийдвэрлэсэн 1 шүүгчид ногдох захиргааны хэргийн тоогоор ижил кластерт багтсан шүүхүүд



Зураг 2.14. АЭХАШШ-д шийдвэрлэсэн 1 шүүгчид ногдох захиргааны хэргийн тоогоор ялгаатай кластерт багтсан шүүхүүд

Г. Сум дундын шүүх

Сум дундын шүүхийн шүүгч эрүү, зөрчил, иргэний хэрэг дээр ажилладаг онцлогтой. Сум дундын 8 шүүхэд хянан шийдвэрлэсэн хэрэг (эрүү, зөрчил, иргэн)-н өгөгдөлд кластерийн

шинжилгээ хийв. Кластерийн шинжилгээний үр дүнг Хотелингийн шинжүүрээр шалгаж баталгаажуулсны дараа 3 ба 4-р бүлэгт кластерт багтсан нэгжүүдийн тухай итгэлтэй ярих нөхцөл бүрдэнэ. Учир нь Хотелингийн шинжүүрээр шалгасан кластерийн шинжилгээний үр дүн 4-р бүлгийн шаардлагатай шүүгчийн тоог тодорхойлох тэнцэтгэл бишийн системд бүлэг бүлгээрээ тусдаа зааглалтын нөхцөлийг бүрдүүлэх юм. Хотелингийн шинжүүрийн онолын ойлголттой 1-р бүлгээс товч танилцана уу.

• Эрүүгийн хэрэг

Сум дундын 8 шүүхийн нэг шүүгчийн нэг жилд хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоонд кластерийн шинжилгээ явуулахад 2 ижил төсөвтэй хэв шинжээрээ бүлэглэгдсэн кластерийн бүлгүүд үүссэн бөгөөд 1-р кластерт Тосонцэнгэл, Сайхан, Хо.Булган, Бор-Өндөр гэсэн СДШ-д оров.

№	Кластерын бүрэлдэхүүн	Дундаж $\bar{x}_i = [\bar{x}_{i1} \quad \bar{x}_{i2}]$	Таамаглал $H_0: \mu'_i = [\mu'_{i1}, \mu'_{i2}]$	Шинжүүр		Дүгнэлт $H_0: T_i^2 < T_{\text{онол}}^2$
				T_i^2	$T_{\text{онол}}^2$	
1	Тосонцэнгэл, Сайхан, Хо.Булган, Бор-Өндөр	$\bar{x}_1 = [66.1 \quad 3.09]$	$H_0: \mu'_1 = [70, 3]$	2.87	57.	$H_0: T_1^2 < T_{\text{онол}}^2$
2	Замын-Үүд, Ханбогд, Хархорин, Мандал	$\bar{x}_2 = [131.9 \quad 3.53]$	$H_0: \mu'_2 = [140, 4]$	8.15	57.	$H_0: T_2^2 < T_{\text{онол}}^2$

Хүснэгт 2.33. СДШ-н шүүхэд шийдвэрлэсэн 1 шүүгчид ногдох эрүүгийн хэргийн тоонд хийсэн Хотелингийн шинжүүрийн үр дүн



Дундаж: 1-р кластерт орсон сум дундын (Тосонцэнгэл, Сайхан, Хо.Булган, Бор-Өндөр) шүүхэд 3.1 шүүгч ажилласан бөгөөд нэг шүүх 66 эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэсэн байна.

Таамаглал: 1-р кластерт орсон эдгээр сум дундын (Тосонцэнгэл, Сайхан, Хо.Булган, Бор-Өндөр) шүүхэд ойролцоогоор 3 шүүгч ажиллаж нэг шүүх эрүүгийн 70 орчим хэрэг хянан шийдвэрлэсэн гэдэг үнэн үү?

Шинжүүр: Таамаглалыг шалгах тооцооллын ба онолын коэффициентийн утга

Дүгнэлт: Таамаглал зөв тул 1-р кластерт орсон сум дундын (Тосонцэнгэл, Сайхан, Хо.Булган, Бор-Өндөр) шүүхүүд 3-н шинж (тухайн шүүхэд хянан шийдвэрлэсэн нэг шүүх хэргийн тоо, тухайн шүүхэд ажилласан шүүгчийн тоо, тухайн шүүхийн нэг шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн ачаалал)-ээрээ ижил байсан байна.

Гэх мэт бусад кластерийн тайлбарын энд өгсөн тайлбартай ижил утгаар ойлгоно.



Зураг 2.15. СДШ-д шийдвэрлэсэн 1 шүүгчид ногдох эрүүгийн хэргийн тоогоор ижил кластерт багтсан шүүхүүд

• Зөрчлийн хэрэг

Сум дундын 8 шүүхийн нэг шүүгчийн нэг жилд хянан шийдвэрлэсэн зөрчлийн хэргийн тоонд кластерийн шинжилгээ явуулахад 2 ижил төсөөтэй хэв шинжээрээ бүлэглэгдсэн кластерийн бүлгүүд үүссэн бөгөөд 3-р кластерт Хархорины СДШ нэг шүүгчийн 1 жилд шийдвэрлэсэн зөрчлийн хэргийн тоогоор өөрийн гэсэн онцлог хэв шинжтэй гэсэн ангилалд оров.

№	Кластерын бүрэлдэхүүн	Дундаж		Таамаглал $H_0: \mu'_i = [\mu_{i1}, \mu_{i2}]$	Шинжүүр		Дүгнэлт $H_0: T_i^2 < T_{\text{онол}}^2$
		$\bar{x}_i = [\bar{x}_{i1} \quad \bar{x}_{i2}]$			T_i^2	$T_{\text{онол}}^2$	
1	Замын-Үүд, Ханбогд, Сайхан, Бор-Өндөр	$\bar{x}_1 = [131.1 \quad 3.52]$		$H_0: \mu'_1 = [140, 4]$	3.02	57.	$H_0: T_1^2 < T_{\text{онол}}^2$
2	Тосонцэнгэл, Мандал, Хо.Булган	$\bar{x}_2 = [199.8 \quad 3.14]$		$H_0: \mu'_1 = [200, 3]$	28.43	798.	$H_0: T_2^2 < T_{\text{онол}}^2$
3	Хархорин	(395.25 2.9)		—	—	—	—

Хүснэгт 2.34. СДШ-н шүүхэд шийдвэрлэсэн 1 шүүгчид ногдох зөрчлийн хэргийн тоонд хийсэн Хотелингийн шинжүүрийн үр дүн


Дундаж: 1-р кластерт орсон сум дундын (Замын-Үүд, Ханбогд, Сайхан, Бор-Өндөр) шүүхэд 3.5 шүүгч ажилласан бөгөөд нэг шүүх 131 зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэсэн байна.

Таамаглал: 1-р кластерт орсон эдгээр сум дундын (Замын-Үүд, Ханбогд, Сайхан, Бор-Өндөр) шүүхэд ойролцоогоор 4 шүүгч ажиллаж нэг шүүх 140 орчим зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэсэн гэдэг үнэн үү?

Шинжүүр: Таамаглалыг шалгах тооцооллын ба онолын коэффициентийн утга

Дүгнэлт: Таамаглал зөв тул 1-р кластерт орсон сум дундын (Замын-Үүд, Ханбогд, Сайхан, Бор-Өндөр) шүүхүүд 3-н шинж (тухайн шүүхэд хянан шийдвэрлэсэн нэг шүүх хэргийн тоо, тухайн шүүхэд ажилласан шүүгчийн тоо, тухайн шүүхийн нэг шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн ачаалал)-ээрээ ижил байсан байна.

Гэх мэт бусад кластерийн тайлбарын энд өгсөн тайлбартай ижил утгаар ойлгоно.



Зураг 2.16. СДШ-д шийдвэрлэсэн 1 шүүгчид ногдох зөрчлийн хэргийн тоогоор ижил кластерт багтсан шүүхүүд



Зураг 2.17. СДШ-д шийдвэрлэсэн 1 шүүгчид ногдох зөрчлийн хэргийн тоогоор ялгаатай кластерт багтсан шүүхүүд

• Иргэний хэрэг

СДШ-н нэг шүүгчийн 1 жилд шийдвэрлэсэн иргэний хэргийн тоогоор кластерийн шинжилгээ явуулахад 2 ижил төсөөтэй хэв шинжээрээ бүлэглэгдсэн кластерийн бүлгүүд үүссэн бөгөөд 1-р кластерийн бүлэгт Замын-Үүд, Ханбогд, Сайхан, Хо.Булган, Бор-Өндөрийн СДШ-н нэг шүүгчийн 1 жилд шийдвэрлэсэн иргэний хэргийн тоогоор ижил хэв шинжтэй шүүхүүд гэсэн ангилалд оров.

№	Кластерын бүрэлдэхүүн	Дундаж $\bar{x}_i = [\bar{x}_{i1} \quad \bar{x}_{i2}]$	Таамаглал $H_0: \mu'_i = [\mu_{i1}, \mu_{i2}]$	Шинжүүр		Дүгнэлт $H_0: T_i^2 < T_{\text{онол}}^2$
				T_i^2	$T_{\text{онол}}^2$	
1	Замын-Үүд, Ханбогд, Сайхан Хо.Булган, Бор-Өндөр	$\bar{x}_1 = [249.8 \quad 3.4]$	$H_0: \mu'_1 = [260, 3]$	3.5	25.5	$H_0: T_1^2 < T_{\text{онол}}^2$
2	Госонцэнгэл, Хархорин, Мандал	$\bar{x}_2 = [425.9 \quad 3.2]$	$H_0: \mu'_1 = [450, 3]$	6.78	798.	$H_0: T_2^2 < T_{\text{онол}}^2$

Хүснэгт 2.35. СДШ-н шүүхэд шийдвэрлэсэн 1 шүүгчид ногдох иргэний хэргийн тоонд хийсэн Хотелингийн шинжүүрийн үр дүн


Дундаж: 1-р кластерт орсон сум дундын (Замын-Үүд, Ханбогд, Сайхан, Хо.Булган, Бор-Өндөр) шүүхэд 3.4 шүүгч ажилласан бөгөөд нэг шүүх 250 иргэний хэрэг хянан шийдвэрлэсэн байна.

Таамаглал: 1-р кластерт орсон эдгээр сум дундын (Замын-Үүд, Ханбогд, Сайхан, Хо.Булган, Бор-Өндөр) шүүхэд ойролцоогоор 3 шүүгч ажиллаж нэг шүүх 260 орчим иргэний хэрэг хянан шийдвэрлэсэн гэдэг үнэн үү?


Шинжүүр: Таамаглалыг шалгах тооцооллын ба онолын коэффициентийн утга

Дүгнэлт: Таамаглал зөв тул 1-р кластерт орсон сум дундын шүүхүүд 3-н шинж (тухайн шүүхэд хянан шийдвэрлэсэн нэг шүүх хэргийн тоо, тухайн шүүхэд ажилласан шүүгчийн тоо, тухайн шүүхийн нэг шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн ачаалал)-ээрээ ижил байсан байна.

Гэх мэт бусад кластерийн тайлбарын энд өгсөн тайлбартай ижил утгаар ойлгоно.



Зураг 2.18. СДШ-д шийдвэрлэсэн 1 шүүгчид ногдох иргэний хэргийн тоогоор ижил кластерт багтсан шүүхүүд



Зураг 2.19. СДШ-д шийдвэрлэсэн 1 шүүгчид ногдох иргэний хэргийн тоогоор ялгаатай кластерт багтсан шүүхүүд

2.2.2. Давж заалдах шатны шүүх

Давж заалдах шатны шүүх нь 21 аймагт 23 шүүх, нийслэлд 3 байдаг. АДЗШШ-д хянан шийдвэрлэсэн хэрэг (эрүү, зөрчил, иргэн)-н өгөгдөлд кластерийн шинжилгээ хийв. Кластерийн шинжилгээний үр дүнг Хотелингийн шинжүүрээр шалгаж баталгаажуулсны дараа 3 ба 4-р бүлэгт кластерт багтсан нэгжүүдийн тухай итгэлтэй ярих нөхцөл бүрдэнэ. Учир нь Хотелингийн шинжүүрээр шалгасан кластерийн шинжилгээний үр дүн 4-р бүлгийн шаардлагатай шүүгчийн тоог тодорхойлох тэнцэтгэл бишийн системд бүлэг бүлгээрээ тусдаа зааглалтын нөхцөлийг бүрдүүлэх юм. Хотелингийн шинжүүрийн онолын ойлголттой 1-р бүлгээс товч танилцана уу.

• Эрүүгийн хэрэг

АДЗШШ-н шүүгч эрүүгийн, зөрчлийн болон иргэний хэрэг дээр давхар ажилладаг онцлогтой. Аймгийн 19 ДЗШШ-н нэг шүүгчийн нэг жилд шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоонд кластерийн шинжилгээ явуулахад 6 ижил төсөөтэй хэв шинжээрээ бүлэглэгдсэн кластерийн бүлгүүд үүссэн бөгөөд 1-р кластерийн Говьсүмбэр аймгийн ДЗШШ-н нэг шүүгчийн 1 жилд шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоогоор өөрийн гэсэн онцлог хэв шинжтэй шүүх гэсэн ангилалд оров. Орхон, Дархан-Уул аймгийн ДЗШШ нь эрүүгийн болон иргэний хэргийн ДЗШШ гэж салдаг онцлогтой тул кластерийн шинжилгээнд тусдаа дангаараа бүлэг болж орно.

№	Кластерын бүрэлдэхүүн	Дундаж $\bar{x}_i = [\bar{x}_{i1} \ \bar{x}_{i2}]$	Таамаглал $H_0: \mu'_i = [\mu_{i1}, \mu_{i2}]$	Шинжүүр		Дүгнэлт $H_0: T_i^2 < T_{\text{онол}}^2$
				T_i^2	$T_{\text{онол}}^2$	
1	Говьсүмбэр	(21.8 2.98)	—	—	—	—
2	Завхан, ГовьАлтай, Дундговь, Сүхбаатар	$\bar{x}_2 = [23.1 \ 3.1]$	$H_0: \mu'_1 = [25, 3]$	1.72	57.	$H_0: T_2^2 < T_{\text{онол}}^2$
3	БаянӨлгий, Увс, Булган, Хэнтий	$\bar{x}_3 = [35.85 \ 2.5]$	$H_0: \mu'_1 = [40, 3]$	40.06	57.	$H_0: T_3^2 < T_{\text{онол}}^2$
4	Ховд, Хөвсгөл Архангай, Өвөрхангай, Дорнод	$\bar{x}_4 = [39.16 \ 2.9]$	$H_0: \mu'_1 = [40, 3]$	19.13	25.47	$H_0: T_4^2 < T_{\text{онол}}^2$
5	Сэлэнгэ, Төв Дорноговь	$\bar{x}_5 = [68.2 \ 3.31]$	$H_0: \mu'_1 = [70, 3.5]$	0.3	798.	$H_0: T_5^2 < T_{\text{онол}}^2$
6	Баянхонгор, Өмнөговь	(74.6 2.46) (58.8 2.6)	—	—	—	—
7	Орхон, Дархан-Уул	(78. 3.) (72.4 3.02)	—	—	—	—



Хүснэгт 2.36. АДЗШШ-н шүүхэд шийдвэрлэсэн 1 шүүгчид ногдох эрүүгийн хэргийн тоонд хийсэн Хотелингийн шинжүүрийн үр дүн


Дундаж: 2-р кластерт орсон аймгуудын (Завхан, Говь-Алтай, Дундговь, Сүхбаатар) давж заалдах шатны шүүхэд 3.1 шүүгч ажилласан бөгөөд нэг шүүх 23 эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэсэн байна.

Таамаглал: 2-р кластерт орсон эдгээр аймгуудын (Завхан, Говь-Алтай, Дундговь, Сүхбаатар) давж заалдах шатны шүүхэд ойролцоогоор 3 шүүгч ажиллаж нэг шүүх 25 орчим эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэсэн гэдэг үнэн үү?

Шинжүүр: Таамаглалыг шалгах тооцооллын ба онолын коэффициентийн утга

Дүгнэлт: Таамаглал зөв тул 2-р кластерт орсон аймгууд 3-н шинж (тухайн шүүхэд хянан шийдвэрлэсэн нэг шүүх хэргийн тоо, тухайн шүүхэд ажилласан шүүгчийн тоо, тухайн шүүхийн нэг шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн ачаалал)-ээрээ ижил байсан байна. Гэх мэт бусад кластерийн тайлбарын энд өгсөн тайлбартай ижил утгаар ойлгоно. 1-р кластерийн Говьсүмбэр аймгийн ДЗШШ хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргээрээ өөр онцлогтой шүүх гэсэн утгаар тайлбарлагдана.





Зураг 2.20. АДЗШШ-д шийдвэрлэсэн 1 шүүгчид ногдох эрүүгийн хэргийн тоогоор ижил кластерт багтсан шүүхүүд



Зураг 2.21. АДЗШШ-д шийдвэрлэсэн 1 шүүгчид ногдох эрүүгийн хэргийн тоогоор ялгаатай кластерт багтсан шүүх

• Зөрчлийн хэрэг

Аймгийн 19 ДЗШШ-н нэг шүүгчийн нэг жилд шийдвэрлэсэн зөрчлийн хэргийн тоонд кластерийн шинжилгээ явуулахад 6 ижил төсөөтэй хэв шинжээрээ бүлэглэгдсэн кластерийн бүлгүүд үүссэн бөгөөд 7-р кластерийн Говьсүмбэр, Дундговь, Увс, Хөвсгөл, Сэлэнгэ, аймгийн ДЗШШ-үүдийн нэг шүүгчийн 1 жилд шийдвэрлэсэн зөрчлийн хэргийн тоогоор зарим нь өөр хоорондоо ойролцоо хэв шинжтэй ч өөрийн гэсэн онцлог хэв шинжтэй шүүхүүд гэсэн ангилалд оров. Орхон, Дархан-Уул аймгийн ДЗШШ нь эрүүгийн болон иргэний хэргийн ДЗШШ гэж салдаг онцлогтой тул кластерийн шинжилгээнд тусдаа дангаараа бүлэг болж орно.

№	Кластерын бүрэлдэхүүн	Дундаж $\bar{x}_i = [\bar{x}_{i1} \quad \bar{x}_{i2}]$	Таамаглал $H_0: \mu'_i = [\mu_{i1}, \mu_{i2}]$	Шинжүүр		Дүгнэлт $H_0: T_i^2 < T_{\text{онол}}^2$
				T_i^2	$T_{\text{онол}}^2$	
1	Төв, Сүхбаатар	(5. 4.) (4.25 3.25)	—	—	—	—
2	ГовьАлтай, Архангай	(11.75 3.) (11.25 3.)	—	—	—	—





3	Булган, Өмнөговь, Дорнод	$\bar{x}_3 = [7.42 \quad 2.65]$	$H_0: \mu'_1 = [8, 3]$	7.88	798.	$H_0: T_3^2 < T_{\text{онол}}^2$
4	Завхан, Баянхонгор, Дорноговь	$\bar{x}_4 = [11.08 \quad 3.11]$	$H_0: \mu'_1 = [10, 3]$	13.93	798.	$H_0: T_4^2 < T_{\text{онол}}^2$
5	БаянӨлгий, Өвөрхангай	$\begin{pmatrix} 8.25 & 2.73 \\ 12. & 2.63 \end{pmatrix}$	—	—	—	—
6	Ховд, Хэнтий	$\begin{pmatrix} 16.5 & 2.68 \\ 14.5 & 2.25 \end{pmatrix}$	—	—	—	—
7	Говьсүмбэр, Дундговь, Увс	$\begin{pmatrix} 2.5 & 3. \\ 3.75 & 2.73 \\ 8.5 & 2.7 \end{pmatrix}$	—	—	—	—
	Хөвсгөл, Сэлэнгэ	$\begin{pmatrix} 17. & 2.85 \\ 28.25 & 2.9 \end{pmatrix}$	—	—	—	—
	Дархан-Уул, Орхон	$\begin{pmatrix} 14.25 & 3.03 \\ 20.5 & 3. \end{pmatrix}$	—	—	—	—


Хүснэгт 2.37. АДЗШШ-н шүүхэд шийдвэрлэсэн 1 шүүгчид ногдох зөрчлийн хэргийн тоонд хийсэн Хотелингийн шинжүүрийн үр дүн

Дундаж: 1-р кластерт орсон Төв аймгийн давж заалдах шатны шүүхэд 4 шүүгч, Сүхбаатар аймгийн давж заалдах шатны шүүхэд 3.3 шүүгч ажилласан бөгөөд Төв аймгийн давж заалдах шатны шүүхэд 5 зөрчлийн хэрэг, Сүхбаатар аймгийн давж заалдах шатны шүүхэд 4.3 зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэсэн байна.


Таамаглал: Кластерийн бүлэг 2 элементтэй үед таамаглал дэвшүүлдэггүй бөгөөд шууд үр дүнг хэрэглэдэг.

Гэх мэт бусад кластерийн тайлбарын энд өгсөн болон дээр өгсөн тайлбартай ижил утгаар ойлгоно. 7-р кластерийн аймгуудын ДЗШШ хянан шийдвэрлэсэн зөрчлийн хэргээрээ өөр онцлогтой шүүх гэсэн утгаар тайлбарлагдана.





Зураг 2.22. АДЗШШ-д шийдвэрлэсэн 1 шүүгчид ногдох зөрчлийн хэргийн тоогоор ижил кластерт багтсан шүүхүүд



Зураг 2.23. АДЗШШ-д шийдвэрлэсэн 1 шүүгчид ногдох зөрчлийн хэргийн тоогоор ялгаатай кластерт багтсан шүүхүүд

• Иргэний хэрэг

АДЗШШ-н шүүгч эрүүгийн, зөрчлийн болон иргэний хэрэг дээр давхар ажилладаг онцлогтой. Аймгийн 19 ДЗШШ-н нэг шүүгчийн нэг жилд шийдвэрлэсэн иргэний хэргийн тоонд кластерийн шинжилгээ явуулахад 7 ижил төсөтэй хэв шинжээрээ бүлэглэгдсэн кластерийн бүлгүүд үүссэн бөгөөд 8-р кластерийн Баян-Өлгий аймгийн ДЗШШ-н нэг шүүгчийн 1 жилд шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоогоор өөрийн гэсэн онцлог хэв шинжтэй шүүх гэсэн ангилалд оров. Орхон, Дархан-Уул аймгийн ДЗШШ нь эрүүгийн болон иргэний хэргийн ДЗШШ гэж салдаг онцлогтой тул кластерийн шинжилгээнд тусдаа дангаараа бүлэг болж орно.

№	Кластерын бүрэлдэхүүн	Дундаж $\bar{x}_i = [\bar{x}_{i1} \quad \bar{x}_{i2}]$	Таамаглал $H_0: \mu'_i = [\mu_{i1}, \mu_{i2}]$	Шинжүүр		Дүгнэлт $H_0: T_i^2 < T_{\text{онол}}^2$
				T_i^2	$T_{\text{онол}}^2$	
1	Говьсүмбэр, Сүхбаатар	(21.4 3.0) (17. 3.1)	-	-	-	-

2	Булган, Архангай, Дундговь	$\bar{x}_2 = [24.9 \ 2.8]$	$H_0: \mu'_1 = [25, 3]$	60.09	798.	$H_0: T_2^2 < T_{\text{онол}}^2$
3	Завхан, Төв	$\begin{pmatrix} 30.2 & 3.6 \\ 32.6 & 4. \end{pmatrix}$	—	—	—	—
4	ГовьАлтай, Өвөрхангай, Баянхонгор, Дорноговь	$\bar{x}_4 = [31.45 \ 2.8]$	$H_0: \mu'_1 = [32, 3]$	3.3	57.	$H_0: T_4^2 < T_{\text{онол}}^2$
5	Увс, Хэнтий	$\begin{pmatrix} 26.2 & 2.6 \\ 25.2 & 2.3 \end{pmatrix}$	—	—	—	—
6	Хөвсгөл, Өмнөговь, Дорнод	$\bar{x}_5 = [32.5 \ 2.8]$	$H_0: \mu'_1 = [33, 3]$	7.8	798.	$H_0: T_4^2 < T_{\text{онол}}^2$
7	Ховд, Сэлэнгэ	$\begin{pmatrix} 52.6 & 2.7 \\ 56.8 & 2.9 \end{pmatrix}$	—	—	—	—
8	БаянӨлгий, Орхон, ДарханУул	$\begin{pmatrix} 103.4 & 2.7 \\ 158. & 2.9 \\ 136.4 & 3.2 \end{pmatrix}$	—	—	—	—




Хүснэгт 2.38. АДЗШШ-н шүүхэд шийдвэрлэсэн 1 шүүгчид ногдох иргэний хэргийн тоонд хийсэн Хотелингийн шинжүүрийн үр дүн

Дундаж: 1-р кластерт орсон Говьсүмбэр аймгийн давж заалдах шатны шүүхэд 3 шүүгч, Сүхбаатар аймгийн давж заалдах шатны шүүхэд 3.1 шүүгч ажилласан бөгөөд Говьсүмбэр аймгийн давж заалдах шатны шүүхэд 21.4 иргэний хэрэг, Сүхбаатар аймгийн давж заалдах шатны шүүхэд 17 иргэний хэрэг тус тус хянан шийдвэрлэсэн байна.



Таамаглал: Кластерийн бүлэг 2 элементтэй үед таамаглал дэвшүүлдэггүй бөгөөд шууд үр дүнг хэрэглэдэг.

Гэх мэт бусад кластерийн тайлбарын энд өгсөн болон дээр өгсөн тайлбартай ижил утгаар ойлгоно. 8-р кластерийн аймгуудын ДЗШШ хянан шийдвэрлэсэн иргэний хэргээрээ өөр хэв шинжтэй, онцлогтой шүүх гэсэн утгаар тайлбарлагдана.





Зураг 2.24. АДЗШШ-д шийдвэрлэсэн 1 шүүгчид ногдох иргэний хэргийн тоогоор ижил кластерт багтсан шүүхүүд



Зураг 2.25. АДЗШШ-д шийдвэрлэсэн 1 шүүгчид ногдох иргэний хэргийн тоогоор ялгаатай кластерт багтсан шүүхүүд

• Захиргааны хэрэг

Тус шүүх нь Улсын хэмжээнд нэг тул кластерийн шинжилгээ хийгдэхгүй бөгөөд бие даасан шинжтэй байна.

Шүүх	Захиргаа	
	Бүс	Динамик
Анхан	Баруун 47.84	×
	Зүүн 26.67	
Давж заалдах	Хянасан бүгд	•
	Баруун 17.76	
Анхан шатны шүүхийн шийдвэрийг хянасан	Зүүн 6.93	—
	Баруун 31.68	
	Зүүн 10.00	

Хүснэгт 2.39. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн хянасан бүгд тоонд хийсэн дисперсийн шинжилгээ

Үүнд: • - нөлөөлөлтэй, ×- нөлөөлөлгүй, — - тооцоо хийгдэхгүй

2.3. ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ХЭРГИЙН АЧААЛЛЫН ШИНЖИЛГЭЭ

Хянан шийдвэрлэсэн хэргийн ачааллыг тооцохдоо хэргийн төрөл, шүүхийн тогтолцоо, хэрэг хуваарилах журам, шинжилгээнд ирүүлсэн өгөгдлийн онцлогийг тус тус харгалзан сүүлийн 5 жилийн динамикийн хувьд нэг шүүгчийн нэг жилд хянан шийдвэрлэсэн хэргийн ачааллын дүнг тооцсон. АЭХАШШ, нийслэлийн захын дүүргийн ЭХАШШ-н шүүгч эрүү, зөрчлийн хэрэг дээр, СДШ-н шүүгч эрүү, зөрчил, иргэний хэрэг дээр, АДЗШШ-н шүүгч эрүү, зөрчил, иргэний хэрэг дээр ажилладаг онцлогтой. Бид 4-р бүлэгт шүүгчийн ажлын ачааллыг тооцоход эдгээр олон төрлийн хэрэг дээр ажилладаг шүүгчийн ажлыг нэг хэргийн нэгж рүү шилжүүлсний дараа тооцоо хийх боломжтой болох тул 1 эрүү=? зөрчил, 1 эрүү=? иргэн хэрэгтэй тэнцэх коэффициентийг энэ бүлэгт тодорхойлно.

2.3.1. Анхан шатны шүүхэд хянан шийдвэрлэсэн хэргийн ачаалал


Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд анхан болон давж заалдах шатны шүүхийн нэг шүүгч нэг жилд авсан ачаалал түүнд дүүргийн болон динамикийн нөлөө байгаа эсэхийг дараах хүснэгтээр харуулъя.

Хэргийн төрөл	Анхан шатны шүүх			Давж заалдах шатны шүүх	
	Дүүрэг	Динамик	Дундаж	Хэргийн төрөл	Динамик
Иргэн	Төв 326	×	234	160	×
	Зах 142				
Эрүү	Төв	[2017], 84	136	78	
		[2018], 157			
		[2019], 170			
		[2020], 151			
		[2021], 119			
Зөрчил	Төв	×	1390		
Захиргаа	Нийслэл	×	54	62	


Хүснэгт 2.40. Нийслэлийн нэг шүүгчид ногдох шийдвэрлэсэн дундаж хэргийн тоо

Үүнд: ● - нөлөөлөлтэй, × - нөлөөлөлгүй, — - тооцоо хийгдэхгүй


Нэг ба 2 хүчин зүйлийн дисперсийн шинжилгээний үр дүн болох Хүснэгт 2.40-н эрүү ба зөрчлийн хэргийг тус тусдаа шийдвэрлэсэн нийслэлийн шүүгчийн ажлын ачаалал дээр үндэслэн 1 эрүүгийн хэргийг 10.2 зөрчлийн хэрэгтэй, 1 эрүүгийн хэргийг 2.4 иргэний хэрэгтэй адилтгаж үзэх санал дэвшүүлж байна. Дэвшүүлсэн саналаа батлахын тулд Зураг 2.26, 2.27, 2.28, 2.29-д нийслэлийн нэг шүүгчид ногдох шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг ба зөрчлийн хэрэг, иргэний хэрэг ба эрүүгийн хэргийн тооны харьцааг 2017-2021 оны байдлаар дүүрэг тус бүрээр харуулъя.




Зураг 2.26. Төвийн 6 дүүргийн нэг шүүгчид ногдох шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг ба зөрчлийн хэргийн тооны харьцаа



Зураг 2.27. 2018-2021 оны дунджаар төвийн 6 дүүргийн нэг шүүгчид ногдох шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг ба зөрчлийн хэргийн тооны харьцаа



Зураг 2.28. Төвийн 6 дүүргийн нэг шүүгчид ногдох шийдвэрлэсэн иргэний хэрэг ба эрүүгийн хэргийн тооны харьцаа



Зураг 2.29. 2017-2021 оны дунджаар төвийн 6 дүүргийн нэг шүүгчид ногдох шийдвэрлэсэн иргэний хэрэг ба эрүүгийн хэргийн тооны харьцаа

Зураг 2.26, 2.27, 2.28, 2.29-н үр дүнг дундажлан харуулбал 10.2 ба 2.4 болох тул програмын үр дүнгийн харьцааг зөв гэж үзэж болно. Иймд дараагийн судалгаанд эрүү, зөрчил ба иргэний хэргийг хамт шийдвэрлэдэг нийслэлийн захын 3 дүүрэг, аймаг дахь сум дундын 21 шүүх, сум дахь 8 анхан шатны болон аймгийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн ажлын ачаалал тооцоход **1 эрүүгийн хэрэг=10.2 зөрчлийн хэрэг, 1 эрүүгийн хэрэг=2.4 иргэний хэрэг** гэсэн зарчмыг баримтална.

Хэргийн төрөл	Анхан шатны шүүх	
	Захын дүүрэг	Динамик
Эрүү	44	×
Зөрчил	58	×
Эрүүгийн хэрэгт шилжүүлсэн дүн	43.91+57.81:10=50	-

Хүснэгт 2.41. Нийслэлийн захын дүүргийн нэг шүүгчид ногдох шийдвэрлэсэн дундаж хэргийн тоо

Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд захын дүүргийн нэг шүүгч нэг жилд 50 хэрэг (эрүүгийн хэрэг, зөрчил) шийдвэрлэсэн байна. Анхан шатны шүүхийн шүүгчийн ажлын ачаалал, нийслэл ба улсын хэмжээнд:

Хэргийн төрөл	Анхан шат			
	Дүүрэг	Дундаж	Эрүүгийн хэргийн тоонд шилжүүлсэн дүн	Нийслэлийн дундаж
Эрүү	Төв	136	136	93
	Зах	44	44+58:10.2=50	
Зөрчил	Төв	1390	1390:10.2=136	-
	Зах	58	-	-
Иргэн	Төв	326	234:2.4=98	234
	Зах	142	142:2.4=59	
Нийслэл захиргаа		54	-	-

Хүснэгт 2.42. Нэг шүүгчид ногдох шийдвэрлэсэн дундаж хэргийн тоо, нийслэлийн дүнгээр

Нийслэлийн хэмжээнд ДЭХАШШ-ны 9 шүүх, ДИХАШШ-ны 9 шүүх, ЗХАШШ-ны 1 шүүх ажиллаж байгаа бөгөөд эдгээр шүүхийн шүүгчид нь иргэн, захиргааны хэргийг дагнан шийдвэрлэдэг бол эрүү болон зөрчлийн хэргийг шийдвэрлэх шүүгч төвийн болон захын дүүрэгт хэрэг хуваарилах журам харилцан адилгүй байгаатай холбоотойгоор зарим дүүрэгт дагнасан, заримд нь дагнаагүй байна. Иймд энэ онцлогтой холбоотойгоор дундаж хэмжээг тооцохдоо дүүргүүдийг төв болон зах гэж бүлэглэн тус тусад нь тооцож, нийслэлийн дунджийг 9 дүүргийн хэмжээнд тооцов.

Эрүү болон зөрчлийн хэрэг: Төвийн дүүрэг нь захын дүүргээсээ хэргийн төрөл үл хамааран өндөр дүнтэй ачаалал их байсан нь харагдаж байна. Тухайлбал, төвийн дүүрэг нь захын дүүргээс эрүүгийн хэрэг 3 дахин, зөрчлийн хэрэг 24 дахин, иргэний хэрэг 2 дахин ачаалалтай байжээ. Тэгвэл төвийн ДЭХАШШ-н нэг шүүгч 1 жилд 136 эрүүгийн хэрэг шийдвэрлэсэн байхад захын дүүргийн мөн шүүгч эрүү болон зөрчлийн хэргийг шийдвэрлэсэн дүнг эрүүгийн хэрэгт шилжүүлсэн нэг шүүх дүнгээр эрүүгийн 50 хэрэг шийдвэрлэсэн байна. Төвийн ДЭХАШШ-н зөрчил дагнан шийдвэрлэдэг нэг шүүгч нэг жилд зөрчлийн 136 хэргийг шийдвэрлэсэн байхад захын дүүргийн нэг шүүгч зөрчлийн 58 хэрэг шийдвэрлэжээ.

Иргэний хэрэг: ДИХАШШ-н шүүгчийн хувьд төвийн дүүргийн нэг шүүгч нэг жилд эрүүгийн хэрэгт шилжүүлсэн дүнгээр 97 эрүүгийн хэрэг, захын дүүргийн нэг шүүгч шилжүүлсэн дүнгээр 59 эрүүгийн хэрэг шийдвэрлэсэн байна.

Захиргааны хэрэг: Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн нэг шүүгч нэг жилд шийдвэрлэсэн захиргаа (захиргаа мөн зөрчлийн хэрэг)-ны хэрэг 54 байгаа нь орон нутгийн ЗХАШШ-н шүүгчийнхээс 4 дахин өндөр дүнтэй байна.

Дээр дурдсан хэргийн төрлөөр хянан шийдвэрлэсэн дүнг сүүлийн 5 жилийн динамикийн хувьд нэг шүүгч нэг жилд шийдвэрлэсэн хэргийн дүн гэж ойлгоно.

Анхан шатны шүүхийн шүүгчийн шийдвэрлэсэн хэргийн ачаалал, улсын хэмжээнд:

Шүүх	Анхан шат		
	Хэргийн төрөл	Дундаж	Эрүүгийн хэргийн тоонд шилжүүлсэн дүн
Нийслэл, дүүргийн шүүхийн дундаж	Эрүү	93	93
	Зөрчил	948	948:10.2=93
	Иргэн	234	234:2.4=98
	Захиргаа	54	-
	Эрүү	79	79+143:10.2=93
	Зөрчил	143	

Аймгийн дахь анхан шатны шүүхийн дундаж	Иргэн	267	267:2.4=111
	Захиргаа	13	–
Сум дундын шүүхийн дундаж	Эрүү	28	28+71:10.2+105:2.4=79
	Зөрчил	71	
	Иргэн	105	
Улсын дундаж	Эрүү	89	89
	Иргэн	250	104
	Захиргаа	34	–

Хүснэгт 2.43. Нэг шүүгчид ногдох шийдвэрлэсэн дундаж хэргийн тоо, улсын дүнгээр

Хүснэгтээр харуулсан анхан шатны шүүхийн шүүгчийн шийдвэрлэсэн хэргийн ачаалал нь сүүлийн 5 жилийн динамикийн хувьд тооцогдсон бөгөөд нэг шүүгчид нэг жилд ногдох дундаж гэж ойлгоно.

Нийслэл, дүүргийн шүүхийн шүүгч: эрүүгийн хэргийн шүүгч 93 хэрэг, зөрчлийн хэргийг дагнан шийдвэрлэж байгаа шүүгч 948 хэрэг, иргэний хэргийн шүүгч 234, захиргаа (захиргаа, зөрчил)-ны хэргийн шүүгч 54 хэргийг тус тус шийдвэрлэснээс эрүүгийн хэргийн тоонд шилжсэн дүнгээр иргэний хэрэг 98 буюу шилжүүлсэн дүнгээр эрүүгийн 5 хэргээр илүү байна.

Аймаг дахь анхан шатны шүүхийн шүүгч: Энэ шүүхийн эрүүгийн хэргийн шүүгчийн ачаалал дүүргийн шүүхийн шүүгчийн ачаалалтай тэнцүү байна. Харин иргэний хэргийн шүүхийн шүүгчийн ачаалал нь шилжсэн дүнгээрээ эрүүгийн 18 хэргээр илүү байна. Захиргааны хэргийн шүүгч захиргааны 13 хэрэг шийдвэрлэсэн байна.

Сум дундын шүүхийн шүүгч: Эрүү, зөрчил, иргэний хэргийг тус тус шийдвэрлэдэг тул шилжсэн дүнгээрээ эрүүгийн 79 хэрэг шийдвэрлэсэн нь дүүрэг болон аймаг дахь ЭХАШШ-н шүүгчийн ачааллаас 14 хэргээр бага дүнтэй байна.

2.3.2. Давж заалдах шатны шүүхэд хянан шийдвэрлэсэн хэргийн ачаалал

19 аймгийн хувьд эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүхэд ажиллаж байгаа нэг шүүгч хүснэгтээр харуулсан 3 төрлийн хэргийг шийдвэрлэдэг бол 2 аймгийн хувьд дагнасан шүүхтэй учраас эдгээр шүүхийн шүүгчид иргэн болон эрүүгийн хэргийг дагнан шийдвэрлэдэг онцлогоосоо шалтгаалан дараах хэлбэрээр ачаалал нь тооцогдлоо.

Хэргийн төрөл	Давж заалдах шат						
	Бүс	Бүсийн дундаж	Шийдвэрлэсэн хэргийн дундаж	Эрүүгийн хэргийн тоонд шилжүүлсэн дүн	Динамик		
Эрүү	Баруун	11	15	15+0.4+5=20	•		
	Зүүн	13					
	Төв	17					
	Хангай	18					
	Дархан-Уул	24				25	25+0.6=26
	Орхон	26					
Зөрчил	Төв	3	4	3.87:10.2=0.38	•		
	Зүүн	3					
	Хангай	4					
	Баруун	4					
	Орхон	5				6	6:10.2=0.6
	Дархан-Уул	7					
Иргэн	Зүүн	9	12	12:2.4=5	×		
	Хангай	10					
	Төв	11					
	Баруун	18					

Дархан-Уул	39	46	46:2.4=19
Орхон	54		

Хүснэгт 2.44. Нэг шүүгчид ногдох шийдвэрлэсэн дундаж хэргийн тоо, аймгийн дүнгээр

Үүнд: • - нөлөөлөлтэй, × - нөлөөлөлгүй, — - тооцоо хийгдэхгүй

Эрүүгийн хэрэгт шилжүүлсэн дүнгээр: Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд иргэний хэрэгт нөлөөлөлгүй, эрүүгийн хэрэгт өсөөд буурах хандлагатай байгаа нь ковидоос шалтгаалсан байж болох юм. Орхон, Дархан-Уул аймаг дахь ДЗШШ-н нэг шүүгч нэг жилд 20 хэрэг шийдвэрлэсэн бол бусад 19 аймаг дахь давж заалдах шатны шүүхийн нэг шүүгч нэг жилд 26 хэрэг шийдвэрлэсэн байна. Шилжүүлсэн дүнгээс харвал давж заалдах шатны шүүхэд эрүүгийн хэрэг иргэний хэргээсээ илүү дүнтэй хянагдаж байна.

Улсын хэмжээнд захиргааны хэргийн давж заалдах шатны 1 шүүх байдаг бөгөөд Нийслэлийн захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн “хянасан бүгд” үзүүлэлтийн хүрээнд тооцсон ачааллыг харуулбал:

Хянасан бүгд	Давж заалдах шатны шүүх		
	Дундаж	Нэг шүүх дүн	Динамик
Нийслэлээс хянагдсан хэрэг	64	96	×
Шүүхийн Ёс зүйн хороо	2		
Мэргэжлийн хариуцлагын хороо	1		
Анхан шатны журмаар	2		
Аймгаас хянагдсан хэрэг	27		

Хүснэгт 2.45. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн нэг шүүгчид ногдох хянасан бүгд, хэргийн төрлөөр

Давж заалдах шатны шүүхэд хянагдаж байгаа хэргийн төрлийг харвал нийслэлээс болон аймгаас хянагдсан захиргаа (захиргааны болон зөрчлийн)-ны хэрэг хамгийн өндөр дүнг эзэлж байна. Үүнд хэргээс гадна захирамж, тогтоол хянах ажиллагаа багтсан дүн юм. Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд ЗХДЗШШ-ийн нэг шүүгч нэг жилд 96 хэрэг (захирамж, тогтоол, бусад) хянасан байна. Нэг шүүгч нэг жилд ёс зүйн хорооны 2, мэргэжлийн хариуцлагын хорооны 1 хэрэг тус тус шийдвэрлэсэн байна.

Хянасан бүгд ⁴	Давж заалдах шатны шүүх		
	Дундаж	Нэг шүүх дүн	Динамик
Анхан шатны шүүхийн шийдвэртэй хэргийг хянасан	62	96	×
Бусад хянасан	34		

Хүснэгт 2.46. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн нэг шүүгчид ногдох хянасан бүгд

Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд ЗХДЗШШ-н нэг шүүгчид нэг жилд анхан шатны шүүхийн шийдвэртэй 62 хэрэг, бусад хянасан хэрэг, материал 34, нэг шүүх 96 хэрэг, материал ногдож байгаа нь захиргааны хэргийн шүүх ачааллын хувьд өндөр байгааг мөн энэ шүүх улсын хэмжээнд ганц байдаг учраас аймгийн болон нийслэл дэх АШШ-с хянуулахаар ирсэн хэрэг, материалын тоо өндөр байгааг дээрх хүснэгтээс харж болохоор байна.

Анхан шатны шүүхийн шийдвэрийг хянасан захиргааны хэрэг, бүгд	Дундаж	Нэг шүүх дүн
Нийслэлээс хянагдсан хэрэг	41	62
Шүүхийн Ёс зүйн хороо	2	

⁴ Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн бүтэн жилийн тайлан, мэдээллийн “Хянасан бүгд” үзүүлэлтийн дүн болно. Тус шүүх нь өөрийн өвөрмөц онцлог бүхий хянан шийдвэрлэх процесс ажиллагааг хэрэгжүүлдгийн нэг хэлбэр нь захирамж, тогтоол хянах ажиллагаа байна. Энэ ажиллагаа нь ижил шатны эрүү, иргэний хэргийн шүүхэд байдаггүй бөгөөд өөрийнх нь практикт ийнхүү хянуулах тохиолдол өндөр байна.

Мэргэжлийн хариуцлагын хороо	1
Анхан шатны журмаар	2
Аймгаас хянагдсан хэрэг	16

Хүснэгт 2.47. Захиргааны хэргийн давж заалдах шатны нэг шүүгчид ногдох анхан шатны шүүхийн шийдвэрийг хянасан хэргийн тоо

Анхан шатны шүүхийн шийдвэрийг хянасан захиргааны хэрэг, бүгд	Динамик				
	2017	2018	2019	2020	2021
	93	66	57	53	64

Хүснэгт 2.48. Захиргааны хэргийн давж заалдах шатны нэг шүүгчид ногдох анхан шатны шүүхийн шийдвэрийг хянасан хэргийн тоо, динамикаар

ДЗШШ-д Анхан шатны шүүхийн шийдвэртэй Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэртэй 41 хэрэг хянагдсан нь ижил шатны аймаг дахь ЗХАШШ-н дүнгээс 2.6 дахин их байна.

Шүүх	Хэргийн төрөл	Давж заалдах шат	
		Дундаж	Эрүүгийн хэргийн тоонд шилжүүлсэн дүн
Нийслэлийн шүүхийн дундаж	Эрүү	69	69+11:10.2=70
	Зөрчил	11	
	Иргэн	160	160.3:2.4=67
	Захиргаа	62	–
Аймгийн шүүхийн дундаж	Эрүү	15	15+0.4+5=20
	Зөрчил	4	
	Иргэн	12	
Орхон, Дархан-Уул	Эрүү	25	25+0.6=26
	Зөрчил	6	
	Иргэн	46	46:2.4=19
Улсын дундаж	Эрүү	39	39
	Иргэн	103	43
	Захиргаа	62	–

Хүснэгт 2.49. Нэг шүүгчид ногдох шийдвэрлэсэн дундаж хэргийн тоо, улсын дүнгээр

Сүүлийн 5 жилийн хувьд давж заалдах шатны шүүхэд ажиллаж байгаа нэг шүүгч нэг жилд ногдох ачааллыг дэлгэрэнгүй тайлбалъя.

Нийслэлийн шүүхийн шүүгч: эрүүгийн 69, зөрчлийн 11, иргэний 160, захиргааны 62 хэргийг шийдвэрлэсэн байна. Бусад хэргийг эрүүгийн хэрэгт шилжүүлсэн дүнгээр эрүүгийн хэргийн шүүгч нэг шүүх 70 эрүүгийн хэрэг, иргэний хэргийн шүүгч 67 эрүүгийн хэргийг шийдвэрлэсэн ачаалалтай байна. Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд эрүүгийн болон иргэний хэргийн ДЗШШ-н шүүгчдийн шийдвэрлэсэн хэргийн дүнгээс харвал эрүүгийн хэргийн нэг шүүгч нэг жилд иргэний хэргийн шүүгчээс шийдвэрлэсэн 3 хэргээр илүү ачаалалтай байжээ. Захиргааны хэргийн нэг шүүгч нэг жилд захиргааны 62 хэргийн ачаалалтай байна.

Аймгийн шүүхийн шүүгч: Эдгээр шүүгч нь 3-н төрлийн хэргийг хамт шийдвэрлэдэг тул ачааллыг хэргийн нэг нэгж рүү шилжүүлэн тооцоход сүүлийн 5 жилийн динамикийн хувьд нэг шүүх 20 эрүүгийн хэрэг шийдвэрлэсэн байна. Энэ нь нийслэлийн шүүхийн шүүгчийн ачааллаас 3.5 дахин бага ачаалалтай байгааг харуулж байна.

Орхон, Дархан-Уул аймаг дахь шүүхийн шүүгчид: шилжүүлсэн дүнгээр энэ аймгууд дахь ЭХДЗШШ-н нэг шүүгч нэг жилд эрүүгийн 26 хэрэг шийдвэрлэсэн бол бусад 19 аймаг дахь давж заалдах шатны шүүхийн нэг шүүгч нэг жилд эрүүгийн 20 хэрэг шийдвэрлэсэн байна. Шилжүүлсэн дүнгээр энэхүү 2 аймаг дахь ачаалал бусад 19 аймаг дахь давж заалдах шатны шүүхийн нэг шүүгчийнхээс 1.7 дахин их байгаа хэдий ч нийслэлийн шүүхийн

шүүгчдийнхээс эрүүгийн хэрэг нь 2.7 дахин, иргэний хэрэг нь 3.5 дахин бага ачаалалтай байжээ.

Улсын дундаж: Нийслэлийн болон 19 аймгийн (дагнаагүй), 2 аймгийн (дагнасан) нэг шүүх давж заалдах шатны шүүхэд ажиллаж байгаа нэг шүүгч нэг жилд эрүүгийн 39, иргэний 43, захиргааны 62 хэргийн ачаалалтай байна. Энэ ачаалал нь сүүлийн 5 жилийн динамикийн хувьд нэг шүүгч нэг жилд авч байгаа бодит ачаалал юм. Энэ ачааллыг бодит дундаж гэж нэрлэвэл бодит дунджаас нийслэлийн шүүхийн эрүүгийн хэргийн шүүгч 1.8 дахин, иргэний хэргийн шүүгч 1.6 дахин их ачаалалтай байгаа бол 21 аймаг дахь шүүхийн шүүгчид бодит дунджид хүрэхээр ачаалал аваагүй байна.

2.4. АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН АЖИЛЛАГААНЫ АЧААЛЛЫН ШИНЖИЛГЭЭ

2.4.1. Дүүрэг, Нийслэлийн шүүх

А. Эрүүгийн хэргийн ажиллагаа

Мэдээллийн технологи, хэргийн хөдөлгөөний удирдлагын хэлтсийн Нэгдсэн системүүдээс гаргаж ирүүлсэн “Ажиллагааны ачааллын” үзүүлэлтийг ашиглан, дүүрэг, нийслэл, аймаг, сум дундын шүүхийн нэг шүүгчид ногдох ажиллагааны ачаалалд бүс, динамикийн нөлөөлөл байгаа эсэхэд шинжилгээ хийлээ. Шүүхийн хэргийн төрөл тус бүрээр хийсэн ажлын төрөл, хэмжээний өгөгдөлд өмнөх дэд бүлгийн тайлбарт дурдагдсан 2 хүчин зүйлийг дисперсийн шинжилгээ хийсэн үр дүнг хүснэгтээр харуулсан. Эрүүгийн хэргийн ажиллагаанд багтсан шийтгэвэр гэх ажиллагаа нь бүхэлдээ зөрчлийн хэрэгтэй хамаатай бөгөөд зөрчлийн хэрэгт тусдаа ажиллагааны ачааллын өгөгдлийг гаргаж өгөөгүй тул шийтгэвэрийн дүн эрүүгийн хэргийн ажиллагаанд хамт шинжлэгдсэн.

Дүүргийн нөлөөлөл: Шинжилгээ хийгдсэн 9 төрлийн ажиллагаанаас мэдэгдэх хуудас, албан бичиг гэх ажиллагааны дүн хоосон ирсэн байна. Иймд 7 төрлийн ажиллагаанд шинжилгээг хийхэд баримт гэсэн ажиллагаанаас бусад ажиллагаанд дүүргийн нөлөөлөл байсан. Энэ нь нэг шүүгчид ногдох ажиллагааны ачаалал нь төвийн ба захын дүүргийн хувьд ялгаатай ажиллагааны ачаалалтай авсныг харуулж байна. Тухайлбал, шийтгэх тогтоол нь захын дүүрэгт хамгийн бага буюу 32.5 байхад төвийн дүүрэгт хамгийн их буюу 104 ширхэг байна.

Динамикийн нөлөөлөл: Шийтгэх тогтоол, баримт гэсэн ажиллагаанаас бусад ажиллагаанд динамикийн нөлөөлөл байсан байна. Энэ нь дүүргийн шүүхүүдийн эрүүгийн хэргийн ажиллагааны ачаалалд хууль эрх зүйн ямар нэгэн өөрчлөлт нөлөөлсөн эсвэл Ковид-19-н болон нэгдсэн системийн бүртгэлийг хөтөлж буй шүүхийн захиргааны үйл ажиллагааны нөлөөлөлтэй холбоотой байх талтай юм. Гэх мэтчилэн бусад ажиллагааны хувьд динамикийн нөлөөллийг энд өгсөн тайлбартай адил утгаар ойлгоно.

Дундаж: ДЭХАШШ-н 5 жилийн динамикийн хувьд нэг шүүгчид оногдох шийтгэх тогтоолын хувьд 68 материал, шүүгчийн захирамжийн хувьд 292.5 материал байна.

Эрүүгийн хэргийн ажиллагааны ачаалалд холбогдуулан ШЕЗ-с өгсөн ажиллагааны хугацаа, эзлэх хувь хэмжээ, ажлын өдрийн мэдээллийг үндэслэн аймгийн ДЭХАШШ-д ажиллаж байгаа нэг шүүгчид ногдох ажиллагааны тоо, эзлэх хувь, зарцуулсан хугацаа⁵, өдрийн талаарх мэдээлэлд шинжилгээ хийж, үр дүнг дараах хүснэгтээр харуулав.

№	Ажлын төрлүүд	Дүүрэг	Ажиллагааны тоогоор	Ачаалал тооцоход эзлэх хувиар	Судалгааны үр дүнгийн минутаар	Ажлын өдрөөр
1	Шийтгэх тогтоол	Зах	32.5	16.2	9740.9	0.1

⁵ ШЕЗ-н захиалгаар гүйцэтгэсэн 2018 оны ачааллын судалгааны дүнг баримтлав.

		Төв	103.6	51.8	31089.4	0.4
	Дундаж		68.05	34.0	20415.1	0.3
2	Шүүгчийн захирамж	Зах	189.4	18.9	34095	0.8
		Төв	395.5	39.5	71201.9	1.7
	Дундаж		292.5	29.2	52648.5	1.3
3	Шүүхийн тогтоол	Зах	4.4	0.4	799.1	0.01
		Төв	14.4	1.4	2606.16	0.06
	Дундаж		9.5	0.9	1702.6	0.04
4	Мэдэгдэх хуудас	-	-	-	-	-
5	Албан бичиг	-	-	-	-	-
6	Шийтгэвэр	Зах	44.5	4.4	8023.6	0.2
		Төв	122.7	12.1	21801.8	0.5
	Дундаж		83.6	8.3	14912.7	0.4
7	Гүйцэдгэх хуудас	Зах	33.7	1.6	-	0.1
		Төв	78.6	3.9	-	0.3
	Дундаж		134.7	2.8	-	0.25
8	Баримт	×	×	×	×	0.6
9	Урьдчилсан хэлэлцүүлэг	Зах	6.15	0.3	369.1	0.02
		Төв	15.1	0.7	909.5	0.06
	Дундаж		10.6	0.5	639.3	0.04
	Ажиллагааны ачаалал	Зах	310.65	41.8	53027.7	1.23
		Төв	729.9	109.4	127608.76	3.02
	Дундаж		598.95	75.7	90318.2	2.33

Хүснэгт 2.50. Дүүргийн эрүүгийн хэргийн 1 шүүгчид ногдох ажиллагааны ачаалал, бусад хэмжээсээр

Ажиллагааны нэг шүүх ачаалалд хамаарах мэдээллийг дэлгэрэнгүй хэлбэрээр тайлбарля.

Ачаалал тооцоход эзлэх хувиар: ДЭХАШШ-н 5 жилийн мэдээллээр нэг шүүгч жилд дунджаар хийсэн ажлыг 100 хувь гэж үзвэл, захын дүүрэг хамгийн бага буюу 42, төвийн дүүрэг хамгийн их буюу 109 хувийг эзэлж байгаа бол нэг шүүх 9 дүүргийн дундаж нь 76 хувийг эзэлж байна. Энэ нь ДЭХАШШ-н 1 шүүгчийн хийх ажил 75⁶ хувь байгаагаас шийтгэх тогтоол 34 хувийг, шүүгчийн захирамж 29 хувийг гэх мэтээр ажиллагаа бүрийн эзлэх хувь тооцогдсон гэж ойлгоно.

Судалгааны үр дүнгийн минутаар: ДЭХАШШ-н 5 жилийн динамикийн хувьд нэг шүүгч жилд дунджаар хийсэн ажиллагаанд зарцуулсан хугацааг үзвэл захын дүүрэг хамгийн бага буюу 53027 минут, төвийн дүүрэг хамгийн их буюу 127609 минут байгаа бол нэг шүүх 9 дүүргийн дундаж нь 90318 минут байна. Энэ нь ДЭХАШШ-н 1 шүүгч нэг жилд шийтгэх тогтоол, шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол, шийтгэвэр, урьдчилсан хэлэлцүүлэг гэх ажиллагаандаа дунджаар 90318 минут буюу 1505 цаг зарцуулсан байна.

Ажлын өдрөөр: ДЭХАШШ-н 5 жилийн динамикийн хувьд нэг шүүгч жилд дунджаар хийсэн ажиллагаанд зарцуулсан ажлын өдрийг үзвэл захын дүүрэг хамгийн бага буюу 1 өдөр, төвийн дүүрэг хамгийн их буюу 3 өдрийг зарцуулж бол нэг шүүх 9 дүүргийн дундаж нь 2 өдөр байна. Энэ нь ДЭХАШШ-н 1 шүүгч 1 материал (цаасан хэлбэрээр) боловсруулахад захын дүүрэгт ажлын 1 өдөр, төвийн дүүрэгт ажлын 3 өдөр, дүүргийн дунджаар ажлын 2 өдөр зарцуулсан гэж ойлгоно.

Энэ мэтчилэн доор хүснэгтээр харуулсан иргэн, захиргааны хэргийн ажиллагааны үр дүн зарчмын хувьд ижил байсан байна. тайлбарлагдана.

⁶ 100 хувиас биш 75 хувиас энэ тооцоолол дүгнэгдэж байгаа нь шүүгчийн зарим ажиллагааны өгөгдөл шинжилгээнд ирээгүй, зарим ажиллагааны элзэх хувийн мэдээлэл дутуу байгаагаар холбоотой.

Үүнээс гадна ямар нэгэн өсөлт бууралтын хандлага байхгүй тул иргэний хэрэгт хамаарах иргэний тоо өөрчлөлтгүй, тогтмол гэсэн утгыг мөн илтгэнэ. Гэх мэтчилэн иргэний хэргийн хуулийн этгээдийн тооны тухай үр дүнг энд өгсөн тайлбартай адил утгаар ойлгоно.

Б. Иргэний хэргийн ажиллагаа

№	Ажлын төрлүүд	Бүс	Ажиллагааны тоогоор	Ачаалал тооцоход эзлэх хувиар	Судалгааны үр дүнгийн минутаар	Ажлын өдрөөр
1	Шийдвэр	Зах	140	70	27302.7	0.6
		Төв	297.8	148.9	58082.8	1.3
	Дундаж		218.9	109.4	42692.8	1.0
2	Шүүгчийн захирамж	Зах	452.4	45.2	42984.8	2
		Төв	1267.3	126.7	120396	5.7
	Дундаж		859.8	85.9	81690.3	3.8
3	Шүүхийн тогтоол	Зах	5.3	0.5	505.6	0.02
		Төв	34.2	3.4	3250.8	0.1
	Дундаж		19.7	1.9	1878.2	0.08
4	Шийтгэвэр	-	×	×	×	×
			0.6	0.01	61	0.002
5	Гүйцэдгэх хуудас	Зах	82.8	2.07	-	0.3
		Төв	106.9	2.6	-	0.4
	Дундаж		94.9	2.3	-	0.4
6	Мэдэгдэх хуудас	Төв	64.9	2.6	-	0.3
		Зах	86.9	1.9	-	0.3
	Дундаж		75.9	2.3	-	0.3
7	Баримт	Зах	842.08	168.4	-	3.7
		Төв	1097.2	219.4	-	4.9
	Дундаж		969.6	193.9	-	4.3
8	Албан бичиг	Зах	38.3	0.7	-	0.2
		Төв	167.2	3.3	-	0.7
	Дундаж		102.8	2.05	-	0.4
	Ажлын ачаалал	Зах	1648.5	289.47	70793.1	7.4
		Төв	3036.5	506.2	181729.6	13.6
	Дундаж		2342.5	397.8	126261.35	10.5

Хүснэгт 2.51. Дүүргийн иргэний хэргийн 1 шүүгчид ногдох ажиллагааны ачаалал, бусад хэмжээсээр

2.4.2. Аймгийн шүүх

2.4.1-д тайлбарласан дүүрэг, нийслэлийн шүүхийн эрүүгийн хэргийн ажиллагаанд дэлгэрэнгүй тайлбарласан тайлбартай танилцаж доорх хүснэгтийн утгыг олгоно уу.

А. Эрүүгийн хэргийн ажиллагаа

№	Ажлын төрлүүд	Бүс	Ажиллагааны тоогоор	Ачаалал тооцоход эзлэх хувиар	Судалгааны үр дүнгийн минутаар	Ажлын өдрөөр
1	Шийтгэх тогтоол	Баруун	51.04	25.5	15311	0.22
		Зүүн	86.73	43.3	26020.3	0.39
		Хангай	90.61	45.3	27184.2	0.40
		Төв	95.75	47.8	28723.7	0.43
	Дундаж		81.03	40.5	24309.8	0.36
	Шүүгчийн захирамж	Баруун	269.93	26.9	48588	1.21

2		Зүүн	385.56	38.5	69400.8	1.73
		Хангай	430.08	43.0	77415	1.93
		Төв	674.71	67.4	121448	3.03
	Дундаж		440.07	44.0	79213	1.98
3	Шүүхийн тогтоол	Баруун	3.64	0.36	655.8	0.01
		Зүүн	6.93	0.69	1248	0.03
		Хангай	9.17	0.91	1651.5	0.04
		Төв	12.34	1.23	2221	0.05
	Дундаж		8.02	0.80	1444.09	0.03
4	Мэдэгдэх хуудас	-	-	-	-	-
5	Албан бичиг	-	-	-	-	-
6	Шийтгэвэр	Баруун	92.8	9.28	16705.2	0.41
		Зүүн	108.6	10.86	19553.1	0.48
		Хангай	123.8	12.38	22287.8	0.55
		Төв	190.7	19.07	34340.5	0.85
	Дундаж		129	12.90	23221.7	0.58
7	Гүйцэдгэх хуудас	Баруун	67.4	3.37	-	0.30
		Зүүн	109.1	5.45	-	0.49
		Хангай	118.4	5.92	-	0.53
		Төв	125.9	6.29	-	0.56
	Дундаж		105.2	5.26	-22.49*100	0.47
8	Баримт	Баруун	0.99	-	-	0.99
		Зүүн	0.84			0.85
		Хангай	1.5			1.46
		Төв	3.1			3.07
			1.61			1.59
9	Урьдчилсан хэлэлцүүлэг	Баруун	6.9	0.3	414	0.031
		Зүүн	8.5	0.4	514.4	0.038
		Хангай	12.05	0.5	723.3	0.05
		Төв	13.7	0.6	825.08	0.06
	Дундаж		10.3	0.5	619.2	0.05
Ажиллагааны ачаалал	Баруун	712.4	65.75%	81674	3.20	
	Зүүн	954.04	108.6%	128168.4	4.75	
	Хангай	1055.09	101.26%	50070.5	8.05	
	Төв	1787.9	139.99%	185917	4.29	
	Дундаж		1127.4	103.9%	128807.79	5.07

Хүснэгт 2.52. Аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн 1 шүүгчид ногдох ажиллагааны ачаалал, бусад хэмжээсээр

Б. Иргэний хэргийн ажиллагаа

№	Ажлын төрлүүд	Бүс	Ажиллагааны тоогоор	Ачаалал тооцоход эзлэх хувиар	Судалгааны үр дүнгийн минутаар	Ажлын өдрөөр
1	Шийдвэр	Төв	215.8	154.2%	42081.1	1.25
		Баруун	249.2	139.1%	48610.1	1.13
		Зүүн	278.2	124.6%	54264.9	1.01
		Хангай	308.5	154.3%	60175.5	0.88
	Дундаж		263	131.5%	51282.9	1.06
2	Шүүгчийн захирамж	Төв	763.2	113.29%	72507.4	4.60
		Зүүн	809.9	85.44%	76936.8	3.47
		Баруун	854.4	80.98%	81172.2	3.28
		Хангай	1133	76.32%	107630	3.10

	Дундаж		890.1	89.01%	84561.7	3.62
3	Шүүхийн тогтоол	Зүүн	6.07	1.37%	576.941	0.05
		Төв	11.1	1.12%	1056.4	0.04
		Баруун	11.3	1.11%	1071.9	0.04
		Хангай	13.7	0.61%	1305.24	0.02
	Дундаж		10.6	1.05%	1002.63	0.04
4	Шийтгэвэр	-	×	×	×	×
	Дундаж		0.19	0.004%	17.63	0.007
5	Гүйцэдгэх хуудас	Төв	114.1	41.18%	-	0.83
		Баруун	148.1	29.83%	-	0.60
		Зүүн	149.2	29.61%	-	0.60
		Хангай	206	22.82%	-	0.46
	Дундаж		154.3	30.86%	-	0.62
6	Мэдэгдэх хуудас	Хангай	121.4	8.04%	-	1.30
		Төв	122.2	5.31%	-	0.86
		Баруун	212.7	3.05%	-	0.49
		Зүүн	321.8	3.03%	-	0.49
	Дундаж		194.5	4.86%	-	0.78
7	Баримт	Төв	890	41.9%	-	5.67
		Баруун	1303.8	40.3%	-	5.46
		Зүүн	1344.8	39.1%	-	5.29
		Хангай	1398	26.6%	-	3.61
	Дундаж		1234	37.02%	-	5.01
8	Албан бичиг	-	×	×	-	×
	Дундаж		76.9	1.53%	-	0.31
	Ажиллагааны ачаалал	Төв	2116.4	357%	115644.9	8.58
		Баруун	2779.5	294.4%	130854.2	11.27
		Зүүн	2909.97	283.15%	131778.641	11.79
		Хангай	3180.6	288.69%	169110.74	12.89
	Дундаж		2823.59	305.81%	136864.86	11.44

Хүснэгт 2.53. Аймаг дахь сум дундын иргэн хэргийн 1 шүүгчид ногдох ажиллагааны ачаалал, бусад хэмжээсээр

В. Захиргааны хэргийн ажиллагаа

№	Ажлын төрлүүд	Бүс	Ажиллагааны тоогоор	Ачаалал тооцоход эзлэх хувиар	Судалгааны үр дүнгийн минутаар	Ажлын өдрөөр
1	Шийдвэр	Зүүн	11.03	2.76%	10368	0.045
		Төв	11.2	2.81%	10548	0.046
		Хангай	12.4	3.11%	11694	0.051
		Баруун	18.9	4.73%	17774	0.077
	Дундаж		13.4	3.35%	12596	0.054
2	Шүүгчийн захирамж	Зүүн	58.5	12.29%	43904	0.24
		Төв	66.5	13.97%	49882	0.27
		Хангай	89.3	18.76%	66986	0.36
		Баруун	112.4	23.61%	84331	0.46
	Дундаж		81.7	17.16%	61276	0.33
3	Шүүхийн тогтоол	-	×	×	×	×
	Дундаж		0.8	0.03%	585	0.003
4	Мэдэгдэх хуудас	-	×	×	×	×
	Дундаж		9.2	0.34%	-	0.04
5		Зүүн	24.6	3.93%	2581	0.20

	Албан бичиг	Төв	50.3	8.05%	5280	0.22
		Хангай	53.2	8.52%	5590	0.09
		Баруун	76.4	12.23%	8024	0.31
	Дундаж		51.3	8.18%	5369	0.21
6	Шийтгэвэр	-	×	×	×	×
	Дундаж		0.06	0.0002%	41	0.0002
7	Гүйцэдгэх хуудас	Төв	4.6	0.02%	-	0.019
		Хангай	6.5	0.03%	-	0.026
		Зүүн	7.9	0.04%	-	0.032
		Баруун	9.3	0.05%	-	0.038
	Дундаж		7.1	0.035%	-	0.029
8	Баримт	Төв	64.5	-	-	0.26
		Зүүн	70.1	-	-	0.28
		Баруун	72.3	-	-	0.29
		Хангай	111.7	-	-	0.45
	Дундаж		79.7	-	-	0.33
9	Үзлэг, нотлох баримт	Зүүн	10.1	2.53%	606	0.041
		Төв	17.7	4.43%	1063	0.072
		Хангай	19.4	4.85%	1165	0.079
		Баруун	37.5	9.38%	2252	0.152
	Дундаж		21.2	5.3%	1272	0.086
10	Урьдчилсан хэлэлцүүлэг		-	-	-	-
11	Тэмдэглэл	Төв	21.2	0.85%	1910	0.086
		Зүүн	23.6	0.94%	2121	0.096
		Хангай	33.9	1.36%	3052	0.138
		Баруун	43.3	1.73%	3898	0.176
	Дундаж		30.5	1.22%	2745	0.124
	Ажиллагааны нэг шүүх ачаалал	Зүүн	209.6	22.49%		0.85
		Төв	248.6	30.13%		1.01
		Хангай	336.9	36.63%		1.37
		Баруун	380.3	51.73%		1.54
	Дундаж		293.8	35.62%	83884	1.19

Хүснэгт 2.54. Аймаг дахь захиргааны хэргийн 1 шүүгчид ногдох ажиллагааны ачаалал, бусад хэмжээсээр

2.4.3. Сум дундын шүүх

2.4.1-д тайлбарласан дүүрэг, нийслэлийн шүүхийн эрүүгийн хэргийн ажиллагаанд дэлгэрэнгүй тайлбарласан тайлбартай танилцаж доорх хүснэгтийн утгыг олгоно уу.

А. Эрүүгийн хэргийн ажиллагаа

№	Ажлын төрлүүд	Бүс	Ажиллагааны тоогоор	Ачаалал тооцоход эзлэх хувиар	Судалгааны үр дүнгийн минутаар	Ажлын өдрөөр
1	Шийтгэх тогтоол	Баруун	11.5	5.7	3465	0.05
		Зүүн	17.9	8.9	5372	0.08
		Хангай	22.74	11.3	6822	0.10
		Төв	32.1	16.1	9654	0.14
	Дундаж		21.1	10.5	6328.2	0.09
2	Шүүгчийн захирамж	Баруун	71.4	7.1	12864	0.3
		Зүүн	113.2	11.3	20390.4	0.5
		Төв	155.4	15.5	27989.7	0.7
		Хангай	205.9	20.5	37067.4	0.9

	Дундаж		136.5	13.6	24577.9	0.6
3	Шүүхийн тогтоол	Баруун	0.7	0.07	139.5	0.003
		Хангай	1.5	0.15	271.8	0.006
		Зүүн	1.8	0.18	328.8	0.008
		Төв	4.2	0.42	760.65	0.019
	Дундаж		2.08	0.2	375.1	0.009
4	Мэдэгдэх хуудас	-	-	-	-	-
5	Албан бичиг	-	-	-	-	-
6	Шийтгэвэр	Баруун	30.3	3.0	5467.5	0.13
		Зүүн	33.3	3.3	5997.6	0.15
		Төв	38.1	3.8	6870	0.17
		Хангай	81.6	8.1	14704.2	0.36
	Дундаж		45.8	4.6	8259.8	0.20
7	Гүйцэдгэх хуудас	Баруун	12.5	0.6	-	0.05
		Зүүн	24.6	1.2	-	0.11
		Төв	30.2	1.5	-	0.13
		Хангай	50.3	2.5	-	0.22
	Дундаж		29.4	1.4	180.4	0.13
8	Баримт	Баруун	1.60	0.08	289.5	0.007
		Хангай	95.93	4.79	17267.4	0.43
		Төв	110.2	5.51	19842.2	0.49
		Зүүн	162.17	8.10	29191.2	0.73
	Дундаж		92.4	4.62	16647.6	0.41
9	Урьдчилсан хэлэлцүүлэг	-	×	×	×	×
	Ажиллагааны ачаалал	Баруун	128	16.55	22225.5	0.533
		Зүүн	352.9	32.98	61280	0.848
		Хангай	457.9	47.34	76132.8	1.586
		Төв	370.2	42.83	65116.55	1.159
	Дундаж		327.28	34.92	56188.7	1.029

Хүснэгт 2.55. Сум дундын шүүхийн 1 шүүгчид ногдох эрүүгийн хэргийн ажиллагааны ачаалал, бусад хэмжээсээр

Б. Иргэний хэргийн ажиллагаа

№	Ажлын төрлүүд	Бүс	Ажиллагааны тоогоор	Ачаалал тооцоход эзлэх хувиар	Судалгааны үр дүнгийн минутаар	Ажлын өдрөөр
1	Шийдвэр	-	×	×	×	×
	Дундаж		103.06	51.5	20090.7	0.46
2	Шүүгчийн захирамж	-	×	×	×	×
	Дундаж		379.6	38.1	36228.7	1.72
3	Шүүхийн тогтоол	-	×	×	×	×
	Дундаж		0.47	0.3	307.7	0.01
4	Шийтгэвэр	Төв	0.	0.	0.	0.
		Баруун	0.	0.	0.	0.
		Зүүн	0.3	0.008	31.6	0.001
		Хангай	0.5	0.01	52.2	0.002
	Дундаж		0.2	0.005	21	0.0009
5	Гүйцэдгэх хуудас	Баруун	26.9	0.7	-	0.1
		Төв	55.7	1.4	-	0.2
		Хангай	66.1	1.6	-	0.3
		Зүүн	87.5	2.2	-	0.4

	Дундаж		58.8	1.5	-	0.27
6	Мэдэгдэх хуудас	Баруун	99.7	2.4	-	0.3
		Төв	104.1	3.1	-	0.4
		Зүүн	136.5	4.1	-	0.6
		Хангай	187.1	5.6	-	0.8
	Дундаж		131.8	3.8	909.6	0.3
7	Баримт	Төв	433.4	86.7	-	1.9
		Баруун	457.5	90.9	-	2.
		Зүүн	527.3	105.4	-	2.3
		Хангай	802.7	160.5	-	3.6
	Дундаж		555.2	110.9	-	2.5
8	Албан бичиг	Хангай	7.4	0.1	-	0.03
		Баруун	9.5	0.2	-	0.046
		Зүүн	9.8	0.2	-	0.044
		Төв	10.6	0.2	-	0.047
	Дундаж		9.3	0.2	-	0.04
	Ажиллагааны ачаалал	Төв	1063.1	91.4	0	2.547
		Баруун	1063.8	94.2	0	2.446
		Зүүн	1179.5	111.9	31.6	3.345
		хангай	1659.9	167.81	52.2	4.732
	Дундаж		1241.6	206.23	57557.7	5.46

Хүснэгт 2.56. Сум дундын шүүхийн 1 шүүгчид ногдох иргэний хэргийн ажиллагааны ачаалал, бусад хэмжээсээр



ГУРАВДУГААР БҮЛЭГ. ШАЛГУУР 1, 3, 6, 14, 26, 34-Д ХАМААРАХ ӨГӨГДӨЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

ШАЛГУУР 1. Шүүн таслах ажиллагааны тайлан

ШАЛГУУР 3. Шүүхийн ачаалал

ШАЛГУУР 6. Шүүх бүрэлдэхүүнд оролцсон томилолтын зардал

ШАЛГУУР 26. Шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн ачаалал

ШАЛГУУР 34. Шүүгчийн цалингийн сан

Шалгуурт хамаарахгүй үзүүлэлт:

- Шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн хүн, иргэний хэргийн хариуцагч, захиргааны хэргийн нэхэмжлэгч, хариуцагч
- Үлдэгдэл хэрэг (эрүү, иргэн, захиргааны хэргийн анхан шатны шүүх)

3.1. ШҮҮХЭД ШИЙДВЭРЛЭСЭН ХЭРГИЙН ТОГТОЛЦООНЫ ШИНЖИЛГЭЭ

3.1.1. Анхан шатны шүүх

Гол хэсгийн шинжилгээг ШЕЗ-с гаргаж өгсөн өгөгдлүүд шүүхийн үйл ажиллагааны загварын хувьсагч болох эсэхийг тодорхойлох, ямар хувьсагчийн өгөгдөл бие биенээ дагах коллениар байгааг тайлбарлах, судалгааны ажлын түлхүүр хувьсагчийг илрүүлэх, судалгааг түлхүүр хувьсагчаар төлөөлүүлж тооцоог үргэлжлүүлэн хийж шүүхийн үйл ажиллагааг дүгнэх зорилгоор хийлээ. Хянан шийдвэрлэсэн хэргийн тоонд хийсэн гол хэсгийн шинжилгээний үр дүнг харуулъя.

Шүүх	Хувьсагч	Корреляцийн коэффициент (r_{y_1, x_k})	Ерөнхий дисперсийн өсөн нэмэгдэх хувь	Шийдвэрлэсэн хэргийн тогтолцооны загвар
Төвийн дүүрэг	Эрүү (x_1)	0.66	0.74	$y = 0.5x_1 + 9x_2 + 0.3x_3 + 0.07x_4$
	Зөрчил (x_2)	0.95		
	Иргэн (x_3)	0.60		
	Захиргаа (x_4)	0.64		
Захын дүүрэг	Эрүү (x_1)	0.45	0.74	$y = 0.1x_1 + 0.5x_2 + x_3$
	Зөрчил (x_2)	0.74		
	Иргэн (x_3)	0.96		
Аймаг	Эрүү (x_1)	0.99	0.88	$y = x_1 + 2x_2 + 2x_3 - 0.13x_4$
	Зөрчил (x_2)	0.69		
	Иргэн (x_3)	0.56		
	Захиргаа (x_4)	-0.84		
Сум дунд	Эрүү (x_1)	0.19	0.78	$y = 0.03 + 0.4x_2 + x_3$
	Зөрчил (x_2)	0.65		
	Иргэн (x_3)	0.98		

Хүснэгт 3.1. Анхан шатны шүүхэд шийдвэрлэсэн хэргийн загварын тодорхойлолт

Төвийн дүүрэг: **Корреляцийн коэффициентийн** утгыг тайлбарлая. Хянан шийдвэрлэсэн хэргийн тогтолцооны загвар (нэг шүүгчид ногдох)-т эрүүгийн хэргийн тоо 0.66 буюу дунд зэрэг, зөрчлийн хэргийн тоо 0.95 буюу хүчтэй, иргэний хэргийн тоо 0.60 буюу дунд зэрэг, захиргааны хэргийн тоо 0.64 буюу дунд зэргийн хамааралтай байна. Хянан шийдвэрлэсэн хэргийн тогтолцооны загварт зөрчлийн хэрэг хамгийн өндөр хамааралтай буюу хүчтэй нөлөөтэй⁷ байгааг харуулж байна.

Ерөнхий дисперсийн өсөн нэмэгдэх хувийн утгыг тайлбарлая. Төвийн дүүргийн хувьд шийдвэрлэсэн хэргийн тогтолцооны загвар нь өгөгдсөн мэдээлэл (эрүү, зөрчил, иргэн, захиргаа)-н 74 хувийг тайлбарлаж байна. Эсрэг утгаар нь тайлбарлавал өгөгдсөн

⁷ ДЭХАШШ нь эрүү болон зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэдэг. Шинжилгээгээр зөрчлийн хэргийн хамаарал өндөр гарч байгаа учраас зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажил нь өөр хэргийн төрлийг хянан шийдвэрлэдэг шүүхэд хамт хийгдэх бус тусдаа дагнан хийгдэх хэмжээнд байж болохоор байна.

мэдээллийн 26 хувийг алдаж байна. Дээр тодорхойлсон загварууд хамгийн боломжит, өндөр хувийг агуулсан хувилбарууд юм.

Шийдвэрлэсэн хэргийн тогтолцооны загварын утгыг тайлбарлая.

$$y = 0.5x_1 + 9x_2 + 0.3x_3 + 0.07x_4$$

Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд ДЭХАШШ-н нэг шүүгчийн нэг жилд шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоо 0.5 хэргээр өссөн (сүүлийн 5 жилийн хугацаанд 2-3 хэргээр өссөн) бол зөрчлийн хэргийг дагнан шийдвэрлэдэг шүүгчийн шийдвэрлэсэн хэрэг жилд 9 хэргээр өссөн байна. ДИХАШШ-н нэг шүүгчийн нэг жилд шийдвэрлэсэн иргэний хэргийн тоо 0.3 хэргээр өссөн (сүүлийн 5 жилийн хугацаанд 1-2 хэргээр өссөн) бол Нийслэл дэх ЗХАШШ-н нэг шүүгчийн нэг жилд шийдвэрлэсэн захиргааны хэргийн тоо 0.07 хэргээр буюу бараг өсөлтгүй байсан байна. Хэргийн төрөл тус бүрийн хувьд нэг шүүгчид нэг жилд ногдох шийдвэрлэсэн хэргийн тооны өсөлтийн хэмжээг харвал зөрчлийн хэрэгт хамгийн их буюу жилд 9 хэргээр өссөн дүнтэй байна.

Захын дүүрэг: **Корреляцийн коэффициентийн** утгыг тайлбарлая. Хянан шийдвэрлэсэн хэргийн тогтолцооны загвар (нэг шүүгчид ногдох)-т эрүүгийн хэргийн тоо 0.45 буюу дунд зэрэг, зөрчлийн хэргийн тоо 0.74 буюу хүчтэй, иргэний хэргийн тоо 0.96 буюу хүчтэй хамааралтай байна. Хянан шийдвэрлэсэн хэргийн тогтолцооны загварт иргэний хэргийн ачаалал хамгийн өндөр хамааралтай буюу хүчтэй хамааралтай байгааг харуулж байна.

Ерөнхий дисперсийн өсөн нэмэгдэх хувийн утгыг тайлбарлая. Захын дүүргийн хувьд шийдвэрлэсэн хэргийн тогтолцооны загвар нь өгөгдсөн мэдээлэл (эрүү, зөрчил, иргэн)-н 74 хувийг тайлбарлаж байна.

Шийдвэрлэсэн хэргийн тогтолцооны загварын утгыг тайлбарлая.

$$y = 0.1x_1 + 0.5x_2 + x_3$$

Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд захын ДЭХАШШ-н нэг шүүгчийн нэг жилд шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоо 0.1 хэргээр (5 жилийн хугацаанд $0.1*5=0.5$) өссөн бол зөрчлийн хэргийн хувьд 0.5 хэргээр (5 жилийн хугацаанд $0.5*5=2.5$), ДИХАШШ-н нэг шүүгчийн нэг жилд шийдвэрлэсэн иргэний хэргийн тоо 1 хэргээр (5 жилийн хугацаанд $1*5=5$) тус тус өсжээ.

Аймгийн шүүх: **Корреляцийн коэффициентийн** утгыг тайлбарлая. Хянан шийдвэрлэсэн хэргийн тогтолцооны загвар (нэг шүүгчид ногдох)-т эрүүгийн хэргийн тоо 0.99 буюу хүчтэй, зөрчлийн хэргийн тоо 0.59 буюу дунд зэрэг, иргэний хэргийн тоо 0.66 буюу хүчтэй, захиргааны хэргийн тоо -0.84 буюу урвуу хүчтэй хамааралтай байна. Хянан шийдвэрлэсэн хэргийн тогтолцооны загварт захиргааны хэрэг урвуу хүчтэй хамааралтай байгаа нь захиргааны хэргийн ачаалал буурсан гэсэн мэдээллийг өгч байна.

Ерөнхий дисперсийн өсөн нэмэгдэх хувийн утгыг тайлбарлая. Аймгийн шүүхийн хувьд шийдвэрлэсэн хэргийн тогтолцооны загвар нь өгөгдсөн мэдээлэл (эрүү, зөрчил, иргэн, захиргаа)-н 88 хувийг тайлбарлаж байна.

Шийдвэрлэсэн хэргийн тогтолцооны загварын утгыг тайлбарлая.

$$y = x_1 + 2x_2 + 2x_3 - 0.13x_4$$

Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд ЭХАШШ-н нэг шүүгчийн нэг жилд шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоо 1 хэргээр, зөрчлийн хэргийн тоо 2 хэргээр, АИХАШШ-н нэг шүүгч нэг жилд шийдвэрлэсэн иргэний хэргийн тоо 2 хэргээр тус тус өссөн байна. ЗХАШШ-н нэг шүүгч нэг жилд шийдвэрлэсэн хэрэг -0.13 хэргээр (5 жилийн хугацаанд $0.13*5=0.65$ буюу 1 хэргээр) буурсан байна.

Сум дундын шүүх: **Корреляцийн коэффициентийн** утгыг тайлбарлая. Хянан шийдвэрлэсэн хэргийн тогтолцооны загвар (нэг шүүгчид ногдох)-т эрүүгийн хэргийн тоо 0.19 буюу сул, зөрчлийн хэргийн тоо 0.65 буюу хүчтэй, иргэний хэргийн тоо 0.98 буюу хүчтэй хамааралтай байна. Хянан шийдвэрлэсэн хэргийн тогтолцооны загварт эрүүгийн хэрэг сул хамааралтай байгаа нь эрүүгийн хэргийн тоо өөрчлөгдөөгүй байсан гэдгийг харуулж байна.

Ерөнхий дисперсийн өсөн нэмэгдэх хувийн утгыг тайлбарлая. Сум дундын шүүхийн хувьд шийдвэрлэсэн хэргийн тогтолцооны загвар нь өгөгдсөн мэдээлэл (эрүү, зөрчил, иргэн)-н 78 хувийг тайлбарлаж байна.

Шийдвэрлэсэн хэргийн тогтолцооны загварын утгыг тайлбарлая.

$$y = 0.03x_1 + 0.4x_2 + x_3$$

Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд сум дундын шүүхийн нэг шүүгчийн нэг жилд ногдох шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоо 0.03 хэргээр буюу өсөөгүй байгаа бол зөрчлийн хэргийн хувьд 0.4 хэргээр (5 жилийн хугацаанд $0.4 \cdot 5 = 2$), иргэний хэргийн тоо 1 хэргээр тус тус өссөн байна. Эдгээр шийдвэрлэсэн хэргийн тооны өсөлт нэг шүүгчийн ачаалалтай холбоотой.

3.1.2. Давж заалдах шатны шүүх

Шүүх	Хувьсагч	Корреляцийн коэффициент (r_{y_1, x_k})	Ерөнхий дисперсийн өсөн нэмэгдэх хувь	Шийдвэрлэсэн хэргийн тогтолцооны загвар
Нийслэл	Эрүү (x_1)	0.91	0.75	$y = 0.7x_1 + 0.01x_2 - 0.04x_3 - 0.7x_4$
	Зөрчил (x_2)	0.18		
	Иргэн (x_3)	-0.16		
	Захиргаа (x_4)	-0.88		
Аймаг	Эрүү (x_1)	0.99	0.92	$y = 0.7x_1 + 0.1x_2 - 0.7x_3$
	Зөрчил (x_2)	0.87		
	Иргэн (x_3)	-0.30		
Орхон, Дархан-Уул	Эрүү (x_1)	0.88	0.78	$y = 0.7x_1 + 0.2x_2 - 0.7x_3$
	Зөрчил (x_2)	0.87		
	Иргэн (x_3)	-0.88		

Хүснэгт 3.2. Давж заалдах шатны шүүхийн шийдвэрлэсэн хэргийн загварын тодорхойлолт

Нийслэлийн шүүх: **Корреляцийн коэффициентийн** утгыг тайлбарлая. Хянан шийдвэрлэсэн хэргийн тогтолцооны загвар (нэг шүүгчид ногдох)-т эрүүгийн хэргийн тоо 0.91 буюу хүчтэй, зөрчлийн хэргийн тоо 0.18 буюу сул, иргэний хэргийн тоо -0.16 буюу урвуу сул, захиргааны хэргийн тоо -0.88 буюу урвуу хүчтэй хамааралтай байна. Хянан шийдвэрлэсэн хэргийн тогтолцооны загварт захиргааны хэрэг урвуу хүчтэй хамааралтай байгаа нь захиргааны хэргийн ачаалал буурсан гэсэн мэдээллийг өгч байна. Зөрчлийн хэргийн тоо эерэг сул хамааралтай байсан бөгөөд маш бага коэффициентээр өсөх хандлагатай байсан гэсэн үг юм. Иргэний хэргийн тоо урвуу сул хамааралтай байсан гэдэг нь бараг өөрчлөлтгүй бөгөөд маш бага коэффициентээр буурах хандлагатай байсан гэсэн үг юм.

Ерөнхий дисперсийн өсөн нэмэгдэх хувийн утгыг тайлбарлая. НДЗШШ-н хувьд шийдвэрлэсэн хэргийн тогтолцооны загвар нь өгөгдсөн мэдээлэл (эрүү, зөрчил, иргэн, захиргаа)-н 75 хувийг тайлбарлаж байна. Эсрэг утгаар нь тайлбарлавал өгөгдсөн

мэдээллийн 25 хувийг алдаж байна. Дээр тодорхойлсон загварууд хамгийн боломжит, өндөр хувийг агуулсан хувилбарууд юм.

Шийдвэрлэсэн хэргийн тогтолцооны загварын утгыг тайлбарлая.

$$y = 0.7x_1 + 0.01x_2 - 0.04x_3 - 0.7x_4$$

Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд НЭХДЗШШ-н нэг шүүгчийн нэг жилд шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоо 0.7 хэргээр (5 жилийн хугацаанд $0.7*5=3.5$) өссөн бол зөрчлийн хэргийн тоо 0.01 хэргээр буюу маш бага тооцоо хийгдэхгүй шахам коэффициентээр өсөх хандлагатай байсан байна. НИХДЗШШ-н нэг шүүгч нэг жилд шийдвэрлэсэн иргэний хэргийн тоо 0.04 хэргээр буюу маш бага тооцоо хийгдэхгүй шахам коэффициентээр буурах хандлагатай байсан байна. ЗХДЗШШ-н нэг шүүгчийн нэг жилд хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийн тоо жилд -0.7 буюу 5 жилийн хугацаанд 3-4 хэргээр буурсан байна.

Аймгийн шүүх: **Корреляцийн коэффициентийн** утгыг тайлбарлая. Хянан шийдвэрлэсэн хэргийн тогтолцооны загвар (нэг шүүгчид ногдох)-т эрүүгийн хэргийн тоо 0.99 буюу хүчтэй, зөрчлийн хэргийн тоо 0.87 буюу хүчтэй, иргэний хэргийн тоо -0.30 буюу урвуу дунд зэрэг хамааралтай байна. Хянан шийдвэрлэсэн хэргийн тогтолцооны загварт иргэний хэрэг урвуу дунд зэрэг хамааралтай байгаа нь иргэний хэргийн ачаалал буурсан гэсэн мэдээллийг өгч байна. Энэ нь ковид болон бусад шалтгаантай холбоотой байж болох талтай. Эрүү болон зөрчлийн хэргийн тоо эерэг хүчтэй хамааралтай байсан гэдэг нь өсөх хандлагатай байсан гэсэн үг юм.

Ерөнхий дисперсийн өсөн нэмэгдэх хувийн утгыг тайлбарлая. АДЗШШ-н хувьд шийдвэрлэсэн хэргийн тогтолцооны загвар нь өгөгдсөн мэдээлэл (эрүү, зөрчил, иргэн)-н 92 хувийг тайлбарлаж байна.

Шийдвэрлэсэн хэргийн тогтолцооны загварын утгыг тайлбарлая.

$$y = 0.7x_1 + 0.1x_2 - 0.7x_3$$

Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд АДЗШШ-н нэг шүүгчийн нэг жилд шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоо 0.7 хэргээр (5 жилийн хугацаанд $0.7*5=3.5$) өссөн бол зөрчлийн хэргийн тоо 0.1 хэргээр буюу бага коэффициентээр өсөх хандлагатай байсан байна. Иргэний хэргийн тооны хувьд -0.7 хэргээр буюу (5 жилийн хугацаанд $-0.7*5=-3.5$) хэргээр буурсан байна.

Орхон, Дархан-Уул аймаг дахь шүүх: **Корреляцийн коэффициентийн** утгыг тайлбарлая. Хянан шийдвэрлэсэн хэргийн тогтолцооны загвар (нэг шүүгчид ногдох)-т эрүүгийн хэргийн тоо 0.88 буюу хүчтэй, зөрчлийн хэргийн тоо 0.87 буюу хүчтэй, иргэний хэргийн тоо -0.88 буюу урвуу хүчтэй хамааралтай байна. Хянан шийдвэрлэсэн хэргийн тогтолцооны загварт иргэний хэрэг урвуу хүчтэй хамааралтай байгаа нь иргэний хэргийн ачаалал буурсан гэсэн мэдээллийг өгч байна. Энэ нь ковид болон бусад шалтгаантай холбоотой байж болох талтай. Эрүү болон зөрчлийн хэргийн тоо эерэг хүчтэй хамааралтай байсан гэдэг нь өсөх хандлагатай байсан гэсэн үг юм.

Ерөнхий дисперсийн өсөн нэмэгдэх хувийн утгыг тайлбарлая. ДЗШШ-н хувьд шийдвэрлэсэн хэргийн тогтолцооны загвар нь өгөгдсөн мэдээлэл (эрүү, зөрчил, иргэн)-н 78 хувийг тайлбарлаж байна.

Шийдвэрлэсэн хэргийн тогтолцооны загварын утгыг тайлбарлая.

$$y = 0.7x_1 + 0.23x_2 - 0.7x_3$$

Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд Орхон, Дархан уул аймаг дахь ЭХАШШ-н нэг шүүгчийн нэг жилд шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоо 0.7 хэргээр (5 жилийн хугацаанд $0.7*5=3.5$), зөрчлийн хэргийн тоо 0.2 хэргээр буюу 5 жилийн хугацаанд 1 хэргээр өссөн байна. Харин иргэний хэрэг -0.7 буюу 5 жилийн хугацаанд 3-4 хэргээр буурсан байна.

3.2. ШҮҮХИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛИЙН ШИНЖИЛГЭЭ

3.2.1. Анхан шатны шүүх

Шүүхэд шийдвэрлэсэн хэргийн тогтолцоо дэд бүлэгт анхан болон давж заалдах шатны шүүхийн нэг шүүгчид ногдох хянан шийдвэрлэсэн хэргийн тооны нөхцөл болон хандлагыг тодорхойлсон. Шүүхэд шийдвэрлэсэн хэргийн тогтолцооны гол хэсгийн загварт орсон хувьсагч (хувьсагчийн тэмдэглэгээг 3.1 дэд бүлгийн хүснэгтээс харна уу.)-д бүгд хэргийн тогтолцоонд тодорхой хэмжээний хамааралтай байна. Иймд эдгээр хувьсагчдын агуулгыг гүйцэд утгаар илэрхийлж чадахуйц дараах үзүүлэлтүүдийг нэмж судалъя. Нэмж судлах үзүүлэлтүүдийн тодорхойлолтыг өгье.

Шүүгчийн тоо гэдэгт тухайн шатны шүүхэд ажилласан шүүгчийн тоог ойлгоно.

Цалин гэдэгт тухайн шүүхийн нийт цалингийн зардлыг шүүхэд ажилласан шүүгчийн тоонд хуваасан хэмжээг ойлгоно.

Ачаалал гэдэгт тухайн шүүхэд хянан шийдвэрлэсэн хэрэг (эрүү, иргэн, зөрчил, захиргаа)-н тоог шүүгчийн тоонд хуваасан дүнг ойлгоно.

3.2.1.1. Дүүргийн шүүх


Нийслэлийн 9 дүүргийн АШШ-н үйл ажиллагааны ачааллын түвшин төвийн болон захын дүүргүүдийн хувьд өөр хэв шинжтэй тул тус тусад нь салгаж шинжилгээ хийсэн. Төвийн 6 дүүргийн анхан шатны шүүхийн үйл ажиллагааны ерөнхий дүр зургийг тодорхойлохын тулд 2D, 3D хэмжээст график дүрслэлийг тус тусад нь байгуулав. Графикийн тэнхлэгийн тухай тайлбарыг оруулъя. Үүнд:

Дүүрэг (x) гэсэн тэнхлэгийн 2, 4, 6 гэсэн тоогоор тэмдэглэсэн цэгийн утгыг нийслэлийн төвийн 6 дүүргийн шүүхээр төлөөлүүлсэн бөгөөд дараах дарааллаар ойлгоно. 1-Чингэлтэй, 2-Баянгол, 3-Баянзүрх, 4-Сүхбаатар, 5-Хан-Уул, 6-Сонгинохайрхан дүүрэг

Он (y) гэсэн тэнхлэгийн 1, 2, 3, 4, 5 гэсэн тоогоор тэмдэглэсэн цэгийн утгыг 2017-2021 он гэж ойлгоно.

Босоо (z) тэнхлэгээр тайлбар өгөхийн зорьсон үзүүлэлт (ачаалал, шүүгчийн тоо, цалин,)-г илэрхийлнэ.


- Төвийн ДЭХАШШ-н тухайд



Зураг 3.1. Төвийн дүүргийн эрүү ба зөрчлийн хэрэг дээр ажилласан шүүгчийн ачаалал


Зураг 3.1-гаас харвал 2017 онд төвийн ДЭХАШ-ны шүүгчийн ажлын ачаалал хамгийн бага байсан байна. 2017-2019 он хүртэл бүх дүүргүүдийн шүүгчийн ачаалал өсөөд, 2021 онд бүх дүүргүүдийн шүүгчийн ачаалал буурсан дүр зураг ажиглагдаж байна. Зөрчлийн хэргийн

хувьд 2017 онд энэ хэргийн мэдээлэл байхгүй байсан байна. 2018-2020 он хүртэл зөрчлийн хэрэг дээр ажилласан шүүгчийн ачаалал тасралтгүй өссөн бөгөөд 2021 онд 2020 оны ачаалал бараг хэвээр хадгалагдсан дүр зураг ажиглагдаж байна.



Зураг 3.2. Эрүүгийн хэрэг болон зөрчлийн хэрэг дээр ажилласан нэг шүүгчийн ачаалал



Зураг 3.1-д өгсөн дүгнэлтийг бататгах зорилгоор дүүрэг тус бүрийн шүүгчийн ачааллыг задалж Зураг 3.2-д харуулав. Босоо тэнхлэгээр зөрчлийн хэрэг дээр ажилласан нэг шүүгчийн ачаалал, хэвтээ тэнхлэгээр эрүүгийн хэрэг дээр ажилласан нэг шүүгчийн ачааллыг 2D зургаар харуулав.





Зураг 3.3. ДЭХАШШ-д ажилласан шүүгчийн тоо, цалин (сая.төг)

Зураг 3.3-гаас харвал 2017 онд төвийн ДЭХАШШ-н шүүгчийн тоо Баянзүрх дүүрэгт хамгийн их буюу 8 шүүгч ажилласан байна. 2018-2021 он хүртэл бүх дүүргүүдэд эрүүгийн хэргийн шүүгчийн тоо тасралтгүй өссөн дүр зураг ажиглагдаж байна. Цалингийн хэмжээний хувьд эрүүгийн хэргийн шүүгчийн нэг жилийн цалингийн хэмжээ 2017-2020 онд 33-45 сая орчим байсан байна. 2021 онд Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүрэгт огцом өссөн байна.

Зураг 13.3-д өгсөн дүгнэлтийг бататгах зорилгоор дүүрэг тус бүрийн эрүүгийн хэрэг дээр ажилласан шүүгчийн тоог шүүгчийн ачааллын хамт задалж Зураг 3.4, 3.5-д харуулав. Босоо тэнхлэгээр эрүүгийн хэргийн шүүгчийн ачаалал, хэвтээ тэнхлэгээр эрүүгийн хэргийн шүүхэд ажилласан шүүгчийн тоог 2D зургаар харуулав. Зураг 3.2, 3.3-д 2-р бүлгийн Хотелингийн шинжүүрийн үр дүн болох кластерийн ангиллын үр дүн (Хүснэгт 2.2б)-г барив.




Зураг 3.4. ДЭХАШШ-д ажилласан шүүгчийн тоо, шүүгчийн ажлын ачаалал



Зураг 3.5. ДЭХАШШ-д ажилласан шүүгчийн тоо, цалин (сая.төг)


Зураг 3.5-д эрүүгийн хэрэг дээр ажилласан шүүгчийн тоо (Шалгуур 3-д өгсөн шүүгчийн тооноос зөрнө. Шалгуур 34-д өгсөн шүүгчийн тоо болно.) нэг шүүгчийн нэг жилийн цалингийн хэмжээг харуулав.



Зураг 3.6. ДЭХАШШ-н шүүгчийн мэдээлэл, кластерийн бүлгээр

Зураг 3.6-д эрүүгийн хэргийн нэг шүүгчийн тухай гурван мэдээллийг 2017-2021 оны хандлагын хамт нэг дор өгөх боломжтой байдлаар дүрслэв. Зураг 3.2-3.6 тайлбарласан шүүгчийн ачаалал, цалингийн хэмжээ мөн 2-р бүлэгт харуулсан шүүгчийн ажиллагааны ачааллын мэдээллийг нэгтгэж 3D зургаар харуулав. Босоо тэнхлэгээр эрүүгийн хэргийн шүүгчийн нэг жилийн цалингийн хэмжээг, хэвтээ тэнхлэгээр шүүгчийн ачаалал болон ажиллагаа (материал)-г тэмдэглэсэн тул тэнхлэгийн тоон утгуудыг харгалзуулан харж ойлгоно уу.


• Төвийн ДИХАШШ-н тухайд



Зураг 3.7. ИХАШШ-д ажилласан шүүгчийн ачаалал, шүүгчийн тоо

Зураг 3.7-гаас харвал 2017 онд төвийн ДИХАШШ-ны шүүгчийн ажлын ачаалал хамгийн бага байсан байна. 2017, 2018 онд Сүхбаатар дүүргээс бусад дүүргүүдийн шүүгчийн ачаалал бага зэрэг өссөн байна. Сүхбаатар дүүргийн шүүгчийн ачаалал огцом буурсан байна. 2019 онд бүх дүүргүүдийн шүүгчийн ачаалал буурч 2020 онд өсөөд, 2021 онд буцаад буурсан дүр зураг ажиглагдаж байна. Шүүгчийн тооны хувьд Баянзүрх дүүрэгт харьцангуй олон шүүгч ажиллаж ирсэн байна. Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүрэгт 9-13 буюу харьцангуй цөөн шүүгч ажиллаж ирсэн байна. 2018-2021 он хүртэл иргэний хэрэг дээр ажилласан шүүгчийн тоо өөрчлөлтгүй тогтмол байсан дүр зураг ажиглагдаж байна.


Зураг 3.7-д өгсөн дүгнэлтийг бататгах зорилгоор дүүрэг тус бүрийн шүүгчийн ачааллыг задалж Зураг 3.8-д харуулав. Босоо тэнхлэгээр иргэний хэргийн нэг шүүгчийн ачаалал, хэвтээ тэнхлэгээр иргэний хэргийн шүүхэд ажилласан шүүгчийн тоог 2D зургаар харуулав.



Зураг 3.8. ДИХАШШ-д ажилласан шүүгчийн ачаалал, шүүгчийн тоо


Зураг 3.8-д 2-р бүлгийн Хотелингийн шинжүүрийн үр дүн болох кластерийн ангиллын үр дүн (Хүснэгт 2.28)-г барив. Зураг 3.8-гээс харвал Сүхбаатар, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн иргэний хэргийн шүүгчийн тоо, ачааллын утгыг илэрхийлэх цэгэн утгууд хоорондоо холилдсон дүр зураг харагдаж байна. Энэ нь ижил хэв шинж гэж үзэх магадлалтай гэсэн утгыг илтгэнэ. Харин Чингэлтэй, Баянгол, Баянзүрх дүүргийн цэгэн утгууд хоорондоо холилдоогүй тусгаар шинжтэй харагдаж байна. Хоорондоо огтлолцохгүй байх гол шалтгаан нь шүүгчийн тоо хэт ялгаатай болохыг харуулж байна. Харин хянан шийдвэрлэсэн хэргийн тоо ижил түвшинд нэлээн олон цэг дээр ажиглагдаж байна. Энэ нэг шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн тоо ойролцоо боловч ажиллах хүний тоо олон цөөн байсан гэдгээрээ ялгаатай байсан гэсэн үг юм. Баянгол дүүрэг тогтмол жигд ачаалалтай

ажилласан харагдаж байна. Чингэлтэй дүүрэг 2020, 2021 онд шүүгчийн тоо буурснаас үүдэлтэй огцом ачаалал авсан харагдаж байна.




Зураг 3.9. ДИХАШШ-н шүүгчийн цалин (сая.төг)

ДИХАШШ-н шүүгчийн цалин 2017-2021 он хүртэл бүх дүүргийн шүүхүүдийн хувьд тогтмол өссөн байна. 2017 онд Сонгинохайрхан дүүргийн иргэний хэргийн шүүгчийн цалингийн хэмжээ хамгийн бага байсан дүр зураг харагдаж байна. Дараагийн 2D зургаас тодорхой харах боломжтой.



Зураг 3.10. ДИХАШШ-д ажилласан шүүгчийн тоо, цалин (сая.төг)

Зураг 3.9-д өгсөн дүгнэлтийг бататгах зорилгоор дүүрэг тус бүрийн иргэний хэрэг дээр ажилласан шүүгчийн тоог шүүгчийн цалингийн хамт задалж Зураг 3.10-д харуулав. Босоо тэнхлэгээр нэг шүүгчийн нэг жилийн цалингийн хэмжээг, хэвтээ тэнхлэгээр иргэний хэргийн шүүхэд ажилласан шүүгчийн тоо (Шалгуур 3-д өгсөн шүүгчийн тооноос зөрнө. Шалгуур 34-д өгсөн шүүгчийн тоо болно.)-г 2D зургаар харуулав. Хянан шийдвэрлэсэн хэргийн тоо шүүгчийн ачаалал (Зураг 3.8, 3.9)-г дагаад өөрчлөгдөж байсан гэж тодорхойлж болохоор дүр зураг ажиглагдаж байна.



Зураг 3.11. ДИХАШШ-н шүүгчийн мэдээлэл, кластерийн бүлгээр

Зураг 3.11-д иргэний хэргийн нэг шүүгчийн тухай гурван мэдээллийг 2017-2021 оны хандлагын хамт нэг дор өгөх боломжтой байдлаар дүрслэв. Зураг 3.9-3.11-д тайлбарласан шүүгчийн ачаалал, цалингийн хэмжээ мөн 2-р бүлэгт харуулсан шүүгчийн ажиллагааны ачааллын мэдээллийг нэгтгэж 3D зургаар харуулав. Босоо тэнхлэгээр иргэний хэргийн шүүгчийн нэг жилийн цалингийн хэмжээг, хэвтээ тэнхлэгээр шүүгчийн ачаалал болон ажиллагаа (материал)-г тэмдэглэсэн тул тэнхлэгийн тоон утгуудыг харгалзуулан харж ойлгох боломжтой.

Шүүхийн үйл ажиллагааг тодорхойлох гол хэсгийн шинжилгээнд хувьсагч болж орох зарим үзүүлэлтүүдийн бодит өгөгдлийг график дүрслэлээр харууллаа. Гол хэсгийн шинжилгээ явуулж түлхүүр хувьсагчийг сонгох тухай судалгаа явууля. Шинжилгээнд хэрэглэгдэх зарим ойлголтыг тайлбарлая. Үүнд:

Шүүхийн үйл ажиллагаа гэдэгт тухайн шүүхэд шийдвэрлэсэн хэргийн тоо, үлдэгдэл хэргийн тоо, ажиллагаа (*Шалгуур 26-д хамаарах үзүүлэлт*)-ны тоо, хариуцагч (нэхэмжлэгч, хэргийн хүн)-н тоо, хүн амын нягтрал, шүүгчийн цалингийн сан, томилолтоор ажилласан зардал зэргийг тухайн жилд шүүхэд ажилласан шүүгчийн тоонд харьцуулж гаргасан утгуудыг ойлгоно.

Хэргийн ачаалал гэдэгт нэг шүүгчийн нэг жилд шийдвэрлэсэн эрүү (иргэн, захиргаа, зөрчил)-н хэргийн тоог ойлгоно.

Үлдэгдэл хэргийн тоо гэдэгт нэг шүүгчид нэг жилд ногдох үлдэгдэл эрүү (иргэн, захиргаа, зөрчил)-н хэргийн тоог ойлгоно.

Томилолтын зардал гэдэгт шүүхэд зарцуулсан томилолтын зардлыг ажилласан шүүгчийн тоонд хуваасан хэмжээг ойлгоно.

Ажиллагаа гэдэгт нэг шүүгчид нэг жилд ногдох эрүү (иргэн, захиргаа)-н хэргийн шалгуур 26-д хамаарах үзүүлэлтийн хүрээнд өгөгдсөн өгөгдлийн нийт ажиллагааны тоог ойлгоно.

Хэргийн хүн, нэхэмжлэгч, хариуцагч гэдэгт (иргэний хэрэгт хариуцагч, захиргааны хэрэгт нэхэмжлэгч, хариуцагч) хэрэгт холбоотой хүний тоог тухайн хэргийн шүүгчийн тоонд хувааж тооцсон тоог ойлгоно.

Хүн амын нягтрал гэдэгт хүн амын тоог харьяалах нутаг дэвсгэрийн талбайн хэмжээнд нь хувааж тооцсон тоог ойлгоно.

Цалин гэдэгт эрүү (иргэн, захиргаа)-н хэргийг хянан шийдвэрлэж буй шүүгчийн цалингийн сангийн төсвийн гүйцэдгэлд тусгагдсан нэг шүүгчид нэг жилд ногдох цалингийн хэмжээг ойлгоно.

Томилолтын зардал гэдэгт шүүх бүрэлдэхүүнд оролцохоор нэг шүүгч нэг жилд томилолтоор ажилласан зардлын хэмжээг ойлгоно.

Шүүх	Хувьсагч	Кор.коэ (r_{y_1, x_k})	Ерөнхий дисперсийн өсөн нэмэгдэх хувь	Шүүхийн үйл ажиллагааны загвар
Эрүү	Ачаалал (x_1)	0.99	0.92	$y = 0.7x_1 + 0.03x_2 + 3x_3 + 0.7x_4 + 0.03x_5 + 0.3x_6 - 210000x_7$
	Үлдэгдэл хэрэг (x_2)	0.70		
	Ажиллагаа (x_3)	0.78		
	Шийдвэрлэсэн хэргийн хүн (x_4)	0.98		
	Үлдэгдэл хэргийн хүн (x_5)	0.42		
	Хүн амын нягтрал (x_6)	0.67		
	Цалин (x_7)	-0.21		
Зөрчил	Ачаалал (x_1)	0.99	0.91	$y = 7x_1 + 6x_2 + 0.3x_3 + 48100x_4$
	Ажиллагаа (x_2)	0.99		
	Хүн амын нягтрал (x_3)	0.65		
	Цалин (x_4)	0.51		

Хүснэгт 3.3. ДЭХАШШ-н үйл ажиллагааны загварын тодорхойлолт

Эрүүгийн хэрэг: **Корреляцийн коэффициентийн** утгыг тайлбарлая. Шүүхийн үйл ажиллагааны загвар (нэг шүүгчид ногдох)-т эрүүгийн хэргийн ачаалал 0.99 буюу хүчтэй, үлдэгдэл хэргийн тоо 0.70 буюу хүчтэй, ажиллагаа (материал)-ны тоо 0.78 буюу хүчтэй, шийдвэрлэсэн хэрэгт хамаарах хүний тоо 0.98 буюу хүчтэй, үлдэгдэл хэрэгт хамаарах хүний тоо 0.42 буюу дунд зэрэг, хүн амын нягтрал 0.68 буюу хүчтэй, цалингийн хэмжээ -0.21 буюу урвуу сул хамааралтай байна. Шүүхийн үйл ажиллагааны загварт цалингийн хэмжээ урвуу сул хамааралтай байгаа нь авсан ачааллын хэмжээнд хүрэхээр цалин аваагүй буюу хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн ачаалал нэмэгдсэн гэсэн мэдээллийг өгч байна. Бүрэлдэхүүн хэсгийн загварт ачаалал, шийдвэрлэсэн хэрэгт хамаарах хүний тоо хамгийн өндөр нөлөө үзүүлж байна.

Ерөнхий дисперсийн өсөн нэмэгдэх хувийн утгыг тайлбарлая. ДЭХАШШ-н хувьд шийдвэрлэсэн хэргийн тогтолцооны загвар нь өгөгдсөн мэдээлэл (ачаалал, үлдэгдэл хэрэг, ажиллагаа гэх мэт)-н 92 хувийг тайлбарлаж байна. Эсрэг утгаар нь тайлбарлавал өгөгдсөн мэдээллийн 8 хувийг алдаж байна. Дээр тодорхойлсон загварууд хамгийн боломжит, өндөр хувийг агуулсан хувилбарууд юм.

Шүүхийн үйл ажиллагааны загварын утгыг тайлбарлая.

$$y = 0.7x_1 + 0.03x_2 + 3x_3 + 0.7x_4 + 0.03x_5 + 0.3x_6 - 210000x_7$$

Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд төвийн ДЭХАШШ-н эрүүгийн хэрэг шийдвэрлэдэг нэг шүүгчийн нэг жилд шийдвэрлэсэн хэргийн тоо 0.7 хэргээр буюу 5 жилд 3-4 хэргээр, үлдэгдэл хэрэг 0.03 хэргээр (бараг өсөлтгүй), ажиллагаа жилд 3 материалаар, шийдвэрлэсэн хэрэгт хамаарах хүний тоо 0.7 буюу 5 жилд 3-4 хүнээр, үлдэгдэл хэрэгт хамаарах хүний тоо 0.03 хүнээр (бараг өсөлтгүй), хүн амын нягтрал 0.3 хүнээр буюу 5 жилд 1-2 хүнээр тус тус өссөн байна. Цалингийн хэмжээ загварт орсон хувьсагчдын өсөлтөөс шалтгаалан жилд 210000 төгрөгөөр буурсан байна. Зураг 16а-д тайлбарласан 2021 оны эрүүгийн хэргийн тооны бууралт 5 жилийн жил тус бүрийн динамикийн абсолют өөрчлөлтийг давахуйц хэмжээнд байгаагүй гэсэн үг юм.

Зөрчлийн хэрэг: **Корреляцийн коэффициентийн** утгыг тайлбарлая. Шүүхийн үйл ажиллагааны загвар (нэг шүүгчид ногдох)-т эрүүгийн хэргийн ачаалал 0.99 буюу хүчтэй, ажиллагаа (материал)-ны тоо 0.99 буюу хүчтэй, хүн амын нягтрал 0.65 буюу хүчтэй,

цалингийн хэмжээ 0.51 буюу дунд зэрэг хамааралтай байна. Шүүхийн үйл ажиллагааны загварт цалингийн хэмжээ эерэг, дунд зэрэг хамааралтай байгаа нь 2021 онд нэмэгдсэн дүр зурагтай байсан ДЭХАШШ-н цалингийн сантай холбоотой гэж үзэж байна.

Ерөнхий дисперсийн өсөн нэмэгдэх хувийн утгыг тайлбарлая. ДЭХАШШ-н хувьд шийдвэрлэсэн хэргийн тогтолцооны загвар нь өгөгдсөн мэдээлэл (ачаалал, үлдэгдэл хэрэг, ажиллагаа гэх мэт)-н 91 хувийг тайлбарлаж байна. Эсрэг утгаар нь тайлбарлавал өгөгдсөн мэдээллийн 9 хувийг алдаж байна. Дээр тодорхойлсон загварууд хамгийн боломжит, өндөр хувийг агуулсан хувилбарууд юм.

Шүүхийн үйл ажиллагааны загварын утгыг тайлбарлая.

$$y = 7x_1 + 6x_2 + 0.3x_3 + 48100x_4$$

Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд төвийн ДЭХАШШ-н зөрчлийн хэрэг шийдвэрлэдэг нэг шүүгчийн шийдвэрлэсэн хэргийн тоо жилд 7 хэргээр, ажиллагаа жилд 6 материалаар, хүн амын нягтрал 0.3 хүнээр буюу 5 жилд 1-2 хүнээр, цалингийн хэмжээ жилд 48100 төгрөгөөр тус тус өссөн байна. Жил бүр зөрчлийн хэргийн тоо (Зураг 3.2-3.3) өсч байгаа ч Зураг 3.4-3.6-д тайлбарласан 2021 оны эрүүгийн хэргийн шүүгчийн цалингийн сангийн өсөлт, зөрчлийн хэрэг дээр ажилладаг шүүгчийн тоо тогтмол байсан зэрэг шалтгаанууд зөрчлийн хэргийн шүүгчийн цалингийн хэмжээг өсөлттэй гаргах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Шүүх	Хувьсагч	Кор.коэ (r_{y_1, x_k})	Ерөнхий дисперсийн өсөн нэмэгдэх хувь	Шүүхийн үйл ажиллагааны загвар
Иргэн	Ачаалал (x_1)	0.98	0.88	$y = 0.7x_1 + 0.3x_2 + 5x_3 + 0.6x_4 + 0.4x_5 + 11600x_6$
	Үлдэгдэл хэрэг (x_2)	0.76		
	Ажиллагаа (x_3)	0.68		
	Шийдвэрлэсэн хэргийн хариуцагч (x_4)	0.94		
	Хүн амын нягтрал (x_5)	0.60		
	Цалин (x_6)	0.28		
Захиргаа	Ачаалал (x_1)	0.65	0.70	$y = 0.3x_1 + 0.5x_2 + 5x_3 - 0.4x_4 + 0.3x_5 + x_6 + 435800x_7$
	Үлдэгдэл хэрэг (x_2)	0.96		
	Ажиллагаа (x_3)	0.88		
	Шийдвэрлэсэн хэргийн нэхэмжлэгч (x_4)	-0.80		
	Шийдвэрлэсэн хэргийн хариуцагч (x_5)	0.69		
	Хүн амын нягтрал (x_6)	0.64		
	Цалин (x_7)	0.89		

Хүснэгт 3.4. Нийслэл дэх ЗХААШШ болон ДИХАШШ-н үйл ажиллагааны загварын тодорхойлолт

Иргэний хэрэг: Корреляцийн коэффициентийн утгыг тайлбарлая. Шүүхийн үйл ажиллагааны загвар (нэг шүүгчид ногдох)-т иргэний хэргийн ачаалал 0.98 буюу хүчтэй, үлдэгдэл хэргийн тоо 0.76 буюу хүчтэй, ажиллагаа (материал)-ны тоо 0.68 буюу хүчтэй, шийдвэрлэсэн хэргийг хариуцагч хүний тоо 0.94 буюу хүчтэй, хүн амын нягтрал 0.60 буюу дунд зэрэг, цалингийн хэмжээ 0.28 буюу дунд зэрэг хамааралтай байна. Шүүхийн үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсгийн загварт цалингийн хэмжээ хамгийн бага хамааралтай байна.

Ерөнхий дисперсийн өсөн нэмэгдэх хувийн утгыг тайлбарлая. ДИХАШШ-н хувьд шийдвэрлэсэн хэргийн тогтолцооны загвар нь өгөгдсөн мэдээлэл (ачаалал, үлдэгдэл хэрэг,

ажиллагаа гэх мэт)-н 88 хувийг тайлбарлаж байна. Эсрэг утгаар нь тайлбарлавал өгөгдсөн мэдээллийн 12 хувийг алдаж байна. Дээр тодорхойлсон загварууд хамгийн боломжит, өндөр хувийг агуулсан хувилбарууд юм.

Шүүхийн үйл ажиллагааны загварын утгыг тайлбарлая.

$$y = 0.7x_1 + 0.3x_2 + 5x_3 + 0.6x_4 + 0.4x_5 + 11600x_6$$

Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд төвийн ДИХАШШ-н шүүгчийн нэг жилд шийдвэрлэсэн хэргийн тоо 0.7 хэргээр буюу 5 жилд 3-4 хэргээр, үлдэгдэл хэрэг 0.3 хэргээр буюу 5 жилд 1-2 хэргээр, ажиллагаа жилд 5 материалаар, шийдвэрлэсэн хэрэгт хамаарах хариуцагчийн тоо 0.6 буюу 5 жилд 3 хариуцагчаар, хүн амын нягтрал 0.4 хүнээр буюу 5 жилд 2 хүнээр тус тус өссөн байна. Цалингийн хэмжээ жилд 11600 төгрөгөөр өссөн байна. Энэ шалтгаан Зураг 3.2, 3.3-д тайлбарласан 2019 оны иргэний хэргийн тооны бууралт 2020 оны өсөлт, 2021 оны бууралт, цалингийн өсөлттэй холбоотой гэж үзэж байна.

Захиргааны хэрэг: **Корреляцийн коэффициентийн** утгыг тайлбарлая. Шүүхийн үйл ажиллагааны загвар (нэг шүүгчид ногдох)-т захиргааны хэргийн ачаалал 0.65 буюу дунд зэрэг, үлдэгдэл хэргийн тоо 0.96 буюу хүчтэй, ажиллагаа (материал)-ны тоо 0.88 буюу хүчтэй, шийдвэрлэсэн хэрэгт хамаарах нэхэмжлэгчийн тоо -0.80 буюу сөрөг хүчтэй, шийдвэрлэсэн хэргийг хариуцагч хүний тоо 0.69 буюу хүчтэй, хүн амын нягтрал 0.64 буюу дунд зэрэг, цалингийн хэмжээ 0.89 буюу хүчтэй хамааралтай байна. Шүүхийн үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсгийн загварт нэхэмжлэгчийн тоо хариуцагчийнхаа эсрэг сөрөг хүчтэй хамааралтай гарсан байна. Энэ нь хариуцагчийн тоо нэмэгдэж, нэхэмжлэгчийн тоо буурсан гэсэн үг юм.

Ерөнхий дисперсийн өсөн нэмэгдэх хувийн утгыг тайлбарлая. НЗХАШШ-н хувьд шийдвэрлэсэн хэргийн тогтолцооны загвар нь өгөгдсөн мэдээлэл (ачаалал, үлдэгдэл хэрэг, ажиллагаа гэх мэт)-н 70 хувийг тайлбарлаж байна. Эсрэг утгаар нь тайлбарлавал өгөгдсөн мэдээллийн 30 хувийг алдаж байна. Дээр тодорхойлсон загварууд хамгийн боломжит, өндөр хувийг агуулсан хувилбарууд юм.


Шүүхийн үйл ажиллагааны загварын утгыг тайлбарлая.

$$y = 0.3x_1 + 0.5x_2 + 5x_3 - 0.4x_4 + 0.3x_5 + x_6 + 435800x_7$$

Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд төвийн НЗХАШШ-н шүүгчийн нэг жилд шийдвэрлэсэн хэргийн тоо 0.3 хэргээр буюу 5 жилд 1-2 хэргээр, үлдэгдэл хэрэг 0.5 хэргээр буюу 5 жилд 3-4 хэргээр, ажиллагаа жилд 5 материалаар, шийдвэрлэсэн хэрэгт хамаарах нэхэмжлэгчийн тоо 0.4 буюу 5 жилд 2 нэхэмжлэгчээр, шийдвэрлэсэн хэрэгт хамаарах хариуцагчийн тоо 0.3 буюу 5 жилд 1-2 хариуцагчаар, хүн амын нягтрал жилд 1 хүнээр тус тус өссөн байна. Цалингийн хэмжээ жилд 435800 төгрөгөөр өссөн байна. Энэ шалтгаан нь захиргааны хэргийн тоо буурсантай холбоотой цалингийн хэмжээ өсөлттэй гарсан байна. Өөрөөр хэлбэл цалингаа бүтэн авсан хэмжээнд хүрч ажиллаж чадаагүй гэсэн үг юм.


- **Захын ДЭХАШШ**

Шүүхийн тоо хэт цөөн тул 3D шугаман график байгуулж ерөнхий төлөвийг харах боломжгүй тул 2D графикаас эхэлье.




Зураг 3.12. Захын ДЭХШ-д ажилласан шүүгчийн ачаалал, шүүгчийн тоо, цалин (сая.төг)

Эрүүгийн хэрэг дээр ажилласан шүүгчийн тоог шүүгчийн цалингийн хамт задалж Зураг 3.12-д харуулав. 1-р зургийн босоо тэнхлэгээр шүүгчийн ачаалал, ажилласан нийт шүүгчийн тоог, 2-р зургийн босоо тэнхлэгээр шүүгчийн нэг жилийн цалингийн хэмжээг, хэвтээ тэнхлэгээр эрүүгийн хэргийн шүүхэд ажилласан шүүгчийн тоо (*Шалгуур 3-д өгсөн шүүгчийн тооноос зөрнө. Шалгуур 34-д өгсөн шүүгчийн тоо болно.*)-г 2D зурагт тус тус харуулав. Багахангай дүүргийн шүүгчийн ачаалал нөгөө 2 дүүргээ бодвол бага бөгөөд өөр хэв шинжтэй байна. Багахангай дүүрэгт 1 эрүүгийн шүүгч ажилладаг бөгөөд жилд 20-45 орчим хэрэг (*эрүүгийн хэрэг дээр зөрчлийн хэргийг 10.2-д хувааж нэмж тооцсон*) хянан шийдвэрлэдэг байна. Налайх, Багануур дүүргийн эрүүгийн хэргийн шүүгчийн ачаалал ижил төсөөтэй хэв шинжтэй бөгөөд жилд 30-80 хүртэлх хэрэг (*эрүүгийн хэрэг дээр зөрчлийн хэргийг 10.2-д хувааж нэмж тооцсон*) хянан шийдвэрлэдэг байна. Налайх дүүргийн эрүүгийн хэргийн шүүгч 2020 онд өндөр ачаалалтай ажиллажээ. Цалингийн хэмжээний хувьд Багануур дүүргийн эрүүгийн хэргийн шүүгч 2017, 2018 онд өндөр цалин авч байжээ. Шалтгааныг нь тодорхойлох боломжгүй.




Зураг 3.13. ДЭХАШШ-н шүүгчийн мэдээлэл

Зураг 3.13-д эрүүгийн хэргийн нэг шүүгчийн тухай гурван мэдээллийг 2017-2021 оны хандлагын хамт нэг дор өгөх боломжтой байдлаар дүрслэв. Зураг 3.12-д тайлбарласан шүүгчийн ачаалал, цалингийн хэмжээ мөн 2-р бүлэгт харуулсан шүүгчийн ажиллагааны ачааллын мэдээллийг нэгтгэж 3D зургаар харуулав. Босоо тэнхлэгээр эрүүгийн хэргийн шүүгчийн нэг жилийн цалингийн хэмжээг, хэвтээ тэнхлэгээр шүүгчийн ачаалал болон ажиллагаа (материал)-г тэмдэглэсэн тул тэнхлэгийн тоон утгуудыг харгалзуулан харж ойлгох боломжтой.



Зураг 3.14. Захын ДИХШ-д ажилласан шүүгчийн ачаалал, шүүгчийн тоо, цалин (сая.төг)

Иргэний хэргийн шүүгчийн тоог шүүгчийн цалингийн хамт задалж Зураг 3.14-д харуулав. 1-р зургийн босоо тэнхлэгээр шүүгчийн ачаалал, ажилласан нийт шүүгчийн тоог, 2-р зургийн босоо тэнхлэгээр шүүгчийн нэг жилийн цалингийн хэмжээг, хэвтээ тэнхлэгээр эрүүгийн хэргийн шүүхэд ажилласан шүүгчийн тоо (Шалгуур 3-д өгсөн шүүгчийн тооноос зөрнө. Шалгуур 34-д өгсөн шүүгчийн тоо болно.)-г 2D зурагт тус тус харуулав. Багахангай дүүргийн иргэний хэргийн шүүгчийн ачаалал нөгөө 2 дүүргийн шүүгчийг бодвол мөн адил бага бөгөөд өөр хэв шинжтэй байна. Багахангай дүүрэгт 1 иргэний хэргийн шүүгч ажилладаг бөгөөд жилд 20-45 орчим хэрэг хянан шийдвэрлэдэг байна. Налайх, Багануур дүүргийн иргэний хэргийн шүүгчийн ачаалал ижил төсөөтэй хэв шинжтэй бөгөөд жилд 100-200 хүртэлх хэрэг хянан шийдвэрлэдэг байна. Багануур дүүргийн иргэний хэргийн шүүгч 2020 онд өндөр ачаалалтай ажиллажээ. Цалингийн хэмжээний хувьд Багануур дүүргийн иргэний хэргийн шүүгчийн цалин 2017-2021 онд тасралтгүй өсөөд 2021 онд хамгийн өндөр цалин авчжээ. Шалтгааныг нь тодорхойлох боломжгүй.



Зураг 3.15. ДИХАШШ-н шүүгчийн мэдээлэл

Зураг 3.15-д иргэний хэргийн нэг шүүгчийн тухай гурван мэдээллийг 2017-2021 оны хандлагын хамт нэг дор өгөх боломжтой байдлаар дүрслэв. Зураг 3.16-д тайлбарласан шүүгчийн ачаалал, цалингийн хэмжээ мөн 2-р бүлэгт харуулсан шүүгчийн ажиллагааны ачааллын мэдээллийг нэгтгэж 3D зургаар харуулав. Босоо тэнхлэгээр иргэний хэргийн шүүгчийн нэг жилийн цалингийн хэмжээг, хэвтээ тэнхлэгээр шүүгчийн ачаалал болон ажиллагаа (материал)-г тэмдэглэсэн тул тэнхлэгийн тоон утгуудыг харгалзуулан харж ойлгох боломжтой.

Шүүх	Хувьсагч	Кор.коэ (r_{y_1, x_k})	Ерөнхий дисперсийн өсөн нэмэгдэх хувь	Шүүхийн үйл ажиллагааны загвар
------	----------	-------------------------------	--	-----------------------------------

Эрүү	Ачаалал (x_1)	0.74	0.81	$y = 0.3x_1 + 0.05x_2 + 4x_3 + 0.4x_4 + 0.06x_5 + 0.1x_6 - 93600x_7$
	Үлдэгдэл хэрэг (x_2)	0.98		
	Ажиллагаа (x_3)	0.82		
	Шийдвэрлэсэн хэргийн хүн (x_4)	0.96		
	Үлдэгдэл хэргийн хүн (x_5)	0.98		
	Хүн амын нягтрал (x_6)	0.39		
	Цалин (x_7)	-0.40		
Иргэн	Ачаалал (x_1)	0.98	0.95	$y = 0.8x_1 + 0.01x_2 + 7x_3 + 0.6x_4 - 18000x_6 - 47x_7$
	Үлдэгдэл хэрэг (x_2)	0.26		
	Ажиллагаа (x_3)	0.84		
	Шийдвэрлэсэн хэргийн хариуцагч (x_4)	0.97		
	Хүн амын нягтрал (x_5)	0.16		
	Цалин (x_6)	-0.34		
	Томилолтын зардал (x_7)	-0.41		

Хүснэгт 3.5. Захын 3 дүүргийн анхан шатны шүүхийн үйл ажиллагааны загварын тодорхойлолт

Эрүүгийн хэрэг: **Корреляцийн коэффициентийн** утгыг тайлбарлая. Шүүхийн үйл ажиллагааны загвар (нэг шүүгчид ногдох)-т эрүүгийн хэргийн ачаалал 0.74 буюу хүчтэй, үлдэгдэл хэргийн тоо 0.98 буюу хүчтэй, ажиллагаа (материал)-ны тоо 0.82 буюу хүчтэй, шийдвэрлэсэн хэрэгт хамаарах хүний тоо 0.96 буюу хүчтэй, үлдэгдэл хэрэгт хамаарах хүний тоо 0.98 буюу хүчтэй, хүн амын нягтрал 0.39 буюу дунд зэрэг, цалингийн хэмжээ -0.40 буюу урвуу, дунд зэрэг хамааралтай байна. Шүүхийн үйл ажиллагааны загварт цалингийн хэмжээ урвуу, дунд зэрэг хамааралтай байгаа нь авсан ачаалал нэмэгдэхэд цалин буурсан гэсэн мэдээллийг өгч байна. Бүрэлдэхүүн хэсгийн загварт шийдвэрлэсэн хэрэг хамаарах хүний тоо, үлдэгдэл хэрэгт хамаарах хүний тоо өндөр нөлөө үзүүлж байна. Эрүүгийн хэргийн үйл ажиллагаанд хэрэгт хамаарах хүний тоо шийдвэрлэсэн хэргийн тооноос бага зэрэг өндөр байдаг гэсэн мэдээллийг өгч байна.

Ерөнхий дисперсийн өсөн нэмэгдэх хувийн утгыг тайлбарлая. ДЭХАШШ-н хувьд шийдвэрлэсэн хэргийн тогтолцооны загвар нь өгөгдсөн мэдээлэл (ачаалал, үлдэгдэл хэрэг, ажиллагаа гэх мэт)-н 81 хувийг тайлбарлаж байна. Эсрэг утгаар нь тайлбарлавал өгөгдсөн мэдээллийн 19 хувийг алдаж байна. Дээр тодорхойлсон загварууд хамгийн боломжит, өндөр хувийг агуулсан хувилбарууд юм.

Шүүхийн үйл ажиллагааны загварын утгыг тайлбарлая.

$$y = 0.3x_1 + 0.05x_2 + 4x_3 + 0.4x_4 + 0.06x_5 + 0.1x_6 - 93600x_7$$

Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд захын ДЭХАШШ-н эрүү, зөрчлийн хэрэг шийдвэрлэдэг нэг шүүгчийн нэг жилд шийдвэрлэсэн хэргийн тоо 0.3 хэргээр буюу 5 жилд 1-2 хэргээр, үлдэгдэл хэрэг 0.05 хэргээр (бараг өсөлтгүй), ажиллагаа жилд 4 материалаар, шийдвэрлэсэн хэрэгт хамаарах хүний тоо 0.4 буюу 5 жилд 2 хүнээр, үлдэгдэл хэрэгт хамаарах хүний тоо 0.06 хүнээр (бараг өсөлтгүй), хүн амын нягтрал 0.1 хүнээр буюу 5 жилд 0-1 хүнээр тус тус өссөн байна. Цалингийн хэмжээ загварт орсон хувьсагчдын өсөлтөөс шалтгаалан жилд 936000 төгрөгөөр буурсан байна. 2018 онд Багануур дүүргийн эрүү, зөрчлийн хэргийн шүүгчийн цалин өсөөд (Зураг 3.15-д тайлбарласан) буцаад буурсан, 2017, 2018 онд Багахангай дүүргийн шүүгчийн ачаалал бага байх үед цалин өндөр байснаа 2019 оноос хойш ачаалал өсөж байхад цалин буурсантай холбоотойгоор 936000 төгрөгөөр буурсан гэсэн үр дүнг харуулж байна. Шалтгааныг өөрөөр тайлбарлах боломжгүй.

Иргэний хэрэг: **Корреляцийн коэффициентийн** утгыг тайлбарлая. Шүүхийн үйл ажиллагааны загвар (нэг шүүгчид ногдох)-т иргэний хэргийн ачаалал 0.98 буюу хүчтэй, үлдэгдэл хэргийн тоо 0.26 буюу сулавтар, ажиллагаа (материал)-ны тоо 0.84 буюу хүчтэй, шийдвэрлэсэн хэргийг хариуцагч хүний тоо 0.97 буюу хүчтэй, хүн амын нягтрал 0.16 буюу сул, цалингийн хэмжээ -0.34 буюу сөрөг, дунд зэрэг, томилолтын зардал -0.41 буюу сөрөг, дунд зэрэг хамааралтай байна. Шүүхийн үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсгийн загварт хүн амын нягтрал хамгийн бага хамааралтай байна.

Ерөнхий дисперсийн өсөн нэмэгдэх хувийн утгыг тайлбарлая. ДИХАШШ-н хувьд шийдвэрлэсэн хэргийн тогтолцооны загвар нь өгөгдсөн мэдээлэл (эрүү, зөрчил, иргэн, захиргаа)-н 95 хувийг тайлбарлаж байна. Эсрэг утгаар нь тайлбарлавал өгөгдсөн мэдээллийн 5 хувийг алдаж байна. Дээр тодорхойлсон загварууд хамгийн боломжит, өндөр хувийг агуулсан хувилбарууд юм.


Шүүхийн үйл ажиллагааны загварын утгыг тайлбарлая.

$$y = 0.8x_1 + 0.01x_2 + 7x_3 + 0.6x_4 - 18000x_6 - 47x_7$$

Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд төвийн ДИХАШШ-н шүүгчийн нэг жилд шийдвэрлэсэн хэргийн тоо 0.8 хэргээр буюу 5 жилд 4 хэргээр, үлдэгдэл хэрэг 0.01 хэргээр (бараг өсөлтгүй), ажиллагаа жилд 7 материалаар, шийдвэрлэсэн хэрэгт хамаарах хариуцагчийн тоо 0.6 буюу 5 жилд 3 хариуцагчаар тус тус өссөн байна. Цалингийн хэмжээ жилд 18000 төгрөгөөр, томилолтын зардал 47 төгрөгөөр тус тус буурсан байна. Энэ нь 2021 онд Налайх дүүргийн иргэний хэргийн шүүгчийн цалин өссөн ч (Зураг 3.15-д тайлбарласан) 2017, 2018, 2019 оны цалингийн хэмжээ 2020 оны цалингаас өндөр байсан бөгөөд харгалзах жилүүдийн ачаалал цалингийнхаа эсрэг байсан гэх мэт шалтгаантай холбоотой. Үлдсэн 2 дүүргийн хувьд Зураг 3.15-гаас харна уу. Хүн амын нягтрал загвараас хасагдахуйц хамаарал сулаас гадна бараг өсөлтгүй шахаж коэффициенттой байсан тул загварт ороогүй болно.

- **Нийслэлийн хувьд**

Нийслэлийн 9 дүүргийн ДЭХАШШ, ДИХАШШ-н ерөнхий мэдээллийг товч Зураг 25а-д үзүүлэв. Зурагт захын болон төвийн дүүргийн шүүгчийн ажлын ачааллыг босоо тэнхлэгээр, шүүгчийн тоог хэвтээ тэнхлэгээр тэмдэглэн харуулав. Зураг 3.16-н эхний зурагт ЭХАШШ-н шүүгчийн ачааллыг, дараагийн зурагт ИХАШШ-н шүүгчийн ачаалал ба шүүгчийн тоог харуулав. Аль ч хэргийн шүүхийн хувьд төвийн дүүрэгт ажиллаж буй шүүгчийн ачаалал өндөр харагдаж байна.




Зураг 3.16. ДЭХАШШ, ДИХАШШ-д ажилласан шүүгчийн ачаалал, шүүгчийн тоо


Зураг 3.16-д захын болон төвийн дүүргийн шүүгчийн цалингийн хэмжээг босоо тэнхлэгээр, Шалгуур 34-д өгсөн шүүгчийн тоог хэвтээ тэнхлэгээр харуулав. Зураг 3.16-гийн эхний зурагт ЭХАШШ-н шүүгчийн цалин, дараагийн зурагт ИХАШШ-н шүүгчийн

цалингийн хэмжээг дүрслэв. Эхний зурагт дүрсэлсэн эрүү, зөрчлийн хэргийн шүүгчийн цалингийн хэмжээ төвийн ба захын дүүргийн шүүгчийн цалингийн хувьд бараг адил харагдаж байна. 2021 онд төвийн дүүргийн шүүгчийн жилийн цалингийн хэмжээ өссөн дүр зураг харагдаж байна. Зураг 3.15, 3.16-гээс харвал ачаалал, цалингийн хэмжээ 2 хоорондоо уялдахгүй байгааг харуулж байна.

Зураг 3.17-гийн дараагийн зурагт дүрсэлсэн иргэний хэргийн шүүгчийн цалингийн хэмжээний хувьд төвийн дүүрэгт ажиллаж буй шүүгчийн цалингийн хэмжээ, захын дүүргийн цалингийн хэмжээг бодвол бага харагдаж байна. Гэтэл Зураг 3.16-д төвийн дүүргийн иргэний хэргийн шүүгчийн ачаалал, захын дүүргийн шүүгчийн ачааллыг бодвол их байсан. Ачаалал, цалингийн хэмжээ 2 хоорондоо мөн уялдахгүй байгааг харуулж байна.



Зураг 3.17. Захын ДЭХАШШ, ДИХАШШ-н шүүгчийн тоо, цалин (сая.төг)



Зураг 3.18. ДЭХАШШ, ДИХАШШ-н шүүгчийн мэдээлэл

Зураг 3.18-д эрүү, иргэний хэргийн нэг шүүгчийн тухай гурван мэдээллийг 2017-2021 оны хандлагын хамт нэг дор өгөх боломжтой байдлаар дүрслэв. Зураг 3.16, 3.17-д тайлбарласан шүүгчийн ачаалал, цалингийн хэмжээ мөн 2-р бүлэгт дурдсан шүүгчийн ажиллагааны мэдээллийг нэгтгэж 3D зургаар харуулав. Зураг 3.18-ийн эхний зурагт ДЭХАШШ-н шүүгчийн мэдээллийг, 2-р зурагт ДИХАШШ-н шүүгчийн мэдээллийг дүрслэв. Босоо тэнхлэгээр шүүгчийн нэг жилийн цалингийн хэмжээг, хэвтээ тэнхлэгээр шүүгчийн ачаалал болон ажиллагаа (материал)-г тэмдэглэсэн тул тэнхлэгийн тоон утгуудыг харгалзуулан харж ерөнхий мэдээлэл авах боломжтой.

3.2.1.2. Аймгийн шүүх

Аймаг дахь эрүү, иргэн, захиргааны хэргийн 21 АШШ-н үйл ажиллагааг ерөнхий дүр зургаар тодорхойлохын тулд 3D хэмжээст график дүрслэлээр харуулав. Графикийн тэнхлэгийн тухай тайлбарыг оруулъя. Үүнд:


Аймаг гэсэн тэнхлэгийн 5, 10, 15, 20 гэсэн тоогоор тэмдэглэсэн цэгийн утгыг аймаг дахь анхан шатны шүүхээр төлөөлүүлсэн бөгөөд дараах дарааллаар ойлгоно.

- | | | |
|--------------|----------------|--------------|
| 1-Баян-Өлгий | 8-Булган | 15-Дундговь |
| 2-Говь-Алтай | 9-Орхон | 16-Өмнөговь |
| 3-Завхан | 10-Хөвсгөл | 17-Сэлэнгэ |
| 4-Увс | 11-Өвөрхангай | 18-Төв |
| 5-Ховд | 12-Говьсүмбэр | 19-Дорнод |
| 6-Архангай | 13- Дархан-Уул | 20-Хэнтий |
| 7-Баянхонгор | 14-Дорноговь | 21-Сүхбаатар |

Он гэсэн тэнхлэгийн 1, 2, 3, 4, 5 гэсэн тоогоор тэмдэглэсэн цэгийн утгыг 2017-2021 он гэж ойлгоно.


Босоо тэнхлэгээр тайлбар өгөх үзүүлэлт (ачаалал, шүүгчийн тоо, цалин)-г илэрхийлнэ.

- Эрүү, зөрчлийн хэргийн хувьд



Зураг 3.19. АЭХАШШ-д ажилласан нэг шүүгчийн ачаалал


Зураг 3.19-д эрүүгийн хэргийн шүүхэд ажилласан шүүгчийн нэг жилд хянан шийдвэрлэсэн эрүү ба зөрчлийн хэргийн тоог харуулав. АЭХАШШ-н шүүгч эрүү ба зөрчлийн хэрэг дээр ажилладаг онцлогтой тул Зураг 3.19 нэг шүүгчийн ачаалалтай холбоотой. Зургаас харвал 2017-2020 он хүртэл хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоо аймаг бүр дээр жил бүр бага зэргийн өсөлттэй явсан байна. 2021 онд хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоо буурсан төлөв харагдаж байна. Зөрчлийн хэргийн хувьд 2017 онд энэ хэргийн мэдээлэл байхгүй байсан байна. 2018-2020 он хүртэл зөрчлийн хэргийн ачаалал өссөн бөгөөд 2021 онд 2020 оныхтой адил ачаалал бараг хэвээр хадгалагдсан дүр зураг ажиглагдаж байна.



Зураг 3.20. АЭХАШШ-д ажилласан шүүгчийн тоо, цалин (сая.төг)


Зураг 3.20-д АЭХАШШ-д ажилласан шүүгчийн тоо, шүүгчийн нэг жилийн цалингийн хэмжээг харуулав. Зургаас харвал 2019 онд зарим аймгийн эрүүгийн хэргийн шүүгчийн тоо буурсан байна. 2020-2021 онд шүүгчийн тоо өссөн төлөв харагдаж байна. Цалингийн хувьд 5 жилийн огцом өөрчлөлтгүй хэвээр хадгалагдсан гэж тайлбарлаж болохоор байна.

Зураг 3.19, 3.20-д харуулсан мэдээллийг 2-р бүлгийн Хотелингийн шинжүүрийн үр дүн (Хүснэгт 2.29)-г баримтлан дээр 2D, 3D хэмжээст график дүрслэлээр аймаг тус бүрийн шүүхийн үйл ажиллагаагаар задлая. Зураг 3.20-н мэдээллийг 2-р бүлгийн Хотелингийн шинжүүрийн үр дүнтэй холбож задлахдаа шүүгчийн эрүүгийн хэргийн хянан шийдвэрлэсэн ачааллыг Хүснэгт 2.29, зөрчлийн хэргийн хянан шийдвэрлэсэн ачааллыг Хүснэгт 2.30-г баримтлан задлах ёстой боловч нэг шүүгчийн ачаалалтай холбоотой тул дүгнэлтийг хялбар тайлбарлах үүднээс Хүснэгт 2.29-н кластерийг баримтлан тайлбар өгнө.



Зураг 3.21. АЭХАШШ-н шүүгчийн эрүү, зөрчлийн хэргийн ачаалал, шүүгчийн тоо, 1-р кластер


Зураг 3.21-гийн эхний зурагт шүүгчийн хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн ачаалал, дараагийн зурагт зөрчлийн хэргийн ачааллын харуулав. Хоёр графикийн өгөгдөл нэг шүүгчийн ачаалалтай холбоотой тайлбарлагдана. Дундговь, Завхан, Говь-Алтай аймгийн шүүгчийн эрүүгийн хэргийн ачаалал 2021 онд өндөр байжээ. Зөрчлийн хэргийн ачааллаар Завхан, Говь-Алтай аймгийн шүүгч 2020 онд, Дундговь аймгийн шүүгч 2021 онд өндөр байжээ. Говьсүмбэр аймгийн шүүгчийн эрүүгийн хэргийн ачаалал 2019 онд, зөрчлийн хэргийн ачаалал 2021 онд хамгийн өндөр байжээ.



Зураг 3.22. АЭХАШШ-н шүүгчийн эрүү, зөрчлийн хэргийн ачаалал, шүүгчийн тоо, 2-р кластер


Зураг 3.22-н эхний зурагт шүүгчийн хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн ачаалал, дараагийн зурагт зөрчлийн хэргийн ачааллын харуулав. Хоёр графикийн өгөгдөл нэг шүүгчийн ачаалалтай холбоотой тайлбарлагдана. Баян-Өлгий аймгийн шүүгчийн эрүү,

зөрчлийн хэргийн ачаалал 2020 онд хамгийн өндөр байжээ. Өмнөговь аймгийн шүүгчийн эрүүгийн хэргийн ачаалал 2018 онд, зөрчлийн хэргийн ачаалал 2021 онд хамгийн өндөр байжээ. Дорноговь аймгийн шүүгчийн эрүүгийн хэргийн ачаалал 2019 онд өндөр, зөрчлийн хэргийн ачаалал 2019-2021 онд ижил 80 орчим байжээ.



Зураг 3.23. АЭХАШШ-н шүүгчийн тоо, цалин (сая.төг), 1,2-р кластер


Зураг 3.21, 3.22-д эрүүгийн хэргийн шүүгчийн 1, 2-р кластерийн ачааллыг тайлбарласан. Эдгээр кластерийн шүүгчийн цалингийн тухай Зураг 3.23-д шүүгчийн цалин, шүүгчийн тоо (Шалгуур 3-д өгсөн шүүгчийн тооноос зөрнө. Шалгуур 34-д өгсөн шүүгчийн тоо болно.)-г харуулав. 1, 2-р кластерийн аймгуудын хувьд 5 жилийн хугацаанд бүгд 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй ажилласан байна. Дорноговь аймагт 2021 онд 4 шүүгч ажиллажээ. Завхан аймгийн шүүгчийн цалин 2018 онд хамгийн өндөр буюу 42.5-45 сая төгрөг байжээ. Зураг 3.21-гийн өгөгдөлтэй холбож үзэхэд 2018 онд эрүү, зөрчлийн хэргийн ачаалал бусад ижил кластерийн аймгуудаас ялгарахуйц өндөр биш байсан нь ачаалал, цалингийн хэмжээ 2 хоорондоо уялдахгүй байгааг харуулж байна. 2-р зургийн хувьд Дорноговь аймгийн шүүгчийн цалин 2017, 2018 онд хамгийн өндөр буюу 47.5-50 сая төгрөг байжээ. Зураг 3.22-гийн өгөгдөлтэй холбож үзэхэд 2017, 2018 онд эрүү, зөрчлийн хэргийн ачаалал бусад ижил кластерийн аймгуудаас ялгарахуйц өндөр биш байсан нь ачаалал, цалингийн хэмжээ 2 хоорондоо уялдахгүй байгааг харуулж байна. Энд өгсөн дүгнэлтийн хувьд өөр шалгаан байхыг үгүйсгэх үндэсгүй юм.



Зураг 3.24. АЭХАШШ-н шүүгчийн мэдээлэл, 1, 2-р кластер


Зураг 3.24-д 1-р кластерийн дөрвөн аймаг, 2-р кластерийн гурван аймгийн эрүүгийн хэргийн нэг шүүгчийн тухай гурван мэдээллийг 2017-2021 оны хандлагын хамт нэг дор өгөх боломжтой байдлаар дүрслэв. Эрүүгийн хэргийн нэг шүүгчийн ачааллыг тухайн жилд хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоон дээр зөрчлийн хэргийн тоог 10.2-д хуваасан

дүнг нэмж нийт шүүгчийн тоонд хувааж тодорхойлсон дүн болно. Зураг 3.20, 3.21, 3.22-д тайлбарласан шүүгчийн ачаалал, цалингийн хэмжээ мөн 2-р бүлэгт дурдсан шүүгчийн ажиллагааны мэдээллийг нэгтгэж 3D зургаар харуулав. Босоо тэнхлэгээр шүүгчийн нэг жилийн цалингийн хэмжээг, хэвтээ тэнхлэгээр шүүгчийн ачаалал болон ажиллагаа (материал)-г тэмдэглэсэн тул тэнхлэгийн тоон утгуудыг харгалзуулан харж ерөнхий мэдээлэл авна уу.



Зураг 3.25. АЭХАШШ-н шүүгчийн эрүү, зөрчлийн хэргийн ачаалал, шүүгчийн тоо, 3-р кластер


Зураг 3.25-гийн эхний зурагт шүүгчийн хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн ачаалал, дараагийн зурагт зөрчлийн хэргийн ачааллын харуулав. Хоёр графикийн өгөгдөл нэг шүүгчийн ачаалалтай холбоотой тайлбарлагдана. Увс, Ховд, Өвөрхангай аймгийн шүүгчийн эрүүгийн хэргийн ачаалал 2019 онд хамгийн өндөр буюу 100 орчим хэрэг хянан шийдвэрлэжээ. Зөрчлийн хэргийн ачааллаар Увс аймгийн шүүгч 2020, 2021 онд, Ховд аймгийн шүүгч 2019, 2020 онд 200 орчим хэрэг, Өвөрхангай аймгийн шүүгч 2019 онд өндөр хамгийн өндөр буюу 500 орчим хэрэг хянан шийдвэрлэжээ. Өвөрхангай аймгийн шүүгч бусад аймгийн шүүгчийг бодвол олон зөрчлийн хэрэг дээр ажилладаг онцлогтой харагдаж байна.



Зураг 3.26. АЭХАШШ-н шүүгчийн эрүү, зөрчлийн хэргийн ачаалал, шүүгчийн тоо, 4-р кластер


Зураг 3.26-гийн эхний зурагт шүүгчийн хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн ачаалал, дараагийн зурагт зөрчлийн хэргийн ачааллын харуулав. Хоёр графикийн өгөгдөл нэг шүүгчийн ачаалалтай холбоотой тайлбарлагдана. Эхний зураг буюу эрүүгийн хэргийн хувьд 4-р кластер дотроос Хэнтий аймгийн шүүгч 2020, 2021 онд хамгийн өндөр ачаалалтай ажиллаж 130-150 хэрэг хянан шийдвэрлэжээ. 2-р зураг буюу зөрчлийн хэргийн хувьд 4-р кластер дотроос Хэнтий аймгийн шүүгч мөн адил 2020, 2021 онд хамгийн өндөр, Баянхонгор аймгийн шүүгч 2021 өндөр ачаалалтай ажиллаж 250 орчим хэрэг хянан

шийдвэрлэжээ. Хэнтий аймгийн шүүгч бусад аймгийн шүүгчийг бодвол олон зөрчлийн хэрэг дээр ажилладаг онцлогтой харагдаж байна.



Зураг 3.27. АЭХАШШ-н шүүгчийн тоо, цалин (сая.төг), 3,4-р кластер


Зураг 3.24, 3.25-д эрүүгийн хэргийн шүүгчийн 3, 4-р кластерийн ачааллыг тайлбарласан. Эдгээр кластерийн шүүгчийн цалингийн тухай Зураг 3.26-д шүүгчийн цалин, шүүгчийн тоо (Шалгуур 3-д өгсөн шүүгчийн тооноос зөрнө. Шалгуур 34-д өгсөн шүүгчийн тоо болно)-г харуулав. 3, 4-р кластерийн аймгуудын хувьд 5 жилийн ихэнх хугацаанд 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй ажилласан байна. Эхний зургийн хувьд Ховд аймагт 2018, 2019 онд 2 шүүгч ажиллажээ. Ховд аймгийн шүүгчийн цалин 2018, 2019 онд хамгийн өндөр буюу 42.5 сая төгрөг орчим байжээ. Зураг 3.26-гийн өгөгдөлтэй холбож үзэхэд 2019 онд эрүүгийн хэргийн ачаалал бусад ижил кластерийн аймгуудаас ялгарахуйц өндөр байсан нь ачаалал, цалингийн хэмжээ 2 хоорондоо уялдаатай байгааг харуулж байна. 2-р зургийн хувьд Сэлэнгэ аймгийн шүүгчийн цалин 2020 онд хамгийн өндөр буюу 62 сая төгрөг орчим байжээ. Зураг 3.23-гийн өгөгдөлтэй холбож үзэхэд 2020 онд эрүү, зөрчлийн хэргийн ачаалал бусад ижил кластерийн аймгуудаас ялгарахуйц өндөр биш байсан нь ачаалал, цалингийн хэмжээ 2 хоорондоо уялдахгүй байгааг харуулж байна. Хэнтий, Баянхонгор аймгийн эрүүгийн хэргийн шүүгчийн ачаалал 2020, 2021 онд 4-р кластерийн бусад аймгаас өндөр байсан ч цалингийн хэмжээтэй уялдахгүй байна. Энд өгсөн дүгнэлтийн хувьд өөр шалгаан байхыг үгүйсгэх үндэсгүй юм.



Зураг 3.28. АЭХАШШ-н шүүгчийн мэдээлэл, 3,4-р кластер

Зураг 3.28-д 3-р кластерийн гурван аймаг, 4-р кластерийн зургаан аймгийн эрүүгийн хэргийн нэг шүүгчийн тухай гурван мэдээллийг 2017-2021 оны хандлагын хамт нэг дор өгөх


боломжтой байдлаар дүрслэв. Эрүүгийн хэргийн нэг шүүгчийн ачааллыг тухайн жилд хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоон дээр зөрчлийн хэргийн тоог 10.2-д хуваасан дүнг нэмж нийт шүүгчийн тоонд хувааж тодорхойлсон дүн болно. Зураг 3.24, 3.25, 3.26-д тайлбарласан шүүгчийн ачаалал, цалингийн хэмжээ мөн 2-р бүлэгт дурдсан шүүгчийн ажиллагааны мэдээллийг нэгтгэж 3D зургаар харуулав. Босоо тэнхлэгээр шүүгчийн нэг жилийн цалингийн хэмжээг, хэвтээ тэнхлэгээр шүүгчийн ачаалал болон ажиллагаа (материал)-г тэмдэглэсэн тул тэнхлэгийн тоон утгуудыг харгалзуулан харж ерөнхий мэдээлэл авна уу.



Зураг 3.29. АЭХАШШ-н шүүгчийн эрүү, зөрчлийн хэргийн ачаалал, шүүгчийн тоо, кластергүй бүлэг

Зураг 3.28, 3.29-д дүрсэлсэн кластергүй бүлэгт хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоогоор бусад аймгуудаас ялгаатай өөрийн гэсэн онцлогтой аймгуудыг багтаасан.


Зураг 3.29-гийн эхний зурагт шүүгчийн хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн ачаалал, дараагийн зурагт зөрчлийн хэргийн ачааллын харуулав. Хоёр графикийн өгөгдөл нэг шүүгчийн ачаалалтай холбоотой тайлбарлагдана. Хөвсгөл аймгийн шүүгчийн эрүүгийн хэргийн ачаалал 2019 онд хамгийн өндөр буюу 130 орчим хэрэг хянан шийдвэрлэжээ. Зөрчлийн хэргийн ачааллаар Орхон аймгийн шүүгч 2019, 2020 онд 300 орчим хэрэг буюу хамгийн өндөр хэрэг хянан шийдвэрлэжээ. Орхон аймгийн шүүгч олон зөрчлийн хэрэг дээр ажилладаг онцлогтой харагдаж байна.



Зураг 3.30. АЭХАШШ-н шүүгчийн эрүү, зөрчлийн хэргийн ачаалал, шүүгчийн тоо, кластергүй бүлэг


Зураг 3.30-гийн эхний зурагт шүүгчийн хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн ачаалал, дараагийн зурагт зөрчлийн хэргийн ачааллын харуулав. Хоёр графикийн өгөгдөл нэг шүүгчийн ачаалалтай холбоотой тайлбарлагдана. Эхний зураг буюу эрүүгийн хэргийн хувьд кластергүй бүлэгт Дорнод аймгийн шүүгч хамгийн өндөр ачаалалтай ажилладаг бөгөөд хамгийн багадаа 70 хэрэг, хамгийн ихдээ 160 хүртэл хэргийг нэг жилд хянан шийдвэрлэжээ. 2-р зураг буюу зөрчлийн хэргийн хувьд кластергүй бүлэг дотроос мөн Дорнод аймгийн шүүгч хамгийн өндөр ачаалалтай ажиллаж 200 хүртэл хэрэг 2019, 2020 онд

хянан шийдвэрлэжээ. Дорнод аймгийн шүүгч бусад аймгийн шүүгчийг бодвол хамгийн олон эрүү, зөрчлийн хэрэг дээр ажилладаг онцлогтой харагдаж байна.



Зураг 3.31. АЭХАШШ-н шүүгчийн тоо, цалин (сая.төг), кластергүй бүлэг

Зураг 3.29, 3.30-д эрүүгийн хэргийн шүүгчийн ачааллын кластергүй бүлэг буюу өөрийн онцлогтой аймгуудын шүүгчийн ачааллыг тайлбарласан. Эдгээр кластерийн шүүгчийн цалингийн тухай Зураг 3.31-д шүүгчийн цалин, шүүгчийн тоо (Шалгуур 3-д өгсөн шүүгчийн тооноос зөрнө. Шалгуур 34-д өгсөн шүүгчийн тоо болно.)-г харуулав. Кластергүй бүлгийн аймгуудын хувьд 5 жилийн ихэнх хугацаанд 4-5 шүүгчийн бүрэлдэхүүнтэй ажилласан байна. Эхний зургийн хувьд Орхон, Хөвсгөл аймагт 2017-2021 онд 4 шүүгч ажиллажээ. Орхон аймгийн шүүгчийн цалин 2020 онд хамгийн өндөр буюу 45 сая төгрөг орчим байжээ. Зураг 3.29-гийн өгөгдөлтэй холбож үзэхэд Хөвсгөл аймгийн эрүүгийн хэргийн шүүгчийн ачааллаас ялгарахуйц өндөр биш байсан нь ачаалал, цалингийн хэмжээ 2 хоорондоо уялдахгүй байгааг харуулж байна. 2-р зургийн хувьд Дорнод аймагт эрүүгийн хэргийн 3 шүүгч ажиллаж ирсэн бөгөөд Дархан-Уул, Төв аймгийн шүүгчийн цалингийн хэмжээнээс 2017, 2018 онд өндөр байжээ. Зураг 3.30-гийн өгөгдөлтэй холбож үзэхэд Дорнод аймгийн шүүгч 2019-2021 онд ачааллын хэмжээндээ хүрэхүйц цалинтай байгаагүй харагдаж байгаа нь цалингийн хэмжээ, ачааллын түвшинтэй уялдахгүй байсныг харуулж байна. Энд өгсөн дүгнэлтийн хувьд өөр шалгаан байхыг үгүйсгэх үндэсгүй юм.




Зураг 3.32. АЭХАШШ-н шүүгчийн мэдээлэл, кластергүй бүлэг

Зураг 3.32-д кластергүй бүлгийн таван аймгийн эрүүгийн хэргийн нэг шүүгчийн тухай гурван мэдээллийг 2 хувааж 2017-2021 оны хандлагын хамт нэг дор өгөх боломжтой байдлаар дүрслэв. Эрүүгийн хэргийн нэг шүүгчийн ачааллыг тухайн жилд хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоон дээр зөрчлийн хэргийн тоог 10.2-д хуваасан дүнг нэмж нийт шүүгчийн тоонд хувааж тодорхойлсон дүнг болно. Зураг 3.29, 3.30, 3.31-д


тайлбарласан шүүгчийн ачаалал, цалингийн хэмжээ мөн 2-р бүлэгт дурдсан шүүгчийн ажиллагааны мэдээллийг нэгтгэж 3D зургаар харуулав. Босоо тэнхлэгээр шүүгчийн нэг жилийн цалингийн хэмжээг, хэвтээ тэнхлэгээр шүүгчийн ачаалал болон ажиллагаа (материал)-г тэмдэглэсэн тул тэнхлэгийн тоон утгуудыг харгалзуулан харж ерөнхий мэдээлэл авна уу.

- Иргэний хэргийн хувьд



Зураг 3.33. АИХАШШ-д ажилласан шүүгчийн ачаалал, шүүгчийн тоо


Зураг 3.33-д иргэний хэргийн шүүхэд ажилласан шүүгчийн нэг жилд хянан шийдвэрлэсэн хэргийн тоог харуулав. Зургаас харвал 2017-2021 он хүртэл хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн тоо аймаг бүр дээр жил бүр өсөлттэй явсан байна. 2021 онд хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн тоо буурсан төлөв харагдаж байна. Шүүгчийн тооны хувьд 2017-2021 онд шүүгчийн тоо огцом өөрчлөлтгүй хэвийн байсан төлөв харагдаж байна.



Зураг 3.34. АИХАШШ-д ажилласан шүүгчийн цалин (сая.төг)


Цалингийн хувьд 2017-2020 он хүртэл огцом өөрчлөлтгүй хэвээр хадгалагдсан гэж тайлбарлаж болохоор байна. 2021 онд цалингийн хэмжээ бага зэрэг буурсан төлөв ажиглагдаж байна. Сэлэнгэ аймгийн иргэний хэргийн шүүгчийн цалин 2021 онд өссөн бөгөөд хамгийн өндөр цалин авсан харагдаж байна.

Зураг 3.33, 3.34-д харуулсан мэдээллийг дэлгэрэнгүй тайлбарлая. 2-р бүлгийн Хотелингийн шинжүүрийн үр дүн (Хүснэгт 2.31)-г баримтлан дээр 2D, 3D хэмжээст график дүрслэлээр аймаг тус бүрийн шүүхийн үйл ажиллагааг харуулъя.




Зураг 3.35. АИХАШШ-н шүүгчийн ачаалал, шүүгчийн тоо, 1-р кластер

Зураг 3.35-д Шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн тоогоор 1-р кластерт орсон зургаан аймгийн мэдээллийг харуулав. Дундговь, Говь-Алтай аймгийн иргэний хэргийн шүүгч 2020 онд, Завхан аймгийн иргэний хэргийн шүүгч 2018 онд хамгийн их ачаалалтай ажилласан байна. Сэлэнгэ аймгийн иргэний хэргийн шүүгч 2020 онд, Өмнөговь аймгийн иргэний хэргийн шүүгч 2018 онд, Сүхбаатар аймгийн иргэний хэргийн шүүгч 2018, 2020 онд хамгийн их ачаалалтай ажилласан байна. Сэлэнгэ аймгийн ИХАШШ 2017-2019 онд хамгийн олон буюу 4 шүүгчтэй байснаа 2020, 2021 онд шүүгчийн тоо буурсан.




Зураг 3.36. АИХАШШ-н шүүгчийн тоо, цалин (сая.төг), 1-р кластер

Иргэний хэргийн шүүгчийн тоог шүүгчийн цалингийн хамт задалж Зураг 3.36-д харуулав. Зургийн босоо тэнхлэгээр шүүгчийн нэг жилийн цалингийн хэмжээг, хэвтээ тэнхлэгээр эрүүгийн хэргийн шүүхэд ажилласан шүүгчийн тоо (Шалгуур 3-д өгсөн шүүгчийн тооноос зөрнө. Шалгуур 34-д өгсөн шүүгчийн тоо болно.)-г зурагт харуулав. Цалингийн хэмжээний хувьд Говь-Алтай аймгийн шүүгчийн цалин 2019 онд, Сэлэнгэ аймгийн шүүгчийн цалин 2021 онд хамгийн өндөр байжээ. Сэлэнгэ аймгийн иргэний хэргийн шүүхэд 2 шүүгч ажилласантай холбоотой шүүгчийн цалин өндөр байж магадгүй ч нэг шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн тоогоор 1-р кластерийн бусад аймгаас ялгарахуйц өндөр биш харагдаж байна. Сэлэнгэ аймгийн шүүгчийн ачаалал, цалингийн хэмжээ 2 хоорондоо уялдахгүй байгааг харуулж байна.




Зураг 3.37. АИХАШШ-н шүүгчийн мэдээлэл, 1-р кластер

Зураг 3.37-д иргэний хэргийн нэг шүүгчийн тухай гурван мэдээллийг 2017-2021 оны хандлагын хамт нэг дор өгөх боломжтой байдлаар дүрслэв. Зураг 3.35, 3.36-д тайлбарласан шүүгчийн ачаалал, цалингийн хэмжээ мөн 2-р бүлэгт дурдсан шүүгчийн ажиллагааны мэдээллийг нэгтгэж 3D зургаар харуулав. Босоо тэнхлэгээр шүүгчийн нэг жилийн цалингийн хэмжээг, хэвтээ тэнхлэгээр шүүгчийн ачаалал болон ажиллагаа (материал)-г тэмдэглэсэн тул тэнхлэгийн тоон утгуудыг харгалзуулан харж ерөнхий мэдээлэл авах боломжтой.




Зураг 3.38. АИХАШШ-н ачаалал, шүүгчийн тоо, цалин (сая.төг), 2-р кластер

Зураг 3.38-гийн эхний зурагт шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн тоогоор 2-р кластерт орсон гурван аймгийн шүүгчийн ачаалал, шүүгчийн тоон мэдээллийг харуулав. Ховд, Өвөрхангай, Булган аймгийн иргэний хэргийн шүүгч 2020 онд хамгийн их ачаалалтай ажилласан байна. 2021 онд эдгээр гурван аймгийн шүүгчийн ачаалал буурсан байна. Дараагийн зурагт шүүгчийн цалин, шүүгчийн тоо (Шалгуур 3-д өгсөн шүүгчийн тооноос зөрнө. Шалгуур 34-д өгсөн шүүгчийн тоо болно.)-г харуулав. Өвөрхангай аймгийн шүүгч 2017, 2019 онд хамгийн өндөр буюу 45 сая орчим төгрөгийн цалинтай байжээ.




Зураг 3.39. АИХАШШ-н ачаалал, шүүгчийн тоо, цалин (сая.төг), 3-р кластер

Зураг 3.39-гийн эхний зурагт шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн тоогоор 3-р кластерт орсон дөрвөн аймгийн шүүгчийн ачаалал, шүүгчийн тоон мэдээллийг харуулав. Увс, Хэнтий, Баянхонгор, Архангай аймгийн иргэний хэргийн шүүгч 2020 онд хамгийн их ачаалалтай ажилласан байна. 2021 онд эдгээр дөрвөн аймгийн шүүгчийн ачаалал буурсан байна. Дараагийн зурагт шүүгчийн цалин, шүүгчийн тоо (*Шалгуур 3-д өгсөн шүүгчийн тооноос зөрнө. Шалгуур 34-д өгсөн шүүгчийн тоо болно.*)-г харуулав. Хэнтий аймгийн шүүгч 2020 онд хамгийн өндөр буюу 40 сая орчим төгрөгийн цалинтай байжээ.




Зураг 3.40. АИХАШШ-н шүүгчийн мэдээлэл, 1, 2-р кластер

Зураг 3.40-д иргэний хэргийн нэг шүүгчийн тухай гурван мэдээллийг 2017-2021 оны хандлагын хамт нэг дор өгөх боломжтой байдлаар дүрслэв. Зураг 3.40-д тайлбарласан шүүгчийн ачаалал, цалингийн хэмжээ мөн 2-р бүлэгт дурдсан шүүгчийн ажиллагааны мэдээллийг нэгтгэж 3D зургаар харуулав. Босоо тэнхлэгээр шүүгчийн нэг жилийн цалингийн хэмжээг, хэвтээ тэнхлэгээр шүүгчийн ачаалал болон ажиллагаа (материал)-г тэмдэглэсэн тул тэнхлэгийн тоон утгуудыг харгалзуулан харж ерөнхий мэдээлэл авах боломжтой.



Зураг 3.41. АИХАШШ-н ачаалал, шүүгчийн тоо, цалин (сая.төг), 4-р кластер


Зураг 3.41-гийн эхний зурагт шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн тоогоор 4-р кластерт орсон хоёр аймгийн шүүгчийн ачаалал, шүүгчийн тоон мэдээллийг харуулав. Төв, Дорнод аймгийн иргэний хэргийн шүүгч 2020 онд хамгийн их ачаалалтай ажилласан байна. 2021 онд эдгээр аймгийн шүүгчийн ачаалал буурсан байна. Дараагийн зурагт шүүгчийн цалин, шүүгчийн тоо (Шалгуур 3-д өгсөн шүүгчийн тооноос зөрнө. Шалгуур 34-д өгсөн шүүгчийн тоо болно.)-г харуулав. Дорнод аймгийн шүүгч 2021 онд хамгийн өндөр буюу 44 сая орчим төгрөгийн цалинтай байжээ.



Зураг 3.42. АИХАШШ-н шүүгчийн мэдээлэл, 4-р кластер


Зураг 3.42-д иргэний хэргийн нэг шүүгчийн тухай гурван мэдээллийг 2017-2021 оны хандлагын хамт нэг дор өгөх боломжтой байдлаар дүрслэв. Зураг 3.41-д тайлбарласан шүүгчийн ачаалал, цалингийн хэмжээ мөн 2-р бүлэгт дурдсан шүүгчийн ажиллагааны мэдээллийг нэгтгэж 3D зургаар харуулав. Босоо тэнхлэгээр шүүгчийн нэг жилийн цалингийн хэмжээг, хэвтээ тэнхлэгээр шүүгчийн ачаалал болон ажиллагаа (материал)-г тэмдэглэсэн тул тэнхлэгийн тоон утгуудыг харгалзуулан харж ерөнхий мэдээлэл авах боломжтой.

Дараагийн зургаас ялгаатай хэв шинжтэй аймгуудын кластерийн бүлэг буюу кластергүй бүлгийн мэдээлэл эхэлнэ.




Зураг 3.43. АИХАШШ-н ачаалал, шүүгчийн тоо, цалин (сая.төг), кластергүй бүлэг

Зураг 3.43-гийн эхний зурагт шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн тоогоор кластергүй бүлэг буюу өөрийн онцлог шинжтэй аймгуудын шүүгчийн ачаалал, шүүгчийн тоон мэдээллийг харуулав. Дархан-Уул аймгийн иргэний хэргийн шүүгч 2018 онд, Орхон аймгийн шүүгч 2019-2021 онд, Хөвсгөл аймгийн шүүгч 2020 онд их ачаалалтай ажилласан байна. Дараагийн зурагт шүүгчийн цалин, шүүгчийн тоо (Шалгуур 3-д өгсөн шүүгчийн тооноос зөрнө. Шалгуур 34-д өгсөн шүүгчийн тоо болно.)-г харуулав. Дархан-Уул аймгийн иргэний хэргийн шүүгч 2018, 2020 онд хамгийн өндөр буюу 42 сая орчим төгрөгийн цалинтай байжээ.



Зураг 3.44. АИХАШШ-н ачаалал, шүүгчийн тоо, цалин (сая.төг), кластергүй бүлэг


Зураг 3.44-гийн эхний зурагт шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн тоогоор кластергүй бүлэг буюу ялгаатай хэв шинжтэй аймгуудын шүүгчийн ачаалал, шүүгчийн тоон мэдээллийг харуулав. Дорноговь, Баян-Өлгий аймгийн иргэний хэргийн шүүгч 2020 онд хамгийн их ачаалалтай ажилласан байна. Говьсүмбэр аймгийн шүүгчийн ачаалал тогтмол байсан дүр зурагтай харагдаж байна. Дараагийн зурагт шүүгчийн цалин, шүүгчийн тоо (Шалгуур 3-д өгсөн шүүгчийн тооноос зөрнө. Шалгуур 34-д өгсөн шүүгчийн тоо болно.)-г харуулав. Дорноговь аймгийн иргэний хэргийн шүүгч 2021 онд хамгийн өндөр буюу 44 сая орчим төгрөгийн цалинтай байжээ. Говьсүмбэр аймгийн цалингийн мэдээлэл буруу ирсэн байх магадлалтай тул тодорхой дүгнэлт бичих боломжгүй.



Зураг 3.45. АИХАШШ-н шүүгчийн мэдээлэл, 5-р кластер


Зураг 3.45-д иргэний хэргийн нэг шүүгчийн тухай гурван мэдээллийг 2017-2021 оны хандлагын хамт нэг дор өгөх боломжтой байдлаар дүрслэв. Зураг 3.45-д тайлбарласан шүүгчийн ачаалал, цалингийн хэмжээ мөн 2-р бүлэгт дурдсан шүүгчийн ажиллагааны мэдээллийг нэгтгэж 3D зургаар харуулав. Босоо тэнхлэгээр шүүгчийн нэг жилийн цалингийн хэмжээг, хэвтээ тэнхлэгээр шүүгчийн ачаалал болон ажиллагаа (материал)-г тэмдэглэсэн тул тэнхлэгийн тоон утгуудыг харгалзуулан харж ерөнхий мэдээлэл авах боломжтой.

- Захиргааны хэргийн хувьд



Зураг 3.46. АЗХАШШ-д ажилласан шүүгчийн ачаалал, шүүгчийн тоо


Зураг 3.46-д захиргааны хэргийн шүүхэд ажилласан шүүгчийн нэг жилд хянан шийдвэрлэсэн хэргийн тоог харуулав. Зургаас харвал 2017-2021 он хүртэл хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийн тоо аймаг бүр дээр жил бүр тогтмол явсан байна. 2021 онд хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийн тоо буурсан төлөв харагдаж байна. Шүүгчийн тооны хувьд 2017-2021 онд шүүгчийн тоо Дархан-Уул аймгаас бусад аймгийн шүүхийн хувьд огцом өөрчлөлтгүй хэвийн байсан төлөв харагдаж байна.



Зураг 3.47. АЗХАШШ-д ажилласан шүүгчийн цалин (сая.төг)


Цалингийн хувьд 2017 онд бага зэрэг байснаа 2018-2021 он хүртэл огцом өөрчлөлтгүй хэвээр хадгалагдсан гэж тайлбарлаж болохоор байна. Харин Дархан-Уул аймгийн шүүхийн шүүгчийн цалин 2017-2019 онд бусдаасаа эрс бага харагдаж байна. Энэ өгөгдөл зөв ирсэн эсэх нь эргэлзээтэй байна.

Зураг 3.46, 3.47-д харуулсан мэдээллийг 2-р бүлгийн Хотелингийн шинжүүрийн үр дүн (Хүснэгт 2.32)-г баримтлан дээр 2D, 3D хэмжээт график дүрслэлээр аймаг тус бүрийн шүүхийн үйл ажиллагаагаар задлая.




Зураг 3.48. АЗХАШШ-н шүүгчийн ачаалал, шүүгчийн тоо, цалин (сая.төг), 1-р кластер

Зураг 3.48-д захиргааны хэргийн ачааллын хувьд 1-р кластерт орсон дөрвөн аймгийн мэдээллийг тайлбарлая. Эхний зурагт шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн ачаалал, шүүгчийн тоо дараагийн зурагт цалингийн хэмжээ, шүүгчийн тоо (Шалгуур 3-д өгсөн шүүгчийн тооноос зөрнө. Шалгуур 34-д өгсөн шүүгчийн тоо болно.)-г харуулав. Говьсүмбэр аймгийн шүүгчийн ачаалал 2021 онд, Дорноговь аймгийн шүүгчийн ачаалал 2018 онд хамгийн өндөр бөгөөд 15 орчим хэрэг шийдвэрлэжээ. Говьсүмбэр аймгийн шүүгчийн цалин 2020 онд, Хэнтий аймгийн шүүгчийн цалин 2021 онд хамгийн өндөр буюу 45 сая орчим төгрөг байжээ. 1-р кластерт орсон аймгуудын шүүгч 2017-2021 онуудад жилд 5-10 захиргааны хэрэг хянан шийдвэрлэсэн ачаалалтай байжээ. Эдгээр шүүхүүдэд 2-3 шүүгч тогтмол ажиллаж ирсэн байна.




Зураг 3.49. АЗХАШШ-н шүүгчийн ачаалал, шүүгчийн тоо, цалин (сая.төг), 2-р кластер

Зураг 3.49-д захиргааны хэргийн ачааллын хувьд 2-р кластерт орсон хоёр аймгийн мэдээллийг тайлбарлая. Эхний зурагт шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн ачаалал, шүүгчийн тоо дараагийн зурагт цалингийн хэмжээ, шүүгчийн тоо (*Шалгуур 3-д өгсөн шүүгчийн тооноос зөрнө. Шалгуур 34-д өгсөн шүүгчийн тоо болно.*)-г харуулав. Сэлэнгэ, Төв аймгийн шүүгчийн ачаалал 2019 онд хамгийн өндөр буюу 16-18 орчим хэрэг шийдвэрлэжээ. Сэлэнгэ аймгийн шүүгчийн цалин 2021 онд хамгийн өндөр буюу 41 сая орчим төгрөг, Хэнтий аймгийн шүүгчийн цалин 2021 онд хамгийн өндөр буюу 33 сая орчим төгрөг байжээ. 2-р кластерт орсон аймгуудын шүүгч 2017-2021 онуудад жилд 7-16 захиргааны хэрэг хянан шийдвэрлэсэн ачаалалтай байжээ. Эдгээр шүүхүүдэд 2-3 шүүгч тогтмол ажиллаж ирсэн байна.




Зураг 3.50. АЗХАШШ-н шүүгчийн мэдээлэл, 1,2-р кластер

Зураг 3.50-д 1-р кластерийн дөрвөн аймаг, 2-р кластерийн хоёр аймгийн захиргааны хэргийн нэг шүүгчийн тухай гурван мэдээллийг 2017-2021 оны хандлагын хамт нэг дор өгөх боломжтой байдлаар дүрслэв. Зураг 3.48, 3.49-д тайлбарласан шүүгчийн ачаалал, цалингийн хэмжээ мөн 2-р бүлэгт дурдсан шүүгчийн ажиллагааны мэдээллийг нэгтгэж 3D зургаар харуулав. Босоо тэнхлэгээр шүүгчийн нэг жилийн цалингийн хэмжээг, хэвтээ тэнхлэгээр шүүгчийн ачаалал болон ажиллагаа (материал)-г тэмдэглэсэн тул тэнхлэгийн тоон утгуудыг харгалзуулан харж ерөнхий мэдээлэл авна уу.




Зураг 3.51. АЗХАШШ-н шүүгчийн ачаалал, шүүгчийн тоо, цалин (сая.төг), 3-р кластер

Зураг 3.51-д захиргааны хэргийн ачааллын хувьд 3-р кластерт орсон хоёр аймгийн мэдээллийг тайлбарлая. Эхний зурагт шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн ачаалал, шүүгчийн тоо дараагийн зурагт цалингийн хэмжээ, шүүгчийн тоо (*Шалгуур 3-д өгсөн шүүгчийн тооноос зөрнө. Шалгуур 34-д өгсөн шүүгчийн тоо болно.*)-г харуулав. Булган аймгийн шүүгчийн ачаалал 2019 онд хамгийн өндөр бөгөөд 19 хэрэг, Дорнод аймгийн шүүгчийн ачаалал 2021 онд хамгийн өндөр бөгөөд 15 орчим хэрэг шийдвэрлэжээ. Булган аймгийн шүүгчийн цалин 2019 онд хамгийн өндөр буюу 41 сая орчим төгрөг, Дорнод аймгийн шүүгчийн цалин 2021 онд хамгийн өндөр буюу 47 сая орчим төгрөг байжээ. 3-р кластерт орсон аймгуудын шүүгч 2017-2021 онуудад жилд 10-19 захиргааны хэрэг хянан шийдвэрлэсэн ачаалалтай байжээ. Эдгээр шүүхүүдэд 2-2.4 шүүгч тогтмол ажиллаж ирсэн байна.




Зураг 3.52. АЗХАШШ-н шүүгчийн ачаалал, шүүгчийн тоо, цалин (сая.төг), 4-р кластер

Зураг 3.52-д захиргааны хэргийн ачааллын хувьд 4-р кластерт орсон таван аймгийн мэдээллийг тайлбарлая. Эхний зурагт шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн ачаалал, шүүгчийн тоо дараагийн зурагт цалингийн хэмжээ, шүүгчийн тоо (*Шалгуур 3-д өгсөн шүүгчийн тооноос зөрнө. Шалгуур 34-д өгсөн шүүгчийн тоо болно.*)-г харуулав. Дархан-Уул аймгийн шүүгчийн ачаалал 2017 онд хамгийн өндөр бөгөөд 22 хэрэг шийдвэрлэжээ. Орхон, Дархан-Уул аймгийн шүүгчийн цалин 2021 онд хамгийн өндөр буюу 44 сая орчим төгрөг байжээ. 4-р кластерт орсон аймгуудын шүүгч 2017-2021 онуудад жилд 5-15 захиргааны хэрэг хянан шийдвэрлэсэн ачаалалтай байжээ. Эдгээр шүүхүүдэд 2-3 шүүгч тогтмол ажиллаж ирсэн байна.




Зураг 3.53. АЗХАШШ-н шүүгчийн мэдээлэл, 3,4-р кластер

Зураг 3.53-д 3-р кластерийн таван аймаг, 4-р кластерийн хоёр аймгийн захиргааны хэргийн нэг шүүгчийн тухай гурван мэдээллийг 2017-2021 оны хандлагын хамт нэг дор өгөх боломжтой байдлаар дүрслэв. Зураг 42а,б-д тайлбарласан шүүгчийн ачаалал, цалингийн хэмжээ мөн 2-р бүлэгт дурдсан шүүгчийн ажиллагааны мэдээллийг нэгтгэж 3D зургаар харуулав. Босоо тэнхлэгээр шүүгчийн нэг жилийн цалингийн хэмжээг, хэвтээ тэнхлэгээр шүүгчийн ачаалал болон ажиллагаа (материал)-г тэмдэглэсэн тул тэнхлэгийн тоон утгуудыг харгалзуулан харж ерөнхий мэдээлэл авна уу.




Зураг 3.54. АЗХАШШ-н шүүгчийн ачаалал, шүүгчийн тоо, цалин (сая.төг), 5-р кластер

Зураг 3.54-д захиргааны хэргийн ачааллын хувьд 5-р кластерт орсон хоёр аймгийн мэдээллийг тайлбарлая. Эхний зурагт шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн ачаалал, шүүгчийн тоо дараагийн зурагт цалингийн хэмжээ, шүүгчийн тоо (Шалгуур 3-д өгсөн шүүгчийн тооноос зөрнө. Шалгуур 34-д өгсөн шүүгчийн тоо болно.)-г харуулав. Говь-Алтай аймгийн шүүгчийн ачаалал 2019 онд хамгийн өндөр бөгөөд 34 хэрэг шийдвэрлэжээ. Хөвсгөл аймгийн шүүгчийн цалин 2021 онд хамгийн өндөр буюу 47 сая орчим төгрөг байжээ. 5-р кластерт орсон аймгуудын шүүгч 2017-2021 онуудад жилд 8-25 захиргааны хэрэг хянан шийдвэрлэсэн ачаалалтай байжээ. Эдгээр шүүхүүдэд 2 шүүгч тогтмол ажиллаж ирсэн байна.




Зураг 3.55. АЗХАИШШ-н шүүгчийн ачаалал, шүүгчийн тоо, цалин (сая.төг), 6-р кластер

Зураг 3.55-д захиргааны хэргийн ачааллын хувьд 6-р кластерт орсон гурван аймгийн мэдээллийг тайлбарлая. Эхний зурагт шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн ачаалал, шүүгчийн тоо дараагийн зурагт цалингийн хэмжээ, шүүгчийн тоо (*Шалгуур 3-д өгсөн шүүгчийн тооноос зөрнө. Шалгуур 34-д өгсөн шүүгчийн тоо болно.*)-г харуулав. Увс аймгийн шүүгчийн ачаалал 2021 онд хамгийн өндөр бөгөөд 41 хэрэг шийдвэрлэжээ. Ховд аймгийн шүүгчийн цалин 2021 онд, Увс, Хөвсгөл аймгийн шүүгчийн цалин 2020 онд хамгийн өндөр буюу 38 сая орчим төгрөг байжээ. 6-р кластерт орсон аймгуудын шүүгч 2017-2021 онуудад жилд 10-30 орчим захиргааны хэрэг хянан шийдвэрлэсэн ачаалалтай байжээ. Эдгээр шүүхүүдэд 2-3 шүүгч тогтмол ажиллаж ирсэн байна.




Зураг 3.56. АЗХАИШШ-н шүүгчийн мэдээлэл, 5,6-р кластер

Зураг 3.56-д 5-р кластерийн 2 аймаг, 6-р кластерийн 3 аймгийн захиргааны хэргийн нэг шүүгчийн тухай гурван мэдээллийг 2017-2021 оны хандлагын хамт нэг дор өгөх боломжтой байдлаар дүрслэв. Зураг 3.57, 3.58-д тайлбарласан шүүгчийн ачаалал, цалингийн хэмжээ мөн 2-р бүлэгт дурдсан шүүгчийн ажиллагааны мэдээллийг нэгтгэж 3D зургаар харуулав. Босоо тэнхлэгээр шүүгчийн нэг жилийн цалингийн хэмжээг, хэвтээ тэнхлэгээр шүүгчийн ачаалал болон ажиллагаа (материал)-г тэмдэглэсэн тул тэнхлэгийн тоон утгуудыг харгалзуулан харж ерөнхий мэдээлэл авна уу.



Зураг 3.57. АЗХАШШ-н шүүгчийн ачаалал, шүүгчийн тоо, цалин (сая.төг), кластергүй

Зураг 3.57-гийн захиргааны хэргийн ачааллын хувьд кластергүй, өөрийн онцлогтой гурван аймгийн мэдээллийг тайлбарлая. Эхний зурагт шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн ачаалал, шүүгчийн тоо дараагийн зурагт цалингийн хэмжээ, шүүгчийн тоо (Шалгуур 3-д өгсөн шүүгчийн тооноос зөрнө. Шалгуур 34-д өгсөн шүүгчийн тоо болно.)-г харуулав. Баян-Өлгий аймгийн шүүгчийн ачаалал 2021 онд хамгийн өндөр бөгөөд 31 хэрэг шийдвэрлэж, 2021 онд цалингийн хэмжээ хамгийн өндөр буюу 44 сая орчим төгрөг байжээ. Кластергүй ангилалд орсон аймгуудын шүүгч 2017-2021 онуудад жилд 8-30 захиргааны хэрэг хянан шийдвэрлэсэн ачаалалтай байжээ. Эдгээр шүүхүүдэд 2 шүүгч тогтмол ажиллаж ирсэн байна.



Зураг 3.58. АЗХАШШ-н шүүгчийн мэдээлэл, кластергүй

Зураг 3.58-д кластергүй ангилалд орсон 3 аймгийн захиргааны хэргийн нэг шүүгчийн тухай гурван мэдээллийг 2017-2021 оны хандлагын хамт нэг дор өгөх боломжтой байдлаар дүрслэв. Зураг 3.57-д тайлбарласан шүүгчийн ачаалал, цалингийн хэмжээ мөн 2-р бүлэгт дурдсан шүүгчийн ажиллагааны мэдээллийг нэгтгэж 3D зургаар харуулав. Босоо тэнхлэгээр шүүгчийн нэг жилийн цалингийн хэмжээг, хэвтээ тэнхлэгээр шүүгчийн ачаалал болон ажиллагаа (материал)-г тэмдэглэсэн тул тэнхлэгийн тоон утгуудыг харгалзуулан харж ерөнхий мэдээлэл авна уу.

Шүүхийн үйл ажиллагааг тодорхойлох гол хэсгийн шинжилгээнд хувьсагч болж орох зарим үзүүлэлтүүдийн бодит өгөгдлийг график дүрслэлээр харууллаа. Гол хэсгийн шинжилгээ явуулж түлхүүр хувьсагчийг сонгох тухай судалгаа явуулья. Шинжилгээнд хэрэглэгдэх хувьсагчийн тухай ойлголтыг 10-р (хуудасны дугаар бичнэ, Шүүхийн үйл

ажиллагаа Хэргийн ачаалал, Томилолтын зардал гэх мэт тодорхойлолт) хуудаснаас харна уу.

Шүүх	Хувьсагч	Кор.коэ (r_{y_1, x_k})	Ерөнхий дисперсийн өсөн нэмэгдэх хувь	Шүүхийн үйл ажиллагааны загвар
Эрүү	Ачаалал (x_1)	0.98	0.98	$y = 0.7x_1 + 0.07x_2 + 18x_3 + 0.7x_4 + 0.1x_5 + 17500x_7 - 160x_8$
	Үлдэгдэл хэрэг (x_2)	0.85		
	Ажиллагаа (x_3)	0.86		
	Шийдвэрлэсэн хэргийн хүн (x_4)	0.99		
	Үлдэгдэл хэргийн хүн (x_5)	0.89		
	Хүн амын нягтрал (x_6)	-0.40		
	Цалин (x_7)	0.90		
	Томилолтын зардал (x_8)	-0.25		
Иргэн	Ачаалал (x_1)	0.99	0.93	$y = 0.7x_1 + 7x_3 + 0.05x_4 + 125x_6 + 9820x_7$
	Үлдэгдэл хэрэг (x_2)	0.07		
	Ажиллагаа (x_3)	0.98		
	Шийдвэрлэсэн хэргийн хариуцагч (x_4)	0.30		
	Хүн амын нягтрал (x_5)	-0.04		
	Цалин (x_6)	0.53		
Томилолтын зардал (x_7)	0.76			
Захиргаа	Ачаалал (x_1)	0.14	0.66	$y = 0.1x_5 + 858800x_7 + 4990x_8$
	Үлдэгдэл хэрэг (x_2)	-0.19		
	Ажиллагаа (x_3)	0.01		
	Шийдвэрлэсэн хэргийн нэхэмжлэгч (x_4)	0.17		
	Шийдвэрлэсэн хэргийн хариуцагч (x_5)	0.22		
	Хүн амын нягтрал (x_6)	-0.48		
	Цалин (x_7)	0.97		
	Томилолтын зардал (x_8)	0.94		

Хүснэгт 3.6. Аймаг дахь анхан шатны шүүхийн үйл ажиллагааны загварын тодорхойлолт

Эрүүгийн хэрэг: **Корреляцийн коэффициентийн** утгыг тайлбарлая. Шүүхийн үйл ажиллагааны загвар (нэг шүүгчид ногдох)-т эрүүгийн хэргийн ачаалал 0.98 буюу хүчтэй, үлдэгдэл хэргийн тоо 0.85 буюу хүчтэй, ажиллагаа (материал)-ны тоо 0.86 буюу хүчтэй, шийдвэрлэсэн хэрэгт хамаарах хүний тоо 0.99 буюу хүчтэй, үлдэгдэл хэрэгт хамаарах хүний тоо 0.89 буюу хүчтэй, хүн амын нягтрал -0.40 буюу сөрөг дунд зэрэг, цалингийн хэмжээ 0.90 буюу хүчтэй, томилолтын зардал -0.25 буюу сөрөг сул хамааралтай байна. Шүүхийн үйл ажиллагааны загварт хүн амын нягтрал урвуу дунд хамааралтай байгаа нь аймгийн эрүүгийн хэргийн шүүхийн үйл ажиллагаанд хүн амын нягтрал төдийлөн нөлөө үзүүлэхгүй байна гэсэн мэдээллийг өгч байна. Бүрэлдэхүүн хэсгийн загварт ачаалал, шийдвэрлэсэн хэрэгт хамаарах хүний тоо хамгийн өндөр нөлөө үзүүлж байна.

Ерөнхий дисперсийн өсөн нэмэгдэх хувийн утгыг тайлбарлая. АЭХАШШ-н үйл ажиллагааны загвар нь өгөгдсөн мэдээлэл (ачаалал, үлдэгдэл хэрэг, ажиллагаа гэх мэт)-н 98 хувийг тайлбарлаж байна. Энд тодорхойлсон загвар хамгийн боломжит, өндөр хувийг агуулсан хувилбар юм.

Шүүхийн үйл ажиллагааны загварын утгыг тайлбарлая.

$$y = 0.7x_1 + 0.07x_2 + 18x_3 + 0.7x_4 + 0.1x_5 + 17500x_7 - 160x_8$$

Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд АЭХАШШ-н эрүүгийн хэрэг шийдвэрлэдэг нэг шүүгчийн нэг жилд шийдвэрлэсэн хэргийн тоо 0.7 хэргээр буюу 5 жилд 3-4 хэргээр,

үлдэгдэл хэрэг 0.07 хэргээр (бараг өсөлтгүй), ажиллагаа жилд 18 материалаар, шийдвэрлэсэн хэрэгт хамаарах хүний тоо 0.7 буюу 5 жилд 3-4 хүнээр, үлдэгдэл хэрэгт хамаарах хүний тоо 0.1 хүнээр (бараг өсөлтгүй), цалингийн хэмжээ 17500 төгрөгөөр тус тус өссөн байна. Харин томилолтын зардал 160 төгрөгөөр буурчээ. Зураг 3.3-3.32-д тайлбарласан үр дүнтэй загварын утгыг холбож ойлгоно уу. (Дүүргийн шүүхийн жишээн дээр өмнөх дэд бүлгүүдэд өгсөн дэлгэрэнгүй тайлбартай дахин танилцаж Зураг 3.3-3.32-ийн тайлбартай холбож ойлгоно уу.)

Иргэний хэрэг: **Корреляцийн коэффициентийн** утгыг тайлбарлая. Шүүхийн үйл ажиллагааны загвар (нэг шүүгчид ногдох)-т иргэний хэргийн ачаалал 0.99 буюу хүчтэй, үлдэгдэл хэргийн тоо 0.07 буюу нөлөөгүй, ажиллагаа (материал)-ны тоо 0.98 буюу хүчтэй, шийдвэрлэсэн хэргийг хариуцагч хүний тоо 0.30 буюу сул, хүн амын нягтрал 0.04 буюу нөлөөгүй, цалингийн хэмжээ 0.53 буюу дунд зэрэг, томилолтын зардал 0.76 буюу хүчтэй хамааралтай байна. Шүүхийн үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсгийн загварт хүн амын нягтрал, үлдэгдэл хэргийн тоо хамгийн бага хамааралтай байна.

Ерөнхий дисперсийн өсөн нэмэгдэх хувийн утгыг тайлбарлая. АИХАШШ-н хувьд шийдвэрлэсэн хэргийн тогтолцооны загвар нь өгөгдсөн мэдээлэл (ачаалал, үлдэгдэл хэрэг, ажиллагаа гэх мэт)-н 93 хувийг тайлбарлаж байна. Энд тодорхойлсон загвар хамгийн боломжит, өндөр хувийг агуулсан хувилбар юм.

Шүүхийн үйл ажиллагааны загварын утгыг тайлбарлая.

$$y = 0.7x_1 + 7x_3 + 0.05x_4 + 125x_6 + 9820x_7$$

Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд АИХАШШ-н шүүгчийн нэг жилд шийдвэрлэсэн хэргийн тоо 0.7 хэргээр буюу 5 жилд 3-4 хэргээр, ажиллагаа жилд 7 материалаар, шийдвэрлэсэн хэрэгт хамаарах хариуцагчийн тоо 0.05 хүнээр буюу бараг өсөлтгүй, цалингийн хэмжээ 125 төгрөгөөр, томилолтын зардал 9820 төгрөгөөр тус тус өссөн байна. Дүүргийн шүүхийн жишээн дээр өмнөх дэд бүлгүүдэд өгсөн дэлгэрэнгүй тайлбартай дахин танилцаж Зураг 3.33-3.45-н тайлбартай холбож ойлгоно уу.

Захиргааны хэрэг: **Корреляцийн коэффициентийн** утгыг тайлбарлая. Шүүхийн үйл ажиллагааны загвар (нэг шүүгчид ногдох)-т захиргааны хэргийн ачаалал 0.14 буюу сул, үлдэгдэл хэргийн тоо -0.19 буюу урвуу сул, ажиллагаа (материал)-ны тоо 0.01 буюу нөлөөгүй, шийдвэрлэсэн хэрэгт хамаарах нэхэмжлэгчийн тоо 0.17 буюу сул, шийдвэрлэсэн хэргийг хариуцагч хүний тоо 0.22 буюу сул, хүн амын нягтрал -0.48 буюу урвуу, дунд зэрэг, цалингийн хэмжээ 0.97 буюу хүчтэй, томилолтын зардал 0.94 буюу хүчтэй хамааралтай байна. Шүүхийн үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсгийн загварт ачаалал, ажиллагаа зэрэг хувьсагч хамгийн бага хамааралтай гарсан байна. Энэ нь захиргааны хэргийн үйл ажиллагааны загварыг ачаалал, ажиллагаа гэсэн хувьсагчгүйгээр илэрхийлж болно гэсэн үг юм.

Ерөнхий дисперсийн өсөн нэмэгдэх хувийн утгыг тайлбарлая. АЗХАШШ-н хувьд шийдвэрлэсэн хэргийн тогтолцооны загвар нь өгөгдсөн мэдээлэл (ачаалал, үлдэгдэл хэрэг, ажиллагаа гэх мэт)-н 66 хувийг тайлбарлаж байна. Энд тодорхойлсон загвар хамгийн боломжит, өндөр хувийг агуулсан хувилбар юм.

Шүүхийн үйл ажиллагааны загварын утгыг тайлбарлая. АЗХАШШ-н үйл ажиллагааны загварыг 8 хувьсагчтай тодорхойлсон ч хувьсагчдын өмнөх коэффициентийн утга өчүүхэн бага, зарим нь нөлөөлөлгүй хувьсагч байсан тул загвар дараах гурван хувьсагчаар тодорхойлогдож байна.

$$y = 0.1x_5 + 858800x_7 + 4990x_8$$

Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд АЗХАШШ-н шүүгчийн нэг жилд шийдвэрлэсэн хэргийн тоо 0.1 хэргээр (өсөлтгүй), үлдэгдэл хэрэг 0.5 хэргээр буюу 5 жилд 3-4 хэргээр, ажиллагаа жилд 5 материалаар, цалингийн хэмжээ жилд 858800 төгрөгөөр, томилолтын зардал 4990 төгрөгөөр өссөн байна. Дүүргийн шүүхийн жишээн дээр өмнөх дэд бүлгүүдэд өгсөн дэлгэрэнгүй тайлбартай дахин танилцаж Зураг 3.46-3.58-н тайлбартай холбож ойлгоно уу.


3.2.1.3. Сум дундын шүүх

Монгол улсад сум дундын 8 шүүх үйл ажиллагаа явуулж байна. Сум дундын шүүхийн үйл ажиллагааны хувьд нэг шүүгч эрүү, зөрчил, иргэний хэрэг дээр ажилладаг онцлогтой. Сум дундын 8 шүүхийн үйл ажиллагааг ерөнхий дүр зургаар тодорхойлохын тулд 3D хэмжээст график дүрслэлээр харуулав. Графикийн тэнхлэгийн тухай тайлбарыг оруулъя. Үүнд: **Сум дунд** гэсэн тэнхлэгийн 2, 4, 6, 8 гэсэн тоогоор тэмдэглэсэн цэгийн утгыг сум дундын шүүхээр төлөөлүүлсэн бөгөөд дараах дарааллаар ойлгоно.

- | | | |
|----------------|--------------|--------------|
| 1- Тосонцэнгэл | 4- Замын-Үүд | 7- Мандал |
| 2- ХовдБулган | 5- Ханбогд | 8- Бор-Өндөр |
| 3- Хархорин | 6- Сайхан | |


Он гэсэн тэнхлэгийн 1, 2, 3, 4, 5 гэсэн тоогоор тэмдэглэсэн цэгийн утгыг 2017-2021 он гэж ойлгоно.

Босоо тэнхлэгээр тайлбар өгөх үзүүлэлт (ачаалал, шүүгчийн тоо, цалин)-г илэрхийлнэ.




Зураг 3.59. Сум дундын шүүхэд ажилласан шүүгчийн эрүү, зөрчлийн хэргийн ачаалал

Сум дундын шүүхийн шүүгч эрүү, зөрчил, иргэний хэрэг дээр ажилладаг онцлогтой тул Зураг 3.59-д нэг шүүгчийн ачаалалтай холбоотой. Зураг 3.59-д сум дундын шүүхэд ажилласан шүүгчийн нэг жилд хянан шийдвэрлэсэн эрүү ба зөрчлийн хэргийн тоог харуулав. Зургаас харвал 2017-2020 он хүртэл хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоо сум бүр дээр жил бүр бага зэргийн өсөлттэй явсан байна. 2021 онд хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоо буурсан төлөв харагдаж байна. Зөрчлийн хэргийн хувьд 2017 онд энэ хэргийн мэдээлэл байхгүй байсан байна. 2018-2020 он хүртэл зөрчлийн хэргийн ачаалал өссөн бөгөөд 2021 онд 2020 оныхтой адил ачаалал бараг хэвээр хадгалагдсан дүр зураг ажиглагдаж байна. Хархорин сумын шүүхийн шүүгч 2020 онд хамгийн их зөрчлийн хэрэг шийдвэрлэжээ.



Зураг 3.60. Сум дундын шүүхэд ажилласан шүүгчийн иргэний хэрэг ба нийт хэргийн ачаалал

Зураг 3.60-д сум дундын шүүхэд ажилласан шүүгчийн нэг жилд хянан шийдвэрлэсэн иргэний хэрэг ба хянан шийдвэрлэсэн нийт хэргийн тоог харуулав. Ачаалал гэсэн тэнхлэгтэй 2-р зурагт тухайн сум дундын шүүхэд ажилласан шүүгчдийн шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг дээр зөрчил (10.2-д хуваасан), иргэний хэргийн тоо (2.4-д хуваасан)-г нэмж шүүхэд ажилласан шүүгчийн тоонд хувааж нэг шүүгчид ногдох шийдвэрлэсэн хэргийн тоог тодорхойлов. Зургаас харвал 2017-2020 он хүртэл хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн тоо сум бүр дээр жил бүр бага зэргийн өсөлттэй явсан байна. 2021 онд хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн тоо буурсан төлөв харагдаж байна. Эрүүгийн хэргийн тоонд шилжүүлж тооцсон нийт хянан шийдвэрлэсэн хэргийн хувьд 2017-2020 он хүртэл хэргийн ачаалал өссөн бөгөөд 2021 онд ачаалал буурсан дүр зураг ажиглагдаж байна. Хархорин сумын шүүхийн шүүгч мөн 2020 онд хамгийн хэрэг хянан шийдвэрлэжээ.




Зураг 3.61. Сум дундын шүүхэд ажилласан шүүгчийн тоо ба шүүгчийн цалин (сая.төг)

Зураг 3.61-д сум дундын шүүхэд ажилласан шүүгчийн тоо, шүүгчийн нэг жилийн цалингийн хэмжээг харуулав. Зургаас харвал 2017 онд Ханбогд сумын шүүхэд хамгийн цөөн шүүгч ажилласан байна. 2017-2020 он хүртэл шүүгчийн тоо бага зэргийн өөрчлөлттэй харагдаж байна. 2021 онд шүүгчийн тоо эрс өссөн төлөв харагдаж байна. Цалингийн хувьд 5 жилийн огцом өөрчлөлтгүй хэвээр хадгалагдсан гэж тайлбарлаж болохоор байна. 2021 оны Ханбогд сумын шүүгчийн цалин огцом буурсан харагдаж байна. Мэдээлэл зөв ирсэн эсэхэд эргэлзээтэй байна.


Зураг 3.59, 3.60-д харуулсан мэдээллийг 2-р бүлгийн Хотелингийн шинжүүрийн үр дүн (Хүснэгт 2.33)-г баримтлан дээр 2D, 3D хэмжээст график дүрслэлээр аймаг тус бүрийн шүүхийн үйл ажиллагаагаар задлая. Зураг 3.59, 3.60-н мэдээллийг 2-р бүлгийн Хотелингийн шинжүүрийн үр дүнтэй холбож задлахдаа шүүгчийн эрүүгийн хэргийн хянан шийдвэрлэсэн ачааллыг Хүснэгт 2.33, зөрчлийн хэргийн хянан шийдвэрлэсэн ачааллыг Хүснэгт 2.34, иргэний хэргийн хянан шийдвэрлэсэн ачааллыг Хүснэгт 2.35-г баримтлан задлах ёстой

боловч нэг шүүгчийн ачаалалтай холбоотой тул дүгнэлтийг хялбар тайлбарлах үүднээс Хүснэгт 2.33-н кластерийг баримтлан тайлбар өгнө.




Зураг 3.62. Сум дундын шүүхийн шүүгчийн эрүүгийн хэргийн ачаалал, шүүгчийн тоо

Зураг 3.62-н сум дундын шүүхийн шүүгчийн эрүүгийн хэргийн ачаалал буюу хянан шийдвэрлэсэн хэргийн мэдээллийг тайлбарлая. Сум дундын шүүхүүд дотроос Мандал сумын шүүхийн шүүгч 2019 онд хамгийн өндөр ачаалалтай байсан бөгөөд 60 хэрэг шийдвэрлэжээ. Сум дундын шүүхийн шүүгч 2017-2021 онуудад жилд 15-50 эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэсэн ачаалалтай байжээ. Эдгээр шүүхүүдэд 2.5-4 шүүгч тогтмол ажиллаж ирсэн байна.




Зураг 3.63. Сум дундын шүүхийн шүүгчийн зөрчлийн хэргийн ачаалал, шүүгчийн тоо

Зураг 3.63-н сум дундын шүүхийн шүүгчийн зөрчлийн хэргийн ачаалал буюу хянан шийдвэрлэсэн хэргийн мэдээллийг тайлбарлая. Сум дундын шүүхүүд дотроос Хархорин сумын шүүхийн шүүгч 2020 онд хамгийн өндөр ачаалалтай байсан бөгөөд 230 орчим хэрэг шийдвэрлэжээ. Сум дундын шүүхийн шүүгч 2017-2021 онуудад жилд 50-200 орчим зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэсэн ачаалалтай байжээ. Эдгээр шүүхүүдэд 2-4 шүүгч тогтмол ажиллаж ирсэн байна.





Зураг 3.64. Сум дундын шүүхийн шүүгчийн иргэний хэргийн ачаалал, шүүгчийн тоо

Зураг 3.64-гийн сум дундын шүүхийн шүүгчийн иргэний хэргийн ачаалал буюу хянан шийдвэрлэсэн хэргийн мэдээллийг тайлбарлая. Сум дундын шүүхүүд дотроос Хархорин сумын шүүхийн шүүгч 2020 онд хамгийн өндөр ачаалалтай байсан бөгөөд 200 орчим иргэний хэрэг шийдвэрлэжээ. Сум дундын шүүхийн шүүгч 2017-2021 онуудад жилд 50-150 орчим зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэсэн ачаалалтай байжээ. Эдгээр шүүхүүдэд 2.5-4 шүүгч тогтмол ажиллаж ирсэн байна.



Зураг 3.65. Сум дундын шүүхийн шүүгчийн тоо, цалин (сая.төг)

Зураг 3.65-д сум дундын шүүхийн шүүгчийн цалингийн хэмжээ, шүүгчийн тоо (Шалгуур 3-д өгсөн шүүгчийн тооноос зөрнө. Шалгуур 34-д өгсөн шүүгчийн тоо болно.)-г харуулав. Ховдын Булган, Замын-Үүдийн сум дундын шүүхийн шүүгчийн цалин бусад сумаас өндөр байна.



Зураг 3.66-д сум дундын 8 шүүхийн нэг шүүгчийн тухай гурван мэдээллийг 2017-2021 оны хандлагын хамт нэг дор өгөх боломжтой байдлаар дүрслэв. Зураг 3.67-д тайлбарласан шүүгчийн ачаалал, цалингийн хэмжээ мөн шүүгчийн тооны мэдээллийг нэгтгэж 3D зургаар харуулав. Босоо тэнхлэгээр шүүгчийн нэг жилийн цалингийн хэмжээг, хэвтээ тэнхлэгээр шүүгчийн тоо болон ачааллыг тэмдэглэсэн тул тэнхлэгийн тоон утгуудыг харгалзуулан харж ерөнхий мэдээлэл авна уу.

Шүүхийн үйл ажиллагааг тодорхойлох гол хэсгийн шинжилгээнд хувьсагч болж орох зарим үзүүлэлтүүдийн бодит өгөгдлийг график дүрслэлээр харууллаа. Гол хэсгийн шинжилгээ явуулж түлхүүр хувьсагчийг сонгох тухай судалгаа явууля. Шинжилгээнд хэрэглэгдэх хувьсагчийн тухай ойлголтыг 10-р (хуудасны дугаар бичнэ, *Шүүхийн үйл ажиллагаа Хэргийн ачаалал, Томилолтын зардал гэх мэт тодорхойлолт*) хуудаснаас харна уу.

Шүүх	Хувьсагч	Кор.коэ (r_{y_1, x_k})	Ерөнхий дисперсийн өсөн нэмэгдэх хувь	Шүүхийн үйл ажиллагааны загвар
Эрүү	Ачаалал (x_1)	0.70	0.78	$y = 0.2x_1 + 0.03x_2 + 8x_3 + 0.2x_4 + 0.05x_5 - 41000x_7$
	Үлдэгдэл хэрэг (x_2)	0.84		
	Ажиллагаа (x_3)	0.94		
	Шийдвэрлэсэн хэргийн хүн (x_4)	0.50		
	Үлдэгдэл хэргийн хүн (x_5)	0.90		
	Хүн амын нягтрал (x_6)	0.27		
	Цалин (x_7)	-0.54		
Иргэн	Ачаалал (x_1)	0.98	0.90	$y = x_1 + 0.04x_2 + 9x_3 + 0.4x_4 - 23400x_6$
	Үлдэгдэл хэрэг (x_2)	0.37		
	Ажиллагаа (x_3)	0.91		
	Шийдвэрлэсэн хэргийн хариуцагч (x_4)	0.80		
	Хүн амын нягтрал (x_5)	0.37		
	Цалин (x_6)	-0.43		
	Томилолтын зардал (x_7)	0.0		

Хүснэгт 62. Сум дахь сум дундын шүүхийн үйл ажиллагааны загварын тодорхойлолт

Эрүүгийн хэрэг: **Корреляцийн коэффициентийн** утгыг тайлбарлая. Шүүхийн үйл ажиллагааны загвар (нэг шүүгчид ногдох)-г эрүүгийн хэргийн ачаалал 0.70 буюу дунд зэрэг, үлдэгдэл хэргийн тоо 0.84 буюу хүчтэй, ажиллагаа (материал)-ны тоо 0.94 буюу хүчтэй, шийдвэрлэсэн хэрэгт хамаарах хүний тоо 0.50 буюу дунд зэрэг, үлдэгдэл хэрэгт хамаарах хүний тоо 0.90 буюу хүчтэй, хүн амын нягтрал 0.27 буюу сул, цалингийн хэмжээ -0.54 буюу урвуу, дунд зэрэг хамааралтай байна. Шүүхийн үйл ажиллагааны загварт хүн амын нягтрал сул хамааралтай байгаа нь сум дундын шүүхийн үйл ажиллагаанд хүн амын нягтрал төдийлөн нөлөө үзүүлэхгүй байна гэсэн мэдээллийг өгч байна. Бүрэлдэхүүн хэсгийн загварт ажиллагаа хамгийн өндөр нөлөө үзүүлж байна.

Ерөнхий дисперсийн өсөн нэмэгдэх хувийн утгыг тайлбарлая. Сум дундын шүүхийн үйл ажиллагааны загвар нь өгөгдсөн мэдээлэл (ачаалал, үлдэгдэл хэрэг, ажиллагаа гэх мэт)-н 78 хувийг тайлбарлаж байна. Энд тодорхойлсон загвар хамгийн боломжит, өндөр хувийг агуулсан хувилбар юм.

Шүүхийн үйл ажиллагааны загварын утгыг тайлбарлая.

$$y = 0.2x_1 + 0.03x_2 + 8x_3 + 0.2x_4 + 0.05x_5 - 41000x_7$$

Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд сум дундын шүүхийн шүүгчийн нэг жилд шийдвэрлэсэн хэргийн тоо 0.2 хэргээр буюу 5 жилд 1 хэргээр, үлдэгдэл хэрэг 0.03 хэргээр (бараг өсөлтгүй), ажиллагаа жилд 8 материалаар, шийдвэрлэсэн хэрэгт хамаарах хүний тоо 0.2 буюу 5 жилд 1 хүнээр, үлдэгдэл хэрэгт хамаарах хүний тоо 0.05 хүнээр (бараг өсөлтгүй), тус тус өссөн байна. Цалингийн хэмжээ 41000 төгрөгөөр буурсан байна. Дүүргийн шүүхийн жишээн дээр өмнөх дэд бүлгүүдэд өгсөн дэлгэрэнгүй тайлбартай дахин танилцаж Зураг 3.61-3.66-н тайлбартай холбож ойлгоно уу.

Иргэний хэрэг: **Корреляцийн коэффициентийн** утгыг тайлбарлая. Шүүхийн үйл ажиллагааны загвар (нэг шүүгчид ногдох)-т иргэний хэргийн ачаалал 0.98 буюу хүчтэй, үлдэгдэл хэргийн тоо 0.37 буюу сул, ажиллагаа (материал)-ны тоо 0.91 буюу хүчтэй, шийдвэрлэсэн хэргийг хариуцагч хүний тоо 0.80 буюу хүчтэй, хүн амын нягтрал 0.37 буюу сул, цалингийн хэмжээ -0.43 буюу дунд зэрэг, томилолтын зардал 0.0 буюу нөлөөгүй хамааралтай байна.

Ерөнхий дисперсийн өсөн нэмэгдэх хувийн утгыг тайлбарлая. Сум дундын шүүхийн хувьд шийдвэрлэсэн хэргийн тогтолцооны загвар нь өгөгдсөн мэдээлэл (ачаалал, үлдэгдэл хэрэг, ажиллагаа гэх мэт)-н 90 хувийг тайлбарлаж байна. Энд тодорхойлсон загвар хамгийн боломжит, өндөр хувийг агуулсан хувилбар юм.

Шүүхийн үйл ажиллагааны загварын утгыг тайлбарлая.

$$y = x_1 + 0.04x_2 + 9x_3 + 0.4x_4 - 23400x_6$$

Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд сум дундын шүүхийн шүүгчийн нэг жилд шийдвэрлэсэн иргэний хэргийн тоо 1 хэргээр, үлдэгдэл хэрэг 0.04 хэргээр буюу бараг өсөлтгүй, ажиллагаа жилд 9 материалаар, шийдвэрлэсэн хэрэгт хамаарах хариуцагчийн тоо 0.4 хүнээр буюу 5 жилд 2 хүнээр тус тус өссөн байна. Цалингийн хэмжээ 23400 төгрөгөөр, буурсан байна. Дүүргийн шүүхийн жишээн дээр өмнөх дэд бүлгүүдэд өгсөн дэлгэрэнгүй тайлбартай дахин танилцаж Зураг 3.61-3.66-н тайлбартай холбож ойлгоно уу.


3.2.2. Давж заалдах шатны шүүх

Аймгийн давж заалдах шатны ижил статустай 19 шүүх үйл ажиллагаа явуулж байна. Аймгийн давж заалдах шатны шүүхийн үйл ажиллагааны хувьд нэг шүүгч эрүү, зөрчил, иргэний хэрэг дээр ажилладаг онцлогтой. Аймгийн давж заалдах шатны шүүхийн үйл ажиллагааг ерөнхий дүр зургаар тодорхойлохын тулд 3D хэмжээст график дүрслэлээр харуулав. Графикийн тэнхлэгийн тухай тайлбарыг оруулья. Үүнд: **Аймаг** гэсэн тэнхлэгийн 1, ..., 19 гэсэн тоогоор тэмдэглэсэн цэгийн утгыг аймгийн давж заалдах шатны шүүхээр төлөөлүүлсэн бөгөөд дараах дарааллаар ойлгоно.

1-Баян-Өлгий	8-Булган	14- Өмнөговь
2-Говь-Алтай	9- Хөвсгөл	15- Сэлэнгэ
3-Завхан	10-Өвөрхангай	16- Төв
4-Увс	11-Говьсүмбэр	17- Дорнод
5-Ховд	12- Дорноговь	18- Хэнтий
6-Архангай	13- Дундговь	19- Сүхбаатар
7-Баянхонгор		


Он гэсэн тэнхлэгийн 1, 2, 3, 4, 5 гэсэн тоогоор тэмдэглэсэн цэгийн утгыг 2017-2021 он гэж ойлгоно.

Босоо тэнхлэгээр тайлбар өгөх үзүүлэлт (ачаалал, шүүгчийн тоо, цалин)-г илэрхийлнэ.




Зураг 3.67. АДЗШШ-д ажилласан шүүгчийн эрүү, зөрчлийн хэргийн ачаалал

АДЗШШ-н шүүгч эрүү, зөрчил, иргэний хэрэг дээр ажилладаг онцлогтой тул Зураг 3.67 нэг шүүгчийн ачаалалтай холбоотой. Зураг 3.67-д АДЗШШ-д ажилласан шүүгчийн нэг жилд хянан шийдвэрлэсэн эрүү ба зөрчлийн хэргийн тоог харуулав. Зургаас харвал 2017-2020 он хүртэл хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоо аймаг бүр дээр жил бүр өсөлттэй явсан байна. 2021 онд хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоо хадгалагдсан төлөв харагдаж байна. Зөрчлийн хэргийн хувьд 2017 онд энэ хэргийн мэдээлэл байхгүй байсан байна. 2018-2021 он хүртэл зөрчлийн хэргийн ачаалал өссөн дүр зураг ажиглагдаж байна. Ховд аймгийн давж заалдах шатны шүүхийн шүүгч 2021 онд хамгийн их зөрчлийн хэрэг шийдвэрлэжээ.



Зураг 3.68. АДЗШШ-д ажилласан шүүгчийн иргэний хэрэг ба нийт хэргийн ачаалал


Зураг 3.68-д АДЗШШ-д ажилласан шүүгчийн нэг жилд хянан шийдвэрлэсэн иргэний хэрэг ба хянан шийдвэрлэсэн нийт хэргийн тоог харуулав. Ачаалал гэсэн тэнхлэгтэй 2-р зурагт тухайн АДЗШШ-д ажилласан шүүгчдийн шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг дээр зөрчил (10.2-д хуваасан), иргэний хэргийн тоо (2.4-д хуваасан)-г нэмж шүүхэд ажилласан шүүгчийн тоонд хувааж нэг шүүгчид ногдох шийдвэрлэсэн хэргийн тоог тодорхойлов. Зургаас харвал 2017-2020 он хүртэл хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн тоо аймаг бүр дээр жил бүр тогтмол байсан байна. 2021 онд хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн тоо буурсан төлөв харагдаж байна. Эрүүгийн хэргийн тоонд шилжүүлж тооцсон нийт хянан шийдвэрлэсэн хэргийн хувьд 2017-2020 он хүртэл хэргийн ачаалал өссөн бөгөөд 2021 онд ачаалал хадгалагдсан дүр зураг ажиглагдаж байна.



Зураг 3.69. АДЗШШ-д ажилласан шүүгчийн тоо ба шүүгчийн цалин (сая.төг)


Зураг 3.69-д АДЗШШ-д ажилласан шүүгчийн тоо, шүүгчийн нэг жилийн цалингийн хэмжээг харуулав. 2017-2020 он хүртэл шүүгчийн тоо тогтмол байсан харагдаж байна. 2021 онд шүүгчийн тоо эрс өссөн төлөв харагдаж байна. Завхан аймгийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн тоо 2019 онд хамгийн их байсан байна. Цалингийн хувьд 5 жилийн огцом өөрчлөлтгүй хэвээр хадгалагдсан гэж тайлбарлаж болохоор байна.

Зураг 3.67, 3.68-д харуулсан мэдээллийг 2-р бүлгийн Хотелингийн шинжүүрийн үр дүн (Хүснэгт 2.36)-г баримтлан дээр 2D, 3D хэмжээст график дүрслэлээр аймаг тус бүрийн шүүхийн үйл ажиллагаагаар задлая. Зураг 3.67, 3.68-н мэдээллийг 2-р бүлгийн Хотелингийн шинжүүрийн үр дүнтэй холбож задлахдаа шүүгчийн эрүүгийн хэргийн хянан шийдвэрлэсэн ачааллыг Хүснэгт 2.36, зөрчлийн хэргийн хянан шийдвэрлэсэн ачааллыг Хүснэгт 2.37, иргэний хэргийн хянан шийдвэрлэсэн ачааллыг Хүснэгт 2.38-г баримтлан задлах ёстой боловч нэг шүүгчийн ачаалалтай холбоотой тул дүгнэлтийг хялбар тайлбарлах үүднээс Хүснэгт 2.36-н кластерийг баримтлан тайлбар өгнө.




Зураг 3.70. АДЗШШ-н шүүгчийн шийдвэрлэсэн хэргийн ачаалал, шүүгчийн тоо, 1,2-р кластер

Зураг 3.70-гийн АДЗШШ-н шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн ачааллыг тайлбарлая. АДЗШШ-н 1-р кластерт орсон шүүхүүдийн шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн ачаалал 2017-2021 онуудад жилд 5-15 хэрэг байжээ. Эдгээр шүүхүүдэд 3 шүүгч тогтмол ажиллаж ирсэн байна. АДЗШШ-н 2-р кластерт орсон шүүхүүдийн шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн ачаалал 2017-2021 онуудад жилд 10-40 хэрэг байжээ. Эдгээр шүүхүүдэд 2-3 шүүгч тогтмол ажиллаж ирсэн байна.




Зураг 3.71. АДЗШШ-н шүүгчийн мэдээлэл, 1,2-р кластер

Зураг 3.71-д АДЗШШ-н 1, 2-р кластерт орсон шүүхүүдийн нэг шүүгчийн тухай гурван мэдээллийг 2017-2021 оны хандлагын хамт нэг дор өгөх боломжтой байдлаар дүрслэв. Зураг 3.70-д тайлбарласан шүүгчийн ачаалал, цалингийн хэмжээ мөн шүүгчийн тооны мэдээллийг нэгтгэж 3D зургаар харуулав. Босоо тэнхлэгээр шүүгчийн нэг жилийн цалингийн хэмжээг, хэвтээ тэнхлэгээр шүүгчийн тоо болон ачааллыг тэмдэглэсэн тул тэнхлэгийн тоон утгуудыг харгалзуулан харж ерөнхий мэдээлэл авна уу.




Зураг 3.72. АДЗШШ-н шүүгчийн шийдвэрлэсэн хэргийн ачаалал, шүүгчийн тоо, 3,4-р кластер

Зураг 3.72-н АДЗШШ-н шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн ачааллыг тайлбарлая. АДЗШШ-н 3-р кластерт орсон шүүхүүдийн шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн ачаалал 2017-2021 онуудад жилд 10-30 хэрэг байжээ. Эдгээр шүүхүүдэд 2.8-3 шүүгч тогтмол ажиллаж ирсэн байна. АДЗШШ-н 4-р кластерт орсон шүүхүүдийн шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн ачаалал 2017-2021 онуудад жилд 10-40 хэрэг байжээ. Эдгээр шүүхүүдэд 3-4 шүүгч тогтмол ажиллаж ирсэн байна.




Зураг 3.73. АДЗШШ-н шүүгчийн мэдээлэл, 3,4-р кластер

Зураг 3.73-д АДЗШШ-н 3, 4-р кластерт орсон шүүхүүдийн нэг шүүгчийн тухай гурван мэдээллийг 2017-2021 оны хандлагын хамт нэг дор өгөх боломжтой байдлаар дүрслэв. Зураг 3.72-д тайлбарласан шүүгчийн ачаалал, цалингийн хэмжээ мөн шүүгчийн тооны мэдээллийг нэгтгэж 3D зургаар харуулав. Босоо тэнхлэгээр шүүгчийн нэг жилийн цалингийн хэмжээг, хэвтээ тэнхлэгээр шүүгчийн тоо болон ачааллыг тэмдэглэсэн тул тэнхлэгийн тоон утгуудыг харгалзуулан харж ерөнхий мэдээлэл авна уу.



Зураг 3.74. АДЗШШ-н шүүгчийн шийдвэрлэсэн хэргийн ачаалал, шүүгчийн тоо, 5-р кластер, кластергүй бүлэг

Зураг 3.74-н АДЗШШ-н шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн ачааллыг тайлбарлая. АДЗШШ-н 5-р кластерт орсон шүүхүүдийн шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн ачаалал 2017-2021 онуудад жилд 15-50 хэрэг байжээ. Эдгээр шүүхүүдэд 2-3 шүүгч тогтмол ажиллаж ирсэн байна. АДЗШШ-н кластергүй бүлэг Говьсүмбэр аймаг орсон бөгөөд энэ шүүхийн шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн ачаалал 2017-2021 онуудад жилд 5-15 хэрэг байжээ. Энэ шүүхэд 3 шүүгч тогтмол ажиллаж ирсэн байна.



Зураг 3.75. АДЗШШ-н шүүгчийн мэдээлэл, 5-р кластер, кластергүй бүлэг

Зураг 3.75-д АДЗШШ-н 5-р кластер, кластергүй бүлэгт орсон шүүхүүдийн нэг шүүгчийн тухай гурван мэдээллийг 2017-2021 оны хандлагын хамт нэг дор өгөх боломжтой байдлаар дүрслэв. Зураг 3.74-д тайлбарласан шүүгчийн ачаалал, цалингийн хэмжээ мөн шүүгчийн тооны мэдээллийг нэгтгэж 3D зургаар харуулав. Босоо тэнхлэгээр шүүгчийн нэг жилийн цалингийн хэмжээг, хэвтээ тэнхлэгээр шүүгчийн тоо болон ачааллыг тэмдэглэсэн тул тэнхлэгийн тоон утгуудыг харгалзуулан харж ерөнхий мэдээлэл авна уу.

Шүүхийн үйл ажиллагааг тодорхойлох гол хэсгийн шинжилгээнд хувьсагч болж орох зарим үзүүлэлтүүдийн бодит өгөгдлийг график дүрслэлээр харууллаа. Гол хэсгийн шинжилгээ явуулж түлхүүр хувьсагчийг сонгох тухай судалгаа явуулья. Шинжилгээнд хэрэглэгдэх хувьсагчийн тухай ойлголтыг 10-р (хуудасны дугаар бичнэ, *Шүүхийн үйл ажиллагаа Хэргийн ачаалал, Томилолтын зардал гэх мэт тодорхойлолт*) хуудаснаас харна

Хувьсагч	Кор.коэ (r_{y_1, x_k})	Ерөнхий дисперсийн өсөн нэмэгдэх хувь	Шүүхийн үйл ажиллагааны загвар
Ачаалал (x_1)	0.96	0.81	$y = 0.9x_1 + 3.5x_2 + 0.01x_3 + 260000x_4$
Ажиллагаа (x_2)	0.66		
Хүн амын нягтрал (x_3)	0.62		
Цалин (x_4)	0.78		
Томилолтын зардал (x_5)	0.40		

Хүснэгт 3.7. Аймгийн давж заалдах шатны шүүхийн үйл ажиллагааны загварын тодорхойлолт

Корреляцийн коэффициентийн утгыг тайлбарлая. Шүүхийн үйл ажиллагааны загвар (нэг шүүгчид ногдох)-т хэргийн ачаалал 0.96 буюу хүчтэй, ажиллагаа (материал)-ны тоо 0.66 буюу дунд зэрэг, хүн амын нягтрал 0.62 буюу дунд зэрэг, цалингийн хэмжээ 0.78 буюу дунд зэрэг, томилолтын зардал 0.40 буюу сул хамааралтай байна.


Ерөнхий дисперсийн өсөн нэмэгдэх хувийн утгыг тайлбарлая. АДЗШШ-н хувьд шийдвэрлэсэн хэргийн тогтолцооны загвар нь өгөгдсөн мэдээлэл (ачаалал, ажиллагаа гэх мэт)-н 81 хувийг тайлбарлаж байна. Энд тодорхойлсон загвар хамгийн боломжит, өндөр хувийг агуулсан хувилбар юм.

Шүүхийн үйл ажиллагааны загварын утгыг тайлбарлая.

$$y = 0.9x_1 + 3.5x_2 + 0.01x_3 + 260000x_4$$


Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд АДЗШШ-н шүүгчийн нэг жилд шийдвэрлэсэн хэргийн тоо 1 хэргээр, ажиллагаа жилд 3.5 материалаар, хүн амын нягтрал 0.01 хүнээр (буюу бараг өсөлтгүй) тус тус өссөн байна. Цалингийн хэмжээ 260000 төгрөгөөр өссөн байна. Дүүргийн шүүхийн жишээн дээр өмнөх дэд бүлгүүдэд өгсөн дэлгэрэнгүй тайлбартай дахин танилцаж Зураг 3.67-3.75-н тайлбартай холбож ойлгоно уу.

Орхон, Дархан-Уул аймаг дахь давж заалдах шатны шүүх нь эрүү, иргэний хэргийг дагнан шийдвэрлэдэг шүүгчидтэй тул энэ онцлогоосоо шалтгаалан эдгээр шүүхийн үйл ажиллагаа бусад 19 аймгаасаа тусдаа, бие даасан бүлэг болон шинжилгээ хийгдсэн. Гол хэсгийн шинжилгээний үр дүнг дараах 3 болон 2 хэмжээст зургаар харуулбал:




Зураг 3.76. Орхон, Дархан-Уул аймгийн давж заалдах шатны шүүхийн эрүүгийн хэргийн үйл ажиллагаа

Зураг 3.76-н Орхон, Дархан-Уул аймгийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн ачааллыг тайлбарлая. Орхон, Дархан-Уул аймгийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн ачаалал 2017-2021 онуудад жилд 8-32 хэрэг байжээ. Эдгээр шүүхүүдэд 3-8 хүртэл шүүгч ажиллаж ирсэн байна.



Зураг 3.77. Орхон, Дархан-Уул аймгийн давж заалдах шатны шүүхийн иргэний хэргийн үйл ажиллагаа

Зураг 3.77-н Орхон, Дархан-Уул аймгийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн ачааллыг тайлбарлая. Орхон, Дархан-Уул аймгийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн ачаалал 2017-2021 онуудад жилд 40-80 орчим хэрэг байжээ. Эдгээр шүүхүүдэд 3-8 хүртэл шүүгч ажиллаж ирсэн байна.



Зураг 3.78. Орхон, Дархан-Уул аймгийн давж заалдах шатны эрүү, иргэний хэргийн шүүхэд томилолтоор ажилласан шүүгчийн тоо, цалин (сая.төг)

Зураг 3.78-гийн Орхон, Дархан-Уул аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүхэд томилолтоор ажилласан шүүгчийн тооны хувьд Орхон аймгийн шүүхэд хамгийн олон шүүгч ажиллажээ. Дархан-Уул аймагт ажилласан шүүгчийн томилолтын зардал хамгийн өндөр байсан байна.

Шүүх	Хувьсагч	Кор.коэ (r_{y_1, x_k})	Ерөнхий дисперсийн өсөн нэмэгдэх хувь	Шүүхийн үйл ажиллагааны загвар
Эрүү	Ачаалал (x_1)	0.96	0.63	$y = -0.9x_1 - 1.5x_2 - 0.8x_3 + 460000x_4$
	Ажиллагаа (x_2)	0.25		
	Хүн амын нягтрал (x_3)	0.85		
	Цалин (x_4)	-0.72		
	Томилолт (x_5)	0.64		
Иргэн	Ачаалал (x_1)	-0.87	0.70	$y = -0.6x_1 - 4x_2 - 224600x_4$
	Ажиллагаа (x_2)	-0.98		
	Хүн амын нягтрал (x_3)	0.62		
	Цалин (x_4)	-0.42		
	Томилолт (x_5)	0.92		

Хүснэгт 3.8. Орхон, Дархан-Уул аймгийн давж заалдах шатны шүүхийн үйл ажиллагааны загварын тодорхойлолт

Эрүүгийн хэрэг: **Корреляцийн коэффициентийн** утгыг тайлбарлая. Шүүхийн үйл ажиллагааны загвар (нэг шүүгчид ногдох)-т хэргийн ачаалал 0.96 буюу хүчтэй, ажиллагаа (материал)-ны тоо 0.25 буюу сул, хүн амын нягтрал 0.85 буюу хүчтэй, цалингийн хэмжээ - 0.72 буюу урвуу, дунд зэрэг, томилолтын зардал 0.64 буюу дунд зэрэг хамааралтай байна.

Ерөнхий дисперсийн өсөн нэмэгдэх хувийн утгыг тайлбарлая. АДЗШШ-н хувьд шийдвэрлэсэн хэргийн тогтолцооны загвар нь өгөгдсөн мэдээлэл (ачаалал, ажиллагаа гэх мэт)-н 63 хувийг тайлбарлаж байна. Энд тодорхойлсон загвар хамгийн боломжит, өндөр хувийг агуулсан хувилбар юм.

Шүүхийн үйл ажиллагааны загварын утгыг тайлбарлая.

$$y = -0.9x_1 - 1.5x_2 - 0.8x_3 + 460000x_4$$

Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд Орхон, Дархан-Уул аймаг дахь ДЗШШ-н эрүүгийн хэрэг шийдвэрлэдэг нэг шүүгчийн нэг жилд шийдвэрлэсэн хэргийн тоо 1 хэргээр, ажиллагаа 1.5 материалаар, хүн амын нягтрал 1 хүнээр тус тус буурч байсан бол цалин

460.000 төгрөгөөр өссөн байна. Дүүргийн шүүхийн жишээн дээр өмнөх дэд бүлгүүдэд өгсөн дэлгэрэнгүй тайлбартай дахин танилцаж Зураг 3.76-3.78-н тайлбартай холбож ойлгоно уу.

Иргэний хэрэг: Корреляцийн коэффициентийн утгыг тайлбарлая. Шүүхийн үйл ажиллагааны загвар (нэг шүүгчид ногдох)-г хэргийн ачаалал -0.87 буюу урвуу, хүчтэй, ажиллагаа (материал)-ны тоо -0.98 буюу урвуу, хүчтэй, хүн амын нягтрал 0.62 буюу дунд зэрэг, цалингийн хэмжээ -0.42 буюу урвуу, дунд зэрэг, томилолтын зардал 0.92 буюу хүчтэй хамааралтай байна.


Ерөнхий дисперсийн өсөн нэмэгдэх хувийн утгыг тайлбарлая. АДЗШШ-н хувьд шийдвэрлэсэн хэргийн тогтолцооны загвар нь өгөгдсөн мэдээлэл (ачаалал, ажиллагаа гэх мэт)-н 70 хувийг тайлбарлаж байна. Энд тодорхойлсон загвар хамгийн боломжит, өндөр хувийг агуулсан хувилбар юм.

Шүүхийн үйл ажиллагааны загварын утгыг тайлбарлая.

$$y = -0.6x_1 - 4x_2 - 224600x_4$$


Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд Орхон, Дархан-Уул аймаг дахь ДЗШШ-н иргэний хэрэг шийдвэрлэдэг нэг шүүгчийн нэг жилд шийдвэрлэсэн хэргийн тоо 0.6 хэргээр, ажиллагаа 4 материалаар, хүн аймаг нягтрал 1 хүнээр тус тус буурч байсан бол цалин 460.000 төгрөгөөр өссөн байна. Дүүргийн шүүхийн жишээн дээр өмнөх дэд бүлгүүдэд өгсөн дэлгэрэнгүй тайлбартай дахин танилцаж Зураг 3.76-3.78-н тайлбартай холбож ойлгоно уу.

Нийслэлд давж заалдах шатны шүүх ганц байдаг шүүхүүдийн кластерийн тухай энэ хэсэгт яригдахгүй. Нийслэлийн эрүү, иргэн, захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхүүд үйл ажиллагаа явуулдаг.




Зураг 3.79. Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн үйл ажиллагаа

Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч 2020 онд хамгийн их хэрэг шийдвэрлэсэн байна. 2021 онд хамгийн олон шүүгч буюу 16 шүүгчийн бүрэлдэхүүнтэй ажилласан байна.



Зураг 3.80. Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн үйл ажиллагаа

Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч 2017 онд хамгийн их хэрэг шийдвэрлэсэн байна. 2020, 2019 онд хамгийн олон шүүгч буюу 16 шүүгчийн бүрэлдэхүүнтэй ажилласан байна.



Зураг 3.81. Нийслэлийн захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн үйл ажиллагаа

Нийслэлийн захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч 2017 онд хамгийн их хэрэг шийдвэрлэсэн байна. 2020 онд хамгийн олон шүүгч буюу 14 шүүгчийн бүрэлдэхүүнтэй ажилласан байна.

Шүүх	Хувьсагч	Кор.коэ (r_{y_1, x_k})	Ерөнхий дисперсийн өсөн нэмэгдэх хувь	Шүүхийн үйл ажиллагааны загвар
Эрүү	Ачаалал (x_1)	-0.98	0.82	$y = -x_1 + 2x_2 - 0.3x_3$
	Ажиллагаа (x_2)	0.52		
	Хүн амын нягтрал (x_3)	-0.21		
	Цалин (x_4)	0.04		
Иргэн	Ачаалал (x_1)	0.91	0.89	$y = 4x_1 + 8x_2 - x_3 + 287100x_4$
	Ажиллагаа (x_2)	0.98		
	Хүн амын нягтрал (x_3)	-0.31		
	Цалин (x_4)	0.74		
Захиргаа	Ачаалал (x_1)	0.99	0.97	$y = x_1 + 5x_2 - x_3 + 28300x_4$
	Ажиллагаа (x_2)	0.98		
	Хүн амын нягтрал (x_3)	-0.96		
	Цалин (x_4)	0.21		

Хүснэгт 3.9. Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн үйл ажиллагааны загварын тодорхойлолт

Эрүүгийн хэрэг: **Корреляцийн коэффициентийн** утгыг тайлбарлая. Шүүхийн үйл ажиллагааны загвар (нэг шүүгчид ногдох)-г хэргийн ачаалал -0.98 буюу урвуу, хүчтэй,

ажиллагаа (материал)-ны тоо 0.52 буюу дунд зэрэг, хүн амын нягтрал -0.21 буюу урвуу сул, цалингийн хэмжээ 0.04 буюу нөлөөгүй зэрэг хамааралтай байна.

Ерөнхий дисперсийн өсөн нэмэгдэх хувийн утгыг тайлбарлая. НЭХДЗШШ-н хувьд шийдвэрлэсэн хэргийн тогтолцооны загвар нь өгөгдсөн мэдээлэл (ачаалал, ажиллагаа гэх мэт)-н 82 хувийг тайлбарлаж байна. Энд тодорхойлсон загвар хамгийн боломжит, өндөр хувийг агуулсан хувилбар юм.

Шүүхийн үйл ажиллагааны загварын утгыг тайлбарлая.

$$y = -x_1 + 2x_2 - 0.3x_3$$

Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд НЭХДЗШШ-н шүүгчийн шийдвэрлэсэн хэргийн тоо жилд 1 хэргээр буурсан, ажиллагаа 2 материалаар өссөн, хүн амын нягтрал 0.3 хүнээр буюу 5 жилд 1-2 хүнээр буурсан байна. Цалингийн хэмжээ загварын хувьсагчаас хасагдах бөгөөд маш бага коэффициенттэй байна. Дүүргийн шүүхийн жишээн дээр өмнөх дэд бүлгүүдэд өгсөн дэлгэрэнгүй тайлбартай дахин танилцаж Зураг 3.79-н тайлбартай холбож ойлгоно уу.

Иргэний хэрэг: **Корреляцийн коэффициентийн утгыг тайлбарлая.** Шүүхийн үйл ажиллагааны загвар (нэг шүүгчид ногдох)-т хэргийн ачаалал 0.91 буюу хүчтэй, ажиллагаа (материал)-ны тоо 0.98 буюу хүчтэй, хүн амын нягтрал -0.31 буюу урвуу, сул, цалингийн хэмжээ 0.74 буюу дунд зэрэг хамааралтай байна.

Ерөнхий дисперсийн өсөн нэмэгдэх хувийн утгыг тайлбарлая. НИХДЗШШ-н хувьд шийдвэрлэсэн хэргийн тогтолцооны загвар нь өгөгдсөн мэдээлэл (ачаалал, ажиллагаа гэх мэт)-н 89 хувийг тайлбарлаж байна. Энд тодорхойлсон загвар хамгийн боломжит, өндөр хувийг агуулсан хувилбар юм.

Шүүхийн үйл ажиллагааны загварын утгыг тайлбарлая.

$$y = 4x_1 + 8x_2 - x_3 + 287100x_4$$

Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд НИХДЗШШ-н шүүгчийн нэг жилд шийдвэрлэсэн хэргийн тоо 4 хэргээр, ажиллагаа 8 материалаар өсч, хүн амын нягтрал 1 хүнээр тус тус буурч байсан бол цалин 287100 төгрөгөөр өссөн байна. Дүүргийн шүүхийн жишээн дээр өмнөх дэд бүлгүүдэд өгсөн дэлгэрэнгүй тайлбартай дахин танилцаж Зураг 3.80-н тайлбартай холбож ойлгоно уу.

Захиргааны хэрэг: **Корреляцийн коэффициентийн утгыг тайлбарлая.** Шүүхийн үйл ажиллагааны загвар (нэг шүүгчид ногдох)-т хэргийн ачаалал 0.99 буюу хүчтэй, ажиллагаа (материал)-ны тоо 0.98 буюу хүчтэй, хүн амын нягтрал -0.96 буюу урвуу, хүчтэй, цалингийн хэмжээ 0.21 буюу сул хамааралтай байна.

Ерөнхий дисперсийн өсөн нэмэгдэх хувийн утгыг тайлбарлая. НИХДЗШШ-н хувьд шийдвэрлэсэн хэргийн тогтолцооны загвар нь өгөгдсөн мэдээлэл (ачаалал, ажиллагаа гэх мэт)-н 97 хувийг тайлбарлаж байна. Энд тодорхойлсон загвар хамгийн боломжит, өндөр хувийг агуулсан хувилбар юм.

Шүүхийн үйл ажиллагааны загварын утгыг тайлбарлая.

$$y = x_1 + 5x_2 - x_3 + 28300x_4$$

Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд ЗХДЗШШ-н шүүгчийн нэг жилд шийдвэрлэсэн хэргийн тоо 1 хэргээр, ажиллагаа 5 материалаар өсч, хүн амын нягтрал 1 хүнээр тус тус буурч байсан бол цалин 283000 төгрөгөөр өссөн байна. Дүүргийн шүүхийн жишээн дээр өмнөх дэд бүлгүүдэд өгсөн дэлгэрэнгүй тайлбартай дахин танилцаж Зураг 3.81-н тайлбартай холбож ойлгоно уу.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ШАЛГУУР 3, 16, 26, 34-Д ХАМААРАХ ӨГӨГДӨЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

4.1. ШААРДЛАГАТАЙ ШҮҮГЧИЙН ТООНЫ ТООЦОО (Хувилбар 1)

4.1.1. Анхан шатны шүүх

Бүлэг 2-т дурдсан шинжилгээгээр шүүхийн тогтолцоо, хэргийн төрөл тус бүрд нэг шүүгчийн нэг жилд шийдвэрлэх хэргийн дундаж хэмжээ, хэрэг хоорондын харьцааг тооцож, эрүүгийн хэргийн нэгжид зөрчил болон иргэний хэргийг шилжүүлсэн. Энэ үр дүнд тулгуурлан бүлэг 4-т нэг шүүгчийн нэг жилд хянан шийдвэрлэсэн хэргийн ачааллын хэмжээгээр оновчлолын онол бодлого зохиож, бодлогын шийдийг ашиглан шүүхийн тогтолцоогоор, анхан болон давж заалдах шатны шүүхэд ажиллах шаардлагатай шүүгчийн тоог тус тус тооцов. *Шаардлагатай шүүгчийн тоог тооцсон үр дүн шүүхийн бүрэлдэхүүнийг өөрчлөх, татан буулгах, шинээр байгуулах, шүүхийн төсвийг хэмнэлттэй, зөв хуваарилах гэх мэт шүүхээс барих бодлогын асуудлыг шийдэх гаргалгаа руу хөтлөх юм.*

Оновчлолын онолын бодлогод ашиглагдах зарим нэр томъёоны тайлбарыг өгье.

Үүнд:

Хувьсагчдын нөхцөлийн доод (дээд) хилийн утга гэдэгт тухайн шүүхийн шүүгчийн шийдвэрлэсэн хэргийн 2017-2021 оны өгөгдлийн хамгийн бага (их) утгыг 2-р бүлэгт хийсэн шинжилгээний үр дүн болох хэргийн төрөл тус бүрийн улсын дунджаас ± 5 интервалд байх утгад хуваасан дүнг ойлгоно.

Шийд гэдэгт хувьсагчдын нөхцөлийн доод, дээд хилийн хооронд орших оновчлолын онолын бодлогоор гарах шийдийн утгыг ойлгоно.

Ажиллаж буй шүүгчийн тоо гэдэгт 5 жилийн дунджаар тухайн шүүхэд ажилласан шүүгчийн тоог ойлгоно.

Ажиллавал зохих шүүгчийн тоо гэдэгт бодлогын шийдийг ажиллаж буй шүүгчийн тоогоор үржүүлж шаардлагатай шүүгчийн тоонд шилжүүлсэн утгыг ойлгоно.

Зөрүү гэдэгт ажиллавал зохих шүүгчийн тооноос ажиллаж буй шүүгчийн тоог хассан утга буюу нэмэх эсвэл багасгах шүүгчийн орон тоог ойлгоно.

4.1.1.1. Дүүрэг, Нийслэлийн шүүх

- Эрүүгийн хэргийн шүүх

Нийслэлийн төвийн дүүргийн ЭХАШШ-д эрүү ба зөрчлийн хэрэг дээр шүүгч дагнан ажилладаг онцлогтой тул шүүгчийн ачааллын коэффициент, шаардлагатай шүүгчийн тоог тодорхойлох оновчлолын бодлогыг эрүү ба зөрчлийн хэрэг дээр ажилладаг шүүгч тус бүрээр тодорхойлно. 2-р бүлгийн судалгааны үр дүн (*Хүснэгт 2.43*)-г баримтлан шүүгчийн хянан шийдвэрлэвэл зохих эрүүгийн хэргийн тооны дээд, доод хилийн утгыг тооцсон. Нэг шүүгчийн хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн улсын дундаж 89 бол өндөр тоо гэсэн саналыг ШЕЗ-н гишүүд өгч байсан тул бодлогын дээд хилийн утгыг 89-ээс хэтрэхгүй байхаар сонгосон. Судалгааны өгөгдлийн утга -5 интервалд байх доод хилийн утгыг тооцоход 95 хувийн магадлалтайгаар интервалын утга 80 гарсан тул бодлогын нөхцөл [80; 89] завсарт тавигдаж бодлогын шийд болох дараах үр дүнг өгөв.

№	Төвийн дүүрэг	Хувьсагчдын нөхцөл	Шийд	Ажиллаж буй шүүгчийн тоо	Зөрүү
---	---------------	--------------------	------	--------------------------	-------

		Доод	Дээд	Ажиллавал			
		хил	хил	зохих шүүгчийн тоо			
		A	B	C	D	C*D	C*D-D
1	Баянзүрх	1.3	2.3	2.0	9.6	19.2	9.6
2	Чингэлтэй	1.3	1.9	1.6	6.2	9.9	3.7
3	Сүхбаатар	1.0	2.0	1.6	6.5	10.4	3.9
4	Баянгол	1.1	1.9	1.4	7.6	10.6	3.0
5	Хан-Уул	0.7	1.6	1.4	6.0	8.4	2.4
6	Сонгинохайрхан	0.9	1.9	1.6	8.2	13.1	4.9
	Дүн	6.3	11.6	9.6	44.1	71.7	27.6

Хүснэгт 4.1. Төвийн 6 дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд шаардлагатай шүүгчийн тоо

Хүснэгтийн эхний дүүрэг дээр тайлбар өгье. Хувьсагчдын нөхцөлийн доод хилийн утгын **Баянзүрх-1.3** нь сүүлийн 5 жилийн өгөгдлийн хувьд Баянзүрх дүүргийн эрүүгийн хэргийн шүүгч хамгийн бага ачаалалтай жилд $1.3-1.0=0.3$ хүний ажлыг илүү хийсэн гэсэн утгыг илтгэж байна.

Хувьсагчдын нөхцөлийн дээд хилийн утгын **Баянзүрх-2.3** нь сүүлийн 5 жилийн өгөгдлийн хувьд Баянзүрх дүүргийн эрүүгийн хэргийн шүүгч хамгийн их ачаалалтай жилд $2.3-1.0=1.3$ хүний ажлыг илүү хийсэн гэсэн утгыг илтгэж байна.

Шийдийн **Баянзүрх-2.0** нь нэг шүүгч 5 жилийн дунджаар ойролцоогоор $2.0-1.0=1.0$ хүний ажлыг илүү хийсэн гэсэн утгыг илтгэж байна.

Ажиллаж буй шүүгчийн тооны **Баянзүрх-9.6** нь энэ дүүрэгт 5 жилийн дунджаар 9.6 шүүгч ойролцоогоор ажилласан гэсэн утгыг илтгэж байна.

Ажиллавал зохих шүүгчийн тооны **Баянзүрх-19.2** нь энэ дүүрэгт 19.2 шүүгч ойролцоогоор ажиллавал зохистой байжээ гэсэн утгыг илтгэж байна.

Зөрүүний **Баянзүрх-9.6** нь энэ дүүргийн эрүүгийн хэргийн шүүхэд 10 шүүгч нэмж ажиллуулах шаардлагатай гэсэн утгыг илтгэж байна.

Дүн гэсэн мөрийн мэдээллийг тайлбарлая. Хувьсагчдын нөхцөлийн доод хилийн утгын **6.3** нь сүүлийн 5 жилийн хувьд нийслэлийн төвийн 6 дүүргийн эрүүгийн хэргийн 6 шүүгч хамгийн бага ачаалалтай жилд $6.3-6.0=0.3$ хүний ажлыг илүү хийсэн гэсэн утгыг илтгэж байна.

Хувьсагчдын нөхцөлийн дээд хилийн утгын **11.6** нь сүүлийн 5 жилийн хувьд нийслэлийн төвийн 6 дүүргийн эрүүгийн хэргийн 6 шүүгч хамгийн их ачаалалтай жилд $11.6-6.0=5.6$ хүний ажлыг илүү хийсэн гэсэн утгыг илтгэж байна.

Шийдийн **9.6** нь сүүлийн 5 жилийн хувьд нийслэлийн төвийн 6 дүүргийн эрүүгийн хэргийн 6 шүүгч дунджаар $9.6-6.0=3.6$ хүний ажлыг илүү хийж иржээ гэсэн утгыг илтгэж байна.

Ажиллаж буй шүүгчийн тооны **44.1** нь нийслэлийн төвийн 6 дүүргийн эрүүгийн хэргийн шүүхэд 5 жилийн өгөгдлийн дунджаар 44.1 шүүгч ажилласан гэсэн утгыг илтгэж байна.

Ажиллавал зохих шүүгчийн тооны **71.7** нь нийслэлийн төвийн 6 дүүргийн эрүүгийн хэргийн шүүхэд 5 жилийн дунджаар 71.7 шүүгч ажиллавал зохистой байсан байна гэсэн утгыг илтгэж байна.

Зөрүүний **27.6** нь нийслэлийн төвийн 6 дүүргийн эрүүгийн хэргийн шүүхэд **28** шүүгч нэмж ажиллуулах шаардлагатай гэсэн утгыг илтгэж байна.

- **Зөрчлийн хэрэг**

Бодлогын нөхцөлд орох зөрчлийн хэргийн дээд доод хилийн утгыг эрүүгийн хэргийн тоонд шилжүүлсэн дүнгээр тооцсон. 2-р бүлгийн судалгааны үр дүн (Зураг 2.26. 1эрүүгийн хэрэг=10.2 зөрчлийн хэрэг)-г баримтлан шүүгчийн хянан шийдвэрлэвэл зохих эрүүгийн хэргийн тооны дээд, доод хилийн утгыг тооцсон. Судалгааны өгөгдлийн утга –5 интервалд байх доод хилийн утгыг тооцоход 95 хувийн магадлалтайгаар интервалын утга 80 гарсан тул бодлогын нөхцөл [80; 89] завсарт тавигдаж бодлогын шийд болох дараах үр дүнг өгөв.

№	Төвийн дүүрэг	Хувьсагчдын нөхцөл		Шийд	Ажиллаж буй шүүгчийн тоо	Ажиллавал зохих шүүгчийн тоо	Зөрүү
		Доод хил	Дээд хил				
		A	B				
1	Баянзүрх	2.3	3.3	3.0	1	3.0	2.0
2	Чингэлтэй	0.7	1.1	1.0	1	1.0	0.0
3	Сүхбаатар	0.6	1.7	1.2	1	1.2	0.2
4	Баянгол	0.6	1.5	1.3	1	1.3	0.3
5	Хан-Уул	1.0	1.8	1.4	1	1.4	0.4
6	Сонгинохайрхан	0.9	2.1	1.7	1	1.7	0.7
	Дүн	6.1	11.5	9.6	6.0	9.6	3.6

Хүснэгт 4.2. Төвийн 6 дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн зөрчлийн хэргийг шийдвэрлэхэд шаардлагатай шүүгчийн тоо

Хүснэгтийн эхний дүүрэг дээр тайлбар өгье. Хувьсагчдын нөхцөлийн доод хилийн утгын **Баянзүрх-2.3** нь сүүлийн 4 жилийн өгөгдлийн хувьд Баянзүрх дүүргийн зөрчлийн хэргийн шүүгч хамгийн бага ачаалалтай жилд $2.3-1.0=1.3$ хүний ажлыг илүү хийсэн гэсэн утгыг илтгэж байна.

Хувьсагчдын нөхцөлийн дээд хилийн утгын **Баянзүрх-3.3** нь сүүлийн 4 жилийн өгөгдлийн хувьд Баянзүрх дүүргийн зөрчлийн хэргийн шүүгч хамгийн их ачаалалтай жилд $3.3-1.0=2.3$ хүний ажлыг илүү хийсэн гэсэн утгыг илтгэж байна.

Шийдийн **Баянзүрх-3.0** нь нэг шүүгч 4 жилийн дунджаар ойролцоогоор $3.0-1.0=2.0$ хүний ажлыг илүү хийсэн гэсэн утгыг илтгэж байна.

Ажиллаж буй шүүгчийн тооны **Баянзүрх-1** нь энэ дүүрэгт 4 жилийн дунджаар 1 шүүгч ажилласан гэсэн утгыг илтгэж байна.

Ажиллавал зохих шүүгчийн тооны **Баянзүрх-3** нь энэ дүүрэгт 3 шүүгч ажиллавал зохистой байжээ гэсэн утгыг илтгэж байна.

Зөрүүний **Баянзүрх-2** нь энэ дүүргийн эрүүгийн хэргийн шүүхэд 2 шүүгч нэмж ажиллуулах шаардлагатай гэсэн утгыг илтгэж байна.

Дүн гэсэн мөрийн мэдээллийг тайлбарлая. Хувьсагчдын нөхцөлийн доод хилийн утгын **6.1** нь сүүлийн 4 жилийн хувьд нийслэлийн төвийн 6 дүүргийн зөрчлийн хэргийн 6 шүүгч хамгийн бага ачаалалтай жилд $6.1-6.0=0.1$ хүний ажлыг илүү хийсэн гэсэн утгыг илтгэж байна.

Хувьсагчдын нөхцөлийн дээд хилийн утгын **11.5** нь сүүлийн 4 жилийн хувьд нийслэлийн төвийн 6 дүүргийн зөрчлийн хэргийн 6 шүүгч хамгийн их ачаалалтай жилд $11.6-6.0=5.5$ хүний ажлыг илүү хийсэн гэсэн утгыг илтгэж байна.

Шийдийн **9.6** нь сүүлийн 4 жилийн хувьд нийслэлийн төвийн 6 дүүргийн зөрчлийн хэргийн 6 шүүгч дунджаар $9.6-6.0=3.6$ хүний ажлыг илүү хийж иржээ гэсэн утгыг илтгэж байна.

Ажиллаж буй шүүгчийн тооны **6.0** нь нийслэлийн төвийн 6 дүүргийн эрүүгийн хэргийн шүүхэд 4 жилийн өгөгдлийн дунджаар 6 шүүгч ажилласан гэсэн утгыг илтгэж байна.

Ажиллавал зохих шүүгчийн тооны **9.6** нь нийслэлийн төвийн 6 дүүргийн эрүүгийн хэргийн шүүхэд 4 жилийн дунджаар 3.6 шүүгч ажиллавал зохистой байсан байна гэсэн утгыг илтгэж байна.

Зөрүүний **3.6** нь нийслэлийн төвийн 6 дүүргийн эрүүгийн хэргийн шүүхэд зөрчлийн 3-4 шүүгч нэмж ажиллуулах шаардлагатай гэсэн утгыг илтгэж байна.

- **Иргэний хэргийн шүүх**

2-р бүлгийн судалгааны үр дүн (*Хүснэгт 2.43*)-г баримтлан шүүгчийн хянан шийдвэрлэвэл зохих иргэний хэргийн тооны дээд, доод хилийн утгыг тооцсон. Нэг шүүгчийн хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн улсын дундаж 250 бол өндөр тоо гэсэн саналыг ШЕЗ-н гишүүд өгч байсан тул бодлогын дээд хилийн утгыг 250-ээс хэтрэхгүй байхаар сонгосон. Судалгааны өгөгдлийн утга –5 интервалд байх доод хилийн утгыг тооцоход 95 хувийн магадлалтайгаар интервалын утга 225 гарсан тул бодлогын нөхцөл [225; 250] завсарт тавигдаж бодлогын шийд болох дараах үр дүнг өгөв.

№	Төвийн дүүрэг	Хувьсагчдын нөхцөл		Шийд	Ажиллаж буй шүүгчийн тоо	Ажиллавал зохих шүүгчийн тоо	Зөрүү
		Доод хил	Дээд хил				
		A	B	C	D	C*D	C*D-D
1	Баянзүрх	1.4	1.5	1.5	16.4	24.6	8.2
2	Чингэлтэй	1.1	1.5	1.3	11.8	15.3	3.5
3	Сүхбаатар	1.2	1.4	1.4	11.5	16.1	4.6
4	Баянгол	1.2	1.3	1.3	14.4	18.7	4.3
5	Хан-Уул	1.4	1.7	1.6	11.0	17.6	6.6
6	Сонгинохайрхан	1.4	1.5	1.4	12.0	16.8	4.8
	Дүн	7.7	8.9	8.5	77.1	109.2	32.1

Хүснэгт 4.3. Төвийн 6 дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд шүүхэд шаардлагатай шүүгчийн тоо

Хүснэгтийн эхний дүүрэг дээр тайлбар өгье. Хувьсагчдын нөхцөлийн доод хилийн утгын **Баянзүрх-1.4** нь сүүлийн 5 жилийн өгөгдлийн хувьд Баянзүрх дүүргийн иргэний хэргийн шүүгч хамгийн бага ачаалалтай жилд $1.4-1.0=0.4$ хүний ажлыг илүү хийсэн гэсэн утгыг илтгэж байна.

Хувьсагчдын нөхцөлийн дээд хилийн утгын **Баянзүрх-1.5** нь сүүлийн 5 жилийн өгөгдлийн хувьд Баянзүрх дүүргийн иргэний хэргийн шүүгч хамгийн их ачаалалтай жилд $1.5-1.0=0.5$ хүний ажлыг илүү хийсэн гэсэн утгыг илтгэж байна.

Шийдийн **Баянзүрх-1.5** нь нэг шүүгч 5 жилийн дунджаар ойролцоогоор $1.5-1.0=0.5$ хүний ажлыг илүү хийсэн гэсэн утгыг илтгэж байна.

Ажиллаж буй шүүгчийн тооны **Баянзүрх-16.4** нь энэ дүүрэгт 5 жилийн дунджаар 16.4 шүүгч ажилласан гэсэн утгыг илтгэж байна.

Ажиллавал зохих шүүгчийн тооны **Баянзүрх-24.6** нь энэ дүүрэгт 24-25 шүүгч ажиллавал зохистой байжээ гэсэн утгыг илтгэж байна.

Зөрүүний **Баянзүрх-8.2** нь энэ дүүргийн иргэний хэргийн шүүхэд 8 шүүгч нэмж ажиллуулах шаардлагатай гэсэн утгыг илтгэж байна.

Дүн гэсэн мөрийн мэдээллийг тайлбарлая. Хувьсагчдын нөхцөлийн доод хилийн утгын **7.7** нь сүүлийн 5 жилийн хувьд нийслэлийн төвийн 6 дүүргийн иргэний хэргийн 6 шүүгч хамгийн бага ачаалалтай жилд $7.7-6.0=1.7$ хүний ажлыг илүү хийсэн гэсэн утгыг илтгэж байна.

Хувьсагчдын нөхцөлийн дээд хилийн утгын **8.9** нь сүүлийн 5 жилийн хувьд нийслэлийн төвийн 6 дүүргийн иргэний хэргийн 6 шүүгч хамгийн их ачаалалтай жилд $8.9-6.0=2.9$ хүний ажлыг илүү хийсэн гэсэн утгыг илтгэж байна.

Шийдийн **8.5** нь сүүлийн 5 жилийн хувьд нийслэлийн төвийн 6 дүүргийн иргэний хэргийн 6 шүүгч дунджаар $8.5-6.0=2.5$ хүний ажлыг илүү хийж иржээ гэсэн утгыг илтгэж байна.

Ажиллаж буй шүүгчийн тооны **77.1** нь нийслэлийн төвийн 6 дүүргийн иргэний хэргийн шүүхэд 5 жилийн өгөгдлийн дунджаар 77.1 шүүгч ажилласан гэсэн утгыг илтгэж байна.

Ажиллавал зохих шүүгчийн тооны **109.2** нь нийслэлийн төвийн 6 дүүргийн иргэний хэргийн шүүхэд 5 жилийн дунджаар 109.2 шүүгч ажиллавал зохистой байсан байна гэсэн утгыг илтгэж байна.

Зөрүүний **32.1** нь нийслэлийн төвийн 6 дүүргийн иргэний хэргийн шүүхэд 32 шүүгч нэмж ажиллуулах шаардлагатай гэсэн утгыг илтгэж байна.

- **Захиргааны хэргийн шүүх**

2-р бүлгийн судалгааны үр дүн (*Хүснэгт 2.43*)-г баримтлан шүүгчийн хянан шийдвэрлэвэл зохих захиргааны хэргийн тооны дээд, доод хилийн утгыг тооцсон. Нэг шүүгчийн хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийн улсын дундаж 34 бол дотооддоо хийсэн судалгааны үр дүнгээс бага тоо гэсэн саналыг ШЕЗ-н гишүүд өгч байсан тул бодлогын дээд хилийн утгыг 40-ээс хэтрэхгүй байхаар сонгосон. Судалгааны өгөгдлийн утга –5 интервалд байх доод хилийн утгыг тооцоход 98 хувийн магадлалтайгаар интервалын утга 34 гарсан тул бодлогын нөхцөл [34; 40] завсарт тавигдаж бодлогын шийд болох дараах үр дүнг өгөв.

Нийслэл	Хувьсагчдын нөхцөл		Шийд	Ажиллаж буй шүүгчийн тоо	Ажиллавал зохих шүүгчийн тоо	Зөрүү
	Доод хил	Дээд хил				
	A	B	C	D	C*D	C*D-D
Дүн	1.4	1.6	1.5	18.5	27.8	9.3

Хүснэгт 4.4. Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүхэд шүүхэд шаардлагатай шүүгчийн тоо

Хүснэгтийн үр дүнг тайлбарлая. Хувьсагчдын нөхцөлийн доод хилийн утгын **1.4** нь сүүлийн 5 жилийн өгөгдлийн хувьд нийслэлийн захиргааны хэргийн шүүгч хамгийн бага ачаалалтай жилд $1.4-1.0=0.4$ хүний ажлыг илүү хийсэн гэсэн утгыг илтгэж байна.

Хувьсагчдын нөхцөлийн дээд хилийн утгын **1.6** нь сүүлийн 5 жилийн өгөгдлийн хувьд нийслэлийн захиргааны хэргийн шүүгч хамгийн их ачаалалтай жилд $1.6-1.0=0.6$ хүний ажлыг илүү хийсэн гэсэн утгыг илтгэж байна.

Шийдийн **1.5** нь нэг шүүгч 5 жилийн дунджаар ойролцоогоор $1.5-1.0=0.5$ хүний ажлыг илүү хийсэн гэсэн утгыг илтгэж байна.

Ажиллаж буй шүүгчийн тооны **18.5** нь нийслэлийн захиргааны хэргийн шүүхэд 5 жилийн дунджаар 18.5 шүүгч ажилласан гэсэн утгыг илтгэж байна.

Ажиллавал зохих шүүгчийн тооны **27.8** нь нийслэлийн захиргааны хэргийн шүүхэд 27-28 шүүгч ажиллавал зохистой байжээ гэсэн утгыг илтгэж байна.

Зөрүүний **9.3** нь нийслэлийн захиргааны хэргийн шүүхэд 9 шүүгч нэмж ажиллуулах шаардлагатай гэсэн утгыг илтгэж байна.

- **Захын 3 дүүргийн эрүүгийн хэргийн шүүх**

Нийслэлийн захын 3 дүүргийн ЭХАШШ-д эрүү ба зөрчлийн хэрэг дээр нэг шүүгч ажилладаг онцлогтой тул шүүгчийн ачааллын коэффициент, шаардлагатай шүүгчийн тоог тодорхойлох оновчлолын бодлогын нөхцөлийг тодорхойлохдоо нэг шүүгчийн хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг дээр хянан шийдвэрлэсэн зөрчлийн хэргийн тоог 10.2-д

хувааж оруулсан. 2-р бүлгийн судалгааны үр дүн (Хүснэгт 2.43)-г баримтлан шүүгчийн хянан шийдвэрлэвэл зохих эрүүгийн хэргийн тооны дээд, доод хилийн утгыг тооцсон. Нэг шүүгчийн хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн улсын дундаж 89 бол өндөр тоо гэсэн саналыг ШЕЗ-н гишүүд өгч байсан тул бодлогын дээд хилийн утгыг 89-ээс хэтрэхгүй байхаар сонгосон. Судалгааны өгөгдлийн утга –5 интервалд байх доод хилийн утгыг тооцоход 95 хувийн магадлалтайгаар интервалын утга 80 гарсан тул бодлогын нөхцөл [80; 89] завсарт тавигдаж бодлогын шийд болох дараах үр дүнг өгөв.

№	Захын дүүрэг	Хувьсагчдын нөхцөл		Шийд	Ажиллаж буй шүүгчийн тоо	Ажиллавал зохих шүүгчийн тоо	Зөрүү
		Доод хил	Дээд хил				
		A	B				
1	Багануур	0.3	0.7	0.5	3.3	1.7	-1.7
2	Налайх	0.5	1.1	0.8	2.7	2.2	-0.5
3	Багахангай	0.1	0.3	0.2	1.0	0.2	-0.8
	Дүн	0.9	2.1	1.5	7.0	4.0	-3.0

Хүснэгт 4.5. Захын 3 дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд шүүхэд шаардлагатай шүүгчийн тоо

Хүснэгтийн эхний дүүрэг дээр тайлбар өгье. Хувьсагчдын нөхцөлийн доод хилийн утгын **Багануур-0.3** нь сүүлийн 5 жилийн өгөгдлийн хувьд Багануур дүүргийн эрүүгийн хэргийн шүүгч хамгийн бага ачаалалтай жилд 0.3-1.0=-0.7 хүний ажлыг дутуу хийсэн гэсэн утгыг илтгэж байна.

Хувьсагчдын нөхцөлийн дээд хилийн утгын **Багануур-0.7** нь сүүлийн 5 жилийн өгөгдлийн хувьд Багануур дүүргийн эрүүгийн хэргийн шүүгч хамгийн их ачаалалтай жилд 0.7-1.0=-0.3 хүний ажлыг дутуу хийсэн гэсэн утгыг илтгэж байна.

Шийдийн **Багануур-0.5** нь нэг шүүгч 5 жилийн дунджаар ойролцоогоор 0.5-1.0=-0.5 хүний ажлыг дутуу хийсэн гэсэн утгыг илтгэж байна.

Ажиллаж буй шүүгчийн тооны **Багануур-3.3** нь энэ дүүрэгт 5 жилийн дунджаар 3.3 шүүгч ойролцоогоор ажилласан гэсэн утгыг илтгэж байна.

Ажиллавал зохих шүүгчийн тооны **Багануур-1.7** нь энэ дүүрэгт 2 шүүгч ойролцоогоор ажиллавал зохистой байжээ гэсэн утгыг илтгэж байна.

Зөрүүний **Багануур--1.7** нь энэ дүүргийн эрүүгийн хэргийн шүүхээс 1-2 шүүгч татаж өөр шүүхэд ажиллуулах шаардлагатай гэсэн утгыг илтгэж байна.

Дүн гэсэн мөрийн мэдээллийг тайлбарлая. Хувьсагчдын нөхцөлийн доод хилийн утгын **0.9** нь сүүлийн 5 жилийн хувьд нийслэлийн захын 3 дүүргийн эрүүгийн хэргийн 3 шүүгч хамгийн бага ачаалалтай жилд 0.9-3.0=-2.1 хүний ажлыг дутуу хийсэн гэсэн утгыг илтгэж байна.

Хувьсагчдын нөхцөлийн дээд хилийн утгын **2.1** нь сүүлийн 5 жилийн хувьд нийслэлийн захын 3 дүүргийн эрүүгийн хэргийн 3 шүүгч хамгийн их ачаалалтай жилд 2.1-3.0=-0.9 хүний ажлыг дутуу хийсэн гэсэн утгыг илтгэж байна.

Шийдийн **1.5** нь сүүлийн 5 жилийн хувьд нийслэлийн захын 3 дүүргийн эрүүгийн хэргийн 3 шүүгч дунджаар 1.5-3.0=-1.5 хүний ажлыг дутуу хийж иржээ гэсэн утгыг илтгэж байна.

Ажиллаж буй шүүгчийн тооны **7.0** нь нийслэлийн захын 3 дүүргийн эрүүгийн хэргийн шүүхэд 5 жилийн өгөгдлийн дунджаар 7.0 шүүгч ажилласан гэсэн утгыг илтгэж байна.

Ажиллавал зохих шүүгчийн тооны **4** нь нийслэлийн захын 3 дүүргийн эрүүгийн хэргийн шүүхэд 4 шүүгч ажиллавал зохистой байсан байна гэсэн утгыг илтгэж байна.

Зөрүүний **-3.0** нь нийслэлийн захын 3 дүүргийн эрүүгийн хэргийн шүүхээс 3 шүүгч татаж өөр шүүхэд ажиллуулах шаардлагатай гэсэн утгыг илтгэж байна.

• **Захын 3 дүүргийн иргэний хэргийн шүүх**

2-р бүлгийн судалгааны үр дүн (*Хүснэгт 2.43*)-г баримтлан шүүгчийн хянан шийдвэрлэвэл зохих иргэний хэргийн тооны дээд, доод хилийн утгыг тооцсон. Нэг шүүгчийн хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн улсын дундаж 250 бол өндөр тоо гэсэн саналыг ШЕЗ-н гишүүд өгч байсан тул бодлогын дээд хилийн утгыг 250-ээс хэтрэхгүй байхаар сонгосон. Судалгааны өгөгдлийн утга -5 интервалд байх доод хилийн утгыг тооцоход 95 хувийн магадлалтайгаар интервалын утга 225 гарсан тул бодлогын нөхцөл [225; 250] завсарт тавигдаж бодлогын шийд болох дараах үр дүнг өгөв.

№	Захын дүүрэг	Хувьсагчдын нөхцөл		Шийд	Ажиллаж буй шүүгчийн тоо	Ажиллавал зохих шүүгчийн тоо	Зөрүү
		Доод хил	Дээд хил				
		A	B	C	D	C*D	C*D-D
1	Багануур	0.5	1.0	0.7	3.4	2.1	-0.9
2	Налайх	0.7	0.9	0.8	3.1	2.5	-0.6
3	Багахангай	0.1	0.2	0.2	1.0	0.2	-0.8
	Дүн	1.3	2.1	1.7	7.5	4.8	-2.3

Хүснэгт 4.6. Захын 3 дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд шүүхэд шаардлагатай шүүгчийн тоо

Хүснэгтийн эхний дүүрэг дээр тайлбар өгье. Хувьсагчдын нөхцөлийн доод хилийн утгын **Багануур-0.5** нь сүүлийн 5 жилийн өгөгдлийн хувьд Багануур дүүргийн иргэний хэргийн шүүгч хамгийн бага ачаалалтай жилд $0.5-1.0=-0.5$ хүний ажлыг дутуу хийсэн гэсэн утгыг илтгэж байна.

Хувьсагчдын нөхцөлийн дээд хилийн утгын **2.1** нь сүүлийн 5 жилийн хувьд нийслэлийн захын 3 дүүргийн эрүүгийн хэргийн 3 шүүгч хамгийн их ачаалалтай жилд $2.1-3.0=-0.9$ хүний ажлыг дутуу хийсэн гэсэн утгыг илтгэж байна.

Шийдийн **1.6** нь сүүлийн 5 жилийн хувьд нийслэлийн захын 3 дүүргийн эрүүгийн хэргийн 3 шүүгч дунджаар $1.6-3.0=-1.7$ хүний ажлыг дутуу хийж иржээ гэсэн утгыг илтгэж байна.

Ажиллаж буй шүүгчийн тооны **7.0** нь нийслэлийн захын 3 дүүргийн эрүүгийн хэргийн шүүхэд 5 жилийн өгөгдлийн дунджаар 7.0 шүүгч ажилласан гэсэн утгыг илтгэж байна.

Ажиллавал зохих шүүгчийн тооны **4.3** нь нийслэлийн захын 3 дүүргийн эрүүгийн хэргийн шүүхэд 4 шүүгч ажиллавал зохистой байсан байна гэсэн утгыг илтгэж байна. Зөрүүний **-2.7** нь нийслэлийн захын 3 дүүргийн эрүүгийн хэргийн шүүхээс 2-3 шүүгч татаж өөр шүүхэд ажиллуулах шаардлагатай гэсэн утгыг илтгэж байна.

- **Захын 3 дүүргийн иргэний хэргийн шүүх**

2-р бүлгийн судалгааны үр дүн (*Хүснэгт 2.43*)-г баримтлан шүүгчийн хянан шийдвэрлэвэл зохих иргэний хэргийн тооны дээд, доод хилийн утгыг тооцсон. Нэг

шүүгчийн хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн улсын дундаж 250 бол өндөр тоо гэсэн саналыг ШЕЗ-н гишүүд өгч байсан тул бодлогын дээд хилийн утгыг 225-ээс хэтрэхгүй байхаар сонгосон. Судалгааны өгөгдлийн утга -5 интервалд байх доод хилийн утгыг тооцоход 95 хувийн магадлалтайгаар интервалын утга 225 гарсан тул бодлогын нөхцөл [200; 225] завсарт тавигдаж бодлогын шийд болох дараах үр дүнг өгөв.

№	Захын дүүрэг	Хувьсагчдын нөхцөл		Шийд	Ажиллаж буй шүүгчийн тоо	Ажиллавал зохих шүүгчийн тоо	Зөрүү
		Доод хил	Дээд хил				
		A	B				
1	Багануур	0.5	1.1	0.8	3.4	2.7	-0.7
2	Налайх	0.8	1.0	0.8	3.1	2.5	-0.6
3	Багахангай	0.2	0.3	0.2	1.0	0.2	-0.8
	Дүн	1.5	2.4	1.8	7.5	5.4	-2.1

Хүснэгт 4.24. Захын 3 дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд шаардлагатай шүүгчийн тоо

Хүснэгтийн эхний дүүрэг дээр тайлбар өгье. Хувьсагчдын нөхцөлийн доод хилийн утгын **Багануур-0.5** нь сүүлийн 5 жилийн өгөгдлийн хувьд Багануур дүүргийн иргэний хэргийн шүүгч хамгийн бага ачаалалтай жилд $0.5-1.0=-0.5$ хүний ажлыг дутуу хийсэн гэсэн утгыг илтгэж байна.

Хувьсагчдын нөхцөлийн дээд хилийн утгын **Багануур-1.1** нь сүүлийн 5 жилийн өгөгдлийн хувьд Багануур дүүргийн иргэний хэргийн шүүгч хамгийн их ачаалалтай жилд $1.1-1.0=0.1$ буюу ачаалал зохистой байсан гэсэн утгыг илтгэж байна.

Шийдийн **Багануур-0.8** нь нэг шүүгч 5 жилийн дунджаар ойролцоогоор $0.8-1.0=-0.2$ хүний ажлыг дутуу хийсэн гэсэн утгыг илтгэж байна.

Ажиллаж буй шүүгчийн тооны **Багануур-3.4** нь энэ дүүрэгт 5 жилийн дунджаар 3.4 шүүгч ойролцоогоор ажилласан гэсэн утгыг илтгэж байна.

Ажиллавал зохих шүүгчийн тооны **Багануур-2.7** нь энэ дүүрэгт 3 шүүгч ойролцоогоор ажиллавал зохистой байжээ гэсэн утгыг илтгэж байна.

Зөрүүний **Багануур--0.7** нь энэ дүүргийн иргэний хэргийн шүүхээс 1 шүүгч татаж өөр шүүхэд ажиллуулах шаардлагатай гэсэн утгыг илтгэж байна.

Дүн гэсэн мөрийн мэдээллийг тайлбарлая. Хувьсагчдын нөхцөлийн доод хилийн утгын **1.5** нь сүүлийн 5 жилийн хувьд нийслэлийн захын 3 дүүргийн иргэний хэргийн 3 шүүгч хамгийн бага ачаалалтай жилд $1.5-3.0=-1.5$ хүний ажлыг дутуу хийсэн гэсэн утгыг илтгэж байна.

Хувьсагчдын нөхцөлийн дээд хилийн утгын **2.4** нь сүүлийн 5 жилийн хувьд нийслэлийн захын 3 дүүргийн иргэний хэргийн 3 шүүгч хамгийн их ачаалалтай жилд $2.4-3.0=-0.6$ хүний ажлыг дутуу хийсэн гэсэн утгыг илтгэж байна.

Шийдийн **1.8** нь сүүлийн 5 жилийн хувьд нийслэлийн захын 3 дүүргийн иргэний хэргийн 3 шүүгч дунджаар $1.8-3.0=-1.2$ хүний ажлыг дутуу хийж иржээ гэсэн утгыг илтгэж байна.

Ажиллаж буй шүүгчийн тооны **7.5** нь нийслэлийн захын 3 дүүргийн иргэний хэргийн шүүхэд 5 жилийн өгөгдлийн дунджаар 7-8 шүүгч ажилласан гэсэн утгыг илтгэж байна.

Ажиллавал зохих шүүгчийн тооны **5.4** нь нийслэлийн захын 3 дүүргийн иргэний хэргийн шүүхэд 5 шүүгч ажиллавал зохистой байсан байна гэсэн утгыг илтгэж байна.

Зөрүүний **-2.1** нь нийслэлийн захын 3 дүүргийн иргэний хэргийн шүүхээс 2 шүүгч татаж өөр шүүхэд ажиллуулах шаардлагатай гэсэн утгыг илтгэж байна.

4.2.1.2. Аймгийн шүүх

- Аймгийн эрүүгийн хэргийн шүүх

АЭХАШШ-д эрүү ба зөрчлийн хэрэг дээр нэг шүүгч ажилладаг онцлогтой тул шүүгчийн ачааллын коэффициент, шаардлагатай шүүгчийн тоог тодорхойлох оновчлолын бодлогын нөхцөлийг тодорхойлохдоо нэг шүүгчийн хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг дээр хянан шийдвэрлэсэн зөрчлийн хэргийн тоог 10.2-д хувааж оруулсан. 2-р бүлгийн судалгааны үр дүн (Хүснэгт 2.43)-г баримтлан шүүгчийн хянан шийдвэрлэвэл зохих эрүүгийн хэргийн тооны дээд, доод хилийн утгыг тооцсон. Нэг шүүгчийн хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн улсын дундаж 89 бол өндөр тоо гэсэн саналыг ШЕЗ-н гишүүд өгч байсан тул бодлогын дээд хилийн утгыг 85-ээс хэтрэхгүй байхаар сонгосон. Судалгааны өгөгдлийн утга –5 интервалд байх доод хилийн утгыг тооцоход 95 хувийн магадлалтайгаар интервалын утга 75 гарсан тул бодлогын нөхцөл [75; 85] завсарт тавигдаж бодлогын шийд болох дараах үр дүнг өгөв.

№	Аймаг	Хувьсагчдын нөхцөл		Шийд	Ажиллаж буй шүүгчийн тоо	Ажиллавал зохих шүүгчийн тоо	Зөрүү
		Доод хил	Дээд хил				
		A	B				
1	Баян-Өлгий	0.7	1.0	0.8	3.3	2.6	-0.7
2	Говь-алтай	0.4	0.7	0.6	3.0	1.8	-1.2
3	Завхан	0.4	0.7	0.6	2.9	1.7	-1.2
4	Увс	0.8	1.3	1.0	2.7	2.7	0.0
5	Ховд	0.7	1.3	1.1	2.6	2.9	0.3
6	Архангай	0.8	1.5	1.2	3.0	3.6	0.6
7	Баянхонгор	0.9	1.8	1.3	3.2	4.2	1.0
8	Булган	0.8	1.4	1.2	2.7	3.2	0.5
9	Орхон	1.4	1.5	1.5	3.9	5.9	2.0
10	Хөвсгөл	1.1	1.7	1.4	3.6	5.0	1.4
11	Өвөрхангай	0.8	1.7	1.3	2.8	3.6	0.8
12	Говь-сүмбэр	0.4	0.6	0.5	2.7	1.4	-1.4
13	Дархан-Уул	1.0	1.5	1.3	4.5	5.9	1.4
14	Дорноговь	0.8	1.2	0.9	2.7	2.4	-0.3
15	Дундговь	0.4	0.7	0.6	2.7	1.6	-1.1
16	Өмнөговь	0.7	0.8	0.8	3.0	2.4	-0.6
17	Сэлэнгэ	0.9	1.3	1.2	2.5	3.0	0.5
18	Төв	1.2	1.4	1.3	4.6	6.0	1.4
19	Дорнод	0.9	2.2	1.8	2.7	4.9	2.2
20	Хэнтий	0.9	2.1	1.5	2.4	3.6	1.2
21	Сүхбаатар	0.7	1.2	1.1	2.7	3.0	0.3
	Дүн	16.7	27.6	23	64.2	71.4	7.2

Хүснэгт 4.25. Аймгийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд шаардлагатай шүүгчийн тоо

Хүснэгтийн эхний аймаг дээр тайлбар өгье. Хувьсагчдын нөхцөлийн доод хилийн утгын **Баян-Өлгий-0.7** нь сүүлийн 5 жилийн өгөгдлийн хувьд Баян-Өлгий аймгийн эрүүгийн хэргийн шүүгч хамгийн бага ачаалалтай жилд $0.7-1.0=-0.3$ хүний ажлыг дутуу хийсэн гэсэн утгыг илтгэж байна.

Хувьсагчдын нөхцөлийн дээд хилийн утгын **Баян-Өлгий-1.0** нь сүүлийн 5 жилийн өгөгдлийн хувьд Баян-Өлгий аймгийн эрүүгийн хэргийн шүүгч хамгийн их ачаалалтай жилд $1.0-1.0=0$ буюу ачаалал авах ажлаа гүйцэд хийсэн гэсэн утгыг илтгэж байна.

Шийдийн **Баян-Өлгий-0.8** нь нэг шүүгч 5 жилийн дунджаар ойролцоогоор $0.8-1.0=-0.2$ хүний ажлыг дутуу хийсэн гэсэн утгыг илтгэж байна.

Ажиллаж буй шүүгчийн тооны **Баян-Өлгий-3.3** нь энэ аймагт 5 жилийн дунджаар 3 шүүгч ойролцоогоор ажилласан гэсэн утгыг илтгэж байна.

Ажиллавал зохих шүүгчийн тооны **Баян-Өлгий-2.6** нь энэ аймагт 2.6 шүүгч ажиллавал зохистой байжээ гэсэн утгыг илтгэж байна.

Зөрүүний **Баян-Өлгий-0.7** нь энэ аймгийн эрүүгийн хэргийн шүүхээс 1 шүүгчийг татаж өөр шүүхэд ажиллуулах шаардлагатай гэсэн утгыг илтгэж байна.

Дүн гэсэн мөрийн мэдээллийг тайлбарлая. Хувьсагчдын нөхцөлийн доод хилийн утгын **16.7** нь сүүлийн 5 жилийн хувьд АЭХАШШ-н 21 шүүгч хамгийн бага ачаалалтай жилд 16-17 хүний ажлыг хийсэн гэсэн утгыг илтгэж байна.

Хувьсагчдын нөхцөлийн дээд хилийн утгын **27.6** нь сүүлийн 5 жилийн хувьд АЭХАШШ-н 21 шүүгч хамгийн их ачаалалтай жилд 26-27 хүний ажлыг хийсэн гэсэн утгыг илтгэж байна.

Шийдийн **23** нь сүүлийн 5 жилийн хувьд АЭХАШШ-н 21 шүүгч дунджаар 23 хүний ажлыг хийж иржээ гэсэн утгыг илтгэж байна.

Ажиллаж буй шүүгчийн тооны **64.2** нь АЭХАШШ-н шүүхэд 64.2 шүүгч ажилласан гэсэн утгыг илтгэж байна.

Ажиллавал зохих шүүгчийн тооны **71.4** нь АЭХАШШ-н шүүхэд 71 шүүгч ажиллавал зохистой байсан байна гэсэн утгыг илтгэж байна.

Зөрүүний **7.2** нь АЭХАШШ-н шүүхэд **7** шүүгч нэмж ажиллуулах шаардлагатай гэсэн утгыг илтгэж байна.

• **Аймгийн иргэний хэргийн шүүх**

2-р бүлгийн судалгааны үр дүн (*Хүснэгт 2.43*)-г баримтлан шүүгчийн хянан шийдвэрлэвэл зохих иргэний хэргийн тооны дээд, доод хилийн утгыг тооцсон. Нэг шүүгчийн хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн улсын дундаж 250 бол өндөр тоо гэсэн саналыг ШЕЗ-н гишүүд өгч байсан тул бодлогын дээд хилийн утгыг 225-ээс хэтрэхгүй байхаар сонгосон. Судалгааны өгөгдлийн утга –5 интервалд байх доод хилийн утгыг тооцоход 95 хувийн магадлалтайгаар интервалын утга 200 гарсан тул бодлогын нөхцөл [200; 225] завсарт тавигдаж бодлогын шийд болох дараах үр дүнг өгөв.

№	Аймаг	Хувьсагчдын нөхцөл		Шийд	Ажиллаж буй шүүгчийн тоо	Ажиллавал зохих шүүгчийн тоо	Зөрүү
		Доод хил	Дээд хил				
		A	B				
1	Баян-Өлгий	1.0	1.5	1.2	4.0	4.8	0.8
2	Говь-алтай	0.8	1.6	1.1	2.7	3.0	0.3
3	Завхан	0.9	1.3	1.1	2.9	3.2	0.3
4	Увс	0.9	1.6	1.4	2.8	3.9	1.1
5	Ховд	1.1	1.8	1.4	2.8	3.9	1.1
6	Архангай	1.2	1.8	1.6	2.8	4.5	1.7
7	Баянхонгор	1.5	1.9	1.7	2.9	4.9	2.0
8	Булган	1.1	1.6	1.4	2.6	3.6	1.0
9	Орхон	1.4	1.6	1.5	5.0	7.5	2.5
10	Хөвсгөл	1.1	1.8	1.5	5.5	8.3	2.8
11	Өвөрхангай	1.2	1.8	1.5	2.6	3.9	1.3
12	Говь-сүмбэр	0.3	0.5	0.4	2.7	1.1	-1.6
13	Дархан-Уул	1.5	1.7	1.6	4.2	6.7	2.5
14	Дорноговь	0.6	0.8	0.7	2.9	2.0	-0.9
15	Дундговь	0.9	1.3	1.1	2.8	3.1	0.3
16	Өмнөговь	0.7	1.0	0.9	2.7	2.4	-0.3
17	Сэлэнгэ	0.7	0.9	0.9	3.7	3.3	-0.4

18	Төв	1.2	2.0	1.6	4.4	7.0	2.6
19	Дорнод	1.2	1.7	1.4	3.8	5.3	1.5
20	Хэнтий	1.2	1.8	1.5	2.6	3.9	1.3
21	Сүхбаатар	0.9	1.1	1.0	2.9	2.9	0.0
	Дүн	21.4	31.1	26.5	69.3	89.3	20.0

Хүснэгт 4.26. Аймгийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд шаардлагатай шүүгчийн тоо

Хүснэгтийн эхний аймаг дээр тайлбар өгье. Хувьсагчдын нөхцөлийн доод хилийн утгын **Баян-Өлгий-1.0** нь сүүлийн 5 жилийн өгөгдлийн хувьд Баян-Өлгий аймгийн иргэний хэргийн шүүгч хамгийн бага ачаалалтай жилд 1.0 хүний ажлыг хийсэн гэсэн утгыг илтгэж байна.

Хувьсагчдын нөхцөлийн дээд хилийн утгын **Баян-Өлгий-1.5** нь сүүлийн 5 жилийн өгөгдлийн хувьд **Баян-Өлгий** аймгийн иргэний хэргийн шүүгч хамгийн их ачаалалтай жилд 1.5 хүний ажлыг хийсэн гэсэн утгыг илтгэж байна.

Шийдийн **Баян-Өлгий-1.2** нь нэг шүүгч 5 жилийн дунджаар ойролцоогоор $1.2-1.0=0.2$ хүний ажлыг илүү хийсэн гэсэн утгыг илтгэж байна.

Ажиллаж буй шүүгчийн тооны **Баян-Өлгий-4** нь энэ аймагт 5 жилийн дунджаар 4 шүүгч ойролцоогоор ажилласан гэсэн утгыг илтгэж байна.

Ажиллавал зохих шүүгчийн тооны **Баян-Өлгий-4.8** нь энэ аймагт 5 шүүгч ажиллавал зохистой байжээ гэсэн утгыг илтгэж байна.

Зөрүүний **Баян-Өлгий-0.8** нь энэ аймгийн иргэний хэргийн шүүхэд 1 шүүгч нэмж ажиллуулах шаардлагатай гэсэн утгыг илтгэж байна.

Дүн гэсэн мөрийн мэдээллийг тайлбарлая. Хувьсагчдын нөхцөлийн доод хилийн утгын **21.4** нь сүүлийн 5 жилийн хувьд АИХАШШ-н 21 шүүгч хамгийн бага ачаалалтай жилд 21.4 хүний ажлыг хийсэн гэсэн утгыг илтгэж байна.

Хувьсагчдын нөхцөлийн дээд хилийн утгын **31.1** нь сүүлийн 5 жилийн хувьд АИХАШШ-н 21 шүүгч хамгийн их ачаалалтай жилд 31 хүний ажлыг хийсэн гэсэн утгыг илтгэж байна.

Шийдийн **26.5** нь сүүлийн 5 жилийн хувьд АИХАШШ-н 21 шүүгч дунджаар 25-26 хүний ажлыг хийж иржээ гэсэн утгыг илтгэж байна.

Ажиллаж буй шүүгчийн тооны **69.3** нь АИХАШШ-н шүүхэд 69.3 шүүгч ажилласан гэсэн утгыг илтгэж байна.

Ажиллавал зохих шүүгчийн тооны **89.3** нь АИХАШШ-н шүүхэд 89 шүүгч ажиллавал зохистой байсан байна гэсэн утгыг илтгэж байна.

Зөрүүний **20** нь АИХАШШ-н шүүхэд **20** шүүгч нэмж ажиллуулах шаардлагатай гэсэн утгыг илтгэж байна.

4.2.1.3. Сум дундын шүүх

Сум дундын шүүхэд эрүү, зөрчил, иргэний хэрэг дээр нэг шүүгч ажилладаг онцлогтой тул шүүгчийн ачааллын коэффициент, шаардлагатай шүүгчийн тоог тодорхойлох оновчлолын бодлогын нөхцөлийг тодорхойлохдоо нэг шүүгчийн хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг дээр хянан шийдвэрлэсэн зөрчлийн хэргийн тоог 10.2-д хувааж, хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн тоог 2.4-д хувааж бүгдийг нь нэмж, ачааллыг эрүүгийн хэргийн тоонд шилжүүлсэн дүнгээр оруулсан. 2-р бүлгийн судалгааны үр дүн (Хүснэгт 2.43)-г баримтлан шүүгчийн хянан шийдвэрлэвэл зохих эрүүгийн хэргийн тооны дээд, доод хилийн утгыг тооцсон. Нэг шүүгчийн хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн улсын дундаж 89 бол өндөр тоо гэсэн саналыг ШЕЗ-н гишүүд өгч байсан тул бодлогын дээд хилийн утгыг 85-ээс хэтрэхгүй байхаар сонгосон. Судалгааны өгөгдлийн утга –5 интервалд байх доод хилийн утгыг тооцоход 95 хувийн магадлалтайгаар интервалын утга 75 гарсан

тул бодлогын нөхцөл [75; 85] завсарт тавигдаж бодлогын шийд болох дараах үр дүнг өгөв.

№	Аймаг	Хувьсагчдын нөхцөл		Шийд	Ажиллаж буй шүүгчийн тоо	Ажиллавал зохих шүүгчийн тоо	Зөрүү
		Доод хил	Дээд хил				
		A	B				
1	Тосонцэнгэл	0.6	1.2	0.9	3.0	2.7	-0.3
2	Ховд-Булган	0.7	1.2	0.9	2.9	2.6	-0.3
3	Хархорин	0.9	1.8	1.3	3.1	4.0	0.9
4	Замын-үүд	0.8	1.0	0.9	4.0	3.6	-0.4
5	Ханбогд	0.7	0.9	0.8	3.4	2.7	-0.7
6	Сайхан	0.6	0.7	0.6	3.6	2.2	-1.4
7	Мандал	1.2	1.5	1.3	3.6	4.7	1.1
8	Бор-өндөр	0.6	0.7	0.6	2.8	1.7	-1.1
	Дүн	6.1	9.0	7.3	26.4	24.2	-2.2

Хүснэгт 4.27. Сум дундын шүүхэд шаардлагатай шүүгчийн тоо

Хүснэгтийн эхний сум дундын шүүх дээр тайлбар өгье. Хувьсагчдын нөхцөлийн доод хилийн утгын **Тосонцэнгэл-0.6** нь сүүлийн 5 жилийн өгөгдлийн хувьд Тосонцэнгэл сумын шүүхийн шүүгч хамгийн бага ачаалалтай жилд 0.6-1.0=-0.6 хүний ажлыг дутуу хийсэн гэсэн утгыг илтгэж байна.

Хувьсагчдын нөхцөлийн дээд хилийн утгын **Тосонцэнгэл-1.2** нь сүүлийн 5 жилийн өгөгдлийн хувьд Тосонцэнгэл сумын шүүхийн шүүгч хамгийн их ачаалалтай жилд 1.2-1.0=0.2 хүний ажлыг илүү хийсэн гэсэн утгыг илтгэж байна.

Шийдийн **Тосонцэнгэл-0.9** нь нэг шүүгч 5 жилийн дунджаар ойролцоогоор 0.9-1.0=-0.1 хүний ажлыг дутуу хийсэн гэсэн утгыг илтгэж байна.

Ажиллаж буй шүүгчийн тооны **Тосонцэнгэл-3.0** нь энэ сумын шүүхэд 5 жилийн дунджаар 3 шүүгч ойролцоогоор ажилласан гэсэн утгыг илтгэж байна.

Ажиллавал зохих шүүгчийн тооны **Тосонцэнгэл-2.7** нь энэ шүүхэд 2.7 шүүгч ажиллавал зохистой байжээ гэсэн утгыг илтгэж байна.

Зөрүүний **Тосонцэнгэл--0.3** нь энэ сумын шүүхээс 0.3 шүүгч татаж өөр шүүхэд ажиллуулах шаардлагатай гэсэн утгыг илтгэж байна. 0.3 бага тоо тул энэ хэвээр байлгаж болох юм.

Дүн гэсэн мөрийн мэдээллийг тайлбарлая. Хувьсагчдын нөхцөлийн доод хилийн утгын **6.1** нь сүүлийн 5 жилийн хувьд сум дундын шүүхийн 8 шүүгч хамгийн бага ачаалалтай жилд 6.1 хүний ажлыг хийсэн гэсэн утгыг илтгэж байна.

Хувьсагчдын нөхцөлийн дээд хилийн утгын **9.0** нь сүүлийн 5 жилийн хувьд сум дундын шүүхийн 8 шүүгч хамгийн их ачаалалтай жилд 9 хүний ажлыг хийсэн гэсэн утгыг илтгэж байна.

Шийдийн **7.3** нь сүүлийн 5 жилийн хувьд сум дундын шүүхийн 8 шүүгч дунджаар 7.3 хүний ажлыг хийж иржээ гэсэн утгыг илтгэж байна.

Ажиллаж буй шүүгчийн тооны **26.4** нь сум дундын шүүхэд 26 шүүгч ажилласан гэсэн утгыг илтгэж байна.

Ажиллавал зохих шүүгчийн тооны **24.2** нь сум дундын шүүхэд 24 шүүгч ажиллавал зохистой байсан байна гэсэн утгыг илтгэж байна.

Зөрүүний **-2.2** нь сум дундын шүүхээс **2** шүүгчийг татаж өөр шүүхэд ажиллуулах шаардлагатай гэсэн утгыг илтгэж байна.

4.2.2. Бүлгийн ерөнхий дүгнэлт

Ажиллавал зохих шүүгчийн тооны 2-р хувилбарын тооцоо дүүрэг, аймаг, сум дундын ЭХАШШ, ИХАШШ-үүд дээр хийгдсэн. Бусад шүүхүүд дээр анхны барьсан коэффициент өөрчлөгдөхгүй тул үр дүн мөн адил өөрчлөгдөхгүй. Иймд ижилд тооцоог дахин давтаж оруулахгүйгээр нэгдсэн үр дүнг шууд бичье.

- Улсын хэмжээнд АШШ-н хувьд

Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй эрүү, иргэн, захиргааны хэргийн анхан шатны шүүхэд 373 шүүгч (5 жилийн дунджаар) ажиллаж байна гэсэн тооцоо гарсан байна. Эдгээр анхан шатны шүүхэд ажиллавал зохих 446 шүүгч байна гэсэн тооцоо гарсан. Хүснэгт 4.28-д өөр шүүх рүү шилжүүлэх шаардлагатай шүүгчийн тоог – тэмдгээр, нэмж шүүгч өгөх шаардлагатай шүүгчийн тоог + тэмдэгтэй оруулав.

№	Шүүх		Ажиллаж буй	Ажиллавал	Дутагдалтай ба
			шүүгчийн тоо	зохих шүүгчийн тоо	илүүдэлтэй орон тоо
1	Эрүүгийн хэрэг	Төвийн дүүрэг	44	76	32
		Захын дүүрэг	7	4	-3
		Аймаг	64	71	7
		Сум дунд	26	24	-2
2	Зөрчлийн хэрэг	Төвийн дүүрэг	6	10	4
3	Иргэний хэрэг	Төвийн дүүрэг	77	118	41
		Захын дүүрэг	7	5	-2
		Аймаг	69	89	20
4	Захиргааны хэрэг	Нийслэл	19	28	9
		Аймаг	54	21	-33
Дүн			373	446	73

Хүснэгт 4.28. Улсын хэмжээнд анхан шатны шүүхэд шүүхэд шаардлагатай шүүгчийн тоо

Хүснэгт 4.28-гаас харвал улсын хэмжээнд анхан шатны шүүхэд 73 шүүгч шаардлагатай байгаа бөгөөд дэлгэрэнгүй задаргааг хүснэгтээс харна уу.

- Улсын хэмжээнд ДЗАШШ-н хувьд

Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй эрүү, иргэн, захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд 108 шүүгч (5 жилийн дунджаар) ажиллаж байна гэсэн тооцоо гарсан байна. Эдгээр давж заалдах шатны шүүхэд ажиллавал зохих 121 шүүгч байна гэсэн тооцоо гарсан. Хүснэгт В-д өөр шүүх рүү шилжүүлэх шаардлагатай шүүгчийн тоог – тэмдгээр, нэмж шүүгч өгөх шаардлагатай шүүгчийн тоог + тэмдэгтэй оруулав.

№	Шүүх		Ажиллаж буй	Ажиллавал	Дутагдалтай ба
			шүүгчийн тоо	зохих шүүгчийн тоо	илүүдэлтэй орон тоо
1	Эрүүгийн хэрэг	Нийслэл	15	30	15
		Аймаг	55	32	-23
		Орхон, Дархан-Уул	6	5	-1
2	Иргэний хэрэг	Нийслэл	14	23	9
		Орхон, Дархан-Уул	6	3	-3
3	Захиргааны хэрэг	Улс	12	28	16
Дүн			108	121	13

Хүснэгт 4.29. Улсын хэмжээнд давж заалдах шатны шүүхэд шаардлагатай шүүгчийн тоо

Хүснэгт 4.29-с харвал улсын хэмжээнд давж заалдах шатны шүүхэд 13 шүүгч шаардлагатай байгаа бөгөөд дэлгэрэнгүй задаргааг хүснэгтээс харна уу.

- Улсын хэмжээнд шүүхийн хувьд

Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй эрүү, иргэн, захиргааны хэргийн анхан, давж заалдах шатны шүүхэд 482 шүүгч (5 жилийн дунджаар) ажиллаж байна гэсэн тооцоо гарсан байна. Эдгээр анхан ба давж заалдах шатны шүүхэд ажиллавал зохих 570 шүүгч байна гэсэн тооцоо гарсан. Хүснэгт 4.30-д өөр шүүх рүү шилжүүлэх шаардлагатай шүүгчийн тоог – тэмдгээр, нэмж шүүгч өгөх шаардлагатай шүүгчийн тоог + тэмдэгтэй оруулав.

№	Шүүх шат	Хэргийн шүүх	Ажиллаж буй шүүгчийн тоо	Ажиллавал зохих шүүгчийн тоо	Дутагдалтай ба илүүдэлтэй орон тоо
1	Анхан шат	Эрүү	141	175	34
		Зөрчил	6	10	4
		Иргэн	154	212	58
		Захиргаа	73	49	-24
2	Давж заалдах шат	Эрүү	76	67	-9
		Иргэн	20	29	9
		Захиргаа	12	28	16
Дүн			482	570	88

Хүснэгт 4.30. Улсын хэмжээнд шат шатны шүүхэд шаардлагатай шүүгчийн тоо

Хүснэгт 4.30-с харвал улсын хэмжээнд анхан ба давж заалдах шатны шүүхэд нийт 88 шүүгч шаардлагатай байгаа бөгөөд дэлгэрэнгүй задаргааг хүснэгтээс харна уу.

Санамж: Хүснэгтийн утгуудын бутархай орны тооцоог хасч хийсэн тул аравтын орны нарийвчлалаар зарим нэг нүдний тооцоо 1-ээс их, бага гарах явдал гарч магадгүй.



ТАВДУГААР БҮЛЭГ. ШАЛГУУР 11-Д ХАМААРАХ ӨГӨГДӨЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

ШАЛГУУР 11. Шүүн таслах ажиллагааны тодорхой төрлөөр шийдвэрлэсэн хэргийн тоо


- Эрүүгийн хэрэг (Хөнгөн гэмт хэрэг)
- Зөрчлийн хэрэг (Хянан шийдвэрлэсэн хэргийн тоо)
- Иргэний хэрэг (Бага үнийн дүнтэй нэхэмжлэлийн тоо)

5.1. ХӨНГӨН ГЭМТ ХЭРГИЙН ӨГӨГДӨЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

5.1.1. Дүүргийн шүүх

Нийслэлийн 9 дүүргийн хэмжээгээр эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн хэргийн дотроос эрүүгийн хөнгөн гэмт хэргийн тооны статистик үзүүлэлтүүдийг тодорхойлон шүүгчийн ачаалалыг тооцсон.


Нийслэлийн дүүргүүдийн 2018-2021 оны эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн хэргийн тоонд хөнгөн гэмт хэргийн эзлэх хувийн жин дунджаар 16.7 хувь байна.



Зураг 5.1. Сүүлийн 4 жилийн хугацаанд дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоонд эрүүгийн хөнгөн гэмт хэргийн эзлэх хувийн жин

Баянзүрх дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн хэргийн тоонд хөнгөн гэмт хэргийн эзлэх хувь 46% буюу хамгийн өндөр байна. Налайх дүүргийн хөнгөн гэмт хэргийн эзлэх хувь 3% буюу хамгийн бага хувийг эзэлж байна.

Дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн нэг шүүгч жилд дунджаар 84 хөнгөн гэмт хэрэг шийдвэрлэсэн байхад энэ нь дүүрэг бүрд харилцан адилгүй байна. Шийдвэрлэсэн хэргийн тооноос тооцсон хөнгөн гэмт хэргийн голч утга нь **100** байна.



Зураг 5.2. Дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны нэг шүүгч жилд дунджаар шийдвэрлэсэн хөнгөн гэмт хэргийн тооны дундаж утга ба голч утга

Хан-Уул, Налайх, Багануур, Багахангай дүүргийн анхан шатны шүүхийн шүүгчийн шийдвэрлэсэн эрүүгийн хөнгөн гэмт хэргийн тоо дунджаас бага байгаа бол Баянзүрх дүүргийн шүүхийн шүүгчийн шийдвэрлэсэн хөнгөн гэмт хэргийн тооны голч утгаас 1.39 дахин их байна.

Дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд хөнгөн гэмт хэргийг шийдвэрлэдэг шүүгчийн голч ачааллыг 1 гэж үзвэл дараах байдлаар илэрхийлэгдэж байна.

Дүүрэг	Нэг шүүгчид ногдох ачааллын харьцаа	Эрүүгийн хөнгөн гэмт хэргийг шийдвэрлэх шүүгчийн ачаалал*
Багахангай	0.12	↓
Налайх	0.34	↓
Багануур	0.52	↘
Сүхбаатар	0.93	↘
Баянгол	1	↔
Чингэлтэй	1.03	↔
Хан-Уул	1.08	↔
Сонгинохайрхан	1.13	↔
Баянзүрх	1.39	↗

Хүснэгт 5.1. 2018-2021 оны өгөгдлийн шинжилгээнд хийсэн дүгнэлт

Тэмдэглэгээ: ↓-буурах, ↘ -аажим буурах, ↔ -тогтвортой, ↗ -аажим өсөх, ↑ - өсөх

Дүүрэг тус бүрийн хөнгөн гэмт хэргийн тоо дараагийн хоёр жилд хэд болох төлөвтэй байгааг дараах хүснэгтэд харуулав.


Дүүрэг	2022	2023	Тайлбар
Баянзүрх	1174	1135	Шүүгч маш их ачаалалтай.
Чингэлтэй	661	651	Шүүгчийн ачаалалд их нөлөөтэй.
Сүхбаатар	820	826	Шүүгч маш их ачаалалтай.
Баянгол	698	663	Шүүгчийн ачаалалд их нөлөөтэй.
Хан-Уул	649	680	Шүүгчийн ачаалалд их нөлөөтэй.
Сонгинохайрхан	1099	1163	Шүүгч маш их ачаалалтай.
Багануур	75	65	Шүүгчийн ачаалалд нөлөө багатай.
Налайх	25	20	Шүүгчийн ачаалалд нөлөө багатай.
Багахангай	44	116	Шүүгчийн ачаалалд нөлөө багатай.

Хүснэгт 5.2. Дараагийн жилүүдийн эрүүгийн хөнгөн гэмт хэргийн тоонд хийсэн прогноз

Чингэлтэй дүүргийн хувьд сүүлийн 4 жилийн дунджаар тооцож үзэхэд хөнгөн гэмт хэргийн тоо буурах хандлагатай байна. Багахангай дүүрэгт хөнгөн хэргийн өсөлтийн хурд хамгийн их байна.

5.1.2. Аймаг, сум дундын шүүх


Аймаг дахь эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018-2021 оны нийт эрүүгийн хэргийн 83 хувийг хөнгөн гэмт хэрэг эзэлж байна.



Зураг 5.3. Аймаг, сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн хөнгөн гэмт хэргийн эзлэх хувийн жин

Эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрлэсэн хөнгөн гэмт хэргийн нийт эрүүгийн хэрэгт эзлэх хувийн жин Говь-Алтай, Дорноговь аймгуудад хамгийн бага буюу 77 хувийг эзэлж байгаа бол Ховдын Булганд 90 хувийг буюу хамгийн их хувийг эзэлж байна.

Аймаг, сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны нэг шүүгч жилд дунджаар 55 эрүүгийн хөнгөн хэрэг ногдож байхад энэ нь аймаг бүрд харилцан адилгүй байна. Шийдвэрлэсэн эрүүгийн гэмт хэргийн тооны голч утга нь **51** байна.



Зураг 5.4. Аймаг дахь эрүүгийн хэргийн анхан шатны нэг шүүгч жилд дунджаар шийдвэрлэсэн хөнгөн гэмт хэргийн тооны дундаж утга ба голч утга

Аймаг, сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн нэг шүүгчийн шийдвэрлэсэн хөнгөн гэмт хэргийн тооны графикаас харахад Дорнод аймгийн нэг шүүгч жилд 121 хэрэг шийдвэрлэж байхад Тосонцэнгэл, Мандалын нэг шүүгч жилд 17 хэрэг шийдвэрлэдэг байна.

Аймаг, сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн нэг шүүгчийн шийдвэрлэсэн хөнгөн хэргийн тооны графикаас харахад Дорнод аймгийн нэг шүүгч жилд 121 хэрэг шийдвэрлэж байхад Тосонцэнгэл, Мандалын нэг шүүгч жилд 17 хэрэг шийдвэрлэдэг байна.

Аймаг, сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд шийдвэрлэсэн хөнгөн гэмт хэргийн нэг шүүгчид ногдох дундаж ачааллыг 1 гэж үзвэл дараах байдлаар илэрхийлэгдэж байна.

Аймаг, сум	Нэг шүүгчид ногдох ачааллын харьцаа	Эрүүгийн хөнгөн хэргийг шийдвэрлэх шүүгчийн ачаалал*
Мандал	0.33	↓
Тосонцэнгэл	0.33	↓
Бор-Өндөр	0.39	↓
Ховд-Булган	0.44	↓
Замын-Үүд	0.46	↓
Хархорин	0.55	↓
Говь-Алтай	0.62	↘
Говьсүмбэр	0.62	↘
Сайхан	0.69	↘
Ханбогд	0.70	↘
Завхан	0.70	↘
Дундговь	0.78	↘
Өмнөговь	0.90	↔
Дорноговь	1.00	↔
Баян-Өлгий	1.00	↔
Увс	1.20	↔
Өвөрхангай	1.30	↗
Ховд	1.31	↗
Сүхбаатар	1.41	↗
Булган	1.44	↗
Орхон	1.49	↑
Сэлэнгэ	1.50	↑
Архангай	1.55	↑
Дархан-Уул	1.61	↑
Төв	1.62	↑
Хөвсгөл	1.70	↑
Хэнтий	1.74	↑
Баянхонгор	1.79	↑
Дорнод	2.37	↑

Хүснэгт 5.3. 2018-2021 оны эрүүгийн хөнгөн хэргийн тоон дээр хийсэн шинжилгээний дүн

Тэмдэглэгээ: ↓-буурах, ↘ -аажим буурах, ↔ -тогтвортой, ↗ -аажим өсөх, ↑ - өсөх

Аймаг, сум дундын шүүхийн хөнгөн гэмт хэргийн тоо дараагийн хоёр жилд хэд болох төлөвтэй байгааг дараах хүснэгтэд харуулав.

Аймаг	2022	2023	Тайлбар
Сайхан	42	37	Шүүгчийн ачаалалд нөлөө багатай.
Ховд-Булган	45	44	Шүүгчийн ачаалалд нөлөө багатай.
Бор-Өндөр	51	52	Шүүгчийн ачаалалд нөлөө багатай.
Замын-Үүд	72	67	Шүүгчийн ачаалалд нөлөө багатай.
Говьсүмбэр	77	73	Шүүгчийн ачаалалд нөлөө багатай.
Хархорин	80	82	Шүүгчийн ачаалалд нөлөө багатай.
Мандал	93	84	Шүүгчийн ачаалалд нөлөө багатай.
Өмнөговь	110	100	Шүүгчийн ачаалалд нөлөө багатай.
Баян-Өлгий	112	108	Шүүгчийн ачаалалд нөлөө багатай.
Ханбогд	118	114	Шүүгчийн ачаалалд нөлөө багатай.
Тосонцэнгэл	92	117	Шүүгчийн ачаалалд нөлөө багатай.
Говь-Алтай	113	123	Шүүгчийн ачаалалд нөлөө багатай.
Сэлэнгэ	139	126	Шүүгчийн ачаалалд нөлөө багатай.
Өвөрхангай	140	129	Шүүгчийн ачаалалд нөлөө багатай.
Увс	142	138	Шүүгчийн ачаалалд нөлөө багатай.

Дундговь	140	154	Шүүгчийн ачаалалд нөлөөтэй.
Сүхбаатар	162	155	Шүүгчийн ачаалалд нөлөөтэй.
Дорноговь	154	172	Шүүгчийн ачаалалд нөлөөтэй.
Ховд	173	179	Шүүгчийн ачаалалд нөлөөтэй.
Завхан	173	218	Шүүгчийн ачаалалд нөлөөтэй.
Хэнтий	226	239	Шүүгчийн ачаалалд нөлөөтэй.
Булган	233	251	Шүүгчийн ачаалалд нөлөөтэй.
Дархан-Уул	272	253	Шүүгчийн ачаалалд нөлөөтэй.
Хөвсгөл	263	260	Шүүгчийн ачаалалд нөлөөтэй.
Орхон	271	261	Шүүгчийн ачаалалд нөлөөтэй.
Баянхонгор	269	276	Шүүгч маш их ачаалалтай.
Архангай	260	279	Шүүгч маш их ачаалалтай.
Дорнод	341	355	Шүүгч маш их ачаалалтай.
Төв	449	488	Шүүгч маш их ачаалалтай.

Зураг 5.5. Дараагийн жилүүдийн хөнгөн гэмт хэргийн тоонд хийсэн прогност

Аймаг, сум дундын шүүхийн шүүгчийн ачаалал хөнгөн хэргийн хувьд харьцангуй жигд байна. Төв болон Дорнод аймагт эрүүгийн хөнгөн хэргийг шийдвэрлэсэн тоо хамгийн өндөр байх төлөвтэй байна.

Явцын дүгнэлт:


Хөнгөн гэмт хэргийн дундаж дүүрэгт 100, аймаг, сум дундад, 51, улсын хэмжээнд 75.5 хэрэг байна. Дүүргийн хэмжээнд Баянгол, Чингэлтэй, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргүүдэд дүүгийн дундаж болох 100 хэргээр харьцаа үүсгэвэл эдгээр дүүрэгт тус бүр 1 гэсэн дүнтэй байна.

Харин аймаг, сум дундын шүүхийн хэмжээнд дундаж болох 51, түүнээс дээш дүнтэй хөнгөн гэмт хэрэг шийдвэрлэсэн олон аймаг байна. Эдгээрийн хувьд тухайн шүүхийн шүүгчийн хянан шийдвэрлэж буй нийт хэргийн бодит ачааллын дундаж хэмжээг харгалзан хөнгөн гэмт хэргийн хувьд шүүхийг байгуулах, өөрчлөх, байршлыг тогтоох асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй байна. Харин Дорнод аймгийн хувьд хөнгөн гэмт хэргийн дүн дүүргийн дундажтай ижил түвшинд байгааг анхаарах шаардлагатай байна.

5.2. ЗӨРЧЛИЙН ХЭРГИЙН ӨГӨГДӨЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

5.2.1. Дүүргийн шүүх

Дүүргүүдийн 2018-2021 оны эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс шийдвэрлэсэн хэргийн тоонд зөрчлийн хэргийн эзлэх хувийн жин дунджаар 54.1 хувь байна.




Зураг 5.6. Сүүлийн 4 жилийн хугацаанд дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн хэргийн тоонд зөрчлийн хэргийн эзлэх хувийн жин

Багануур болон Багахангай дүүрэгт эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрлэгдсэн хэргийн тоонд зөрчлийн хэргийн эзлэх хувь хамгийн өндөр буюу тус тус 65% ба 62% байгаа бол Налайх, Сүхбаатар дүүрэгт хамгийн бага буюу 42% ба 44%-г эзэлж байна.

Дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн нэг шүүгч жилд дунджаар 891 зөрчлийн хэрэг шийдвэрлэсэн байхад энэ нь дүүрэг бүрд харилцан адилгүй байна. Шийдвэрлэсэн хэргийн тооноос тооцсон зөрчлийн хэргийн голч утга нь мөн адил **891** байна.

Дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны **нэг шүүгч** жилд дунджаар шийдвэрлэсэн зөрчлийн хэргийн тооны дундаж утга



Зураг 5.7. ДЭХАШШ-н 2018-2021 онд шийдвэрлэсэн зөрчлийн хэрэг дундаж

Сүхбаатар, Налайх, Багануур, Багахангай дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн шийдвэрлэсэн зөрчлийн хэргийн тоо дунджаас бага байгаа бол Баянзүрх дүүргийн шүүгчийн шийдвэрлэсэн зөрчлийн хэргийн тоо дундаж утгаас 2.8 дахин их байна.

Дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд зөрчлийн хэргийг шийдвэрлэдэг шүүгчийн дундаж ачааллыг 1 гэж үзвэл дараах байдлаар илэрхийлэгдэж байна.

Дүүрэг	Нэг шүүгчид ногдох ачааллын харьцаа	Зөрчлийн хэргийг шийдвэрлэх шүүгчийн ачаалал*
Багахангай	0.02	↓
Налайх	0.06	↓
Багануур	0.08	↔
Сүхбаатар	0.89	↔
Баянгол	1.11	/
Чингэлтэй	1.12	/
Хан-Уул	1.33	↑
Сонгинохайрхан	1.60	↑
Баянзүрх	2.78	↑

Хүснэгт 5.4. 2018-2021 оны өгөгдлийн шинжилгээнд хийсэн дүгнэлт

Тэмдэглэгээ: ↓-буурах, ↘ -аажим буурах, ↔ -тогтвортой, / -аажим өсөх, ↑ -өсөх

Дүүрэг тус бүрийн зөрчлийн хэргийн тоо дараагийн хоёр жилд хэд болох төлөвтэй байгааг дараах хүснэгтэд харуулав.

Дүүрэг	2022	2023	Тайлбар*
Багахангай	133	333	Шүүгчийн ачаалалд нөлөө багатай.
Налайх	343	548	Шүүгчийн ачаалалд нөлөө багатай.

Багануур	272	299	Шүүгчийн ачаалалд нөлөө багатай.
Сүхбаатар	1015	1313	Шүүгч ачаалалтай.
Баянгол	2055	3160	Шүүгч маш их ачаалалтай.
Чингэлтэй	1375	1842	Шүүгч маш их ачаалалтай.
Хан-Уул	1758	2239	Шүүгч маш их ачаалалтай.
Сонгинохайрхан	2737	3967	Шүүгч маш их ачаалалтай.
Баянзүрх	3207	3736	Шүүгч маш их ачаалалтай.

Хүснэгт 5.5. Дараагийн жилүүдийн зөрчлийн хэргийн тоонд хийсэн прогнозын дүгнэлт

Дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн зөрчлийн хэргийн дундаж тоог шүүгчийн хэргийн ачаалал тооцсон 2-р бүлгийн үр дүн (1 эрүүгийн хэрэг=10.2 зөрчлийн хэрэг)-с ашиглан эрүүгийн хэрэг рүү шилжүүлбэл:

Дүүрэг	2021 он	
	Зөрчлийн хэргийн тоо	Эрүүгийн хэрэгт шилжүүлсэнээр*
Баянзүрх	2753	270
Чингэлтэй	1027	101
Сүхбаатар	784	77
Баянгол	1336	131
Хан-Уул	1381	135
Сонгинохайрхан	1889	185
Багануур	248	24
Налайх	215	21
Багахангай	53	5


Хүснэгт 5.6. Үндсэн шинжилгээний үр дүнг ашиглан зөрчлийн хэргийн тоог эрүүгийн хэрэгт шилжүүлсэн тооцоо

Хүн амын тоо олонтой Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчид 2021 онд 270 эрүүгийн хэрэгтэй тэнцэх хэмжээний зөрчлийн хэргийг шийдвэрлэжээ. Налайх, Багахангай дүүрэгт 2021 онд нийт 26 эрүүгийн хэрэгтэй тэнцэх хэмжээний зөрчлийн хэргийг шийдвэрлэсэн байна.

5.2.2. Аймаг, сум дундын шүүх

Аймаг дахь эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018-2021 онд шийдвэрлэсэн нийт хэргийн 63.4 хувь нь зөрчлийн хэрэг байна.

Аймгийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд зөрчлийн хэргийн эзлэх хувийн жин:




Зураг 5.8. Сүүлийн 4 жилийн хугацаанд аймаг, сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн хэргийн тоонд зөрчлийн хэргийн эзлэх хувийн жин

Аймаг болон сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн хэргийн тоонд зөрчлийн хэргийн эзлэх хувь Баянхонгор, Өвөрхангай аймгуудад хамгийн өндөр 83% ба 82% байгаа бол хамгийн бага нь Дархан-Уул, Сэлэнгэ аймгуудад тус тус 46% ба 47%-г эзэлж байна.

Аймаг, сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн нэг шүүгчид жилд дунджаар 113 зөрчлийн хэрэг ногдож байхад энэ нь аймаг бүрд харилцан адилгүй байна. Шийдвэрлэсэн хэргийн тооноос тооцсон голч утга нь **88** байна.

Аймаг болон бус дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн нэг шүүгчид ногдох шийдвэрлэсэн хэргийн тоог дундаж утгаар нь зурагт харуулбал:



Зураг 5.9. Аймаг, сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018-2021 онд шийдвэрлэсэн зөрчлийн хэрэг дундаж

Өвөрхангай аймгийн эрүүгийн хэргийн шүүх дундаж утгаас 3.3 дахин их зөрчлийн хэрэг шийдвэрлэсэн бол Сэлэнгэ аймгийн Сайхан сумын сум дундын шүүх хамгийн бага хэрэг шийдвэрлэжээ. Аймаг, сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд зөрчлийн хэрэг шийдвэрлэсэн шүүгчийн дундаж ачааллыг 1 гэж үзвэл харьцаа дараах байдлаар илэрхийлэгдэж байна.

Аймаг, сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд зөрчлийн хэрэг шийдвэрлэсэн шүүгчийн дундаж ачааллыг 1 гэж үзвэл дараах байдлаар илэрхийлэгдэж байна.

Аймаг, сум	Нэг шүүгчид ногдох ачааллын харьцаа	Зөрчлийн хэргийг шийдвэрлэх шүүгчийн ачаалал*
Сайхан	0.23	↓
Ханбогд	0.33	↓
Замын-Үүд	0.34	↓
Бор-Өндөр	0.37	↓
Говьсүмбэр	0.51	↓
Дундговь	0.51	↓
Тосонцэнгэл	0.52	↓
Ховд-Булган	0.53	↓

Мандал	0.59	↘
Өмнөговь	0.61	↘
Завхан	0.63	↘
Дорноговь	0.67	↘
Дархан-Уул	0.69	↘
Говь-Алтай	0.69	↘
Сэлэнгэ	0.70	↘
Сүхбаатар	0.85	↘
Баян-Өлгий	0.96	↔
Хархорин	1.20	↔
Увс	1.22	↔
Төв	1.24	↔
Архангай	1.26	↘
Ховд	1.26	↘
Хөвсгөл	1.26	↘
Булган	1.34	↘
Дорнод	1.43	↘
Баянхонгор	1.64	↑
Хэнтий	1.98	↑
Орхон	2.26	↑
Өвөрхангай	3.31	↑

Хүснэгт 5.7. 2018-2021 оны зөрчлийн хэргийн тоон дээр хийсэн шинжилгээний дүн

Тэмдэглэгээ: ↓-буурах, ↘ -аажим буурах, ↔ -тогтвортой, ↙ -аажим өсөх, ↑ -өсөх

Аймаг, сум дундын шүүхийн шийдвэрлэх зөрчлийн хэргийн тоо дараагийн хоёр жилд хэд болох төлөвтэй байгааг дараах хүснэгтэд харуулав.

Аймаг	2022	2023	Тайлбар
Замын-Үүд	100	87	Шүүгчийн ачаалалд нөлөө багатай.
Бор-Өндөр	152	168	Шүүгчийн ачаалалд нөлөө багатай.
Сайхан	168	220	Шүүгчийн ачаалалд нөлөө багатай.
Дундговь	219	243	Шүүгчийн ачаалалд нөлөө багатай.
Сэлэнгэ	240	269	Шүүгчийн ачаалалд нөлөө багатай.
Ханбогд	265	334	Шүүгчийн ачаалалд нөлөө багатай.
Мандал	272	282	Шүүгчийн ачаалалд нөлөө багатай.
Ховд-Булган	273	364	Шүүгчийн ачаалалд нөлөө багатай.
Дорноговь	295	339	Шүүгчийн ачаалалд нөлөө багатай.
Завхан	298	354	Шүүгчийн ачаалалд нөлөөтэй.
Тосонцэнгэл	324	457	Шүүгчийн ачаалалд нөлөөтэй.
Өмнөговь	334	397	Шүүгчийн ачаалалд нөлөөтэй.
Говьсүмбэр	340	456	Шүүгчийн ачаалалд нөлөөтэй.
Ховд	350	372	Шүүгчийн ачаалалд нөлөөтэй.
Хэнтий	409	386	Шүүгчийн ачаалалд нөлөөтэй.
Сүхбаатар	413	529	Шүүгчийн ачаалалд нөлөөтэй.
Говь-Алтай	448	632	Шүүгчийн ачаалалд нөлөөтэй.
Дорнод	470	516	Шүүгчийн ачаалалд нөлөөтэй.
Дархан-Уул	480	554	Шүүгчийн ачаалалд нөлөөтэй.
Хархорин	505	606	Шүүгчийн ачаалалд нөлөөтэй.
Баян-Өлгий	506	615	Шүүгчийн ачаалалд нөлөөтэй.
Архангай	641	810	Шүүгч маш их ачаалалтай.
Булган	700	916	Шүүгч маш их ачаалалтай.
Увс	747	1006	Шүүгч маш их ачаалалтай.
Баянхонгор	786	880	Шүүгч маш их ачаалалтай.
Төв	798	870	Шүүгч маш их ачаалалтай.

Орхон	889	902	Шүүгч маш их ачаалалтай.
Хөвсгөл	1013	1359	Шүүгч маш их ачаалалтай.
Өвөрхангай	1019	1092	Шүүгч маш их ачаалалтай.

Хүснэгт 5.8. Дараагийн жилүүдийн зөрчлийн хэргийн тоонд хийсэн прогнозын дүгнэлт

Аймаг, сум дундын шүүхийн шийдвэрлэсэн зөрчлийн хэргийн тоог эрүүгийн хэрэгт шилжүүлснээр жилд шийдвэрлэх хэргийн тоог хүснэгтээр харуулбал:

Дүүрэг	Зөрчлийн хэргийн тоо	Эрүүгийн хэрэгт шилжүүлснээр
Баян-Өлгий	416	41
Говь-Алтай	317	31
Завхан	251	25
Тосонцэнгэл	230	23
Увс	554	54
Ховд	329	32
Ховд-Булган	205	20
Архангай	507	50
Баянхонгор	701	69
Булган	535	52
Орхон	877	86
Хөвсгөл	755	74
Өвөрхангай	950	93
Хархорин	420	41
Говьсүмбэр	253	25
Дархан-Уул	416	41
Дорноговь	256	25
Замын-Үүд	115	11
Дундговь	197	19
Өмнөговь	280	27
Ханбогд	211	21
Сэлэнгэ	214	21
Сайхан	263	26
Мандал	129	13
Төв	732	72
Дорнод	429	42
Хэнтий	434	43
Бор-Өндөр	138	14
Сүхбаатар	322	32

Хүснэгт 5.9. Үндсэн бүлгийн тооцооллын үр дүнг ашиглан зөрчлийн хэргийг эрүүгийн хэрэгт шилжүүлсэн тооцоо

Аймаг, сум дахь АШШ-н 2021 оны байдлаар шийдвэрлэсэн зөрчлийн хэргийг коэффициент ашиглан эрүүгийн хэрэгт шилжүүлэхэд жилд шийдвэрлэсэн зөрчлийн хэргийн тоо нийслэлийн төвийн 6 дүүрэгтэй харьцуулахад ачаалал нь харьцангуй бага байна.

Дүгнэлт

Зөрчлийн хэргийн 2 жилийн прогноз болон дундаж ачаалал тооцсон шинжилгээний үр дүнгээс ачаалал багатай Багахангай, Налайх, Багануур дүүргүүдийн шүүхийн шийдвэрлэсэн нийт хэргийн тоо төвийн 1 дүүргийн шүүхийн шийдвэрлэсэн хэргийн тооноос бага байна. Хамгийн их ачаалалтай Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн зөрчлийн хэрэг шийдвэрлэж буй шүүгчийн тоонд анхаарал хандуулах шаардлагатай байна.


Аймаг, сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ачаалал Өвөрхангай, Хөвсгөл аймгуудад бусад аймгуудтай харьцуулахад харьцангуй өндөр байгаа боловч нийслэлийн 3 дүүргийн шүүгчдийн ачааллаас бага байна.

5.3. ЗӨРЧЛИЙН ХЭРЭГ, ЭРҮҮГИЙН ХӨНГӨН ГЭМТ ХЭРГИЙН ТООНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН

5.3.1. Дүүргийн шүүх

Дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018-2021 онд шийдвэрлэсэн хэргийн 92 хувийг хөнгөн гэмт хэрэг болон зөрчлийн хэрэг эзэлж байна.

Дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн эрүүгийн хөнгөн хэрэг болон зөрчлийн хэргийн эзлэх хувийн жин




Зураг 5.10. Сүүлийн 4 жилийн хугацаанд дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн хэргийн тоонд зөрчил болон эрүүгийн хөнгөн гэмт хэргийн эзлэх хувийн жин

2018-2021 оны дүүргүүдийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн хэргийн 92 гаруй хувийг зөрчлийн хэрэг болон эрүүгийн хөнгөн гэмт хэрэг эзэлдэг байна.

Дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн нэг шүүгч жилд дунджаар 201 зөрчлийн болон эрүүгийн хөнгөн хэрэг шийдвэрлэсэн байхад энэ нь дүүрэг бүрд харилцан адилгүй байна. Шийдвэрлэсэн хэргийн тооноос тооцсон зөрчил болон эрүүгийн хөнгөн гэмт хэргийн тооны голч утга нь **216** байна.

Дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн **нэг шүүгч** жилд дунджаар шийдвэрлэсэн зөрчил болон эрүүгийн хөнгөн гэмт хэргийн тоо



Зураг 5.11. Дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018-2021 онд шийдвэрлэсэн зөрчил болон эрүүгийн хөнгөн гэмт хэрэг дундаж

Зөрчил болон эрүүгийн хөнгөн хэргийн нэг шүүгчид ногдох ачаалал харилцан адилгүй байна. Баянзүрх дүүргийн шүүгчийн ачаалал голч утгаас 1.7 дахин их байна. Дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд зөрчил болон эрүүгийн хөнгөн хэргийн дундаж ачааллыг 1 гэж үзвэл харьцаа дараах байдлаар илэрхийлэгдэж байна.

Дүүрэг	Нэг шүүгчид ногдох ачааллын харьцаа	Эрүүгийн хөнгөн хэрэг болон зөрчлийн хэрэг шийдвэрлэх шүүгчийн ачаалал*
Багахангай	0.15	↓
Налайх	0.49	↓
Багануур	0.51	↓
Баянгол	0.98	↔
Сүхбаатар	1.00	↔
Чингэлтэй	1.11	↔
Сонгинохайрхан	1.20	↗
Хан-Уул	1.24	↗
Баянзүрх	1.69	↑

Хүснэгт 5.10. 2018-2021 оны өгөгдлийн шинжилгээнд хийсэн дүгнэлт

Тэмдэглэгээ: ↓-буурах, ↘ -аажим буурах, ↔ -тогтвортой, ↗ -аажим өсөх, ↑ -өсөх

Дүүрэг тус бүрийн зөрчил болон эрүүгийн хөнгөн хэргийн тоо дараагийн хоёр жилд хэд болох төлөвтэй байгааг дараах хүснэгтэд харуулав.


Дүүрэг	2021	2022	2023	Тайлбар
Баянзүрх	4213	4471	4745	Шүүгчийн ачаалалд их нөлөөтэй.
Чингэлтэй	1804	1944	2095	Шүүгчийн ачаалалд нөлөөтэй.
Сүхбаатар	1724	1846	1976	Шүүгчийн ачаалалд нөлөөтэй.
Баянгол	2239	2552	2909	Шүүгчийн ачаалалд нөлөөтэй.
Хан-Уул	2241	2650	3134	Шүүгчийн ачаалалд их нөлөөтэй.
Сонгинохайрхан	3160	3808	4588	Шүүгчийн ачаалалд их нөлөөтэй.
Багануур	347	346	344	Шүүгчийн ачаалалд нөлөө багатай
Налайх	406	465	532	Шүүгчийн ачаалалд нөлөө багатай
Багахангай	70	159	360	Шүүгчийн ачаалалд нөлөө багатай

Хүснэгт 5.11. Дараагийн жилүүдийн зөрчил болон эрүүгийн хөнгөн хэргийн тоонд хийсэн прогноз

Эрүүгийн хөнгөн хэрэг болон зөрчлийн хэргийн тоо Багануураас бусад дүүрэгт нэмэгдэх хандлагатай байна.

5.3.2. Аймаг, сумын шүүх

Аймаг, сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018-2021 онд шийдвэрлэсэн хэргийн 91 хувийг эрүүгийн хөнгөн гэмт хэрэг болон зөрчлийн хэрэг эзэлж байна.




Зураг 5.12. Сүүлийн 4 жилийн хугацаанд аймаг, сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн хэргийн тоонд зөрчил болон эрүүгийн хөнгөн гэмт хэргийн эзлэх хувийн жин

2018-2021 оны дүүргүүдийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн хэргийн 90 орчим хувийг зөрчлийн хэрэг болон эрүүгийн хөнгөн гэмт хэрэг эзэлдэг байна.

Аймаг сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн нэг шүүгч жилд дунджаар 169 зөрчлийн болон эрүүгийн хөнгөн хэрэг шийдвэрлэсэн байхад энэ нь дүүрэг бүрд харилцан адилгүй байна. Шийдвэрлэсэн хэргийн тооноос тооцсон зөрчил болон эрүүгийн хөнгөн гэмт хэргийн тооны голч утга нь 159 байна.

Аймаг, сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн нэг шүүгч жилд дунджаар шийдвэрлэсэн зөрчил болон эрүүгийн хөнгөн гэмт хэргийн тоо



Зураг 5.13. Аймаг, сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018-2021 онд шийдвэрлэсэн зөрчил болон эрүүгийн хөнгөн гэмт хэрэг дундаж

Зөрчил болон эрүүгийн хөнгөн хэргийн нэг шүүгчид ногдох ачаалал харилцан адилгүй байна. Хамгийн их ачаалал өндөртэй Өвөрхaнгай аймгийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн нэг шүүгчид ногдох ачаалал голч утгаас 2.7 дахин их байхад хамгийн бага ачаалалтай Сэлэнгэ аймгийн Сайхан сумын сум дундын шүүхийн шүүгчийн ачаалал голч утгаас 3.9 дахин бага байна.

Аймаг, сумын иргэний хэргийн анхан шатны шүүхэд зөрчлийн болон эрүүгийн хөнгөн хэрэг шийдвэрлэсэн шүүгчийн дундаж голчийг 1 гэж үзвэл дараах байдлаар илэрхийлэгдэж байна.

Аймаг, сум	Нэг шүүгчид ногдох ачааллын харьцаа	Зөрчил болон эрүүгийн хөнгөн хэрэг шийдвэрлэх шүүгчийн ачаалал*
Сайхан	0.27	↓
Бор-Өндөр	0.39	↓
Замын-Үүд	0.39	↓
Ханбогд	0.46	↓
Тосонцэнгэл	0.48	↓
Ховд-Булган	0.52	↓
Говьсүмбэр	0.56	↓
Дундговь	0.61	↘
Мандал	0.64	↘
Завхан	0.67	↘

Говь-Алтай	0.69	↘
Өмнөговь	0.72	↘
Дорноговь	0.79	↘
Сэлэнгэ	0.98	↔
Баян-Өлгий	1.00	↔
Дархан-Уул	1.00	↔
Хархорин	1.03	↔
Сүхбаатар	1.05	↔
Увс	1.26	↗
Ховд	1.31	↗
Архангай	1.39	↗
Төв	1.40	↗
Булган	1.42	↗
Хөвсгөл	1.44	↗
Баянхонгор	1.74	↑
Дорнод	1.78	↑
Хэнтий	1.96	↑
Орхон	2.08	↑
Өвөрхангай	2.77	↑

Хүснэгт 5.12. 2018-2021 оны зөрчил болон эрүүгийн хөнгөн хэргийн тоон дээр хийсэн шинжилгээний дүнгээс Тэмдэглэгээ: ↓-буурах, ↘ -аажим буурах, ↔ -тогтвортой, ↗-аажим өсөх, ↑ -өсөх

Хүн амын нягтрал багатай аймаг, сум дундын шүүхийн шүүгчийн ачаалал бага байгаа нь харагдаж байна. Дүүргийн эрүүгийн хэргийн шүүгчээс илүү ачаалалтай ажилладаг шүүгч Баянхонгор, Дорнод, Орхон, Өвөрхангай аймгуудад байна.

Аймаг, сум дундын шүүхийн шийдвэрлэсэн зөрчлийн болон эрүүгийн хөнгөн хэргийн тоо дараагийн хоёр жилд хэд болох төлөвтэй байгааг дараах хүснэгтэд харуулав.

Аймаг	2021	2022	2023	Тайлбар
Баян-Өлгий	592	657	728	Шүүгчийн ачаалалд нөлөөтэй.
Говь-Алтай	463	581	730	Шүүгчийн ачаалалд нөлөөтэй.
Завхан	410	483	569	Шүүгчийн ачаалалд нөлөөтэй.
Тосонцэнгэл	320	418	545	Шүүгчийн ачаалалд нөлөөтэй.
Увс	762	915	1099	Шүүгч маш их ачаалалтай.
Ховд	520	531	542	Шүүгчийн ачаалалд нөлөөтэй.
Ховд-Булган	259	300	348	Шүүгчийн ачаалалд нөлөө багатай.
Архангай	816	956	1121	Шүүгч маш их ачаалалтай.
Баянхонгор	904	928	952	Шүүгчийн ачаалалд нөлөөтэй.
Булган	833	1024	1260	Шүүгч маш их ачаалалтай.
Орхон	1206	1171	1138	Шүүгч маш их ачаалалтай.
Хөвсгөл	1101	1299	1533	Шүүгч маш их ачаалалтай.
Өвөрхангай	1156	1188	1221	Шүүгч маш их ачаалалтай.
Хархорин	514	567	625	Шүүгчийн ачаалалд нөлөөтэй.
Говьсүмбэр	352	404	465	Шүүгчийн ачаалалд нөлөө багатай.
Дархан-Уул	767	764	760	Шүүгчийн ачаалалд нөлөөтэй.
Дорноговь	449	495	546	Шүүгчийн ачаалалд нөлөөтэй.
Замын-Үүд	212	185	162	Шүүгчийн ачаалалд нөлөө багатай.
Дундговь	341	362	384	Шүүгчийн ачаалалд нөлөө багатай.
Өмнөговь	429	449	471	Шүүгчийн ачаалалд нөлөө багатай.
Ханбогд	375	414	457	Шүүгчийн ачаалалд нөлөө багатай.
Сэлэнгэ	401	395	389	Шүүгчийн ачаалалд нөлөө багатай.
Мандал	385	368	352	Шүүгчийн ачаалалд нөлөө багатай.
Сайхан	200	213	226	Шүүгчийн ачаалалд нөлөө багатай.

Төв	1231	1330	1437	Шүүгч маш их ачаалалтай.
Дорнод	831	874	919	Шүүгчийн ачаалалд нөлөөтэй.
Хэнтий	726	714	702	Шүүгчийн ачаалалд нөлөөтэй.
Бор-Өндөр	205	217	230	Шүүгчийн ачаалалд нөлөө багатай.
Сүхбаатар	564	626	695	Шүүгчийн ачаалалд нөлөөтэй.

Хүснэгт 5.13. Дараагийн жилүүдийн зөрчлийн болон эрүүгийн хөнгөн хэргийн тоонд хийсэн прогноз

2018-2021 оны зөрчлийн болон эрүүгийн хэргийн тоо богино хугацаанд Хэнтий аймгаас бусад аймагт өсөх хандлагатай байна. Замын-Үүдийн сум дундын шүүхийн шийдвэрлэсэн зөрчил болон эрүүгийн хөнгөн хэргийн тоо ковид-19 өвчний тархалтаас шалтгаалан, өмнөд хөрш рүү зорчих хөдөлгөөн зогссонтой холбоотойгоор буурах хандлагатай харагдаж байна. Прогнозын дүнгээр Төв, Хөвсгөл, Өвөрхангай аймгуудын зөрчил болон эрүүгийн хөнгөн гэмт хэргийн тоо хамгийн их хэмжээгээр өсөх тооцоо гарчээ.

Дүгнэлт

Ачаалал ихтэй шүүхийн шүүгчдийн тоог нэмэгдүүлэх, ачаалал багатай шүүхүүдийг нэгтгэн зохион байгуулж болох боловч 3 жилийн тоон дээр нөлөөлөх хүчин зүйлүүдийг тооцолгүй хийгдсэн шинжилгээ учир үндсэн ачаалал тооцсон шинжилгээний үр дүнтэй холбон хэрэглэвэл илүү үр дүнтэй байна.

4-р бүлгийн шинжилгээнээс харвал аймгийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд ажиллаж буй шүүгчийн ачаалал харьцангуй бага буюу 3 шүүгч нэмж ажиллуулах шаардлагатай гэж гарсантай холбоотойгоор Өвөрхангай, Төв, Хөвсгөл аймгуудад нэмж ажиллуулах саналтай байна.

Нийслэлийн төвийн дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчдийн дундаж ачаалал, аймгуудын дунджаас 59 хэргээр илүү байна. Нийслэлийн төвийн 6 дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчдийн тоог нэмэгдүүлэх шаардлагатай. Багануур, Налайх, Багахангай дүүргүүдийн хувьд ачаалал багатай учир 2 шүүгчийг төвийн 6 дүүргүүд рүү шилжүүлэн ажиллуулах боломжтой.

Нийслэлийн төвийн 6 дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчдийн тоог 4, 5-р бүлгийн шинжилгээнд үндэслэн дараах хүснэгтийн дагуу нэмэгдүүлэх боломжтой.

Дүүрэг	Зөрчлийн хэрэг	Эрүүгийн хөнгөн хэрэг	Нийт
	шийдвэрлэх шүүгчийн тоо	шийдвэрлэх шүүгчийн тоо	
Баянзүрх	2	8	10
Чингэлтэй	0	3	3
Сүхбаатар	0	3	3
Баянгол	0	2	2
Хан-Уул	0	2	2
Сонгинохайрхан	1	4	5
Нийт	3	22	25

Хүснэгт 5.14. Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчдийн тоог нэмэгдүүлэх боломжит тоо

Хүснэгт 5.14-н тооцоонд захын 3 дүүргээс шилжүүлэн ажиллуулах боломжтой 2 шүүгчийг оруулж тооцоогүй болно.

5.4. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

ШАЛГУУР 8. Давж заалдах шатны шүүхээр хянагдсан анхан шатны шүүхийн шийдвэрийн тогтвортой байдал

ШАЛГУУР 9. Хяналтын шатны шүүхээр хянагдсан анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалын тогтвортой байдал

5.4.1. Давж заалдах шатны шүүхээр хянагдсан анхан шатны шүүхийн шийдвэрийн тоо

Шалгуур 8-н дагуу шинжилгээнд эрүү, иргэн, захиргааны хэргийн шүүхийн шийдвэрлэсэн хэргийн мэдээлэлд шинжилгээг хийлээ.


Давж заалдах шатны шүүхэд хуралдаанаар шийдвэрлэсэн хэргийн шүүхийн шийдвэрийн тогтвортой байдал, 2021 онд

Хэргийн төрөл	Анхан шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн хэрэг	Давж заалдах шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн хэрэг	Эзлэх хувь, %	Давж заалдах шатны шүүхийн шийдвэрийн тогтвортой байдал, %
Иргэний хэрэг	44938	2529	6%	41%
Эрүүгийн хэрэг	12019	2025	17%	43%
Захиргааны хэрэг	1719	1313	76%	44%
Нийт хэрэг	58676	5867	10%	43%

Хүснэгт 5.15. ДЗШШ-ээр хянагдсан АШШ-н шийдвэрийн тогтвортой байдал, хэргийн төрлөөр

2021 оны байдлаар улсын хэмжээгээр анхан шатны шүүх 58676 хэргийг хянан шийдвэрлэсэн. Анхан шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн хэргийн 77 хувийг иргэний хэрэг, 20 хувийг эрүүгийн хэрэг, 3 хувийг захиргааны хэрэг тус тус эзэлж байна. Анхан шатны шүүхийн шийдвэрийг эсэргүүцэж давж заалдах шатны шүүхээр шийдвэрлүүлсэн хэрэг нийт хэргийн 10 хувийг эзэлж байна. Иргэний болон эрүүгийн хэргийн давж заалдах хэмжээ бага байгаа бол захиргааны хэргийн давж заалдах хэмжээ 76 хувь буюу дийлэнх хэсэг нь давж заалдах шатны шүүхэд ханддаг байна.

Давж заалдах шатны шүүхээс хянасан АШШ-н шийдвэрийн тогтвортой байдал улсын дунджаар 43 хувь байна. Анхан шатны шүүхийн шийдвэрийн тогтвортой байдлыг 3 жилийн давтамжаар авч үзвэл:



Зураг 5.14. Давж заалдах шатны шүүхээс хянасан АШШ-н шийдвэрийн тогтвортой байдал, хэргийн төрлөөр

2019 оноос давж заалдах шатны шүүхийн шийдвэрийн тогтвортой байдал дунджаар 4 пунктээр өссөн байна.

Бүс	Аймаг	Шүүхийн шийдвэр	Шийдвэрийг хэвээр үлдээсэн хэргийн эзлэх хувь			Өөрчлөлт оруулсан хэргийн эзлэх хувь			Хүчингүй болгож буцаасан хэргийн эзлэх хувь		
			он	2019	2020	2021	2019	2020	2021	2019	2020
Баруун бүс	Баян-өлгий	Иргэн	35%	41%	54%	38%	32%	28%	27%	27%	18%
		Эрүү	29%	48%	50%	17%	30%	31%	54%	23%	19%
		Захиргаа	55%	71%	55%	27%	12%	14%	18%	18%	31%
	Говь-алтай	Иргэн	45%	31%	50%	35%	40%	25%	19%	29%	25%
		Эрүү	38%	41%	39%	21%	31%	32%	42%	28%	29%
		Захиргаа	25%	17%	45%	38%	33%	14%	38%	50%	41%
	Завхан	Иргэн	38%	50%	44%	29%	36%	30%	33%	14%	26%
		Эрүү	54%	55%	79%	19%	14%	11%	27%	32%	11%
		Захиргаа	67%	50%	72%	8%	13%	11%	25%	38%	17%
	Увс	Иргэн	53%	54%	59%	11%	0%	23%	37%	46%	18%
		Эрүү	58%	62%	46%	13%	16%	22%	29%	22%	32%
		Захиргаа	44%	71%	18%	11%	14%	11%	44%	14%	71%
Ховд	Иргэн	39%	30%	22%	32%	34%	47%	29%	36%	31%	
	Эрүү	36%	42%	14%	20%	18%	45%	43%	40%	41%	
	Захиргаа	42%	30%	44%	17%	20%	33%	42%	50%	22%	
Хангайн бүс	Архангай	Иргэн	48%	65%	60%	24%	32%	20%	28%	3%	20%
		Эрүү	34%	50%	58%	34%	20%	25%	32%	30%	17%
		Захиргаа	75%	38%	60%	25%	13%	13%	0%	50%	27%
	Баян-хонгор	Иргэн	47%	25%	39%	13%	25%	13%	40%	50%	48%
		Эрүү	41%	36%	56%	27%	31%	15%	33%	32%	29%
		Захиргаа	42%	14%	43%	50%	14%	0%	8%	71%	57%
	Булган	Иргэн	50%	47%	29%	32%	22%	35%	18%	31%	35%
		Эрүү	30%	31%	46%	43%	31%	32%	27%	38%	22%
		Захиргаа	20%	50%	43%	60%	50%	14%	20%	0%	43%
	Орхон	Иргэн	47%	53%	50%	30%	33%	35%	23%	14%	16%
		Эрүү	43%	34%	36%	28%	23%	29%	29%	43%	35%
		Захиргаа	41%	40%	14%	29%	27%	43%	29%	33%	43%
Хөвсгөл	Иргэн	31%	31%	55%	38%	47%	16%	31%	22%	29%	
	Эрүү	45%	42%	35%	14%	16%	23%	41%	42%	43%	
	Захиргаа	42%	18%	80%	8%	36%	0%	50%	45%	20%	
Өвөрхангай	Иргэн	27%	41%	43%	32%	32%	17%	41%	26%	39%	
	Эрүү	38%	44%	33%	31%	24%	25%	31%	32%	42%	
	Захиргаа	29%	17%	20%	29%	33%	60%	43%	50%	20%	
Төвийн бүс	Говь-сүмбэр	Иргэн	25%	18%	23%	38%	68%	38%	38%	14%	38%
		Эрүү	25%	63%	33%	33%	26%	40%	42%	11%	27%
		Захиргаа	29%	100%	0%	43%	0%	0%	29%	0%	100%
	Дархан-Уул	Иргэн	44%	40%	48%	38%	46%	41%	18%	14%	11%
		Эрүү	32%	27%	33%	37%	39%	33%	31%	34%	34%
		Захиргаа	7%	40%	50%	53%	40%	25%	40%	20%	25%
	Дорноговь	Иргэн	29%	49%	33%	54%	28%	48%	17%	23%	19%
		Эрүү	44%	48%	58%	37%	31%	5%	19%	20%	38%
		Захиргаа	29%	30%	33%	14%	20%	67%	57%	50%	0%
	Дундговь	Иргэн	26%	41%	38%	23%	28%	25%	52%	31%	38%
		Эрүү	13%	64%	38%	20%	14%	33%	67%	21%	29%
		Захиргаа	50%	75%	75%	30%	25%	0%	20%	0%	25%

Зүүн бүс	Өмнөговь	Иргэн	16%	19%	5%	47%	30%	23%	37%	51%	73%
		Эрүү	26%	24%	27%	30%	18%	11%	44%	58%	61%
		Захиргаа	20%	50%	29%	40%	17%	0%	40%	33%	71%
	Сэлэнгэ	Иргэн	12%	44%	21%	50%	42%	61%	38%	14%	18%
		Эрүү	35%	35%	32%	18%	28%	36%	47%	38%	32%
		Захиргаа	11%	33%	44%	11%	44%	33%	78%	22%	22%
	Төв	Иргэн	10%	23%	7%	65%	31%	59%	25%	46%	33%
		Эрүү	46%	22%	26%	27%	43%	31%	27%	35%	42%
		Захиргаа	29%	75%	44%	18%	17%	33%	53%	8%	22%
	Дорнод	Иргэн	52%	65%	53%	33%	32%	39%	15%	3%	8%
		Эрүү	54%	53%	59%	39%	32%	27%	7%	16%	14%
		Захиргаа	21%	14%	33%	21%	29%	17%	57%	57%	50%
	Хэнтий	Иргэн	36%	21%	36%	24%	39%	23%	40%	39%	41%
		Эрүү	44%	47%	55%	21%	18%	13%	35%	35%	33%
		Захиргаа	0%	0%	50%	40%	0%	0%	60%	100%	50%
	Сүхбаатар	Иргэн	29%	38%	50%	42%	25%	36%	29%	38%	14%
		Эрүү	35%	44%	44%	15%	21%	11%	50%	35%	44%
		Захиргаа	56%	43%	50%	33%	29%	33%	11%	29%	17%
	Нийслэл	Иргэн	48%	46%	45%	28%	34%	33%	25%	19%	22%
		Эрүү	43%	42%	45%	30%	30%	25%	26%	29%	30%
		Захиргаа	40%	41%	43%	29%	28%	29%	32%	31%	28%
Аймгуудын дундаж	Иргэн	37%	42%	41%	35%	35%	34%	28%	23%	25%	
	Эрүү	39%	40%	41%	27%	26%	25%	34%	34%	34%	
	Захиргаа	37%	42%	44%	28%	23%	18%	35%	35%	37%	
Стандарт хазайлт	Иргэн	0.13	0.14	0.16	0.13	0.12	0.13	0.10	0.14	0.15	
	Эрүү	0.10	0.12	0.14	0.09	0.08	0.11	0.13	0.10	0.12	
	Захиргаа	0.19	0.25	0.20	0.15	0.13	0.19	0.19	0.25	0.23	

Хүснэгт 5.16. Давж заалдах шатны шүүхийн шийдвэрийн тогтвортой байдал, аймгуудаар

Хүснэгтээс харвал аймгууд болон нийслэлийн давж заалдах шатны шүүхийн шийдвэрийн тогтвортой байдал 2019 оныг 2021 онтой харьцуулахад нэмэгдсэн байна. Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн шийдвэрийн тогтвортой байдал, аймгуудын давж заалдах шатны шүүхийн шийдвэрийн тогтвортой байдлаас 2-4 пунктээр илүү байна.

Эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрийн тогтвортой байдлын стандарт хазайлт бага байгаа нь шүүхийн шийдвэрийн дунджаас хэлбэлзэх хэлбэлзэл бага байгааг харуулж байна. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн тогтвортой байдлын стандарт хазайлт илүү их байгаа нь энэ төрлийн хэргийг шийдвэрлэсэн байдал нь дунджаасаа их хэлбэлзэлтэй байна.

Давж заалдах шатны шүүхийн шийдвэрийн тогтвортой байдлыг нэг шүүгчийн шийдвэрлэсэн хэргийн тоотой холбож хамаарлын шинжилгээ хийж корреляцийн коэффициентийг тодорхойлбол:

Хэргийн төрөл	2019	2020	2021
Иргэн	0.173	0.145	0.074
Эрүү	0.210	-0.156	-0.136
Захиргаа⁹	0.058	0.039	-0.017

Хүснэгт 5.17. Давж заалдах шатны шүүхийн шийдвэрийн тогтвортой байдлын корреляцийн коэффициент

Шүүхийн шийдвэрийн тогтвортой байдал болон нэг шүүгчийн шийдвэрлэсэн хэргийн тооны хооронд сул хамааралтай буюу шүүгчийн хувьд ачаалалтай ажиллах нь шийдвэрийн тогтвортой байдалд нөлөө үзүүлдэггүй нь харагдаж байна.

⁹ Ажиглалтын нэгжийн тоо цөөн учир BESD /binom effect-size display/ ашиглан бодов

5.4.2. Хяналтын шатны шүүхээр хянагдсан анхан, давж заалдах шатны шүүхийн шийдвэрийн тоо, чанар


Монгол улсын хяналтын шатны шүүхийн хуралдаанаар шийдвэрлэсэн хэргийн шүүхийн шийдвэрийн тогтвортой байдал, 2021 онд

Хэргийн төрөл	Давж заалдах шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн хэрэг	Хяналтын шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн хэрэг	Эзлэх хувь,%	Хяналтын шатны шүүхийн шийдвэрийн тогтвортой байдал, %
Иргэний хэрэг	2529	1576	62% ¹⁰	58%
Эрүүгийн хэрэг	2025	136	7%	46%
Захиргааны хэрэг	1313	145	11%	60%
Нийт хэрэг	5867	1857	32%	57%

Хүснэгт 5.18. Шүүхийн шийдвэрийн тогтвортой байдал

2021 оны байдлаар улсын хэмжээгээр давж заалдах шатны шүүх 5867 хэргийг хянан шийдвэрлэсэн. Давж заалдах шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн хэргийн 62 хувийг иргэний хэрэг, 7 хувийг эрүүгийн хэрэг, 11 хувийг захиргааны хэрэг тус тус эзэлж байна. Давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг эсэргүүцэж, хяналтын шатны шүүхээр шийдвэрлүүлсэн хэрэг нийт хэргийн 32 хувийг эзэлж байна.

Хяналтын шатны шүүхийн шийдвэрийн тогтвортой байдал улсын дунджаар 57 хувь байна. Хяналтын шатны шүүхийн шийдвэрийн тогтвортой байдлыг улсын дүнгээр 3 жилийн давтамжаар авч үзвэл:



Зураг 5.15. Хяналтын шатны шүүхээс хянасан анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийн тогтвортой байдал, хэргийн төрлөөр

2019 оноос давж заалдах шатны шүүхийн шийдвэрийн тогтвортой байдал дунджаар 2 пунктээр буурсан байна. Үүнд захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн тогтвортой байдал 2021 оныг 2020 онтой харьцуулахад 8 пунктээр буурсан нь гол нөлөөг үзүүлсэн байна.

¹⁰ Тодорхой шалтгааны улмаас хуримтлагдаж байсан хэргүүд шийдвэрлэгдсэн тул өндөр дүнтэй гарсан.

Хяналтын шатны шүүх		Шүүхийн шийдвэр	Шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж гомдлыг хангахгүй орхисон хэргийн эзлэх хувь			Шийдвэр, магадлалд нэмэлт, өөрчлөлт оруулсан хэргийн эзлэх хувь			Шийдвэр, магадлал, тогтоолыг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээх буюу өөрчилсөн болон бусад хэргийн эзлэх хувь		
Бүс	Аймаг	он	2019	2020	2021	2019	2020	2021	2019	2020	2021
Баруун бүс	Баян-өлгий	Иргэн	62%	71%	63%	10%	4%	23%	38%	33%	14%
		Эрүү	54%	78%	60%	38%	22%	20%	46%	11%	20%
		Захиргаа	82%	82%	67%	6%	9%	0%	18%	18%	33%
	Говь-алтай	Иргэн	55%	46%	44%	9%	15%	33%	45%	31%	22%
		Эрүү	57%	100%	50%	29%	0%	25%	43%	13%	25%
		Захиргаа	100%	83%		0%	0%		0%	0%	
	Завхан	Иргэн	57%	36%	57%	43%	36%	21%	43%	0%	21%
		Эрүү	40%	33%	50%	30%	33%	25%	60%	100%	25%
		Захиргаа	67%	100%	60%	0%	0%	20%	22%	67%	20%
	Увс	Иргэн	63%	20%	50%	13%	0%	17%	38%	40%	33%
		Эрүү	11%	14%	80%	22%	14%	0%	89%	86%	20%
		Захиргаа	50%	100%		50%	0%		50%	0%	
Ховд	Иргэн	67%	67%	33%	17%	19%	38%	33%	14%	29%	
	Эрүү	64%	53%	55%	14%	13%	9%	36%	20%	36%	
	Захиргаа	50%	50%	33%	30%	25%	0%	40%	25%	67%	
Архангай	Иргэн	71%	0%	54%	14%	0%	31%	29%	33%	15%	
	Эрүү	38%	86%	67%	50%	0%	0%	63%	29%	33%	
	Захиргаа	67%	86%	100%	33%	14%	0%	33%	0%	0%	
Баян-хонгор	Иргэн	45%	67%	40%	18%	0%	20%	55%	133%	40%	
	Эрүү	60%	45%	45%	20%	32%	18%	40%	18%	36%	
	Захиргаа	75%	75%	0%	0%	0%	0%	25%	25%	100%	
Булган	Иргэн	67%	67%	26%	0%	0%	21%	33%	67%	53%	
	Эрүү	67%	24%	30%	11%	12%	10%	33%	12%	60%	
	Захиргаа	67%	100%		0%	0%		33%	100%		
Орхон	Иргэн	51%	47%	38%	21%	24%	39%	49%	36%	23%	
	Эрүү	27%	35%	29%	33%	22%	36%	73%	26%	36%	
	Захиргаа	63%	80%	100%	6%	0%	0%	25%	60%	200%	
Хөвсгөл	Иргэн	50%	67%	30%	0%	0%	0%	50%	50%	70%	
	Эрүү	56%	43%	67%	13%	29%	0%	44%	71%	33%	
	Захиргаа	43%	100%		29%	0%		57%	40%		
Өвөрхангай	Иргэн	67%	0%	56%	0%	67%	11%	33%	67%	33%	
	Эрүү	50%	63%	50%	14%	0%	25%	50%	63%	25%	
	Захиргаа	75%	50%	33%	0%	0%	33%	0%	0%	33%	
Говь-сүмбэр	Иргэн	46%		33%	31%		33%	54%		33%	
	Эрүү	67%	22%	50%	0%	56%	0%	33%	11%	50%	
	Захиргаа	50%	50%		0%	50%		50%	100%		
Дархан-Уул	Иргэн	70%	45%	44%	18%	41%	26%	30%	17%	30%	
	Эрүү	21%	37%	20%	42%	7%	20%	79%	44%	60%	
	Захиргаа	73%	67%	100%	0%	0%	0%	18%	67%	33%	
Дорноговь	Иргэн	75%	80%	53%	8%	20%	33%	25%	40%	13%	
	Эрүү	56%	50%	40%	28%	25%	20%	44%	20%	40%	
	Захиргаа	40%	71%	100%	0%	0%	0%	60%	43%	0%	

зүүн бүс	Дундговь	Иргэн	29%	60%	67%	43%	20%	0%	71%	40%	33%
		Эрүү	40%	50%	100%	40%	50%	0%	60%	50%	0%
		Захиргаа	100%	50%		0%	33%		0%	0%	
	Өмнөговь	Иргэн	60%	50%	40%	40%	0%	20%	40%	0%	40%
		Эрүү	36%	64%	50%	21%	0%	17%	64%	43%	33%
		Захиргаа	44%	71%	50%	22%	14%	0%	33%	14%	100%
	Сэлэнгэ	Иргэн	56%	43%	27%	25%	36%	50%	44%	21%	23%
		Эрүү	28%	50%	33%	28%	18%	0%	72%	36%	67%
		Захиргаа	60%	20%	0%	20%	20%	0%	40%	20%	100%
	Төв	Иргэн	77%	56%	56%	15%	25%	22%	23%	6%	22%
		Эрүү	29%	50%	40%	38%	30%	80%	54%	20%	0%
		Захиргаа	100%	71%	33%	0%	0%	33%	0%	0%	0%
	Дорнод	Иргэн	88%	38%	35%	0%	38%	47%	13%	13%	18%
		Эрүү	54%	40%	38%	31%	20%	50%	46%	13%	13%
		Захиргаа	30%	20%		10%	20%		60%	100%	
	Хэнтий	Иргэн	29%	57%	33%	14%	29%	17%	71%	57%	50%
		Эрүү	38%	57%	63%	38%	21%	38%	63%	14%	0%
		Захиргаа	50%			0%			50%		
	Сүхбаатар	Иргэн	100%	33%	25%	0%	33%	25%	0%	0%	50%
		Эрүү	20%	40%	43%	20%	40%	43%	80%	60%	14%
		Захиргаа	33%	50%	0%	0%	25%	100%	33%	25%	100%
Нийслэл	Иргэн	64%	59%	63%	13%	22%	21%	36%	26%	17%	
	Эрүү	43%	49%	40%	35%	24%	31%	57%	21%	29%	
	Захиргаа	68%	68%	62%	11%	11%	9%	27%	14%	26%	
Аймгуудын дундаж	Иргэн	37%	42%	41%	35%	35%	34%	28%	23%	25%	
	Эрүү	39%	40%	41%	27%	26%	25%	34%	34%	34%	
	Захиргаа	37%	42%	44%	28%	23%	18%	35%	35%	37%	
Стандарт хазайлт	Иргэн	0.20	0.24	0.16	0.13	0.18	0.13	0.18	0.31	0.16	
	Эрүү	0.18	0.23	0.21	0.13	0.16	0.19	0.20	0.27	0.19	
	Захиргаа	0.24	0.26	0.39	0.15	0.14	0.27	0.19	0.32	0.57	


Хүснэгт 5.19. Хяналтын шатны шүүхийн шийдвэрийн тогтвортой байдал, аймгуудаар

Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн хяналтын шатны шүүхийн шийдвэр нь аймгуудын давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, гомдлыг харгалзахгүй орхисон шийдвэрээс 17 пунктээр илүү их байна. Эрүүгийн хэргийн хувьд хамгийн бага ялгаатай буюу 4 пункт байгаа бол иргэний хэргийн хувьд 11 пункт, захиргааны хэргийн шийдвэрийг хэвээр үлдээсэн нь 25 пунктын ялгаатай байна.


Аймаг болон нийслэлийн давж заалдах шатны шүүхийн шийдвэрийн стандарт хазайлт нь хяналтын шатны шүүхийн хувьд давж заалдах шатны шүүхийн шийдвэрээс 0.07-р илүү байна. 2021 онд захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн тогтвортой байдал нь дунджаас илүү их хэлбэлзэлтэй байна.

Хяналтын шатны шүүхийн шийдвэрийн тогтвортой байдал болон нэг шүүгчид ногдох хэргийн тооны хоорондын хамаарлыг графикаар дүрсэлж харууллаа.

Эрүүгийн хэргийн хувьд:



Иргэний хэргийн хувьд:



Захиргааны хэргийн хувьд:



Зураг 5.16. Нэг шүүгчид ногдох хэргийн тооны хоорондын хамаарал


Дээрх гурван графикаас харахад хяналтын шатны шүүхийн шийдвэрийн тогтвортой байдал болон нэг шүүгчид ногдох хэргийн тооны хооронд хамаарал ажиглагдахгүй байна.

5.5. БАГА ҮНИЙН ДҮНТЭЙ НЭХЭМЖЛЭЛИЙН ӨГӨГДӨЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

Тодорхой төрлийн маргааны тоонд хийх шинжилгээг захиалагч талаас өгсөн сэдвийн дагуу Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарах “Бага үнийн дүнтэй нэхэмжлэлийн тоон өгөгдөл”¹¹-д тулгуурлан хийлээ.

5.5.1. Дүүргийн шүүх


Дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхээс 2017-2021 оны хооронд дунджаар хүлээн авсан нэхэмжлэлийн 46.7 хувийг бага үнийн дүнтэй нэхэмжлэл эзэлж байна.



Зураг 5.17. Дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд хүлээн авсан нийт нэхэмжлэлд бага үнийн дүнтэй нэхэмжлэлийн эзлэх хувийн жин

Дүүргийн иргэний хэргийн анхан шатны нэг шүүгч жилд дунджаар 136 бага үнийн дүнтэй нэхэмжлэл хүлээн авсан байхад энэ нь дүүрэг бүрд харилцан адилгүй байна. Хүлээн авсан нэхэмжлэлээс тооцож байгаа учраас нэхэмжлэлийн дундаж утга нь дүүргийн шүүхэд нэг шүүгч 136 гэж ойлгоно.

Дүүргийн иргэний хэргийн анхан шатны нэг шүүгч жилд дунджаар шийдвэрлэсэн бага үнийн дүнтэй нэхэмжлэлийн тоог харуулбал:



Зураг 5.18. Сүүлийн 4 жилийн хугацаанд дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн нэг шүүгчийн хүлээн авсан дундаж нэхэмжлэлийн тоо

Бага үнийн дүнтэй нэхэмжлэлийн нэг шүүгчид ногдох ачаалал харилцан адилгүй байна. Дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд хүлээн авсан бага үнийн дүнтэй нэхэмжлэлийн нэг шүүгчийн дундаж ачаалал буюу 136 нэхэмжлэлийг 1 гэж үзвэл шүүгчид ногдох харьцаа дараах байдлаар илэрхийлэгдэж байна.

Дүүрэг	Нэг шүүгчид ногдох ачааллын харьцаа	Бага үнийн дүнтэй нэхэмжлэлийг шийдвэрлэх шүүгчийн ачаалал*
--------	-------------------------------------	---

¹¹ 10 саяас доош үнийн дүнтэй нэхэмжлэлүүдийг ийм нэршилд багтааж гаргасан тоон өгөгдлийг шинжилсэн.

Багахангай	1:0.3	↓
Налайх	1:0.7	↔
Багануур	1:0.8	↔
Чингэлтэй	1:0.9	↔
Сүхбаатар	1:0.9	↔
Баянгол	1:1.2	↗
Хан-Уул	1:1.2	↗
Баянзүрх	1:1.4	↑
Сонгинохайрхан	1:1.7	↑

Хүснэгт 5.20. 2017-2021 оны бага үнийн дүнтэй нэхэмжлэлийн өгөгдөлд хийсэн шинжилгээний дүгнэлт
Тэмдэглэгээ: ↓-буурах, ↘ -аажим буурах, ↔ -тогтвортой, ↗ -аажим өсөх, ↑ -өсөх

Хүснэгтээр харуулсан харьцаанаас харвал төвийн 6 дүүргийн ДИХАШШ-д хүлээн авсан энэ төрлийн нэхэмжлэл 136 буюу 1 гэсэн харьцаанд хүрсэн, ялангуяа Сонгинохайрхан дүүргийн шүүхэд 1.7 гэсэн харьцааг илэрхийлж байгаа нь уг дүүргийн нэг шүүгчид бага үнийн дүнтэй нэхэмжлэлийн тоо өндөр байгааг харуулна.

Дүүрэг тус бүрийн хүн амын тоо 1000 хүнээр нэмэгдэж байхад бага үнийн дүнтэй нэхэмжлэлийн тоо дүүрэг тус бүр дээр харилцан адилгүй байна. Дараах хүснэгтээр харуулбал:

Дүүрэг	Шийдвэрлэх хэргийн тоо	Тайлбар
Багахангай	24.7	Уг нэхэмжлэлийн тоо нэмэгдэнэ.
Налайх	16.4	Уг нэхэмжлэлийн тоо нэмэгдэнэ.
Багануур	-4.2	Өөр нэхэмжлэлийн тоо нэмэгдэнэ.
Чингэлтэй	-9.8	Өөр нэхэмжлэлийн тоо нэмэгдэнэ.
Сүхбаатар	-5.3	Өөр нэхэмжлэлийн тоо нэмэгдэнэ.
Баянгол	21.3	Уг нэхэмжлэлийн тоо нэмэгдэнэ.
Хан-Уул	9.5	Уг нэхэмжлэлийн тоо нэмэгдэнэ.
Баянзүрх	4.3	Уг нэхэмжлэлийн тоо нэмэгдэнэ.
Сонгинохайрхан	41.4	Уг нэхэмжлэлийн тоо нэмэгдэнэ.

Хүснэгт 5.21. Хүн амын тооны өсөлтөөс шалтгаалсан өөрчлөлтийн дүгнэлт

Хүн амын тооны өсөлт нь энэ төрлийн нэхэмжлэлийн тооны өсөлтөд Багануур, Чингэлтэй, Сүхбаатар дүүрэгт урвуу, бусад дүүрэгт шууд хамааралтай байна. Урвуу хамааралтай дүүргүүдэд хүн ам өсөхөд энэ төрлийн нэхэмжлэл бус бусад төрлийн нэхэмжлэлийн тоо илүү өснө, шууд хамааралтай шүүхүүдийн хувьд хүн ам өсөхөд энэ төрлийн нэхэмжлэлийн тоо өсөх зүй тогтолтой байгааг харуулж байна.

Дүүрэг тус бүрийн бага үнийн дүнтэй нэхэмжлэлийн тоо ирэх хоёр жилд хэд болох төлөвтэй байгааг экстраполяцийн арга ашиглан тооцож дараах хүснэгтэд харуулбал:

Дүүрэг	2021	2022	2023	Тайлбар
Багахангай	40	60	101	Шүүгчийн ачаалалд нөлөө багатай.
Налайх	300	315	308	Шүүгчийн ачаалалд нөлөөтэй.
Багануур	411	415	413	Шүүгчийн ачаалалд их нөлөөтэй.
Чингэлтэй	1560	1703	1641	Шүүгч маш их ачаалалтай.
Сүхбаатар	1494	1483	1488	Шүүгч маш их ачаалалтай.
Баянгол	2640	2720	2682	Шүүгч маш их ачаалалтай.
Хан-Уул	2057	2238	2159	Шүүгч маш их ачаалалтай.
Баянзүрх	3389	3529	3463	Шүүгч маш их ачаалалтай.
Сонгинохайрхан	3159	3617	3441	Шүүгч маш их ачаалалтай.

Хүснэгт 5.22. Дараагийн жилүүдийн бага үнийн дүнтэй нэхэмжлэлийн тоонд хийсэн прогнозын дүгнэлт.

Дүүргийн бага үнийн дүнтэй нэхэмжлэлийн тоонд шүүгчийн ачааллыг тооцохдоо судалгааны жил, ирэх хоёр жилийн динамикийн өсөлтийн дундаж хурднаас үндэслэж

шүүгчийн ачааллын прогнозыг илэрхийлэхэд Багахангай дүүргийн хувьд шүүгчийн ачаалалд нөлөө багатай, Налайх дүүргийн хувьд шүүгчийн ачаалалд нөлөөтэй, Багануур дүүргийн хувьд шүүгчийн ачаалалд их нөлөөтэй харин бусад дүүргийн хувьд шүүгчийн ачаалалд маш их нөлөөтэй гэсэн дүгнэлт гарч байна.

Хүснэгтээс харвал төвийн 6 дүүргийн шүүхэд дараагийн 2 жилд хүлээн авах энэ төрлийн нэхэмжлэл нь тухайн шүүхийн ачаалалд их нөлөөтэй болох нь харагдаж байна. Нэхэмжлэлийн үнийн дүн 10 саяас доош байх бага үнийн дүнтэй хэрэг нь хугацааны хувьд бусад хэргээс ижил хугацаанд шийдвэрлэгддэг. Тэгвэл бага үнийн дүнтэй хэрэг бусад хэргээс богино хугацаанд шийдвэрлэгдэх боломж байгаа эсэхийг хэрэг хянан шийдвэрлэх хугацааны хувьд судлах хэмжээнд энэ төрлийн нэхэмжлэл өндөр дүнгээр дүүргийн шүүхэд ачаалал үзүүлж байна.

Дүүрэг бүрийн бага үнийн дүнтэй нэхэмжлэлд төрөл тус бүрээр шинжилгээ хийж, дараах хүснэгтээр харуулав.

Нэхэмжлэлийн төрөл	Дүүрэг									Бага үнийн дүнтэй нэхэмжлэлийг шийдвэрлэх шүүгчийн ачаалал*
	Багахангай	Налайх	Багануур	Чингэлтэй	Сүхбаатар	Баянгол	Хан-Уул	Баянзүрх	Сонгинохайрхан	
Иргэний хуулиар	1:0.6	1:0.6	1:0.6	1:0.9	1:1.1	1:1.1	1:1.4	1:1.4	1:1.3	↑
Иргэн хянан шийдвэрлэх хуулиар	1:0.7	1:0.5	1:0.6	1:1.6	1:1.2	1:1.2	1:1.1	1:0.9	1:1.2	↔
Гэр бүлийн тухай хуулиар	1:0.5	1:0.4	1:0.3	1:0.4	1:0.4	1:0.5	1:0.6	1:0.6	1:0.8	↔
Хөдөлмөрийн тухай хуулиар	1:0.3	1:0.0	1:0.1	1:0.3	1:0.3	1:0.1	1:0.2	1:0.1	1:0.1	↔


Хүснэгт 5.23. Бага үнийн дүнтэй нэхэмжлэлийг шийдвэрлэх шүүгчийн ачааллыг нэхэмжлэлийн төрлөөр тооцсон шинжилгээний үр дүн

Бага үнийн дүнтэй нэхэмжлэлийг тооцоходоо дүүргийн шүүхийн маргаан тус бүрийн дундаж хэмжээг баримтлан иргэний маргааны төрлүүдэд эзлэх хэмжээг 1 гэсэн харьцаагаар харуулахад, “иргэний хуулиар” шийдвэрлэсэн маргааны төрөлд илүү өндөр харьцааг харуулж байна. Тухайлбал, иргэний хуулиар гэдэг нь нэг шүүгчид дунджаар 33 нэхэмжлэл ногдож байгаа дүнгээс харьцааг тооцсон гэж ойлгоно.

Ерөнхий дүгнэлт: Шинжилгээнд ирүүлсэн өгөгдлөөс харахад маргааны төрлийн хувьд шүүхийг дагнан байгуулахаас илүүтэй төвийн 6 дүүргийн хэмжээнд бага үнийн дүнтэй нэхэмжлэлийг шийдвэрлэх шүүхийг байгуулах, энэ төрлийн нэхэмжлэлээс үүсэх ачааллыг тусад нь дагнан гаргах нь нийт хэргийг шийдвэрлэх ачааллаас хөнгөлөх, бага үнийн дүнтэй хэргийг хөнгөн хялбар байдлаар шийдвэрлэх боломжийг олгохоор байна.

5.5.2. Аймаг, сум дундын шүүх

Аймаг дахь иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017-2021 оны хооронд хүлээн авсан нийт нэхэмжлэлийн 28.4 хувь нь бага үнийн дүнтэй нэхэмжлэл эзэлж байна.




Зураг 5.19. Аймгийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн нийт нэхэмжлэлд, бага үнийн дүнтэй нэхэмжлэлийн эзлэх хувийн жин

Дээрх графикаас харахад нийт хүлээн авсан нэхэмжлэлээс бага үнийн дүнтэй нэхэмжлэлийн эзлэх хувь Говьсүмбэр, Дорнод аймгуудад хамгийн өндөр байна.

Бага үнийн дүнтэй нэхэмжлэлийн хүлээн авсан тоо аймаг, сум дундын иргэний хэргийн анхан шатны нэг шүүгч жилд дунджаар 64 бага үнийн дүнтэй нэхэмжлэл ногдож байна. Хүлээн авсан нэхэмжлэлээс тооцсон бага үнийн дүнтэй нэхэмжлэлийн дундаж утга нь 64 гэж ойлгоно. Аймаг, сум дундын шүүхэд нийт хүлээн авсан нэхэмжлэлийн тоо нь дүүргийн шүүхээс 2.1 дахин бага байна.

Аймаг, сум дундын иргэний хэргийн анхан шатны нэг шүүгч жилд дунджаар ногдох бага үнийн дүнтэй нэхэмжлэлийн тоо



Зураг 5.20. Сүүлийн 4 жилийн хугацаанд аймаг болон сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн нэг шүүгчийн хүлээн авсан дундаж нэхэмжлэлийн тоо

Аймаг, сумын иргэний хэргийн анхан шатны шүүхэд бага үнийн дүнтэй нэхэмжлэлд шүүгчийн дундаж ачаалал буюу 64 нэхэмжлэлийг 1 гэж үзвэл харьцаа дараах байдлаар илэрхийлэгдэж байна.

Аймаг, сум дундын шүүхийн нэр	Нэг шүүгчид ногдох ачааллын харьцаа	Бага үнийн дүнтэй нэхэмжлэлийг шийдвэрлэх шүүгчийн ачаалал*
Ханбогд	1:0.2	↓
Хо.Булган	1:0.3	↓
Тосонцэнгэл	1:0.4	↓
Хархорин	1:0.5	↓
Завхан	1:0.5	↓
Сайхан	1:0.5	↓
Замын-Үүд	1:0.5	↓
Бор-Өндөр	1:0.5	↓
Өмнөговь	1:0.6	↘
Хөвсгөл	1:0.6	↘
Сүхбаатар	1:0.7	↘
Дундговь	1:0.7	↘
Дорноговь	1:0.8	↘
Говь-Алтай	1:0.8	↘

Говь-сүмбэр	1:0.9	↔
Өвөрхангай	1:0.9	↔
Архангай	1:0.9	↔
Төв	1:0.9	↔
Баянхонгор	1:1.0	↔
Мандал	1:1.0	↔
Булган	1:1.1	↔
Баян-Өлгий	1:1.1	↔
Увс	1:1.2	/
Ховд	1:1.4	/
Сэлэнгэ	1:1.5	/
Хэнтий	1:1.7	↑
Дархан-Уул	1:2.4	↑
Орхон	1:2.4	↑
Дорнод	1:2.8	↑

Хүснэгт 5.24. 2017-2021 оны бага үнийн дүнтэй нэхэмжлэлийн тоонд хийсэн шинжилгээний дүн
Тэмдэглэгээ: ↓-буурах, ↘ -аажим буурах, ↔ -тогтвортой, / -аажим өсөх, ↑ -өсөх

Бага үнийн дүнтэй нэхэмжлэлийн тоо буурах аймгуудын шүүгчдийг нэхэмжлэл өсөх аймгийн шүүх рүү томилох, өөр нэхэмжлэл, өөр төрлийн гэмт хэргийн шүүхэд ажиллуулах төлөвлөгөө гаргах хэрэгтэй.

Аймаг, сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд бага үнийн дүнтэй нэхэмжлэл нэг шүүгчид ногдох ачаалал, судалгааны үндсэн хэсгийн дендрограмм (Dendrogram) –г үндэслэн бага үнийн дүнтэй нэхэмжлэлийг хүлээн авч шийдвэрлэх шүүгчдийг дараах байдлаар зохион байгуулах боломжтой гэсэн шинжилгээний үр дүн гарч байна.

Бүлгийн дугаар	Бага үнийн дүнтэй шүүхээр бүлэглэгдэх аймаг	Шүүгчийн ачаалал
1	Өмнөговь, Ханбогд	Бага
2	Хо.Булган, Баян-Өлгий	
3	Завхан, Говь-Алтай	Дунд зэргийн
4	Сайхан, Мандал	
5	Замын-Үүд, Дорноговь	
6	Төв, Дундговь	
7	Сүхбаатар, Говьсүмбэр	
8	Хэнтий, Бор-Өндөр	Ихтэй
9	Сэлэнгэ, Булган	
10	Өвөрхангай, Архангай, Хархорин	
11	Увс, Ховд	
12	Хөвсгөл, Тосонцэнгэл, Баянхонгор	
13	Дархан-Уул	
14	Орхон	
15	Дорнод	

Хүснэгт 5.25. 2017-2021 оны бага үнийн дүнтэй нэхэмжлэлийн тоонд хийсэн шинжилгээний дүнгээс

Бага үнийн дүнтэй нэхэмжлэлийг хүлээн авч буй шүүхүүдийн хувьд шүүгчийн ачаалал бага, дунд, их байгаа энэ дүнгээс гадна хэргийн бодит ачааллыг харгалзан шүүхийг зохион байгуулах шаардлагатай байна.

Аймаг, сум дундын шүүхийн тус бүрийн бага үнийн дүнтэй нэхэмжлэлийн тоо дараагийн хоёр жилд хэд болох төлөвтэй байгааг дараах хүснэгтэд харуулав.

Аймаг	2021	2022	2023	Тайлбар
Ханбогд	21	15	19	Шүүгчийн ачаалалд нөлөө багатай.

Завхан	56	11	43	Шүүгчийн ачаалалд нөлөө багатай.
Тосонцэнгэл	57	53	53	Шүүгчийн ачаалалд нөлөө багатай.
Сүхбаатар	98	63	86	Шүүгчийн ачаалалд нөлөө багатай.
Өмнөговь	92	78	86	Шүүгчийн ачаалалд нөлөө багатай.
Хархорин	84	87	85	Шүүгчийн ачаалалд нөлөө багатай.
Хо.Булган	80	104	101	Шүүгчийн ачаалалд нөлөөтэй.
Булган	138	106	125	Шүүгчийн ачаалалд нөлөөтэй.
Архангай	140	115	130	Шүүгчийн ачаалалд нөлөөтэй.
Замын -Үүд	127	117	122	Шүүгчийн ачаалалд нөлөөтэй.
Өвөрхангай	128	125	126	Шүүгчийн ачаалалд нөлөөтэй.
Дорноговь	145	125	136	Шүүгчийн ачаалалд нөлөөтэй.
Дундговь	136	141	139	Шүүгчийн ачаалалд нөлөөтэй.
Бор-Өндөр	138	157	149	Шүүгчийн ачаалалд нөлөөтэй.
Баянхонгор	173	186	180	Шүүгч маш их ачаалалтай.
Говь-сүмбэр	170	194	185	Шүүгч маш их ачаалалтай.
Сайхан	165	199	188	Шүүгч маш их ачаалалтай.
Баян-Өлгий	243	206	227	Шүүгч маш их ачаалалтай.
Говь-Алтай	221	264	250	Шүүгч маш их ачаалалтай.
Хөвсгөл	256	264	260	Шүүгч маш их ачаалалтай.
Ховд	269	279	274	Шүүгч маш их ачаалалтай.
Хэнтий	309	324	317	Шүүгч маш их ачаалалтай.
Увс	293	351	332	Шүүгч маш их ачаалалтай.
Төв	307	318	312	Шүүгч маш их ачаалалтай.
Мандал	287	329	313	Шүүгч маш их ачаалалтай.
Сэлэнгэ	377	436	414	Шүүгч маш их ачаалалтай.
Дорнод	583	471	537	Шүүгч маш их ачаалалтай.
Орхон	939	1087	1032	Шүүгч маш их ачаалалтай.
Дархан-Уул	1146	1480	1426	Шүүгч маш их ачаалалтай.

Хүснэгт 5.26. Дараагийн жилүүдэд хүлээн авах бага үнийн дүнтэй нэхэмжлэлийн тоонд хийсэн прогноз

Бага үнийн дүнтэй нэхэмжлэлийн прогнозын үр дүнгээр шүүгч маш их ачаалалтай гэсэн аймгуудад цаашид шүүгчийг тодорхой хугацаанд томилолтоор ажиллуулах, орон тоог нэмэгдүүлэх байдлаар зохион байгуулах төлөвлөгөө боловсруулах боломжтой.

Шинжилгээнд ирүүлсэн өгөгдлөөс харахад аймаг, сум дундын шүүх тус бүрд бага үнийн дүнтэй нэхэмжлэл хүлээн авч хэргийг шийдвэрлэх дагнасан шүүх шаардлагагүй. Харин шүүгчийн ачааллыг тэнцвэржүүлж, орон тоог оновчтой тодорхойлох нь чухал байна.

Шинжилгээнд ирүүлсэн өгөгдлөөс харахад маргааны төрлийн хувьд шүүхийг дагнан байгуулахаас илүүтэй төвийн 6 дүүргийн хэмжээнд бага үнийн дүнтэй нэхэмжлэлийг шийдвэрлэх шүүхийг байгуулах, энэ төрлийн нэхэмжлэлээс үүсэх ачааллыг тусад нь дагнан гаргах нь нийт хэргийг шийдвэрлэх ачаалаас хөнгөлөх, бага үнийн дүнтэй хэргийг хөнгөн хялбар байдлаар шийдвэрлэх боломжийг олгохоор байна.

Ерөнхий дүгнэлт: Шинжилгээнд ирүүлсэн өгөгдлөөс харахад аймаг, сум дундын шүүх тус бүрд бага үнийн дүнтэй нэхэмжлэлийг хүлээн авах шаардлагагүй. Бага үнийн дүнтэй нэхэмжлэхийн хувьд шүүгчийн ачааллыг тэнцвэржүүлж, дагнасан бага үнийн дүнтэй шүүхийг зохион байгуулсанаар уг хэргийг хөнгөн, хялбар байдлаар шийдвэрлэх боломж харагдаж байна.

ДУГНЭЛТ

Шинжилгээнд ирүүлсэн өгөгдлийн агуулга, төрлийг судлан үзэхэд шинжилгээ нь бүтцийн хувьд шүүхийн тогтолцоо, хэргийн төрлийг даган хийгдэхээр байсан. Иймд тайлангийн бүтэц, бичвэр, дүгнэлт нь мөн эдгээр онцлогоо дагасан хэлбэрээр дүгнэгдлээ.

НЭГ. ХЭРГИЙН БОЛОН АЖИЛЛАГААНЫ АЧААЛЛЫН ХҮРЭЭНД

Хэргийн ачааллыг хянан шийдвэрлэсэн хэргийн дүнгээр, шүүхийн тогтолцоо, хэргийн төрлийн хүрээнд авч судалсан бол ажиллагааны ачааллыг Хэргийн хөдөлгөөний бүртгэл, хяналтын нэгдсэн системээс гаргасан үзүүлэлтэд тулгуурлан тодорхой ажиллагааны төрөлд хамаарах тоог хамааруулан хэргийн төрлөөр, зөвхөн анхан шатны шүүхэд хамаарах ажиллагааг судаллаа. Ажиллагааны ачаалалд хамаарах үзүүлэлт нь гол төлөв нэгдсэн системийн дугаар авах ажиллагаанд холбогдох өгөгдлөөс бүрдэж, энд дурдсан ажиллагааг хийж гүйцэтгэхэд зарцуулах хугацаанд харгазлах мэдээллийг 2018 онд хийгдсэн ачаалын судалгаанд дурдсан хугацааг баримтлан шинжиллээ.

Сүүлийн 4-5 жилийн өгөгдлийн хувьд хэргийн болон ажиллагааны ачааллыг тодорхойлохын тулд дисперсийн болон кластерийн шинжилгээг хийж, кластерийн шинжилгээний үр дүнг Хотелингийн шинжүүрээр таамаглал дэвшүүлэн бататгаж, нэг шүүгчид нэг жилд ногдож байгаа бодит ачааллын хэмжээг хэргийн төрлөөр мөн хэд хэдэн төрлийн хэргийг хянан шийдвэрлэж байгаа шүүгчдийн хувьд бусад хэргийг эрүүгийн хэргийн дүнд шилжүүлэх байдлаар тооцон гаргалаа. Энэхүү шинжилгээ нь иргэн, эрүү (зөрчил)-н хэргийн шүүгчийн ачааллыг шүүхийн тогтолцоогоор нь нэг хэргийн нэгжээр илэрхийлэн тодорхойлсон анхны шинжилгээ юм.

1.1. Хэргийн ачааллын хувьд:

1.1.1. Анхан шатны шүүгч хянан шийдвэрлэсэн хэргийн ачааллын хувьд

Дүүрэг, Нийслэл: Нийслэлийн төвийн 6 дүүргийн анхан шатны шүүхийн нэг шүүгчийн хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийг 5 жилийн дунджаар тооцоход жилд 136, зөрчлийн хэрэг 1390, иргэний хэрэг 326, нийслэлийн хувьд захиргааны хэрэг 54 байна. Тэгвэл захын дүүргийн нэг шүүгчийн ачааллын хувьд эрүүгийн хэрэг 44, зөрчлийн хэрэг 58, иргэний хэрэг 142-г тус тус хянан шийдвэрлэсэн байна.

Аймаг: Аймгийн 21 анхан шатны шүүхийн нэг шүүгчийн хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийг 5 жилийн дунджаар тооцоход жилд 79, зөрчлийн хэрэг 143, иргэний хэрэг 267, захиргааны хэрэг 13 байна. Аймгийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүгч эрүү, зөрчлийн хэрэг дээр ажилладаг онцлогтой тул эдгээр хэргийг эрүүгийн хэрэгт шилжүүлсэн дүнгээр тооцоход $79+143:10.2=93$ байна.

Сум дунд: Сум дундын 8 шүүхийн нэг шүүгчийн хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийг 5 жилийн дунджаар тооцоход жилд 28, зөрчлийн хэрэг 71, иргэний хэрэг 105 байна. Сум дундын шүүгч эрүү, зөрчил, иргэний хэрэг дээр ажилладаг онцлогтой тул эдгээр хэргийг эрүүгийн хэрэгт шилжүүлсэн дүнгээр тооцоход $28+71:10.2+105:2.4=79$ байна.

Улсын дундаж. Улсын дунджаар анхан шатны шүүхийн нэг шүүгч жилд эрүүгийн 89 (зөрчлийн хэргийг шилжүүлсэн дүн багтсан), иргэний 250, захиргааны 34 хэрэг тус тус хянан шийдвэрлэсэн ачаалалтай ажиллажээ. Дээр дурдсан дүгнэлтийг хүснэгт хэлбэрээр харуулъя.

Шүүхийн тогтолцоо	Эрүү		Зөрчил ¹²		иргэн		Захиргаа
	төв	зах	төв	зах	төв	зах	
Дүүрэг, Нийслэл	136	44	1390	58	326	142	54
Аймаг анхан шат	79		143		267		13
Сум дунд	28		71		105		-
Анхан шат Улсын дундаж		89			250		34
Улсын дунджийг эрүүгийн хэрэгт шилжүүлсэн дүн		89			104		34

Улсын дундаж буюу бодит ачааллыг нэг хэргийн нэгжид шилжүүлэн дүгнэвэл анхан шатны шүүхэд иргэний хэрэг эрүүгийн хэрэгт шилжсэн дүнгээрээ 15 эрүүгийн хэргээр илүү байна. Энэ нь Улсын хэмжээнд иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчид эрүүгийн хэргийн ижил шатны шүүхийн шүүгчдээс илүү их ачаалалтай ажилласныг харуулж байна. Үүнээс төвийн 6 дүүргийн шүүхийн эрүү, зөрчил, иргэний хэргийн ачаалал маш их байсан байна.

1.1.2. Давж заалдах шатны шүүгч хянан шийдвэрлэсэн хэргийн ачааллын хувьд:

Нийслэл: Нийслэлийн хэмжээнд давж заалдах шатны шүүхийн нэг шүүгчийн хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийг 5 жилийн дунджаар тооцоход жилд 69, зөрчлийн хэрэг 11, иргэний хэрэг 160, захиргааны хэрэг 62 байна. ЭХДЗШШ-н шүүгч эрүү, зөрчлийн хэрэг дээр ажилладаг онцлогтой тул эдгээр хэргийг эрүүгийн хэрэгт шилжүүлсэн дүнгээр тооцоход $69+11:10.2=70$ байна.

Аймаг: Аймгийн 19 давж заалдах шатны шүүхийн нэг шүүгчийн хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийг 5 жилийн дунджаар тооцоход жилд 15, зөрчлийн хэрэг 4, иргэний хэрэг 12 байна. АДЗШШ-н шүүгч эрүү, зөрчил, иргэний хэрэг дээр ажилладаг онцлогтой тул эдгээр хэргийг эрүүгийн хэрэгт шилжүүлсэн дүнгээр тооцоход $15+4:10.2+12:2.4=20.4$ байна.

Орхон, Дархан-Уул: Эдгээр 2 аймгийн хэмжээнд ЭХДЗШШ, ИХДЗШШ гэсэн 2 шүүх тусдаа үйл ажиллагаа явуулдаг тул АДЗШШ-с тусдаа тооцоо хийгдсэн. ЭХДЗШШ-н нэг шүүгч жилд 25 эрүүгийн хэрэг, 6 зөрчлийн хэрэг тус тус хянан шийдвэрлэсэн байна. ИХДЗШШ-н нэг шүүгч жилд 46 иргэний хэрэг хянан шийдвэрлэсэн байна.

Улсын дундаж: Улсын дунджаар давж заалдах шатны шүүхийн нэг шүүгч жилд эрүүгийн 39 (зөрчлийн хэргийг шилжүүлсэн дүн багтсан), иргэний 103, захиргааны 62 хэргийг хянан шийдвэрлэсэн ачаалалтай ажиллажээ. Дээр дурдсан дүгнэлтийг хүснэгт хэлбэрээр харуулъя.

Шүүхийн тогтолцоо	Эрүү	Зөрчил	Иргэн	Захиргаа
Нийслэлийн давах	69	11	160	62
Аймгийн давах (19 аймаг)	15	4	12	-
Орхон, Дархан-Уул	25	6	46	-
Давж заалдах шат Улсын дундаж	39	7	103	62
Улсын дунджийг Эрүүгийн хэрэгт шилжүүлсэн дүн	39	-	43	62

Улсын дундаж буюу бодит ачааллыг нэг хэргийн нэгжид шилжүүлэн дүгнэвэл давж заалдах шатны шүүхэд иргэний хэрэг эрүүгийн хэрэгт шилжсэн дүнгээрээ мөн 4 эрүүгийн хэргээр илүү байна. Энэ нь Улсын хэмжээнд иргэний хэргийн анхан шатны шүүхийн

¹² Зөрчлийн хэрэг, эрүүгийн хэргийн хоорондын харьцааг олохдоо зөрчлийн хэргийг төвийн дүүргийн дангаар шийдвэрлэдэг шүүгчдийн шийдвэрлэсэн хэргийн тооноос тооцож гаргасан тул хүснэгтэд зөрчлийн хэргийг эрүүгийн хэрэгт шилжүүлж, эрүүгийн хэргийг нэмэгдсэн дүнгээр гаргасан.

шүүгчид эрүүгийн хэргийн ижил шатны шүүхийн шүүгчдээс илүү их ачаалалтай ажилласныг харуулж байна. Үүнээс Нийслэлийн иргэний болон эрүүгийн хэргийн давж задлах шатны шүүхэд ачаалал маш их байсан байна. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх нь эрүүгийн хэргийн дүнгээс 23, иргэний хэрэг эрүүгийн хэрэгт шилжсэн дүнгээс 19 хэргээр тус тус илүү байгаа нь энэ шүүхийн ачаалал их байсныг харуулж байна. ЗХДЗШШ-н дүнд захиргааны хэрэг, мэргэжлийн хариуцлагын хорооны хэрэг, ёс зүйн хорооны хэргийг хянан шийдвэрлэсэн ажлын дүнг тооцсон бөгөөд энэ шүүхийн шүүгч ачаалалтай ажиллажээ.

1.2. Анхан шатны шүүгчийн ажиллагааны ачааллын хувьд:

ШЕЗ-н 58 дугаар тогтоолоор баталсан шалгуур 3 болон 26-ын тайлбарт “ажиллагаа” гэсэн агуулга тусгагдсан байна. Үүний хүрээнд цугласан өгөгдлийг харвал хэргийн хөдөлгөөний бүртгэл, хяналтын нэгдсэн системээс дугаар авч байгаа дийлэнх ажиллагааг хамаарсан байна. Ингэхдээ хэргийн 4 төрлөөс эрүү, иргэн, захиргааны хэрэгт хамаарах тодорхой төрлийн ажиллагааг зөвхөн тоо (ширхэг) талаас нь илэрхийлж, харин зөрчлийн хэргийн шийтгэлийн тоог эрүүгийн хэргийн ажиллагаанд нэг үзүүлэлт байдлаар тодорхойлсон байна.

Шалгуур 3 болон 26-д заасан агуулгыг бүхэлд нь үзвэл шалгуур 3-ын тайлбарт “хэргийн болон ажиллагааны” гэсэн нэр томъёо тусгагдаж, үүгээрээ хэрэг гэсэн цул зүйл, үүнээс гадна энэ цулд ороогүй үлдсэн хэргийн хөдөлгөөнд хамаарах бусад ажиллагааг ч гэсэн ачаалалд оруулан нэг мөр авч үзэх гэсэн утгаар ойлгогдож байна. Мөн шалгуур 26 нь “шүүгчийн ажлын ачаалал” гэсэн нэр томъёогоор тусгагдаж, энэ нь мөн л “хэргийн болон ажиллагааны” гэсэн тайлбартайгаар батлагдсан байна. Шалгуур 26 буюу шүүгчийн ажил гэдэгт хэрэг хянан шийдвэрлэх ажлаас өөр бусад ажил ч хамаарах талтай юм. Тухайлбал, шүүгчдийн зөвлөгөөнд оролцох, сургагч багшаар ажиллах, хурал, хэлэлцүүлэгт шүүгчийн хувиар оролцох, ерөнхий шүүгчийн хуулиар хүлээн бүрэн эрхэд хамаарах ажлуудыг энд дурдах боломжтой юм. Иймд ажиллагааны ачаалалд яг юуг хамааруулах, тэдгээр нь хэргийн 4 төрлийн хувьд ямар үзүүлэлтээр тодорхойлогдож судлагдахыг цаашид оновчтой, тодорхой болгож, шалгуур үзүүлэлт, түүний тайлбарт нэр томъёо, агуулгыг оновчтой томъёолох шаардлага үүсэж байна.

2 дугаар бүлэгт хийгдсэн дисперсийн шинжилгээгээр шинжилгээний нийт өгөгдлөөс эрүү, иргэний хэргийн анхан шатны шүүх, захиргааны хэргийн аймаг дахь анхан шатны шүүхийн өгөгдөлд ажиллагааны ачааллыг шинжлэхэд ажиллагааны нийт ачаалал дараах дүнтэй байна.

Эрүүгийн хэргийн хувьд:

Эрүүгийн хэргийн ажиллагаанд шийтгэх тогтоол, шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол, мэдэгдэх хуудас, албан бичиг, шийтгэвэр, гүйцэтгэх хуудас, баримт, урьдчилсан хэлэлцүүлэг гэсэн 9 төрлийн материалын тоо өгөгдсөн.

Дүүрэг: Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд төвийн дүүргийн нэг шүүгчид жилд ногдох ажиллагааны материал 730, захын дүүргийн нэг шүүгчид жилд ногдох ажиллагааны материал 311 байсан бөгөөд дунджаар дүүргийн эрүүгийн хэргийн нэг шүүгч нэг жилд 599 материал боловсруулсан байна.

Аймаг: Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд аймгийн анхан шатны шүүхийн нэг шүүгчид жилд ногдох ажиллагааны материал баруун бүсэд хамгийн бага буюу 712, хангайн бүсэд хамгийн их буюу 1788 байсан бөгөөд дунджаар 1127 материал боловсруулсан байна.

Сум дунд: Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд сум дундын шүүхийн нэг шүүгч нэг жилд авах ажиллагааны ачаалал баруун бүсэд хамгийн бага буюу 128, хангайн бүсэд хамгийн их буюу 458, дундаж нь 330 байна.

Иргэний хэргийн хувьд:

Иргэний хэргийн ажиллагаанд шийдвэр, шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол, шийтгэвэр, гүйцэтгэх хуудас, мэдэгдэх хуудас, албан бичиг, баримт гэсэн 8 төрлийн материалын өгөгдөл орж ирсэн.

Дүүрэг: Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд төвийн дүүргийн нэг шүүгчид жилд ногдох ажиллагааны материал 3036, захын дүүргийн нэг шүүгчид жилд ногдох ажиллагааны материал 1647 байсан бөгөөд дунджаар дүүргийн иргэний хэргийн нэг шүүгч нэг жилд 2342 материал боловсруулсан байна.

Аймаг: Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд аймгийн анхан шатны шүүхийн нэг шүүгчид жилд ногдох ажиллагааны материал төвийн бүсэд хамгийн бага буюу 2116, хангайн бүсэд хамгийн их буюу 3180 байсан бөгөөд дунджаар 2824 материал боловсруулсан байна.

Сум дунд: Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд сум дундын шүүхийн нэг шүүгч нэг жилд авах ажиллагааны ачаалал баруун бүсэд хамгийн бага буюу 128, хангайн бүсэд хамгийн их буюу 457, дундаж нь 330 байна.

Захиргааны хэргийн хувьд:

Захиргааны хэргийн ажиллагаанд шийдвэр, шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол, мэдэгдэх хуудас, албан бичиг, шийтгэвэр, гүйцэдгэх хуудас, баримт, үзлэг-нотлох баримт, урьдчилсан хэлэлцүүлэг, тэмдэглэл гэсэн 11 төрлийн материалын өгөгдөл орж ирсэн.

Аймаг: Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд аймгийн анхан шатны шүүхийн нэг шүүгчид жилд ногдох ажиллагааны материал зүүн бүсэд хамгийн бага буюу 210, баруун бүсэд хамгийн их буюу 380 байсан бөгөөд дунджаар 294 материал боловсруулсан байна.

Хэргийн төрөл тус бүр дэх ажиллагааны ачааллын дүнгээс харвал иргэд хоорондын ахуйн чанартай маргаан өндөр дүнтэй шийдвэрлэгддэг жишгийн дагуу түүнд хийгдэх ажиллагаа нэг бүрийн тоо өндөр дүнтэй гарсан байна. Иргэний хэргийн хувьд түүний энэхүү онцлог байдлаас шалтгаалан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нэг бүрд гүйцэдгэх чиг үүргийг шүүгч, туслах гэх байдлаар хэрэгжүүлж буй субъект талаас нь зааглан судалвал ажиллагааны ачааллын хэдэн хувийг аль субъект авч байгаагаас шалтгаалан хүний нөөцийг оновчтой тодорхойлох асуудал яригдах боломжтой гэж үзэж байна. Харин захиргаа болон сум дундын шүүхийн ажиллагааны ачаалал ойролцоо дүнтэй гарсан нь хянан шийдвэрлэсэн хэргийн дүн нь захиргааны хэрэг бага байгаа хэдий ч түүнд зарцуулах ажиллагаагаараа сум дундын шүүхийн шийдвэрлэдэг эрүү, зөрчил, иргэний хэргийн ажиллагаатай ялгаагүй, ажиллагааны ачаалал ойролцоо болохыг харуулж байна.

ХОЁР. ШҮҮХЭД ШИЙДВЭРЛЭСЭН ХЭРГИЙН ТОГТОЛЦООНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУВЬД

2.1. Хянан шийдвэрлэсэн хэргийн тогтолцоог тодорхойлох загварын хувьд

Шүүхийн үйл ажиллагааг хэргийн 4-н төрлийн хувьд, мөн хэрэг тус бүрийн хувьд загвараар тодорхойллоо. Ингэхдээ шүүхээс хянан шийдвэрлэж буй бүх төрлийн хэргийг шүүхийн тогтолцооны хувьд судалсан загварт эрүү, зөрчил, иргэн, захиргааны хэрэг нь загварын хувьсагч болж судлагдсан бол хэргийн төрөл тус бүр дээр тодорхойлсон тухайн төрлийн хэргийн бие даасан загварт шалгуур үзүүлэлтийн дагуу цугларсан 4-8 төрлийн үзүүлэлт хувьсагч болж судлагдлаа.

2.1.1. Анхан шатны шүүх

Төвийн дүүрэг: Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд ДЭХАШШ-н нэг шүүгчийн нэг жилд шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоо 0.5 хэргээр өссөн (сүүлийн 5 жилийн хугацаанд 2-3 хэргээр өссөн) бол зөрчлийн хэргийг дагнан шийдвэрлэдэг шүүгчийн шийдвэрлэсэн хэрэг жилд 9 хэргээр өссөн байна. ДИХАШШ-н нэг шүүгчийн нэг жилд шийдвэрлэсэн иргэний хэргийн тоо 0.3 хэргээр өссөн (сүүлийн 5 жилийн хугацаанд 1-2 хэргээр өссөн) бол Нийслэл дэх ЗХАШШ-н нэг шүүгчийн нэг жилд шийдвэрлэсэн захиргааны хэргийн тоо 0.07 хэргээр буюу бараг өсөлтгүй байсан байна. Хэргийн төрөл тус бүрийн хувьд нэг шүүгчид нэг жилд ногдох шийдвэрлэсэн хэргийн тооны өсөлтийн хэмжээг харвал зөрчлийн хэрэгт хамгийн их буюу жилд 9 хэргээр өссөн дүнтэй байна.

Захын дүүрэг: Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд захын ДЭХАШШ-н нэг шүүгчийн нэг жилд шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоо 0.1 хэргээр (5 жилийн хугацаанд $0.1*5=0.5$) өссөн бол зөрчлийн хэргийн хувьд 0.5 хэргээр, ДИХАШШ-н нэг шүүгчийн нэг жилд шийдвэрлэсэн иргэний хэргийн тоо 1 хэргээр тус тус өсжээ.

Аймаг: Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд ЭХАШШ-н нэг шүүгчийн нэг жилд шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоо 1 хэргээр, зөрчлийн хэргийн тоо 2 хэргээр, АИХАШШ-н нэг шүүгч нэг жилд шийдвэрлэсэн иргэний хэргийн тоо 2 хэргээр тус тус өссөн байна. ЗХАШШ-н нэг шүүгч нэг жилд шийдвэрлэсэн хэрэг -0.13 хэргээр (5 жилийн хугацаанд $0.13*5=0.65$ буюу 1 хэргээр) буурсан байна.

Сум дунд: Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд сум дундын шүүхийн нэг шүүгчийн нэг жилд ногдох шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоо 0.03 хэргээр буюу өсөөгүй байгаа бол зөрчлийн хэргийн хувьд 0.4 хэргээр (5 жилийн хугацаанд $0.4*5=2$), иргэний хэргийн тоо 1 хэргээр тус тус өссөн байна. Эдгээр шийдвэрлэсэн хэргийн тооны өсөлт нэг шүүгчийн ачаалалтай холбоотой.

2.1.2. Давж заалдах шатны шүүх

Нийслэлийн шүүх: Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд НЭХДЗШШ-н нэг шүүгчийн нэг жилд шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоо 0.7 хэргээр өссөн бол зөрчлийн хэргийн тоо 0.01 хэргээр буюу маш бага тооцоо хийгдэхгүй шахам коэффициентээр өсөх хандлагатай байсан байна. НИХДЗШШ-н нэг шүүгч нэг жилд шийдвэрлэсэн иргэний хэргийн тоо 0.04 хэргээр буюу маш бага тооцоо хийгдэхгүй шахам коэффициентээр буурах хандлагатай байсан байна. ЗХДЗШШ-н нэг шүүгчийн нэг жилд хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийн тоо жилд -0.7 буюу 5 жилийн хугацаанд 3-4 хэргээр буурсан байна.

Аймгийн шүүх: Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд АДЗШШ-н нэг шүүгчийн нэг жилд шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоо 0.7 хэргээр (5 жилийн хугацаанд $0.7*5=3.5$) өссөн бол зөрчлийн хэргийн тоо 0.1 хэргээр буюу бага коэффициентээр өсөх хандлагатай байсан байна. Иргэний хэргийн тооны хувьд -0.7 хэргээр буюу (5 жилийн хугацаанд $-0.7*5=-3.5$) хэргээр буурсан байна.

Орхон, Дархан-Уул аймаг дахь шүүх: Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд Орхон, Дархан уул аймаг дахь ЭХАШШ-н нэг шүүгчийн нэг жилд шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоо 0.7 хэргээр, зөрчлийн хэргийн тоо 0.2 хэргээр буюу 5 жилийн хугацаанд 1 хэргээр өссөн байна. Харин иргэний хэрэг -0.7 буюу 5 жилийн хугацаанд 3-4 хэргээр буурсан байна.

2.2. Шүүхийн үйл ажиллагаанд нөлөөлөх хүчин зүйлийн шинжилгээний хувьд

2.2.1. Төвийн 6 дүүргийн шүүх, Нийслэл дэх ЗХАШШ

Эрүүгийн хэрэг: Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд төвийн ДЭХАШШ-н эрүүгийн хэрэг шийдвэрлэдэг нэг шүүгчийн нэг жилд шийдвэрлэсэн хэргийн тоо 0.7 хэргээр буюу 5 жилд 3-4 хэргээр, үлдэгдэл хэрэг 0.03 хэргээр (бараг өсөлтгүй), ажиллагаа жилд 3

материалаар, шийдвэрлэсэн хэрэгт хамаарах хүний тоо 0.7 буюу 5 жилд 3-4 хүнээр, үлдэгдэл хэрэгт хамаарах хүний тоо 0.03 хүнээр (бараг өсөлтгүй), хүн амын нягтрал 0.3 хүнээр буюу 5 жилд 1-2 хүнээр тус тус өссөн байна. Цалингийн хэмжээ загварт орсон хувьсагчдын өсөлтөөс шалтгаалан жилд 210000 төгрөгөөр буурсан байна.

Зөрчлийн хэрэг: Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд төвийн ДЭХАШШ-н зөрчлийн хэрэг шийдвэрлэдэг нэг шүүгчийн шийдвэрлэсэн хэргийн тоо жилд 7 хэргээр, ажиллагаа жилд 6 материалаар, хүн амын нягтрал 0.3 хүнээр буюу 5 жилд 1-2 хүнээр, цалингийн хэмжээ жилд 48100 төгрөгөөр тус тус өссөн байна. Жил бүр зөрчлийн хэргийн тоо өсч байгаа ч 2021 оны эрүүгийн хэргийн шүүгчийн цалингийн сангийн өсөлт, зөрчлийн хэрэг дээр ажилладаг шүүгчийн тоо тогтмол байсан зэрэг шалтгаанууд зөрчлийн хэргийн шүүгчийн цалингийн хэмжээг өсөлттэй гаргах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Иргэний хэрэг: Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд төвийн ДИХАШШ-н шүүгчийн нэг жилд шийдвэрлэсэн хэргийн тоо 0.7 хэргээр буюу 5 жилд 3-4 хэргээр, үлдэгдэл хэрэг 0.3 хэргээр буюу 5 жилд 1-2 хэргээр, ажиллагаа жилд 5 материалаар, шийдвэрлэсэн хэрэгт хамаарах хариуцагчийн тоо 0.6 буюу 5 жилд 3 хариуцагчаар, хүн амын нягтрал 0.4 хүнээр буюу 5 жилд 2 хүнээр тус тус өссөн байна. Цалингийн хэмжээ жилд 11600 төгрөгөөр өссөн байна. Энэ шалтгаан 2019 оны иргэний хэргийн тооны бууралт 2020 оны өсөлт, 2021 оны бууралт, цалингийн өсөлттэй холбоотой гэж үзэж байна.

Захиргааны хэрэг: Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд НЗХАШШ-н шүүгчийн нэг жилд шийдвэрлэсэн хэргийн тоо 0.3 хэргээр буюу 5 жилд 1-2 хэргээр, үлдэгдэл хэрэг 0.5 хэргээр буюу 5 жилд 3-4 хэргээр, ажиллагаа жилд 5 материалаар, шийдвэрлэсэн хэрэгт хамаарах нэхэмжлэгчийн тоо 0.4 буюу 5 жилд 2 нэхэмжлэгчээр, шийдвэрлэсэн хэрэгт хамаарах хариуцагчийн тоо 0.3 буюу 5 жилд 1-2 хариуцагчаар, хүн амын нягтрал жилд 1 хүнээр тус тус өссөн байна. Цалингийн хэмжээ жилд 435800 төгрөгөөр өссөн байна. Энэ шалтгаан нь захиргааны хэргийн тоо буурсантай холбоотой цалингийн хэмжээ өсөлттэй гарсан байна. Өөрөөр хэлбэл цалингаа бүтэн авсан хэмжээнд хүрч ажиллаж чадаагүй гэсэн үг юм.

2.2.2. Захын 3 дүүргийн шүүх

Эрүүгийн хэрэг: Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд захын ДЭХАШШ-н эрүү, зөрчлийн хэрэг шийдвэрлэдэг нэг шүүгчийн нэг жилд шийдвэрлэсэн хэргийн тоо 0.3 хэргээр буюу 5 жилд 1-2 хэргээр, үлдэгдэл хэрэг 0.05 хэргээр (бараг өсөлтгүй), ажиллагаа жилд 4 материалаар, шийдвэрлэсэн хэрэгт хамаарах хүний тоо 0.4 буюу 5 жилд 2 хүнээр, үлдэгдэл хэрэгт хамаарах хүний тоо 0.06 хүнээр (бараг өсөлтгүй), хүн амын нягтрал 0.1 хүнээр буюу 5 жилд 0-1 хүнээр тус тус өссөн байна. Цалингийн хэмжээ загварт орсон хувьсагчдын өсөлтөөс шалтгаалан жилд 936000 төгрөгөөр буурсан байна. 2018 онд Багануур дүүргийн эрүү, зөрчлийн хэргийн шүүгчийн цалин өсөөд буцаад буурсан, 2017, 2018 онд Багахангай дүүргийн шүүгчийн ачаалал бага байх үед цалин өндөр байснаа 2019 оноос хойш ачаалал өсөж байхад цалин буурсантай холбоотойгоор 936000 төгрөгөөр буурсан гэсэн үр дүнг харуулж байна.

Иргэний хэрэг: Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд захын ДИХАШШ-н шүүгчийн нэг жилд шийдвэрлэсэн хэргийн тоо 0.8 хэргээр буюу 5 жилд 4 хэргээр, үлдэгдэл хэрэг 0.01 хэргээр (бараг өсөлтгүй), ажиллагаа жилд 7 материалаар, шийдвэрлэсэн хэрэгт хамаарах хариуцагчийн тоо 0.6 буюу 5 жилд 3 хариуцагчаар тус тус өссөн байна. Цалингийн хэмжээ жилд 18000 төгрөгөөр, томилолтын зардал 47 төгрөгөөр тус тус буурсан байна. Энэ нь 2021 онд Налайх дүүргийн иргэний хэргийн шүүгчийн цалин өссөн ч 2017, 2018, 2019 оны цалингийн хэмжээ 2020 оны цалингаас өндөр байсан бөгөөд харгалзах жилүүдийн ачаалал цалингийнхаа эсрэг байсан гэх мэт шалтгаантай холбоотой.

2..2.3. Аймаг дахь анхан шатны шүүх

Эрүүгийн хэрэг: Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд АЭХАШШ-н эрүүгийн хэрэг шийдвэрлэдэг нэг шүүгчийн нэг жилд шийдвэрлэсэн хэргийн тоо 0.7 хэргээр буюу 5 жилд 3-4 хэргээр, үлдэгдэл хэрэг 0.07 хэргээр (бараг өсөлтгүй), ажиллагаа жилд 18 материалаар, шийдвэрлэсэн хэрэгт хамаарах хүний тоо 0.7 буюу 5 жилд 3-4 хүнээр, үлдэгдэл хэрэгт хамаарах хүний тоо 0.1 хүнээр (бараг өсөлтгүй), цалингийн хэмжээ 17500 төгрөгөөр тус тус өссөн байна. Харин томилолтын зардал 160 төгрөгөөр буурчээ.

Иргэний хэрэг: Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд АИХАШШ-н шүүгчийн нэг жилд шийдвэрлэсэн хэргийн тоо 0.7 хэргээр буюу 5 жилд 3-4 хэргээр, ажиллагаа жилд 7 материалаар, шийдвэрлэсэн хэрэгт хамаарах хариуцагчийн тоо 0.05 хүнээр буюу бараг өсөлтгүй, цалингийн хэмжээ 125 төгрөгөөр, томилолтын зардал 9820 төгрөгөөр тус тус өссөн байна.

Захиргааны хэрэг: Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд АЗХАШШ-н шүүгчийн нэг жилд шийдвэрлэсэн хэргийн тоо 0.1 хэргээр (өсөлтгүй), үлдэгдэл хэрэг 0.5 хэргээр буюу 5 жилд 3-4 хэргээр, ажиллагаа жилд 5 материалаар, цалингийн хэмжээ жилд 858800 төгрөгөөр, томилолтын зардал 4990 төгрөгөөр өссөн байна.

2.2.4. Сум дундын шүүх

Эрүүгийн хэрэг: Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд сум дундын шүүхийн шүүгчийн нэг жилд шийдвэрлэсэн хэргийн тоо 0.2 хэргээр буюу 5 жилд 1 хэргээр, үлдэгдэл хэрэг 0.03 хэргээр (бараг өсөлтгүй), ажиллагаа жилд 8 материалаар, шийдвэрлэсэн хэрэгт хамаарах хүний тоо 0.2 буюу 5 жилд 1 хүнээр, үлдэгдэл хэрэгт хамаарах хүний тоо 0.05 хүнээр (бараг өсөлтгүй), тус тус өссөн байна. Цалингийн хэмжээ 41000 төгрөгөөр буурсан байна.

Иргэний хэрэг: Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд сум дундын шүүхийн шүүгчийн нэг жилд шийдвэрлэсэн иргэний хэргийн тоо 1 хэргээр, үлдэгдэл хэрэг 0.04 хэргээр буюу бараг өсөлтгүй, ажиллагаа жилд 9 материалаар, шийдвэрлэсэн хэрэгт хамаарах хариуцагчийн тоо 0.4 хүнээр буюу 5 жилд 2 хүнээр тус тус өссөн байна. Цалингийн хэмжээ 23400 төгрөгөөр, буурсан байна.

2.2.5. Давж заалдах шатны шүүх

Аймгийн шүүх: Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд АДЗШШ-н шүүгчийн нэг жилд шийдвэрлэсэн хэргийн тоо 1 хэргээр, ажиллагаа жилд 3.5 материалаар, хүн амын нягтрал 0.01 хүнээр (буюу бараг өсөлтгүй) тус тус өссөн байна. Цалингийн хэмжээ 260000 төгрөгөөр өссөн байна.

Орхон, Дархан-Уул аймгийн эрүүгийн хэргийн шүүх: Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд Орхон, Дархан-Уул аймаг дахь ДЗШШ-н эрүүгийн хэрэг шийдвэрлэдэг нэг шүүгчийн нэг жилд шийдвэрлэсэн хэргийн тоо 1 хэргээр, ажиллагаа 1.5 материалаар, хүн амын нягтрал 1 хүнээр тус тус буурч байсан бол цалин 460000 төгрөгөөр өссөн байна.

Орхон, Дархан-Уул аймгийн иргэний хэргийн шүүх: Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд Орхон, Дархан-Уул аймаг дахь ДЗШШ-н иргэний хэрэг шийдвэрлэдэг нэг шүүгчийн нэг жилд шийдвэрлэсэн хэргийн тоо 0.6 хэргээр, ажиллагаа 4 материалаар, цалин 2246000 төгрөгөөр тус тус буурсан байна

Нийслэл: Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд НЭХДЗШШ-н шүүгчийн шийдвэрлэсэн хэргийн тоо жилд 1 хэргээр буурсан, ажиллагаа 2 материалаар өссөн, хүн амын нягтрал 0.3 хүнээр буюу 5 жилд 1-2 хүнээр буурсан байна. Цалингийн хэмжээ загварын хувьсагчаас хасагдах бөгөөд маш бага коэффициенттэй байна.

Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд НИХДЗШШ-н шүүгчийн нэг жилд шийдвэрлэсэн хэргийн тоо 4 хэргээр, ажиллагаа 8 материалаар өсч, хүн амын нягтрал 1 хүнээр тус тус буурч байсан бол цалин 287100 төгрөгөөр өссөн байна.

Сүүлийн 5 жилийн динамикийн хувьд ЗХДЗШШ-н шүүгчийн нэг жилд шийдвэрлэсэн хэргийн тоо 1 хэргээр, ажиллагаа 5 материалаар өсч, хүн амын нягтрал 1 хүнээр тус тус буурч байсан бол цалин 283000 төгрөгөөр өссөн байна.

ГУРАВ. ШҮҮХ БАЙГУУЛАХ, ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ, ТАТАН БУУЛГАХ, БАЙРШЛЫГ ТОГТООХ ХҮРЭЭНД

Шаардлагатай шүүгчийн тоог тооцсон 4-р бүлгийн үр дүн дээр үндэслэн шүүхийн цалингийн сан дээр хийсэн дүгнэлтийг энэ бүлэгт дурдая. Шүүхийн бүрэлдэхүүнийг өөрчлөх, татан буулгах, шинээр байгуулахдаа шүүхийн төсвийг хэмнэлттэй, зөв хуваарилалтын аргаар хийж чадах нь судалгааны ажлын үр дүн болно. Энэ бүлэгт 34-р шалгуур үзүүлэлтийн цалингийн сан, цалингийн санд мэдээлэгдсэн шүүгчийн тоо, 3-р шалгуур үзүүлэлтийн цэвэр ажилласан шүүгчийн тооны зөрүү дээр дүгнэлт өгнө. Мөн ямар шатны, ямар хэргийн шүүх дээр цалингийн сан үргүй урсаж байгаа, ямар шатны, ямар хэргийн шүүх дээр цалингийн сан дутагдаж байгааг тодорхойлж дүгнэлт өгнө.

3.1. Анхан шатны шүүх

№	Шүүх	Цалингийн сан дээрх шүүгчийн тоо	Ажиллаж буй шүүгчийн тоо	Зөрүү	
1	Эрүүгийн хэрэг	Төвийн дүүрэг	44.6	44.1	0.5
		Захын дүүрэг	7.9	7	0.9
		Аймаг	67.8	64.1	3.7
		Сум дунд	27.6	26	1.6
2	Зөрчлийн хэрэг	Төвийн дүүрэг	6	6	0
3	Иргэний хэрэг	Төвийн дүүрэг	75	77.1	-2.1
		Захын дүүрэг	7.9	7.5	0.4
		Аймаг	72.6	69.3	3.3
4	Захиргааны хэрэг	Нийслэл	16.4	18.5	-2.1
		Аймаг	54.2	54	0.2
Дүн		380	373.6	6.4	

Хүснэгт 90. АШШ-д ажиллаж буй шүүгчийн тооны зөрүү

2017-2021 оны дунджаар 34-р шалгуур үзүүлэлтийн цалингийн сан дээрх шүүгчийн тоо төвийн 6 дүүргийн ЭХАШШ-д 44.6 шүүгч ажилласан гэсэн мэдээ өгсөн байна. Шалгуур 3-ын бодит ажилласан шүүгчийн тоо 44.1 гэсэн мэдээ өгсөн байна. Зөрүүний 0.5-ыг дараах утгаар тайлбарлана. Төвийн ДЭХАШШ-д ажилласан 44.6 шүүгчдийн хувьд жилд чөлөө авах, өвчтэй байх, томилолтоор ажиллах, суралцахаар явах гэх мэт шалтгаантай өдрүүдийг нэмж тооцоход нэг шүүгч хагас жил ажиллаагүй хэмжээний зөрүү гарч байна. Хүснэгт 90-н нийт дүнгийн хувьд АШШ-д цалингийн сан дээрх шүүгчийн тооны мэдээгээр 380 шүүгч ажилласан байна. Ажилласан шүүгчийн тооны мэдээгээр 373.6 шүүгч ажилласан байна. АШШ-д ажилласан 380 шүүгчдийн хувьд жилд чөлөө авах, өвчтэй байх, томилолтоор ажиллах, суралцахаар явах гэх мэт шалтгаантай өдрүүдийг нэмж тооцоход 6.4 шүүгч нэг жилд ажиллаагүй байна.

№	Шүүх	Цалингийн сан дээрх шүүгчийн тоо	Ажиллавал зохих шүүгчийн тоо	Зөрүү	Нэг шүүгчийн цалин (сая.төг)	Нийт цалингийн сангийн хэмжээ (сая.төг)	
1	Эрүү	Төвийн дүүрэг	44.6	72	27.4	40.4	1106.96
		Захын дүүрэг	7.9	4	-3.9	33.1	-129.09
		Аймаг	67.8	66.6	-1.2	36.5	-43.8

		Сум дунд	27.6	23.4	-4.2	35.6	-149.52
2	Зөрчил	Төвийн дүүрэг	6	10	4	40.4	161.6
3	Иргэн	Төвийн дүүрэг	75	109.2	34.2	35.7	1220.94
		Захын дүүрэг	7.9	4.8	-3.1	34.9	-108.19
		Аймаг	72.6	82.3	9.7	36.0	349.2
4	Захиргаа	Нийслэл	16.4	27.8	11.4	32.3	368.22
		Аймаг	54.2	20.6	-33.6	37.5	-1260
Дүн			380	420.7	40.7	-	1516.32

Хүснэгт 91. АШШ-д ажиллавал зохих шүүгчийн тоо, цалингийн сан, 1-р хувилбар

2017-2021 оны дунджаар 34-р шалгуур үзүүлэлтийн цалингийн сан дээрх шүүгчийн тоо төвийн 6 дүүргийн ЭХАШШ-д 44.6 шүүгч ажилласан гэсэн мэдээ өгсөн байна. 4-р бүлгийн судалгааны үр дүнгээр ажиллавал зохих шүүгчийн тооны 1-р хувилбарыг 72 гэж тооцсон. Ажиллавал зохих шүүгчийн тооноос төвийн ДЭХАШШ-д ажилласан шүүгчдийн тоог хасахад 27.4 шүүгч нэмж авах шаардлагатай бөгөөд төвийн ДЭХАШШ-д ажиллах нэг шүүгчийн нэг жилийн цалин 40.4 сая төгрөг байна. Төвийн ДЭХАШШ-д 27 шүүгч нэмж ажиллуулна гэвэл нийт 1106.96 сая төгрөгийн төсөв хэрэгтэй байна. Гэвч захын ДЭХАШШ-д 129.09 сая төгрөг, аймгийн шүүхэд 43.8 сая төгрөг, сум дундын шүүхэд 149.52, захын ДИХАШШ-д 108.19 сая төгрөг, АЗХАШШ-д 1260 сая төгрөгийн үргүй зардал гарч байна. Эдгээр үргүй зардлын нийт хэмжээ 1690.6 сая төгрөг байна. Нэмэх шаардлагатай санхүүжилт 3206.92 сая төгрөг байна. Үргүй урсаж байгаа хэсгийн зардлыг зөв зохион байгуулж чадах, өөрөөр хэлбэл шүүгчийн тоог зохистой хэмжээнд өөрчилсний дараа 40-41 шүүгч нэмж авч ажиллуулбал 1516.32 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт шаардлагатай болж байна.

№	Шүүх	Цалингийн сан дээрх шүүгчийн тоо	Ажиллавал зохих шүүгчийн тоо	Зөрүү	Нэг шүүгчийн цалин (сая.төг)	Нийт цалингийн сангийн хэмжээ (сая.төг)	
1	Эрүү	Төвийн дүүрэг	44.6	76.1	31.5	40.4	1272.6
		Захын дүүрэг	7.9	4.3	-3.6	33.1	-119.16
		Аймаг	67.8	66.6	-1.2	36.5	-43.8
		Сум дунд	27.6	24	-3.6	35.6	-128.16
2	Зөрчил	Төвийн дүүрэг	6	10.3	4.3	40.4	173.72
3	Иргэн	Төвийн дүүрэг	75	118.1	43.1	35.7	1538.67
		Захын дүүрэг	7.9	5.4	-2.5	34.9	-87.25
		Аймаг	72.6	89.3	16.7	36.0	601.2
4	Захиргаа	Нийслэл	16.4	27.8	11.4	32.3	368.22
		Аймаг	54.2	20.6	-33.6	37.5	-1260
Дүн			380	442.5	62.5	-	2316.04

Хүснэгт 92. АШШ-д ажиллавал зохих шүүгчийн тоо, цалингийн сан, 2-р хувилбар

2017-2021 оны дунджаар 34-р шалгуур үзүүлэлтийн цалингийн сан дээрх шүүгчийн тоо төвийн 6 дүүргийн ЭХАШШ-д 44.6 шүүгч ажилласан гэсэн мэдээ өгсөн байна. 4-р бүлгийн судалгааны үр дүнгээр ажиллавал зохих шүүгчийн тооны 2-р хувилбарыг 76 гэж тооцсон. Ажиллавал зохих шүүгчийн тооноос төвийн ДЭХАШШ-д ажилласан шүүгчдийн тоог хасахад 31.5 шүүгч нэмж авах шаардлагатай бөгөөд төвийн ДЭХАШШ-д ажиллах нэг шүүгчийн нэг жилийн цалин 40.4 сая төгрөг байна. Төвийн ДЭХАШШ-д 31-32 шүүгч нэмж ажиллуулна гэвэл нийт 1272.6 сая төгрөгийн төсөв хэрэгтэй байна. Гэвч захын ДЭХАШШ-д 119.2 сая төгрөг, аймгийн шүүхэд 43.8 сая төгрөг, сум дундын шүүхэд 128.2, захын ДИХАШШ-д 87.25 сая төгрөг, АЗХАШШ-д 1260 сая төгрөгийн үргүй зардал гарч байна. Эдгээр үргүй зардлын нийт хэмжээ 1638.37 сая төгрөг байна. Нэмэх шаардлагатай санхүүжилт 3954.4 сая төгрөг байна. Үргүй урсаж байгаа хэсгийн зардлыг зөв зохион байгуулж чадах, өөрөөр хэлбэл шүүгчийн тоог зохистой хэмжээнд өөрчилсний дараа 62-63

шүүгч нэмж авч ажиллуулбал 2316.04 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт шаардлагатай болж байна.

3.2. Давж заалдах шатны шүүх

№	Шүүх	Цалингийн сан дээрх шүүгчийн тоо	Ажиллаж буй шүүгчийн тоо	Зөрүү	
1	Эрүү	Нийслэл	15.2	15	0.2
		Аймаг	54.8	55	-0.2
	Орхон, Дархан-Уул	6.2	6	0.2	
2	Иргэн	Нийслэл	15.2	14	1.2
		Орхон, Дархан-Уул	7.4	6.1	1.3
3	Захиргаа	Улс	12.4	11.7	0.7
Дүн			111.2	107.8	3.4

Хүснэгт 93. ДЗШШ-д ажиллаж буй шүүгчийн тооны зөрүү

2017-2021 оны дунджаар 34-р шалгуур үзүүлэлтийн цалингийн сан дээрх шүүгчийн тоо нийслэлийн ДЗШШ-д 15.2 шүүгч ажилласан гэсэн мэдээ өгсөн байна. Шалгуур 3-ын бодит ажилласан шүүгчийн тоо 15 гэсэн мэдээ өгсөн байна. Зөрүүний 0.2-ыг дараах утгаар тайлбарлана. Нийслэлийн ДЗШШ-д ажилласан 15.2 шүүгчдийн хувьд жилд чөлөө авах, өвчтэй байх, томилолтоор ажиллах, суралцахаар явах гэх мэт шалтгаантай өдрүүдийг нэмж тооцоход нэг шүүгч 0.2 жил ажилласан хэмжээний зөрүү гарч байна. **Хүснэгт 93**-н нийт дүнгийн хувьд ДЗШШ-д цалингийн сан дээрх шүүгчийн тооны мэдээгээр 111.2 шүүгч ажилласан байна. Ажилласан шүүгчийн тооны мэдээгээр 107.8 шүүгч ажилласан байна. ДЗШШ-д ажилласан 111 шүүгчдийн хувьд жилд чөлөө авах, өвчтэй байх, томилолтоор ажиллах, суралцахаар явах гэх мэт шалтгаантай өдрүүдийг нэмж тооцоход 3.4 шүүгч нэг жилд ажиллаагүй гэсэн зөрүү гарч байна.

№	Шүүх	Цалингийн сан дээрх шүүгчийн тоо	Ажиллавал зохих шүүгчийн тоо	Зөрүү	Нэг шүүгчийн цалин (сая.төг)	Нийт цалингийн сангийн хэмжээ (сая.төг)	
1	Эрүү	Нийслэл	15.2	30	14.8	46.9	694.1
		Аймаг	54.8	31.3	-23.5	46.5	-1092.8
		Орхон, Дархан-Уул	6.2	4.5	-1.7	51.2	-87.0
2	Иргэн	Нийслэл	15.2	23	7.8	45.7	356.5
		Орхон, Дархан-Уул	7.4	2.7	-4.7	43.6	-204.9
3	Захиргаа	Улс	12.4	28.1	15.7	40.7	639.0
Дүн		-	111.2	119.6	8.4	-	304.9

Хүснэгт 94. ДЗШШ-д ажиллавал зохих шүүгчийн тоо, цалингийн сан, хувилбаргүй

2017-2021 оны дунджаар 34-р шалгуур үзүүлэлтийн цалингийн сан дээрх шүүгчийн тоо нийслэлийн ДЗШШ-д 15.2 шүүгч ажилласан гэсэн мэдээ өгсөн байна. 4-р бүлгийн судалгааны үр дүнгээр ажиллавал зохих шүүгчийн тооны 30 гэж тооцсон. Ажиллавал зохих шүүгчийн тооноос нийслэлийн ДЗШШ-д ажилласан шүүгчдийн тоог хасахад 14.8 шүүгч нэмж авах шаардлагатай бөгөөд нийслэлийн ДЗШШ-д ажиллах нэг шүүгчийн нэг жилийн цалин 46.9 сая төгрөг байна. Нийслэлийн ДЗШШ-д 14-15 шүүгч нэмж ажиллуулна гэвэл нийт 694.1 сая төгрөгийн төсөв хэрэгтэй байна. Гэвч АДЗШШ-д 1092.8 сая төгрөг, Орхон, Дархан-Уул АЭХДЗШШ-д 87.0, Дархан-Уул АИХДЗШШ-д 204.9 сая төгрөгийн үргүй зардал гарч байна. Эдгээр үргүй зардлын нийт хэмжээ 745.7 сая төгрөг байна. Нэмэх шаардлагатай санхүүжилт 1689.6 сая төгрөг байна. Үргүй урсаж байгаа хэсгийн зардлыг зөв зохион байгуулж чадах, өөрөөр хэлбэл шүүгчийн тоог зохистой хэмжээнд өөрчилсний дараа ДЗШШ-д 8 шүүгч нэмж авч ажиллуулбал 304.9 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт шаардлагатай болж байна.

3.3. Шүүхийн ерөнхий санхүүжилт

№	Шүүх шат	Хэргийн шүүх	Цалингийн сан дээрх шүүгчийн тоо	Ажиллаж буй шүүгчийн тоо	Зөрүү
1	Анхан шат	Эрүү	147.9	141.7	6.2
		Зөрчил	6	6	0
		Иргэн	183.1	153.9	29.2
		Захиргаа	70.6	72.5	-1.9
2	Давж заалдах шат	Эрүү	76.2	76	0.2
		Иргэн	22.6	20.5	2.1
		Захиргаа	12.4	11.7	0.7
Дүн			518.8	482.3	36.5

Хүснэгт 95. Шүүхэд ажиллаж буй шүүгчийн тооны зөрүү

2017-2021 оны дунджаар 34-р шалгуур үзүүлэлтийн цалингийн сан дээрх шүүгчийн тоо ЭХАШШ-д 147.9 шүүгч ажилласан гэсэн мэдээ өгсөн байна. Шалгуур 3-ын бодит ажилласан шүүгчийн тоо 141.7 гэсэн мэдээ өгсөн байна. Зөрүүний 6.2-ыг дараах утгаар тайлбарлана. ЭХАШШ-д ажилласан 147.9 шүүгчдийн хувьд жилд чөлөө авах, өвчтэй байх, томилолтоор ажиллах, суралцахаар явах гэх мэт шалтгаантай өдрүүдийг нэмж тооцоход жилд 6.2 шүүгчээр дутуу ажилласан хэмжээний зөрүү гарч байна. **Хүснэгт 95-ийн** нийт дүнгийн хувьд АШШ, ДЗШШ-д нийт цалингийн сан дээрх шүүгчийн тооны мэдээгээр 518.8 шүүгч ажилласан байна. Бодит ажилласан шүүгчийн тооны мэдээгээр 482.3 шүүгч ажилласан байна. АШШ, ДЗШШ-д ажилласан 519 шүүгчдийн хувьд жилд чөлөө авах, өвчтэй байх, томилолтоор ажиллах, суралцахаар явах гэх мэт шалтгаантай өдрүүдийг нэмж тооцоход жилд 36.5 шүүгчээр дутуу ажилласан гэсэн зөрүү гарч байна.

№	Шүүх шат	Хэргийн шүүх	Цалингийн сан дээрх шүүгчийн тоо	Ажиллавал зохих шүүгчийн тоо	Зөрүү	Нэг шүүгчийн цалин (сая.төг)	Нийт цалингийн сангийн хэмжээ (сая.төг)
1	Анхан шат	Эрүү	147.9	166	18.1	37.2	673.3
		Зөрчил	6	10	4.3	37.2	148.8
		Иргэн	183.1	196.3	13.2	35.3	466.0
		Захиргаа	70.6	48.4	-22.2	34.9	-774.8
2	Давж заалдах шат	Эрүү	76.2	65.8	-10.4	48.2	-501.3
		Иргэн	22.6	25.7	3.1	44.7	138.6
		Захиргаа	12.4	28.1	15.7	40.7	639.0
Дүн			518.8	540.3	21.5	-	789.6

Хүснэгт 96. Шүүхэд ажиллавал зохих шүүгчийн тоо, цалингийн сан, 1-р хувилбар

2017-2021 оны дунджаар 34-р шалгуур үзүүлэлтийн цалингийн сан дээрх шүүгчийн тоо ЭХАШШ-д 147.9 шүүгч ажилласан гэсэн мэдээ өгсөн байна. 4-р бүлгийн судалгааны үр дүнгээр ажиллавал зохих шүүгчийн тооны 1-р хувилбарыг 166 гэж тооцсон. Ажиллавал зохих шүүгчийн тооноос цалингийн сан дээрх шүүгчийн тоог хасахад 18.1 шүүгч нэмж авах шаардлагатай бөгөөд ЭХАШШ-д ажиллах нэг шүүгчийн нэг жилийн цалин улсын дунджаар 37.2 сая төгрөг байна. ЭХАШШ-д 18 шүүгч нэмж ажиллуулна гэвэл нийт 673.3 сая төгрөгийн төсөв хэрэгтэй байна. Гэвч АЗХАШШ-д -774.8 сая төгрөг, ЭХДЗШШ-д -501.3 сая төгрөгийн үргүй зардал гарч байна. Эдгээр үргүй зардлын нийт хэмжээ 1276.1 сая төгрөг байна. Нэмэх шаардлагатай санхүүжилт 2065.7 сая төгрөг байна. Үргүй урсаж байгаа хэсгийн зардлыг зөв зохион байгуулж чадах, өөрөөр хэлбэл шүүгчийн тоог зохистой хэмжээнд өөрчилсний дараа АШШ, ДЗШШ-д нийт 21-22 шүүгч нэмж авч ажиллуулбал 789.6 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт Монгол улсын шүүхэд шаардлагатай болж байна.

№	Шүүх шат	Хэргийн шүүх	Цалингийн сан дээрх шүүгчийн тоо	Ажиллавал зохих шүүгчийн тоо	Зөрүү	Нэг шүүгчийн цалин	Нийт цалингийн сангийн
---	----------	--------------	----------------------------------	------------------------------	-------	--------------------	------------------------

						цалин (сая.төг)	хэмжээ (сая.төг)
1	Анхан шат	Эрүү	147.9	176	28.1	37.2	1045.3
		Зөрчил	6	10.3	4.3	37.2	160.0
		Иргэн	183.1	212.8	29.7	35.3	1048.4
		Захиргаа	70.6	48.4	-22.2	34.9	-774.8
2	Давж заалдах шат	Эрүү	76.2	65.8	-10.4	48.2	-501.3
		Иргэн	22.6	25.7	3.1	44.7	138.6
		Захиргаа	12.4	28.1	15.7	40.7	639.0
Дүн			518.8	567.1	48.3	-	1755.2

Хүснэгт 97. Шүүхэд ажиллавал зохих шүүгчийн тоо, цалингийн сан, 2-р хувилбар

2017-2021 оны дунджаар 34-р шалгуур үзүүлэлтийн цалингийн сан дээрх шүүгчийн тоо ЭХАШШ-д 147.9 шүүгч ажилласан гэсэн мэдээ өгсөн байна. 4-р бүлгийн судалгааны үр дүнгээр ажиллавал зохих шүүгчийн тооны 2-р хувилбарыг 176 гэж тооцсон. Ажиллавал зохих шүүгчийн тооноос цалингийн сан дээрх шүүгчийн тоог хасахад 37.2 шүүгч нэмж авах шаардлагатай бөгөөд ЭХАШШ-д ажиллах нэг шүүгчийн нэг жилийн цалин улсын дунджаар 37.2 сая төгрөг байна. ЭХАШШ-д 28 шүүгч нэмж ажиллуулна гэвэл нийт 1045.3 сая төгрөгийн төсөв хэрэгтэй байна. Гэвч АЗХАШШ-д -774.8 сая төгрөг, ЭХДЗШШ-д -501.3 сая төгрөгийн үргүй зардал гарч байна. Эдгээр үргүй зардлын нийт хэмжээ 1276.1 сая төгрөг байна. Нэмэх шаардлагатай санхүүжилт 3031.3 сая төгрөг байна. Үргүй урсаж байгаа хэсгийн зардлыг зөв зохион байгуулж чадах, өөрөөр хэлбэл шүүгчийн тоог зохистой хэмжээнд өөрчилсний дараа АШШ, ДЗШШ-д нийт 48 шүүгч нэмж авч ажиллуулбал 1755.2 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт Монгол улсын шүүхэд шаардлагатай болж байна.

3.4. Өөрчлөн байгуулах, байршлыг тогтоох шаардлагатай шүүхүүд

ARCGIS видео болон Дорнод аймгаас татсан дендрограмтай танилцсаны үндсэн дээр хууль эрхзүйн мэдлэгтэй, шүүхийн удирдлагын туршлагатай, салбарын онцлогийг мэддэг баг судалгааны ажлын дүгнэлтийг үндэслэн шүүхийг өөрчлөн байгуулах, байршлыг тогтоох шаардлагатай шүүхүүд дээр шийдвэр, бодлого боловсруулахаар санал болгож байна.

ДӨРӨВ. ДАГНАСАН ШҮҮХ БАЙГУУЛАХ ХҮРЭЭНД

Дүүргийн хувьд: Шинжилгээнд ирүүлсэн өгөгдлөөс харахад маргааны төрлийн хувьд шүүхийг дагнан байгуулахаас илүүтэй төвийн 6 дүүргийн хэмжээнд бага үнийн дүнтэй нэхэмжлэлийг шийдвэрлэх шүүхийг байгуулах, энэ төрлийн нэхэмжлэлээс үүсэх ачааллыг тусад нь дагнан гаргах нь нийт хэргийг шийдвэрлэх ачааллаас хөнгөлөх, бага үнийн дүнтэй хэргийг хөнгөн хялбар байдлаар шийдвэрлэх боломжийг олгохоор байна.

Бага үнийн дүнтэй нэхэмжлэл дээр Сонгинохайрхан, Баянзүрх дүүргүүдэд судалгааны дүнг үндэслэн иргэний хэргийн анхан шатны шүүхэд бага үнийн дүнтэй хэргийг шийдвэрлэдэг шүүгч нэмэх (шүүх байгуулах) талаар судлах хэрэгтэй.

Аймгийн хувьд: Шинжилгээнд ирүүлсэн өгөгдлөөс харахад аймаг, сум дундын шүүх тус бүрд бага үнийн дүнтэй нэхэмжлэлийг хүлээн авах шаардлагагүй. Бага үнийн дүнтэй нэхэмжлэхийн хувьд шүүгчийн ачааллыг тэнцвэржүүлж, дагнасан бага үнийн дүнтэй шүүхийг зохион байгуулснаар уг хэргийг хөнгөн, хялбар байдлаар шийдвэрлэх боломж харагдаж байна.

Хэнтий, Дорнод аймгийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд хэрэв судалгааны үр дүнг үндэслэн шүүгч нэмэхээр болвол бага үнийн дүнтэй хэргийг шүүгчээр ажилуулбал иргэний хэргийн анхан шатны шүүхэд ирэх хэргийн ачаалал багасна.

Орхон, Дархан-Уул аймгийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд хэрэв судалгааны үр дүнг үндэслэн шүүгч нэмэхээр болвол бага үнийн дүнтэй хэргийг шүүгчээр ажилуулбал иргэний хэргийн анхан шатны шүүхэд ирэх хэргийн ачаалал багасна.

САНАЛ

Нэг. Хэргийн болон ажиллагааны ачааллын хүрээнд

1.1. Хэргийн ачааллын хувьд:

1. Шалгуур үзүүлэлтэд дурдсан хэргийн ачаалал, шүүхийн ачаалал, шүүгчийн ажлын ачаалал гэх зэргээр ачаалалд хамаарах ойлголтуудыг оновчтой тодорхойлох;
2. Тухайн ачаалалд ямар ажлууд хамаарах, тэдгээрийн үзүүлэлт нэг бүрийг тодорхой заах, өгөгдөл, үзүүлэлтийн загвар маягтуудыг батлах;
3. Мэдээллийг цуглуулах давтамж, хугацааг нарийвчлан заах, өгөгдөл, үзүүлэлтийг анхан шатны мэдээлэгч болон шүүхийн захиргааны байгууллага хоорондоо нэг мөр ойлгож хэрэглэх, хэвшүүлэх.

1.2. Ажиллагааны ачааллын хувьд:

1. Ажиллагааны ачаалалд хамаарах өгөгдөл, үзүүлэлтийг хэргийн төрөл мөн шүүхийн тогтолцоо, нутаг дэвсгэрийн онцлог, эрх зүйн зөрчлийн гаралт, онцлогийг харгалзан тус тусад нь боловсруулах;
2. Ажиллагааг тоогоор, хугацаагаар, хуудас цаасаар, давтамжаар гэх зэргээр ямар хэмжээс, хэмжигдэхүүнээр илэрхийлэхийг тодорхой заах.

Хоёр. Шүүх байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, байршлыг тогтоох хүрээнд

- 2.1.4-р бүлгийн тооцоонд гарсан дутагдалтай шүүгчийн орон тоог тухайн шүүхийн үйл ажиллагаатай бодитоор танилцаж ажлын байрны нөхцөл байдлыг тодорхойлсны дараа батлах
- 2.2. Тухайн шүүх болон тухайн хэргийн шүүгчийн ажлын онцлогийг нягт сайн мэддэг хууль эрх зүйн мэдлэгтэй удирдлагын багийн дунд судалгааны ажлын тооцоо, дүгнэлтийг хэлэлцэж шийдвэр гаргах
- 2.3. Шинжлэх ухааны үндэслэлтэй онол, аргагүй, програмын үр дүн, тооцоог шүүхийн болон шүүгчийн бодит үйл ажиллагаатай хэр зэрэг уялдаатай байгааг хянаж үзсэний дараа шүүхийн үйл ажиллагааны эргэлтэд оруулах
- 2.4. Тухайн шүүхүүдийн байрлаж буй бүс нутгийн онцлог, хэтийн төлөвийг харгалзан үзэж судалгааны ажлын дүгнэлттэй харьцуулах замаар бодлого шийдвэрээ тодорхойлох
- 2.5. Тухайн шүүхийн үйл ажиллагааны тухай тооны хэл дээр буулгасан дүр зураг гэдэг талаас нь харгалзан үзэж бодлого шийдвэр гаргахдаа мэргэжлийн үүднээс зөвөөр холбох.
- 2.6. Шүүгчийн орон тоог нэмж зарлах эсвэл шүүгч илүүдэлтэй байгаа хэсгээс шүүгчийг татахдаа ялангуяа төвийн 6 дүүргийн хэмжээнд ажлын өрөө, хуралдааны заалны хүрэлцээг харгалзан, ажлыг үе шаттай зохион байгуулах;
- 2.7. Орон нутгийн шүүхэд ажиллах шүүгчийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулахдаа ялангуяа захиргааны хэргийн шүүгчийн хувьд шийдвэрлэсэн хэргийн тоо маш байгаа онцлогийг харгалзан магадгүй өөр хэргийг хянан шийдвэрлэхэд бүрэлдэхүүнээр орох зэрэг байдлаар ачаалал ихтэй хэсгийн ачааллаас хуваалцах, хэд хэдэн төрлийн хэргийг шийдвэрлэх бодит нөхцлийг тооцох;

- 2.8. Орон нутгийн шүүхээс ачааллыг харгалзан шүүгчдийг татан авах тохиолдолд бүрэлдэхүүнтэй хуралдааны тоо, давтамжийн мэдээллийг харгалзах, томилолтын зардал, төсвийн зарцуулалтыг тооцох;
- 2.9. Ачаалал багатай хэсэгт ажиллаж байгаа шүүгчдийг шүүхийн сургалт, захиргааны ажилтны сургалтад багшлуулах, гарын авлага, хөтөлбөр боловсруулах, эрх зүйн онол, шүүх эрх мэдэл, шүүхийн практик болон шүүхийн шийдвэрийн шүүмж судлал зэрэг чиглэлд татан авч оролцуулах, ажиллуулах, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийлгэх зэргээр хөгжүүлэх, үр ашигтай ажиллуулах.

Гурав. Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 58 дугаар тогтоолоор батлагдсан шалгуур үзүүлэлт, түүнд хамаарах өгөгдлийн хүрээнд

Шалгуур 34 үзүүлэлт, түүний хүрээнд цугларсан өгөгдлийг судлан үзэхэд бүтэц болон агуулга талаас дараах саналыг өгөх боломжтой байна.

3.1. Бүтцийн хувьд:

1. Мэдээллийн бааз бүрдүүлэх, түүнийгээ баяжуулах, шинжлэх зэрэг асуудалтай холбоотойгоор тайлангийн хавсралт 6-д заасан маягтын загвараар мэдээллээ тогтсон давтамжийн хүрээнд цуглуулах, нэгтгэх;
2. Шүүхийн тогтолцоо, хэргийн төрөл, шүүгч, шүүхийн захиргааны ажилтны гүйцэтгэж буй ажлын төрөл бусад өгөгдөлд нэгжүүдээ тодорхойлж, нэгжүүдийн дараалал динамикийн хувьд ижилхэн байхаар мөр болон баганын хувьд үзүүлэлтийг жигдлэх;
3. Динамикаар харуулж буй мэдээлэл дарааллын хувьд багаасаа ихэссэн байх;
4. Өгөгдлийг өөрчлөх, баяжуулахдаа агуулгын хувьд хавсралтад ангилсан загварууд шиг тухайн бүлэг (багц)-г нь багтаах.

3.2. Агуулгын хувьд:

1. Статистик мэдээлэл үнэн, зөв байх хуулийн болон Олон улсын аргачлалаар цуглуулж, нэгтгэсэн өгөгдөл бүрдүүлэх;
2. Статик болон динамик үзүүлэлтээр бааз үүсгэхдээ албан ёсны эх сурвалжаас авах, байгууллагын албан ёсны болон захиргааны статистик мэдээллийг баланс тулгаж, хянасан байх;
3. Бусад статистик өгөгдлийг боловсруулахдаа мэдээллийн хэд хэдэн эх сурвалжийг ашиглаж, дүнг тулгаж зөрөөг арилгах;
4. Шалгуурын хүрээнд яг ямар нэгжид задарсан, хэдэн жилийн динамиктай өгөгдөл байх талаар тодорхой тайлбар өгч жагсаалт гаргасан, эсвэл загвар маягтыг үйлдсэн байх;
5. Шалгуур хоорондын уялдаа холбоог тайлбар хэсэгт тодорхой заах;
6. Хэрэг, хүн, шүүгч, төгрөг, цаас, хуудас, ширхэг гэх мэт олон төрлийн хэмжигдэхүүн бүхий өгөгдлүүд байгаа тул хэмжих нэгжийг үзүүлэлт бүрд тэмдэглэсэн байх, их тайлбартай талбарын нэршлийг кодолж олон улсын жишигт нийцүүлэх;
7. Давтагдсан олон шалгуурыг нэгтгэж ижил шинж тэмдгээр нь бүлэглэлт үүсгэж, судлаач болон шинжилгээ хийхэд хялбар байх боломжийг бүрдүүлэх;
8. Шалгуур 1 нь их өргөн хүрээний ойлголт байх тул шалгуур гэдэг агуулгадаа нийцэх эсэхийг эргэн харах;

9. Шалгуур 3, 26, 28-д яг ямар үзүүлэлт, өгөгдөл хамаарах талаар агуулга, ойлголт тодорхой бус тул тодорхойлсны дараа шалгуур болгох, аль нэг шалгуурт тайлбарыг нь тодорхой өгөх байдлаар багтаах, мөн эдгээрийн хүрээнд шалгуур 4-г багтаах;
10. Ажиллагаа гэдэгт юуг хамааруулахыг тодорхой болгож, шалгуур 2, 5, 7, 8, 9-г ажиллагаа эсвэл ачааллын шалгуурт агуулгаар нь багтаах;
11. Шалгуур 6-г санхүү, төсөвт хамаарах шалгууруудтай хамт дарааллын хувьд нэг хэсэгт багтаах;
12. Шалгуурт багтаж байгаа 2 болон түүнээс дээш өгөгдлийн харьцаа, тооцооллоор гарах үзүүлэлтийг тусад нь шалгуур болгож, давталт үүсгэхгүй байх;



ЗӨВЛӨМЖ

Судалгааны ажил бүх шүүхүүдийг хамарсан нэлэнхүй ажиглалтын өгөгдөл тул зарим ажиллагаатай холбоотой чухал мэдээлэл орхигдсон ч бодит тоон утгын дүгнэлтэд нөлөөлөхүйц хэмжээнд хүрэхгүй тул тоон өгөгдлийн тоон утгын тайлбарыг тайланд өгснөөр ойлгож болно.

Гэхдээ эрүү, иргэн, захиргааны хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн үйл ажиллагааг хянан шийдвэрлэсэн хэргийн тоо, хэрэгтэй холбоотой баримт материалын тоогоор тооцож харуулсан нь тухайн шүүхүүдийн үйл ажиллагааны онцлог, хэргийн бүтэц, хэргийг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны чанар зэргийг орхигдуулсан байх талтай тул шүүхүүдийн бодит үйл ажиллагаатай ил тод болон нууц хэлбэрээр танилцах түүвэр явуулсаны дараа судалгааны ажлын дүгнэлттэй харьцуулан үзэх нь оновчтой шийдвэр байх болно.

Хянан шийдвэрлэсэн хэргийн тоогоор өндөр дүнтэй ч ажлын чанарын тал учир дутагдалтай эсвэл чанартай үйл ажиллагаа явуулдаг шүүх байхыг үгүйсгэх аргагүй юм. Шүүхийн хүний нөөц, шүүгчийн ачааллаас гадна шүүх ба шүүгчийн ажлын чанарыг үнэлж эрэмбэлж үзэх судалгааг хийх нь чухал юм. Энэ нь шүүх ба шүүгчийг чадваржуулах үнэтэй арга, санааг олох боломжийг бүрдүүлж магадгүй юм.

Захиргааны хэргийн шүүхийн үйл ажиллагааны онцлогийг харуулах өгөгдөл, үзүүлэлтийг тодорхойлж, бааз бүрдүүлэх, судалгааны эргэлтэд оруулах нь зүйтэй байна. Мөн Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүх нь нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд захиргааны хэргийн хариуцагчид хамаарах захиргааны маргааныг шийдвэрлэж буй тул нэхэмжлэгч, хариуцагчийн харьяалах дүүргийн мэдээллийг харах, өгөгдлийг энэ талаас нь шинжлэх, дүгнэх нь захиргааны хэргийн шүүхийн өөрийн мөн чанарт илүүтэй нийцэхээр байна.

Нийслэл дэх захиргааны хэргийн шүүхийг нийслэлийн хэмжээнд ганц байхаар зохион байгуулсан байгаа нь энэ шүүхийн шүүгчдийн нэг шүүгчид ногдох ачааллыг улсын дундаж хэмжээнээс өндөр хэмжээнд хүргэж, тухайн шүүх өөр эн зэрэгцэх ижил шатны шүүхтэй үйл ажиллагаа нь харьцуулагдах, хөгжих, чанаржих боломжгүй нөхцөл байдлыг бүрдүүлж байна. Мөн энэ байдал Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн хувьд ч нэгэн адил ажиглагдлаа.

Ажиллагааны ачааллыг ерөнхий шүүгч, ерөнхий шүүгчийн туслах, шүүгч, шүүгчийн туслах, нарийн бичгийн дарга, эвлэрүүлэн зуучлагч гэх мэтээр шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа субъект бүрээр тодорхой тооцох шаардлагатай эсэх асуудлыг эхний ээлжид тодорхойлох нь зүйтэй байна.

Ажиллагаа өндөр дүнтэй байгаа хэргийн төрөл болох иргэний хэрэг шийдвэрлэх ажиллагаанд шүүгч, туслахын гүйцэтгэж байгаа чиг үүргийг тодорхойлж, техник ажиллагаа ихээр шаардсан ажиллагаанд шүүгчээс гадна туслахын орон тоог нэмэгдүүлэх нь хүний нөөцийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлэх, шүүхийн төсвийг үр ашигтай зарцуулахад ач холбогдолтой байх талтай юм. Мөн ажиллагаа өндөртэй хэргийн төрөл, шүүхүүдийн хувьд шүүхийн үйл ажиллагааг цахимжуулах эрх зүйн орчин, бааз, бодлогын шийдэл үгүйлэгдэж байна.

Аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхийн нэг шүүгч нь хянан шийдвэрлэсэн хэргийн дүн маш бага байгаа хэдий ч захиргааны хэргийн ажиллагааны дүнгээрээ сум дундын эрүү, иргэн, зөрчлийн хэргийг хамтад нь шийдвэрлэдэг шүүгчийн ажиллагааны ачаалалтай ойрхон дүнтэй байна. Энэ нь аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хамгийн багадаа 1 шүүгч заавал ажиллах шүүхийн үйл ажиллагаа, хэрэгцээ

шаардлага практикт байгааг харуулж байна. Шүүхийг өөрчлөн байгуулах асуудалд захиргааны хэргийн шүүхийн үйл ажиллагааны энэ онцлог нөхцөл байдлыг харгалзах нь зүйтэй юм.

Энэхүү шинжилгээгээр анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчдийн бодит ачааллыг тооцож, шүүхийн тогтолцоо бүрд, хэргийн төрөл тус бүрийг хянан шийдвэрлэж байгаа шүүгчдийн хувьд нэг шүүгчийн нэг жилд хянан шийдвэрлэх хэргийн тоог тогтоож өгсөн. Ингэснээр шүүхийн захиргааны байгууллагын хүлээсэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэвийн, тасралтгүй хэрэгжүүлэх нөхцөлөөр хангах чиг үүргийн хэрэгжилт хангагдах төдийгүй хэргийн хөдөлгөөний хурд, менежмент сайжирч, улмаар шүүхийн шийдвэрийн тогтвортой байдлын хэмжээ нэмэгдэж, шүүхийн үйлчилгээ иргэнд чирэгдэлгүй, чанартай хүрэх, шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлэх зэрэг олон эерэг үр дүнг авчрах эерэг талтай юм.

Эсрэгээрээ нэг шүүгчид нэг жилд ногдох хянан шийдвэрлэсэн хэргийн дундаж ачааллыг баримтлан шүүхийг зохион байгуулах, шүүгчийн орон тоог тогтоох, сонгон шалгаруулалт зарлахад шүүхийн байр, дэд бүтэц, хуралдааны заал, захиргааны ажилтны хүрэлцээ, цаашлаад шүүгчийн цалингийн сан, шүүхийн төсвийн асуудлыг давхар анхаарах нь чухал байна. Ялангуяа дүүргийн шүүхэд шаардлагатай байгаа шүүгчийн тоог бүрдүүлэхдээ эхний ээлжид захын дүүргийн эсвэл орон нутагт байгаа илүүдэлтэй шүүгчдээс татан авч ажиллуулах ажлыг зохион байгуулах нь зохимжтой байна.

ШЕЗ-н 58 дугаар тогтоолоор баталсан 34 шалгуур үзүүлэлтийг төрөлжүүлж, зарим нэр томьёо, агуулга, тайлбарыг оновчтой болгох нь зүйтэй байна. Шүүхийн тухай хуулийн 14.3-т заасан харгалзан үзэх үзүүлэлт нь шүүх байгуулах, өөрчлөн байгуулах асуудалд хамааралтай хэдий ч байршлыг тогтоох асуудалд төдийлэн хамаарахгүй байх талтай байна. Учир нь хүн амын нягтрал нь шүүхийн үйл ажиллагааг тодорхойлогч гол хувьсагч биш болох нь шинжилгээнээс тодорхой харагдаж байгаа тул манай улсын үндэсний онцлог болох газар нутгийн алслагдмал байдал, хүн амын суурьшлын онцлог, шүүх төдийгүй хуулийн бусад байгууллагын болон төрийн бусад байгууллагын байршил, бүтэц тогтолцоог харгалзан үзэх нь чухал байна. Ялангуяа эрүүгийн болон зөрчлийн хэрэг, иргэний бүртгэл, газар, татвар, тендер, ашигт малтмалын маргаан гэх зэрэг хэрэг, маргааны төрөл, онцлог нөхцөл байдалтай холбоотойгоор тухайн аймаг, сум нь хүн ам багатай, нутаг дэвсгэрийн хэмжээ жижигхэн байлаа ч шүүх байгууллага байхаас аргагүй нөхцөлтэй байгааг анхаарч үзэх нь зүйтэй.

Зөрчлийн хэрэг жилээс жилд нэмэгдэж, бүртгэх, хянах, шийдвэрлэх ажиллагаа хэвшиж байгаа үед зөрчлийн хэргийг дүүргийн шүүхийн нэг шүүгч дангаараа хариуцаж зарим дүүрэгт энэ төрлийн хэрэг нэг хүний авах ачааллаас давсан өндөр дүнтэй байна. Төвийн 6 дүүргийн хэмжээнд зөрчлийн хэргийн дагнасан шүүхийг байгуулах бодит хэрэгцээ шаардлага үүссэнийг анхаарах нь зүйтэй юм. Мөн төвийн 6 дүүргийн эрүүгийн хэрэг, иргэний хэргийн шүүгчдийн ачаалал нийтлэг байдлаар их байгаа тул эрүүгийн хэргээс хөнгөн гэмт хэргийг, иргэний хэргээс бага үнийн дүнтэй хэргийг шийдвэрлэх шүүхийг дагнан байгуулах нь эдгээр шүүхийн нэг шүүгчид ирэх ачааллыг бууруулах бодит алхам болох нь дамжиггүй байна.

ХАВСРАЛТ

ХАВСРАЛТ А.

ШАЛГУУР 2. Хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулсан хугацаа, өдрөөр

Утга	Бүс	Шүүх	Төрөл	Бүс Шүүх	Шүүх Төрөл
MAX	×	Анхан 831.4	Эрүү 117.6	×	Анхан Эрүү 173.4
					Анхан Иргэн 1469.8
	×	Давах 423.8	Иргэн 1127.8		Анхан захиргаа 850.8
			Захиргаа 850.8		Давах Эрүү 61.8
					Давах Иргэн 785.8
MIN	×	Анхан 1.2	Эрүү 3.1	×	Анхан Эрүү 0.8
					Анхан Иргэн 1.0
		Давах 3.7	Иргэн 1.5		Анхан захиргаа 1.7
					Давах Эрүү 5.5
			Захиргаа 1.7		Давах Иргэн 2.0
MEAN	×	Анхан 51.3	Эрүү 15.5	×	×
			Иргэн 43.9		
		Давах 30.5	Захиргаа 95.9		

Хүснэгт А.1. Хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулсан хугацаанд хийсэн дисперсийн шинжилгээний үр дүн (Аймаг дахь сум дундын шүүх)

Утга	Бүс	Төрөл	Бүс Төрөл
MAX	×	Эрүү 99.2	×
		Иргэн 1113.0	
MIN	×	Төв 0.9	×
		Зүүн 2.2	
		Баруун 0.8	
		Хангай 0.5	
MEAN	×	Эрүү 10.8	×
		Иргэн 43.5	

Хүснэгт А.2. Хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулсан хугацаанд хийсэн дисперсийн шинжилгээний үр дүн (Сум дундын шүүх)

Үүнд: ×- нөлөөлөлгүй, – - тооцоо хийгдэхгүй

ШАЛГУУР 5, 7. Шүүх хуралдааны дундаж тоо, шүүх хуралдаанд биечлэн оролцсон оролцогчийн дундаж тоо

Шүүх	Анхан				Давах			
	Товлосон		Хойшилсон		Товлосон		Хойшилсон	
	Бүс	Динамик	Бүс	Динамик	Бүс	Динамик	Бүс	Динамик
Иргэн	хангай 1035.1	×	хангай 184.5	×	×		төв 10.9	
	зүүн 483.0		зүүн 48.5			×	зүүн 3.3	×
Эрүү	хангай 705.5	•	хангай 169.3	×	–		–	–
	төв 285.5		Зүүн 48.7			–		–
Захиргаа	баруун 137.5	×	баруун 48.8	×	–	–	–	–
	зүүн 60.0		зүүн 14.6					

Хүснэгт А.3. Шүүх хуралдааны дундаж тоонд хийсэн дисперсийн шинжилгээний үр дүн (аймаг дахь болон сум дахь сум дундын шүүх)

Шүүх	Анхан				Давах			
	Бүс	Динамик	Бүс	Динамик	Бүс	Динамик	Бүс	Динамик
Иргэн	×	•	×		баруун 122.40	•	баруун [2022], 225.80	
					зүүн 46.78		баруун [2020], 39.6	

Эрүү	×	•	×	×	•	×
Захиргаа	×	•	баруун [2021],199.3	–	–	–
			баруун [2022],24.4			

Хүснэгт А.4. Шүүх хуралдаанд биечлэн оролцсон оролцогчийн дундаж тоонд хийсэн дисперсийн шинжилгээний үр дүн

Үүнд: • - нөлөөлөлтэй, ×- нөлөөлөлгүй, – - тооцоо хийгдэхгүй

ШАЛГУУР 12-15. Хүн амын тоо, нутаг дэсгэрийн хэмжээ, нягтрал

Бүс	№	Аймаг, сумдын нэр	Нягтралын хэмжээ км2, хүн	Нягтрал багатай	Дундаж нягтралтай	Нягтрал ихтэй
Баруун бүс	1	Завхан	2.0	+		
	2	Тосонцэнгэл	1.1	+		
	3	Говь-Алтай	0.4	+		
	4	Баян-Өлгий	2.3	+		
	5	Ховд	1.2	+		
	6	Ховдын Булган	1.7	+		
	7	Увс	1.2	+		
Хангайн бүс	8	Орхон	13.9			+
	9	Өвөрхангай	1.07	+		
	10	Хархорин	1.5	+		
	11	Булган	1.3	+		
	12	Баянхонгор	0.8	+		
	13	Архангай	1.7	+		
	14	Хөвсгөл	1.3	+		
	15	Төв	1.3	+		
Төвийн бүс	16	Говьсүмбэр	3.2		+	
	17	Сэлэнгэ	0.7	+		
	18	Мандал	0.3	+		
	19	Сайхан	0.5	+		
	20	Дорноговь	4.0		+	
	21	Замын-Үүд	4.1		+	
	22	Дархан	32.1			+
	23	Өмнөговь	4.9		+	
	24	Ханбогд	3.4		+	
	25	Дундговь	0.6	+		
Зүүн бүс	26	Дорнод	0.7	+		
	27	Сүхбаатар аймаг	0.8	+		
	28	Хэнтий	1.6	+		
	29	Бор-Өндөр	1.7	+		

Хүснэгт А. 5. Аймаг дахь болон сум дундын шүүхүүдийн байрлах нутаг дэвсгэрийн хүн амын нягтрал

ШАЛГУУР 16. Аймаг дахь болон сум дундын шүүхүүдийн төвөөс сум хоорондын зай

Бүс	№	Аймаг, сум дундын шүүх хоорондын зай	Ойр зайтай сум	Дундаж зайтай сум	Хол зайтай сум
Баруун бүс	1	Завхан	Цагаанхайрхан, Яруу, Идэр	Цагаанчулуут, Шилүүстэй, Отгон, Эрдэнэхайрхан, Завханмандал, Дөрвөлжин	Алдархаан(332км), Сантмаргаз, Сонгино, Ургамал

	2	Тосонцэнгэл	Түдэвтэй, Тэлмэн, Нөмрөг	Их-Уул, Асгат, Баянхайрхан	Тэс, Баянтэс
	3	Говь-Алтай	Тайшир, Халиун, Шарга, Дэлгэр, Жаргалан, Бигэр, Баян-Уул	Төгрөг, Цээл, Цогт, Чандмань	Алтай(318км), Дарви, Хөхморьт, Тонхил, Эрдэнэ, Бугат
	4	Баян-Өлгий	Бугат, Сагсай, Улаанхус, Алтанцөгц	Цагааннуур, Цэнгэл, Толбо,Буянт	Булган(320км), Ногооннуур, Баяннуур, Дэлүүн, Алтай
	5	Ховд	Буянт, Ховд, Мянгад, Эрдэнэбүрэн	Дуут, Манхан, Дөргөн	Дарви, Зэрэг, Мөнххайрхан, Чандмань
	6	Ховдын Булган	Үенч, Алтай	Цэцэг	Мөст
	7	Увс	Тариалан, Түргэн, Сагил, Наранбулаг, Малчин	Өмнөговь, Өлгий, Давст, Тэс, Зүүнговь, Хяргас, Завхан, Ховд	Цагаанхайрхан, Өндөрхангай, Зүүнхангай
Хангайн бүс	8	Орхон	Жаргалант(32км)		
	9	Өвөрхангай	Тарагт, Зүүнбаян- Улаан, Уянга, Баянгол, Хайрхандулаан	Гучин-Ус, Нарийнтээл, Сант,Төгрөг	Богд, Баруунбаян- Улаан
	10	Хархорин	Бат-Өлзий	Баян-Өндөр,Бүрд, Есөнзүйл	Өлзийт, Хужирт
	11	Булган	Орхон, Хишиг- Өндөр, Бүрэгхангай, Булган	Могод, Гурванбулаг, Сайхан, Дашинчилэн, Хангал, Сэлэнгэ, Хутаг-Өндөр, Баян-Агт	Рашаант, Баяннуур, Тэшиг
	12	Баянхонгор	Галуут, Өлзийт, Эрдэнэцогт,Баян- Овоо, Жинст	Бөмбөгөр, Бууцагаан, Заг, Жаргалант, Баацагаан, Богд	Баянговь, Баянцагаан, Шинэжинст, Баянлиг, Баян- Өндөр, Баянбулаг, Хүрээмарал, Гурванбулаг
	13	Архангай	Ихтамир, Хотонт, Төвшрүүлэх,Цэнхэр, Булган, Батцэнгэл	Эрдэнэмандал, Тариат, Өгийнуур, Өлзийт, Өндөр-Улаан,Чулуут	Хашаат, Цэцэрлэг, Цахир, Жаргалант, Хангай, Хайрхан
	14	Хөвсгөл	Төмөрбулаг, Тосонцэнгэл, Бүрэнтогтох,Түнэл, Арбулаг, Алаг- Эрдэнэ	Жаргалант, Галт, Рашаант, Тариалан, Их-Уул, Цагаан-Уул, Шинэ-Идэр, Хатгал, Цагаан-Үүр, Улаан- Уул, Чандмань-Өндөр, Баянзүрх, Эрдэнэбулган	Цэцэрлэг, Ханх, Ренчинлхүмбэ, Цагааннуур
Төвийн бүс	15	Төв	Сэргэлэн, Баян,Эрдэнэ, Алтанбулаг	Баян-Өнжүүл, Баянжаргалан, Баянцагаан, Архуст, Баянчандмань, Баяндэлгэр,Батсүмбэр,	Бүрэн, Дэлгэрхаан, Өндөрширээт, Эрдэнэсант, Цээл, Заамар, Жаргалант Мөнгөнморьт,


			Баянхангай, Борнуур, Баянцогт, Аргалант	Угтаалцайдам, Сүмбэр, Лүн
	16	Говьсүмбэр	Шивээговь, Баянтал	
	17	Сэлэнгэ	Шаамар, Алтанбулаг, Зүүнбүрэн	Түшиг, Хүдэр
	18	Мандал	Баянгол	
	19	Сайхан	Орхон	Орхонтуул
	20	Дорноговь	Алтанширээ, Сайхандулаан,	Хатанбулаг, Хөвсгөл, Мандах
	21	Замын-Үүд	Эрдэнэ, Улаанбадрах	Өргөн
	22	Дархан	Шарын гол, Орхон, Хонгор	
	23	Өмнөговь	Ханхонхор, Хүрмэн	Цогт-Овоо, Мандал- Овоо, Булган, Номгон, Баяндалай
	24	Ханбогд	Манлай	Баян-Овоо
	25	Дундговь	Луус, Гурвансайхан, Дэлгэрцогт, Дэрэн	Өлзийт, Хулд, Дэлгэрхангай, Эрдэнэдалай, Говь- Угтаал, Адаацаг
Зүүн бүс	26	Дорнод	Булган, Сэргэлэн, Чойбалсан, Баянтүмэн	Хөлөнбуйр, Матад, Цагаан-Овоо, Гурванзагал
	27	Сүхбаатар аймаг	Сүхбаатар, Халзан, Уулбаян, Асгат	Мөнххаан, Түмэнцогт, Онгон, Дарьганга, Түвшинширээ, Баяндэлгэр
	28	Хэнтий	Мөрөн, Баянхутаг	Жаргалтхаан, Батноров, Өмнөдэлгэр, Баян-Овоо, Цэнхэрмандал, Баян- Адарга
	29	Бор-Өндөр	Дархан	Галшар
				Баянмөнх

Хүснэгт А.6. Аймаг дахь болон сум дундын шүүхүүдийн төвөөс сум хоорондын зай

Завхан



Говь-Алтай




Ховд




Тосонцэнгэл




Баян-Өлгий



Ховдын Булган



Увс




Өвөрхангай



Хархорин




Булган




Баянхонгор




Архангай




Хөвсгөл



Төв




Говьсүмбэр



Сэлэнгэ




Сайхан




Дорноговь



Замын-Үүд




Дархан



Өмнөговь



Ханбогд



Дундговь



Дорнод




Сүхбаатар




Хэнтий



Бор-Өндөр




Зураг А.1. Аймгуудын дендрограммын үр дүн



Зураг А.2. Дорнод аймгаас 20 аймаг, нийслэл, 8 сум хүртэлх зайн дендрограмм





Зураг А.3. Дорнод аймгаас 20 аймаг, нийслэл хүртэлх зайн дендрограмм



ХАВСРАЛТ Б.

Шалгуур үзүүлэлтээр өгөгдөл цуглуулах маягтын загвар
ШАЛГУУР 1. ШҮҮГЧИЙН ТОО, ОРОЛЦОГЧДЫН ТОО, АНГИЛЛААР

№	Шүүхийн нэр	Батлагдсан орон тоо	Тухайн жилд ажилласан шүүгчийн тоо	Томилолтоор ажилласан шүүгчийн тоо	Шүүхийн захиргааны ажилтан	
					Батлагдсан	Ажилласан
1 дахь Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх					
2 дахь Иргэний хэргийн анхан шатны шүүх					
3 дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх					
4 дахь Эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх					
 дахь Эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх					
 дахь Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх					
 дахь Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх					
ХШШ-н эрүүгийн хэргийн танхим					
ХШШ-н иргэний хэргийн танхим					
ХШШ-н захиргааны хэргийн танхим					

Нэг шүүгчид ногдох хэргийн тоо=Шалгуур 2 (нийт хэрэг)/Шүүгчийн тоо

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 1 шүүгчид ногдох ажиллагааны ачаалал=Шалгуур 2 (эрүү хэрэг)/ Тухайн жилд ажилласан шүүгчийн тоо

Шүүхийн захиргааны ажилтны ажлын ачаалал= Шалгуур 2 (нийт хэрэг)/Захиргааны ажилтны тоо

1 хүн амд ногдох шүүгч=Шүүгчийн тоо/Хүн амын тоо

Хүн амын тоог https://www.1212.mn/Stat.aspx?LIST_ID=976_L03&type=tables авна.

ШАЛГУУР 2. ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГАА, АЙМАГ, ДҮҮРЭГ ТУС БҮРЭЭР, ХЭРГИЙН ТӨРЛӨӨР (ЭРҮҮ, ЗӨРЧИЛ, ИРГЭН ЗАХИРГАА), УЛИРАЛ, ХАГАС БҮТЭН ЖИЛЭЭР

№	Шүүхийн нэр	Шүүх бүрэлдэхүүн	Нийт шүүх хуралдааны тоо	Оролцогчдын тоо	Хэрэг хянан шийдвэрлэх дундаж хугацаа	Давж заалдах шатны шүүхээр хянагдсан	Хяналтын шатны шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн хэрэг					Шалгуур 11 (Дагнасан шүүх)																	
							С1	С2	С3	С4	С5	М1	М2	М3	М4	М5	М6	М7	М8										
Хэрэг	мөрийн дугаар	Хүлээн авсан хэрэг	Шийдвэрлэсэн хэрэг	Дангаараа	Бүрэлдэхүүнтэй	Товолсон	Хойшилсон	Биечлэн оролцсон	Биечлэн оролцоогүй	Хэрэг хянан шийдвэрлэх дундаж хугацаа	хэвээр үлдээсэн	Өөрчлөлт оруулсан	Хүчингүй болгож, буцаасан																
1	Эрүү дахь сум	дундын анхан	шатны шүүх																									
	 давж	заалдах шатны	шүүх																									
		Хяналтын	шатны шүүх																										
2	Иргэн дахь сум	дундын анхан	шатны шүүх																									
	 Эрүү,	иргэний хэргийн	давж заалдах	шатны шүүх																								
3	Захиргаа дахь сум	дундын анхан	шатны шүүх																									
	 дахь сум	дундын анхан	шатны шүүх																									

..... эрүү,
иргэний хэргийн
давж заалдах
шатны шүүх

Хяналтын
шатны шүүх

Нэг хүнд ногдох хүлээн авсан хэрэг=Хүлээн авсан хэргийн нийт тоо/Хүн амын тоо
Нэг хүнд ногдох шийдвэрлэсэн хэрэг= Шийдвэрлэсэн хэргийн нийт тоо/Хүн амын тоо
Хүн амын тоог https://www.1212.mn/Stat.aspx?LIST_ID=976_L03&type=tables авна.
Бүртгэгдсэн гэмт хэргийн тоог https://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_2300_009V1 авна.
Бүртгэлтэй хуулийн этгээдийн тоог https://www.1212.mn/stat.aspx?LIST_ID=976_L23&type=tables авна.

c1- m1-
c2- m2-
c-3- m3-
c-4- m4-

ШАЛГУУР 3. ШҮҮХИЙН САНХҮҮ, ТӨСӨВ, ЗАРДАЛ, ЦАЛИНГИЙН САН, ТӨГРӨГӨӨР

№	Хэрэг	Шүүхийн нэр	Шүүхийн батлагдсан төсөв	Шүүгчийн цалингийн сан	Томилолтоор ажилласан шүүгчийн зардал	Шүүхийн үндсэн хөрөнгө						Нийт урсгал зардал	
						Барилга, байгууламж	Тээврийн хэрэгсэл	Машин тоног, техөөрөмж	Тавилга, эд хогшил	Номын фонд	Програм хангамж		Бусад биет бус хөрөнгө
1	Эрүү дахь сум дундын анхан шатны шүүх											
	 давж заалдах шатны шүүх											
		Хяналтын шатны шүүх											
2	Иргэн дахь сум дундын анхан шатны шүүх											
	 эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх											
		Хяналтын шатны шүүх											

3	Захиргаа дахь сум дундын анхан шатны шүүх
	 эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх
		Хяналтын шатны шүүх

Нэг хэрэгт ногдох зардал=Нийт урсгал зардал/Шийдвэрлэсэн хэргийн тоо



ШАЛГУУР 4. ЗАСАГ ЗАХИРГААНЫ БУСАД МЭДЭЭЛЭЛ (ЖИЛ БҮР ШИНЭЧЛЭХ)

ЗЗНД нэгжийн нэршил	ААНБ-н хариуцлагын хэлбэр							Нийтийн тээврийн үнэ	Мэдээллийн технологи, харилцаа холбоо
	Бүгд	Компани	Хоршоо	Нөхөрлөл	ТӨҮГ, ОНӨҮГ Төсвийн байгууллага	ТББ	Бусад		
Архангай									

Хөдөлмөр эрхлэлтийн түвшин https://www.1212.mn/Stat.aspx?LIST_ID=976_L04&type=tables авна.
 Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн https://www.1212.mn/Stat.aspx?LIST_ID=976_L05&type=tables авна.
 Ядуурлын хамралтын хүрээ https://www.1212.mn/Stat.aspx?LIST_ID=976_L19&type=tables авна.
 Хүний хөгжлийн индекс https://www.1212.mn/Stat.aspx?LIST_ID=976_L27&type=tables авна.
 Бүс, аймаг, хот, тосгон суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө https://www.1212.mn/Stat.aspx?LIST_ID=976_L28&type=tables, <http://sdg.gov.mn/> авна.

ШАЛГУУР 5. ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН МЭДЭЭЛЭЛ (4 ЖИЛ ТУТАМД ШАЛГАХ)

№	Сумын нэр	Багийн тоо	Хэмжээ /мян.км2/	Сумын төвөөс аймаг хүртэлх зай /км/	Хил залгаа улс, аймаг, сум	Зам				
						Ердийн хөрсөн зам	Сайжруулсан хөрсөн	Хайрган хучилттай	Хагуу хучилттай	
1										
2										
3										

Багийн тоог https://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NS0_0300_004V5 авна.

Хүн амын тоог https://www.1212.mn/Stat.aspx?LIST_ID=976_L03&type=tables авна.

Хүн амын нягтралыг https://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NS0_0300_034V2 авна.

